



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДЫН ХЭРЭГЖИЛТ

ҮНДЭСНИЙ ДӨРӨВ ДЭХ ИЛТГЭЛ

DDC
341.23
M-692

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт
Үндэсний дөрөв дэх илтгэл, 2011 он

Үндэсний дөрөв дэх илтгэлийг монгол, англи хэлээр хэвлэсэн болно. Энэхүү илтгэлд ашигласан тоо, мэдээллийг тусгайлан дурдсанаас бусад тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын албан ёсны эх үүсвэрээс авсан болно.

Харилцах хаяг:

Монгол Улс
Улаанбаатар 15015
Нэгдсэн Үндэстний гудамж 5/1
Засгийн газрын II байр
Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо

Утас: (976)-51-265912, (976)-51-260973, (976)-51-261571

Факс: (976)-51-260973, (976)-51-263569

Веб: <http://www.ndic.gov.mn>

www.undp.mn

Э-шуудан: info@ndic.gov.mn

НҮБХХ-ийн “Ядуурал, МХЗ-уудын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог дэмжих туршилтын төсөл”-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэвлэв.

ISBN 978-99962-1-624-4

АГУУЛГА

Товчилсон үг	4
Тэмдэглэгээ, шигтгээ	6
Хүснэгт	6
Дүрслэл	8
Өмнөх үг	10
Талархал	12
Ерөнхий тойм	14
Үндсэн тайлан	20
БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН МХЗ-УУДЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ	22
Зорилго 1: Ядуурал, өлсгөлөнг бууруулах	22
Зорилго 2: Бүх нийтээр анхан шатны боловсрол эзэмших	38
Зорилго 3: Жендэрийн тэгш байдлыг дэмжин хөгжүүлж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх	46
Зорилго 4: Хүүхдийн эндэгдлийг бууруулах	58
Зорилго 5: Эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах	64
Зорилго 6: Бэлгийн замын халдварт өвчин, ХДХВ, ДОХ, сүрьеэтэй тэмцэх, бусад өвчнийг бууруулах	72
Зорилго 7: Байгаль орчны тогтвортой байдлыг хангах	82
Зорилго 8: Хөгжлийн төлөө дэлхий нийтийн түншлэлийг хөгжүүлэх	104
Зорилго 9: Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх	124
БҮЛЭГ 2. МХЗ-УУД ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ, СУРТАЛЧИЛГАА, ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО	145
БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ИНДЕКС	149
БҮЛЭГ 4. МХЗ-УУДЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ	155
ХАВСРАЛТУУД	158
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖУУД	162
ҮНДЭСНИЙ ИЛТГЭЛИЙГ БЭЛТГЭСЭН БАГ	164

ТОВЧИЛСОН ҮГ

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АНДЭЗНК	Ази, Номхон далайн Эдийн засаг, нийгмийн комисс
АТГ	Авлигатай тэмцэх газар
АХБ	Азийн хөгжлийн банк
АЧС	Агаарын чанарын стандарт
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНФУ	Бүгд Найрамдах Филиппин Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуучлалын яам
БСШУЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам
ГУУКА	Геологи, уул уурхай, кадастрын алба
ГХБГЗЗГ	Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДОХ	Дархлалын олдмол хомсдол
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ЖЭМХ	Жендэрийн эрх мэдлийн хэмжүүр
ЗДТГазар	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
М2	Мөнгөний нийлүүлэлт
МХЗ	Мянганы хөгжлийн зорилт
МСС	Мянганы сорилтын сан
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
МУИС	Монгол Улсын Их сургууль
МШХХТГ	Мэдээлэл шуудан, харилцаа, холбоо технологийн газар
МҮХАҮТ	Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн тэнхим
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
НҮБ	Нэгдсэн Үндэсний байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
НҮЭМ	Нөхөн үржихүйн эрүүл мэнд

ОНББ	Олон найрлагад бичил бэлдмэл
ООТА	Орлогыг орлуулан тооцох арга
ОУВС	Олон Улсын Валютын сан
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨНЭЭС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СЭЗДС	Санхүү, Эдийн Засгийн дээд сургууль
ТББ	Төрийн бус байгууллага
ХАА	Хөдөө аж ахуй
ХААИС	Хөдөө Аж Ахуйн Их сургууль
ХАЁТ	Хөгжлийн Албан Ёсны Тусламж
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХДХВ	Хүний дархлал хомсдлын вирус
ХУИС	Хүмүүнлэгийн Ухааны Их сургууль
ХӨЦМ	Хүүхдийн өвчний цогц менежмент
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай хувьцаат компани
ХХҮХ	Хөдөлмөр халамж, үйлчилгээ хэлтэс
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХИ	Хүний хөгжлийн индекс
ХХХ	Хүлцэх хэм хэмжээ
ХУД	Хан-Уул дүүрэг
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг
УБ	Улаанбаатар
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний Статистикийн хороо
ҮХЦБ	Үндэсний хөгжлийн цогц бодлого
ЦХМ	Цэвэр хөгжлийн механизм
ЧД	Чингэлтэй дүүрэг
ЧХХ	Чөлөөт Худалдааны Хэлэлцээр
ЭМД	Эрүүл Мэндийн даатгал
ЭЗНЗ	Эдийн засаг, нийгмийн зөвлөл
ЭСЯ	Элчин сайдын яам

ШИГТГЭЭ

- Шигтгээ 1. Дэлхийн эдийн засгийн тойм
- Шигтгээ 2. Валютын ханшийн хөдөлгөөн
- Шигтгээ 3. Блүүмберг бизнесийн сэтгүүл
- Шигтгээ 4. Монгол Улсын ядуурлын түвшин
- Шигтгээ 5. МХЗ-д суурилсан цогц бодлогоос

ХҮСНЭГТ

- Хүснэгт 1. Ядуурлын түвшин, гүнзгийрэлт, хэрэглээ, нэг хүнд ногдох ДНБ
- Хүснэгт 2. Тав хүртэлх насны хүүхдийн тураал, өсөлтийн хоцролт, туранхай хүүхдийн хувь
- Хүснэгт 3. Ажиллах хүчний оролцоо, 15-24 насны залуучуудын ажилгүйдэл, 2007-2010 он
- Хүснэгт 4. Хүн амын шилжих хөдөлгөөн, 2006-2010 он
- Хүснэгт 5. Бага боловсролын хамран сургалт, 1-5 дугаар анги хүртэл суралцагчид, бичиг үсэг тайлагдалдалтын хувь
- Хүснэгт 6. Дотуур байранд хамрагдаж байгаа хүүхдийн тоо
- Хүснэгт 7. Бага, ерөнхий болон дээд боловсрол эзэмшигчдийн хүйсийн харьцаа (2010 он)
- Хүснэгт 8. Хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь
- Хүснэгт 9. Төрийн нийт албан хаагчдын дотор эмэгтэй, эрэгтэйчүүдийн эзлэх хувь
- Хүснэгт 10. Улсын Их Хуралд сонгогдсон, нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь
- Хүснэгт 11. Эмэгтэйчүүдийн оролцоо дээшлэхгүй байгаагийн шалтгаан хувиар, (2010 он)
- Хүснэгт 12. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх шалтгаан
- Хүснэгт 13. Эхийн эндэгдэл, эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлт
- Хүснэгт 14. 100000 амьд төрөлт бүрт нас барсан эхийн тоо, эхийн эндэгдлийн түвшин
- Хүснэгт 15. Жирэмсэн эмэгтэйчүүд болон 15-24 насны залуучуудын дундахь ХДХВ-ын халдварын тархалт, хувь
- Хүснэгт 16. Сүрьеэ өвчний тархалт, өвчлөлийн түвшин, нас баралт, оношилгоо, эмчилгээний тохиолдлын хувь
- Хүснэгт 17. 5-6 настай хүүхдийн шүд цоорох өвчний тархалт (хувь)
- Хүснэгт 18. Ойт нутаг болон улсын тусгай хамгаалалтад авсан газар нутаг, нэг хүнд ногдох нүүрсхүчлийн хий, агаар дахь хүхэрлэг хий болон азот давхар ислийн агууламж
- Хүснэгт 19. Ойт нутгийг ойжуулахад оруулсан хөрөнгө оруулалт (хувь)
- Хүснэгт 20. Монгол Улсын ойн сангийн нийт талбайн хэмжээ (мян.га)
- Хүснэгт 21. Нутгийн иргэд, нөхөрлөлд эзэмшүүлсэн ойн сангийн эзлэх хувь
- Хүснэгт 22. Улсын тусгай хамгаалалтанд авсан газар нутгийн хэмжээ, эзлэх хувь
- Хүснэгт 23. Түлшний шаталтаас үүсэх CO2-ын ялгаралтын хэмжээ
- Хүснэгт 24. Хамгаалалтад авсан гол мөрний усны урсац бүрэлдэх ундаргын эхийн эзлэх хувь
- Хүснэгт 25. Төвлөрсөн ус хангамжийн системд холбогдсон барилга байгууламжинд амьдарч буй хүний тоо, 2010 он.

- Хүснэгт 26. Экспортын барааны бүтэц
- Хүснэгт 27. Худалдааны хүчин чадлыг бий болгоход ХАЁТ-ын үзүүлсэн хувь
- Хүснэгт 28. Худалдааны хүчин чадлыг бий болгоход туслахаар үзүүлсэн ХАЁТ-ийн эзлэх хувь (ДНБ-т эзлэх хувиар, сая ам.доллар)
- Хүснэгт 29. Санхүүгийн салбарын актив хөрөнгийн бүтэц (2010)
- Хүснэгт 30. Мөнгөний нийлүүлэлтийн ДНБ-д эзлэх хувь
- Хүснэгт 31. 2003-2010 оны дамжин өнгөрөх тээвэрлэлт (мян.тонн)
- Хүснэгт 32. Төмөр замын дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтийн эзлэх хувь (2007-2010)
- Хүснэгт 33. Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл (2010 оны гүйцэтгэл), тэрбум төгрөг
- Хүснэгт 34. Өрийн тогтвортой байдлын шалгуур үзүүлэлт
- Хүснэгт 35. Засгийн газрын үнэт цаас арилжаалсан байдал (2006-2010)
- Хүснэгт 36. МХЗ-9-ын хэрэгжилтийн хяналт-шинжилгээний шалгуур үзүүлэлтүүд
- Хүснэгт 37. Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтийн түвшинд өгсөн шинжээчдийн үнэлгээ
- Хүснэгт 38. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн улс төр, санхүү, эдийн засгийн хараат бус байдлын талаарх иргэдийн төсөөлөл (улсын дундаж хувиар)
- Хүснэгт 39. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэж буй иргэдийн төсөөлөл (хувиар)
- Хүснэгт 40. ТББ хэрхэн ажилладаг талаарх үнэлэмж, хувиар
- Хүснэгт 41. ТББ-ууд үндсэн чиг үүргээ биелүүлж чаддаг гэж үзсэн оролцогчдын хариулт, хувиар
- Хүснэгт 42. Авлигын цар хүрээний үзүүлэлтүүд
- Хүснэгт 43. Авлигын хэлбэрийн үзүүлэлтүүд
- Хүснэгт 44. Авлигын индекс, аймаг нийслэлээр
- Хүснэгт 45. Хууль хяналтын байгууллага дахь авлигад өртөх эрсдлийн үнэлгээ, байгууллагын түвшин шатлалаар
- Хүснэгт 46. Хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн нөлөөллийн үнэлгээ
- Хүснэгт 47. Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын хүрээнд авлига байгаа эсэх талаарх иргэдийн төсөөлөл
- Хүснэгт 48. Авлигатай тэмцэх газрын батлагдсан төсөв, түүний зарцуулалт, сая төгрөг
- Хүснэгт 49. МХЗ-ын 24 дүгээр зорилтын шалгуур үзүүлэлтүүдийн хүрсэн түвшин болон төлөвлөж буй түвшин
- Хүснэгт 50. МХЗ-ын 24 дүгээр зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн тойм хэмжээ, тэрбум төгрөг

ДҮРСЛЭЛ

- Дүрслэл 1. ДНБ-ий бодит өсөлтийг хангаж буй салбаруудын тархац (хувиар)
- Дүрслэл 2. Инфляцийн түвшин 2010 онд (оны эхнээс)
- Дүрслэл 3. Валютын ханшийн хөдөлгөөний тойм зураг, байршлаар
- Дүрслэл 4. Ам.долларын эсрэг хамгийн их чангарсан валютууд, 2010 он
- Дүрслэл 5. Гадаад худалдаа (2005-2010 он, сая ам.доллараар)
- Дүрслэл 6. Нэг хүнд ногдох ДНБ ба дундаж цалингийн хэмжээ
- Дүрслэл 7. Амьжиргааны доод түвшин (АДТ), ХХДХ, бүрэн, хувь тэнцүүлсэн тэтгэврийн хэмжээ (2009-2010 он, мян.төг)
- Дүрслэл 8. 15-24 насны залуусын нийгмийн байдал, 2010 он
- Дүрслэл 9. 15-24 насны ажил эрхэлдэг хүн ам (мян.хүн ам)
- Дүрслэл 10. Бага, ерөнхий болон дээд боловсрол эзэмшигчдийн хүйсийн харьцаа
- Дүрслэл 11. Нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 1990-2010
- Дүрслэл 12. Тав хүртлэх насны хүүхдийн эндэгдлийн түвшин
- Дүрслэл 13. Эхийн эндэгдлийн түвшин
- Дүрслэл 14. Улсын тусгай хамгаалалтад тухайн онд авсан газар нутгийн хэмжээ, сая га.
- Дүрслэл 15. Улаанбаатар хотын агаарын чанарыг хянах суурин харуулуудын байршил зүйн зураг
- Дүрслэл 16. Агаар бохирдуулах бодис хүхэрлэг хий, азотын давхар ислийн жилийн дундаж агууламж
- Дүрслэл 17. Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн өвлийн сарын хоногийн дундаж агууламж, (2009 оны 11-дүгээр сараас 2010 оны 01-дүгээр сар)
- Дүрслэл 18. Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн өвлийн сарын хоногийн дундаж агууламж (2009 оны 11-р сараас 2010 оны 1-р сар)
- Дүрслэл 19. Гол мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн зураглал
- Дүрслэл 20. Гол мөрний урсац бүрэлдэх эхийн хамгаалалтад авсан байдал (2010)
- Дүрслэл 21. Ус хангамж, сайжруулсан ариун цэврийн байгууламж
- Дүрслэл 22. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ (2006-2010)
- Дүрслэл 23. Ашиглалтад оруулсан орон сууцны тоо, нийт талбайн хэмжээ, орон сууцны фонд (2000-2010)
- Дүрслэл 24. Нэг хүнд ногдох орон сууцны талбайн хэмжээ, м²
- Дүрслэл 25. Экспортын хэмжээ, сая ам.доллар
- Дүрслэл 26. Экспортын барааны бүтэц, хувь, 2010 он.
- Дүрслэл 27. Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц, динамик
- Дүрслэл 28. Засгийн газрын гадаад зээлийг санхүүжүүлэгч байгууллагууд
- Дүрслэл 29. Суурин телефон утасны цэгийн тоо (1000 хүн тутамд)
- Дүрслэл 30. Суурин телефон холбооны хэрэглэгчдийн тоон үзүүлэлт (мянган ширхэгээр)
- Дүрслэл 31. Интернэт байнгын хэрэглэгчийн тоо (1000 хүн тутамд)
- Дүрслэл 32. Интернэтийн байнгын хэрэглэгчдийн тоон үзүүлэлт (мянган ширхэгээр)
- Дүрслэл 33. Үүрэн телефон холбооны хэрэглэгчдийн тоон үзүүлэлт (мянган ширхэгээр)
- Дүрслэл 34. Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо (1000 хүн тутамд)
- Дүрслэл 35. Хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн байдал, хувиар
- Дүрслэл 36. Намд хандах иргэдийн итгэл

- Дүрслэл 37. Хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдэлт
- Дүрслэл 38. Авлигын индекс, түүнийг бүрдүүлэгч үзүүлэлтүүдийн утга
- Дүрслэл 39. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн үзүүлэлт
- Дүрслэл 40. Төрийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтнуудын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ
- Дүрслэл 41. Хууль хяналтын байгууллагын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ (салбараар)
- Дүрслэл 42. Аймаг, нийслэлийн хөгжлийн индексийн ялгааг харуулсан газрын зураг
- Дүрслэл 43. Аймаг, нийслэлийн боловсролын үйлчилгээний хүртээмж
- Дүрслэл 44. Аймаг, нийслэлийн соёл, урлагийн байдал
- Дүрслэл 45. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж
- Дүрслэл 46. Аймаг, нийслэлийн хүрээлэн буй байгаль орчны байдал
- Дүрслэл 47. Аймаг, нийслэлийн нийгэм, эдийн засгийн байдал
- Дүрслэл 48. Аймаг, нийслэлийн санхүүгийн байдал



ӨМНӨХ ҮГ

Дэлхийн улс, гүрнүүд Нэгдсэн Үндэстний байгууллага хэмээх нэгэн том айлд нэгдэн эрдэнэт хүмүүнээ эрх тэгш, эрүүл саруул, айх аюулгүй, элбэг хангалуун аж төрөх боломжоор хангахын төлөө бодол санаагаа Мянганы хөгжлийн нэгэн зорилтод чиглүүлэн хамтран зүтгэж байгаа билээ. Хичээл зүтгэлийнхээ үр шимийг үнэлэх зорилгоор НҮБ-ын Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт хэрхэн байгааг Ерөнхий Ассемблейд авч сонсдог уламжлал тогтоод байна. Манай улс МХЗ-уудын Үндэсний 3 дахь илтгэлээ 2010 онд танилцуулж байсан билээ.

Монгол Улс НҮБ-д гишүүнээр элсэн орж, НҮБ-ын индэр дээрээс Монгол Улсаа тунхаглан зарласны 50 жилийн ой 2011 онд тохиолоо. Энэ хугацаанд Монгол Улс нь НҮБ-ын гишүүн, тусгаар тогтносон бүрэн эрхт улсын хувьд хоёр өөр нийгмийн тогтолцоог дамжин хөгжиж байна. Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн ардчилсан тогтолцоо бүхий орчин үеийн зах зээлийн нийгмийг цогцлоон хөгжүүлэх үйлсэд НҮБ үнэтэй хувь нэмэр оруулж байна.

Бид МХЗ-уудын хэрэгжилтийн Үндэсний 4 дэх илтгэлээ гаргаж буй 2010 онд НҮБ-ын Ази, номхон далайн бүсийн товчооны захирал манай улсад айлчлан бидний өнөөгийн байдалтай танилцаж, олон улсын хэмжээний чуулганыг Монгол Улсад амжилттай зохион байгуулсан нь чухал ач холбогдолтой болсоныг дурьдахад таатай байна.

Бид МХЗ-уудыг хэрэгжүүлэхдээ МХЗ-уудад суурилсан хөгжлийн урт хугацааны төлөвлөгөөг 2021 он хүртэлх хугацаанд улс орноо хөгжүүлэх Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэлбэрээр боловсруулан гаргаад байна. МХЗ-уудыг тодорхойлж, түүнд хүрэх арга замаа оновчтой тогтоож, хэрэгжилтийг нь хангаж байгаа нь манай улсын хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж байгаа юм.

Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн Үндэсний 4 дэх илтгэлийг албан ёсны статистик тоон мэдээлэл дээр үндэслэн, төрийн бус байгууллагуудыг оролцуулан, судлаач эрдэмтдийн саналыг тусган гаргаж байгаа учраас олон түмний оролцоотой бий болдог хөгжлийн бодлого, арга хэмжээнд дүгнэлт хийсэн томоохон тайлан болдог юм.

Дэлхийн нийтийн тулгамдсан асуудлууд болж байгаа байгаль орчны доройтол, алан хядах үйл ажиллагаа, цөмийн зэвсгийн аюул, тив дамжсан гэмт хэрэг, хүний эрхийн зөрчил, хямрал, дэлхийн дулаарал, ядуурал нь дэлхийн улс орнууд зөвхөн өөр өөрийн ашиг сонирхлоор биш, нийтийн эрх ашгийн үүднээс хамтарч ажиллах шаардлагыг бий болгож байна. Монгол Улс ч дэлхийн хамтын нийгэмлэгийн идэвхитэй гишүүн байж, бүс нутгийн болон нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар идэвхитэй байр суурь баримтлан ажиллах болно.

Манай улс МХЗ-уудыг хэрэгжүүлэх хугацааныхаа 11 жилийг ардаа орхиод байна. Өнгөрсөн хугацаанд бидний тавьсан зорилтуудын 77.9 хувь нь биелж, улс орны хөгжилд эерэг нөлөө үзүүлж байна. Мөн зарим зорилтууд өмнө байсан түвшнээсээ буурах, мөн одоогийн хандлагаар үргэлжилбэл 2015 он гэхэд зорилт хангагдах боломжгүй байдалд хүрэх зэрэг анхаарал татсан асуудал ч байна. Тухайлбал, МХЗ-уудын зорилго 1 буюу ядуурлыг хоёр дахин бууруулах, мөн зорилго 7 буюу байгаль орчны бохирдол Монгол хүн бүхний санааг зовоосон зүйл болж хувираад байна.

Бид 2015 онд МХЗ-уудын гүйцэтгэлийн тайлангаа НҮБ-д танилцуулна. Ингэхийн тулд амалсан зорилтондоо хүрэхийн төлөө ажиллах нь зүйн хэрэг. Ойрын 4 жилдээ бид дээрх хоёр асуудалд онцгой анхаарал хандуулж, тусгайлсан хөтөлбөр төсөл боловсруулж ажиллах шаардлага байна. Бид ядуу байгаа иргэдээ ядуу хэмээх ангиллаас гаргахаас гадна, хамгийн гол нь ядуу хэмээх ангилалд ороход бэлэн байгаа иргэд, өрхөө ядуурлаас сэргийлэх талаар ажиллах шаардлагатай болоод байна.

Үүнээс дутахгүй ач холбогдолтой өөр нэг асуудал бол яах аргагүй байгаль орчны асуудал, тэр дундаа Улаанбаатар хот, аймгийн төвүүд, суурин газрын агаарын бохирдлыг бууруулах явдал юм. Агаарын бохирдлоос үүдэн элдэв шинэ өвчин, бусад сөрөг нөлөө ихсээд байна. Манай улс агаарын бохирдлыг бууруулах хүрээнд Их бүтээн байгуулалт хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна. Энэхүү бүтээн байгуулалт энэ хөтөлбөр их хөрөнгө,

цаг хугацаа шаардагдах ч гэсэн бид ирээдүй, үр хүүхдийнхээ төлөө цаг алдалгүй шуурхай хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Үндэсний дөрөв дэх илтгэлийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлсэн НҮБХХ-ийн Суурин төлөөлөгчийн газрын удирдлагад чин сэтгэлийн талархал илэрхийлж, манай улсад үзүүлж буй тусламж дэмжлэг, үр ашигтай хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэн хөгжүүлэхийг хүсье.

Мөн энэхүү илтгэлийг бэлтгэхэд идэвхитэй оролцсон төрийн болон төрийн бус байгууллагуудад талархал илэрхийлж, улам ихийг бүтээхийг хүсэн ерөөе.



ЦАХИАГИЙН ЭЛБЭГДОРЖ
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ



ТАЛАРХАЛ

Юуны өмнө МХЗ-уудад хүрэх арга зам, төсөл, хөтөлбөрүүдийн биелэлт, Төр, төрийн бус байгууллагуудын оролцоог үнэлсэн Үндэсний дөрөв дэх илтгэлийг бэлтгэн гаргаж та бүхэнд хүргэж байгаадаа таатай байна. Манай улс МХЗ-уудын хэрэгжилтийг хоёр жил тутам үнэлж цаашид анхаарах, хэрэгжүүлэх бодлогын хувилбаруудыг тодорхойлж, Монгол Улсын нийт ард түмний болон НҮБ-ын өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж, идэвхи зүтгэл гарган ажиллаж байгаагаараа олон улсын түвшинд үнэлэгдсээр ирсэн.

Монгол Улсын Засгийн газар тэр дундаа манай хороо байгуулагдсан цагаасаа эхлэн МХЗ-уудын хэрэгжилтийг хангахад анхаарч, хэрэгжилт нь сул байгаа зорилтуудыг 2015 он гэхэд зорилтод түвшинд нь хүргэх ажлыг бодлого, төлөвлөлтөндөө тусгаж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Тухайлбал, “Монгол Улсын нийгэм, эдийн засгийг 2011 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл”-ийг боловсруулан УИХ-аар батлуулж, “Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2012-2016 оны тэргүүлэх чиглэлүүд” дунд хугацааны бодлогын

баримт бичгийн төслийг боловсруулан Монгол Улсын Засгийн газарт хүргүүлээд байгаа бөгөөд уг бодлогын баримт бичгүүд нь хүний хөгжлийг хангах тэр дундаа ядуурал, ажилгүйдлийг бууруулах, эрүүл мэнд, боловсролын хүртээмж чанарыг сайжруулах, орон нутгийн хөгжлийн ялгааг арилгахад гол чиглэлээ болгосон юм. Гэвч МХЗ-уудыг хангах чиглэлд томоохон ахиц гаргах, эрчимтэй ажиллах шаардлага байгаа нь энэхүү үндэсний дөрөв дэх илтгэлийн дүгнэлтээс харагдаж байна. Тухайлбал, манай улсын эдийн засаг жил бүр хурдацтай өсч, зах зээлийн хүрээ тэлж байгаа хэдий ч ядуурал дорвитой буурахгүй, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэхгүй байгааг анхаарч хүмүүсийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ажлын байрыг олноор бий болгох, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, улмаар цалин, орлогын түвшинг өсгөх хэрэгтэй байна. Иймд уул уурхайн томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, дэд бүтцийн салбарт бүтээн байгуулалтын ажлуудыг өрнүүлэх уул уурхайгаас орж ирэх орлогыг зөв удирдах, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, макро түвшний тогтвортой байдлыг хангахад төр засгаас анхаарч ажиллаж байна.

МХЗ-уудын үндэсний дөрөв дэх илтгэлээс харахад эх, нялхасын болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, бага боловсролын түвшин, сүрьеэ өвчлөлийн тархалт зэрэг зорилтууд нь 2015 онд бүрэн биелэгдэх, зарим нь төлөвлөсөн зорилтоосоо давж биелэгдэх түвшинд байгааг Та бүхэнд уламжлахад таатай байна.

Энэхүү илтгэлийг боловсруулахад Монгол Улсын Засгийн газраас ихээхэн анхаарч салбарын яамдын удирдлагуудаас бүрдсэн, тус хорооны даргаар ахлуулсан удирдах зөвлөлийн ажлын хэсгийг байгуулан ажиллуулав. Мөн салбарын яамд, агентлагуудын холбогдох мэргэжилтнүүдээс бүрдсэн техникийн ажлын хэсгүүдийг байгуулан ажиллуулж илтгэлийг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо нэгтгэн боловсрууллаа.

Мөн илтгэл боловсруулах ажилд Монгол дахь НҮБ-ын системийн байгууллагууд, түүний дотор НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүн амын сан зэрэг байгууллагаас өөрийн төсөл, хөтөлбөрийн хүрээнд мэргэжилтний болон санхүүгийн туслалцаа үзүүлснийг тэмдэглэе. Иймд эн тэргүүнд эдгээр байгууллага, ялангуяа

НҮБ-ын Монгол дахь Суурин зохицуулагч, НҮБХХ-ийн Суурин төлөөлөгч хатагтай Сезин Синонглед онцлон талархал илэрхийлж байна.

Үндэсний илтгэлийг боловсруулахад эрдэм мэдлэг, хүч хөдөлмөрөө харамгүй дайчлан ажилласан ажлын хэсгийн гишүүд, мөн үнэтэй санал зөвлөмж өгч ажилласан эрдэмтэд, судлаачид, төрийн бус байгууллагын төлөөлөл, энэ ажилд оролцон ажилласан нийт хүмүүст талархлаа илэрхийлье.

Та бүхнийг хүндэтгэсэн,



Ч.ХАШЧУЛУУН

ҮНДЭСНИЙ ХӨГЖИЛ, ШИНЭТГЭЛИЙН ХОРООНЫ ДАРГА


ЕРӨНХИЙ ТОЙМ

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

2010 он гарсаар ДНБ-ий бодит хэмжээ өссөөр оны эцэст 6.4 хувь болж, зэрэгцүүлэх үнээр 4162.8 тэрбум төгрөгт хүрчээ. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөг 3.6 хувь, боловсруулах аж үйлдвэр 6.1 хувь, барилгын салбар 16.5 хувь, бөөний болон жижиглэн

худалдаа 39.3 хувиар өсч ДНБ-ий бодит өсөлтөд нөлөөлсөн байна. Харин өвөлжилт, цаг агаарын хүндрэл, бэрхшээлийн улмаас малын зүй бус хорогдол өсч, ХАА-н салбарын нэмэгдэл өртөгийг 16.6 хувиар буурууллаа.

Дүрслэл 1. ДНБ-ий бодит өсөлтийг хангаж буй салбаруудын тархац (хувиар)



ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР

2010 онд малын тоо өмнөх оныхоос 11.3 саяар, бойжсон төлийн тоо 6.4 саяар буурч, том малын зүй бус хорогдол өмнөх жилүүдийнхээс эрс өсч 10.3 сая толгойд хүрсэнээр мал аж ахуйн салбарын өсөлт саарсан байна. Том малын зүй бус хорогдол өндөр байгаатай холбоотойгоор мал аж ахуйн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох малын мах, сүү, ноос, ноолуурын гарц багасчээ.

Ялангуяа, ямааны зүй бус хорогдол их байсан нь мал аж ахуйн салбарын гол түүхий эд болох ноолуурын үйлдвэрлэлийг бууруулсан байна. Мал аж ахуйн салбарыг байгалийн эрсдэлээс хамгаалах, малчдын амьжиргааг дээшлүүлэх зорилгоор УИХ-аас “Монгол мал” Үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж эхлэв. Цаашид тус хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж,

малжуулах арга хэмжээг цаг алдалгүй авах, малгүй болсон зарим айл өрхийг ажиллах хүчний эрэлт, хэрэгцээ шаардлагатай байгаа бусад салбарт шилжүүлэн ажиллуулах зэрэг арга хэмжээг зохион байгуулах шаардлага гарч байна.

Газар тариалангийн салбарын хувьд “Атрын 3 дахь аян” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд улсын хэмжээнд 2010 онд нийтдээ 315.3 мянган га талбайд тариалалт хийснээс 366.3 мянган тонн үр тариа, 169.0 мянган тонн төмс, 90.3 мянган тонн хүнсний ногоо хураан авч, хүнсний ногооны 53.7 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангалаа. Тариалсан талбайн нийт хэмжээ өнгөрсөн оны мөн үеийнхээс 11.4 хувиар өсч, атаршсан болон өнжсөн талбайгаас нийт 255.3 мянган га талбайг ашиглалтад оруулснаар эргэлтийн талбайн хэмжээ 584.0 мянга га-д хүрлээ.

АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГЫН САЛБАР

Аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 2010 онд зэрэгцүүлэх үнээр 1158.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 4.3 хувиар өссөн байна. 2010 онд нүүрс олборлолт 91.8 хувь, газрын тос 16.7 хувь, төмрийн хүдэр 2.3 дахин нэмэгдсэнээр уул уурхайн салбарын нэмэгдэл өртөг зэрэгцүүлэх үнээр 736.9 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оныхоос 3.6 хувиар өсөв. Шинээр ашиглалтад орсон Овоот толгой, Ухаа худаг, Хөшөөтийн нүүрсний уурхайн олборлолтын хүчин чадал нэмэгдэж нүүрсний олборлолт өссөн байна. Мөн Төмөртэй, Баянгол, Таяннуур, Харангат, Элстэй, Төмөртолгой зэрэг төмрийн хүдрийн уурхайнуудын олборлолт ч нэмэгджээ. Тамсаг, Дорноговийн сав газруудад газрын тосны олборлолтын үйл ажиллагаа эрчимжсэнээр олборлолтын хэмжээ 2010 онд 2.2 сая баррельд хүрчээ.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөг 6.1 хувиар өсч, зэрэгцүүлэх үнээр 248.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Үүнээс хүнсний үйлдвэрлэл хамгийн өндөр өссөн бөгөөд үр тариа, гурилын үйлдвэрлэл, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл ч мөн өссөн дүнтэй гарлаа.

Барилгын салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ зэрэгцүүлэх үнээр 60.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоос 16.5 хувиар өссөн байна.

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих, хөгжүүлэх чиглэлээр 2008 онд Засгийн газраас төсвөлсөн 1 тэрбум төгрөгний эх үүсвэрийг орон нутаг, арилжааны банкуудын оролцоотой 1.4 тэрбум төгрөг болгож 321 иргэн, аж ахуй нэгжид хөнгөлөлттэй зээл олгосон, 2009 онд Улсын төсөвт тусгагдсан 30.85 тэрбум төгрөгний эх үүсвэрийг орон нутаг, арилжааны банкуудын оролцоотой 38,6 тэрбум төгрөгт хүргэж үүний үр дүнд улсын хэмжээгээр 1642 иргэн, аж ахуй нэгжид хөнгөлөлттэй зээл олгож, 515 үйлдвэр шинээр ашиглалтанд орж, 1123 ЖДҮ-ийн үйл ажиллагааг өргөтгөсөн, 2010 онд 30 тэрбум төгрөгний эх үүсвэрийг арилжааны банк болон санхүүгийн бусад байгууллагуудын оролцоотой 40.0 тэрбум төгрөгт хүргэж нийт 1612 иргэн, аж ахуй нэгжид жилийн 12%-ийн хүүтэй, 3 жилийн хугацаатай нөхцлөөр хөнгөлөлттэй зээл олгож үүний үр дүнд

Шигтгээ 1. Дэлхийн эдийн засгийн тойм

Дэлхийн эдийн засаг 2008 оны IV улирлаас уналтанд орсон ба үүний гол шалтгаан нь АНУ-ын орон сууцны зээлийн эргэн төлөлт муудсантай холбоотой. Зээлийн эргэн төлөлт буурсанаар банкны салбарт хүнд цохилт болж улмаар дэлхийн түүхэн дэх 2 дахь том санхүүгийн хямралыг үүсгэсэн байна.

Санхүүгийн хямрал улам даамжирч 2009 оноос эхлэн хүн амын орлогын түвшин, худалдан авах чадвар буурсантай холбоотойгоор зээлийн эргэн төлөлт удааширч, банкны барьцаанд байгаа орон сууцыг эргүүлэн өгөх зэргээс хамааран банкны зээлийн нийлүүлэлт буурч, чанаргүй зээл нэмэгдэж эхэлсэн байна. Улмаар банкны салбарын активт сөргөөр нөлөөлж их хэмжээний үл хөдлөх хөрөнгөтэй болсон банкууд хөрөнгөө зах зээлд хямдруулсан үнээр зарах боллоо. и нгэснээр орон сууцны үнэ огцом буурч эхэлсэн байна.

Дэлхийн зах зээл дээр АНУ-ын гол гол үнэт цаасууд өмнө байгаагүйгээр эрчимтэй унаж эхэлсэн бөгөөд мөн дэлхийн зах зээл дээрх зэс болон бусад голлох металлуудын үнэ ч огцом буурав.

2009 онд дэлхийн санхүүгийн зах зээл бүхэлдээ хямралын байдалтай болсон ба оны эхний хагаст дэлхий нийтийг хамарсан санхүү, эдийн засгийн хямрал санхүүгийн зах зээлд огцом үнэгүйдэл бий болгосон бол оны хоёрдугаар хагаст тогтворжих, зарим орны хувьд өсөх хандлагатай болжээ.

2010 онд дэлхийн зах зээл дээрх түүхийн эдийн үнэ тогтворжиж эдийн засаг эргэн сэргэж эхэлсэн.

улсын хэмжээнд 581 ЖДҮ шинээр байгуулагдаж, 1031 аж ахуй үйлдвэрээ өргөтгөсөн байна.

Улсын хэмжээнд нийт 1096 ЖДҮ шинээр байгуулагдаж, 5946 ажлын байр шинээр бий болсон, 6322 ажлын байр хадгалагдан үлдсэн.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАР

Үйлчилгээний салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ зэрэгцүүлэх үнээр 1770.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 9.8 хувиар өссөн байна. 2009 онд бууралтад ороод байсан бөөний болон жижиглэн худалдааны салбар 2010 онд сэргэж, нэмэгдэл өртгийн хэмжээ 39.3 хувиар өссөн байна. Тус салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ өсөхөд бөөний болон жижиглэн худалдааны нийт борлуулалт оны үнээр өмнөх оныхоос 62.4 хувь, импортын бараа, бүтээгдэхүүний хэмжээ 53.3 хувиар тус тус өссөнөөс гадна уг салбарт үйл ажиллагаагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо өмнөх оныхоос 34.4 хувиар өсч 5058-д хүрсэн нь нөлөөлсөн байна.

Уул уурхайн салбарын олборлолт нэмэгдэж, Оюутолгой төслийн барилга, бүтээн байгуулалтын ажил эхэлж байгаатай холбогдон импортоор орж ирж байгаа ачаа тээврийн хэмжээ нэмэгдэж тээврийн салбарын нэмэгдэл өртгийг 7.0 хувиар өсгөжээ.

ИНФЛЯЦИ

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өсөлтийг нэг оронтой тоонд байлгах зорилт дэвшүүлсэн боловч урьдчилан таамаглахад хүндрэлтэй тодорхой бус нөхцөлүүд, гадаад, дотоод хүчин зүйлсээс шалтгаалж 2010 оны эцэст 13 хувьтай гарлаа. Тухайлбал, оны


эхнээс өндөр өсөлттэй байсан инфляци 2010 оны 5 дугаар сард оргил цэгтээ буюу 13.1 хувьд хүрсэн ч цаашид буурч 2010 оны 11 дүгээр сар хүртэл харьцангуй тогтвортой байлаа. 12 дугаар сард 2.4 хувиар өссөнөөр оны эцэст инфляци 13 хувьтай гарлаа.

Манай Улсын инфляцийг бүлгээр задлан авч үзэхэд хүнсний бүлгийн бүтээгдэхүүн хамгийн өндөр өсөлтийг бий болгосон бөгөөд үүн дотор хамгийн ихээр нөлөө үзүүлсэн хүчин зүйл нь махны үнийн өсөлт юм. Учир нь манай орны хувьд өрхийн хэрэглээний зардлын 16 хувийг махны бүлэг дангаар эзэлдэг буюу мах, махан бүтээгдэхүүн нь хэрэглээний сагсанд хамгийн өндөр хувийн жинтэй байдаг бөгөөд 2010 оны зудны нөлөөгөөр махны нийлүүлэлт ихээхэн буурсны зэрэгцээ нөөцийн махны хэмжээ ч бага байсан нь үүнд нөлөөлсөн байна.

Манай орон хүнсний бараа, бүтээгдэхүүний 70 хувийг импортоор авдаг. Хэрэглээний сагсны 287 нэр төрлийн бараа, үйлчилгээнээс 158 бараа нь импортынх бөгөөд тэдгээрийн сагсанд эзлэх жин 30 хувь байна.

2008 оны өндөр инфляцийн үед хүнсний бус бүлгийн барааны үнэ түүнчлэн мах, гурилаас бусад хүнсний барааны үнэ ихээр өсч нийт инфляцийн 90 хувийг бүрдүүлж байсан бол 2010 онд дээр дурьдсанчлан мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлт нийт инфляцийн 50 хувийг эзэлж, 13 нэгж инфляцийн 6.6 нэгжийг бүрдүүлжээ.

Дүрслэл 2. Инфляцийн түвшин 2010 онд (оны эхнээс)



Эх үүсвэр: УЦХ

Мөн хүнсний бус бүлгийн үнэ 2009 оны эцэстэй харьцуулахад өссөн нь эдийн засаг сэргэж, үйлдвэрлэл нэмэгдэж байгааг илтгэж байна. Нөгөө талаас 2010 онд мөнгөний нийлүүлэлт 62.5 хувиар, дотоод цэвэр зээл 25.3 хувиар өсч, аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 3.3 их наяд төгрөгт хүрч, зах зээлийн нийт үнэлгээ 2.2 дахин нэмэгдсэн нь манай улсын эдийн засаг эрчимтэй тэлж байгааг харуулж байна.

Ийнхүү 2010 онд эдийн засаг сэргэсэн, байгаль, цаг уурын хүндрэл тохиолдож олон аймагт өвөлжилт хүндэрсэн, цахилгаан дулааны үнэ өссөн, ноолуурын үнэ өндөр, хятадын эдийн засаг өндөр инфляцитай, ОХУ-д хэт халуун болон гангийн улмаас ургац алдаж буудайн экспортодоо хориг тавьсан зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляци 13 хувьтай гарлаа.

ВАЛЮТЫН ХАНШ

2009 онд дэлхийн нийт үйлдвэрлэл 0.6 хувиар, хөгжингүй орнуудын эдийн засаг 3.4 хувиар буурсан бол 2010 онд дэлхийн эдийн засаг сэргэж,


дэлхийн нийт үйлдвэрлэл 5 хувиар өсөөд байна. Эдийн засгийн сэргэлтийн нөлөөгөөр хэрэглээ нэмэгдэж, түүхий эд, нөөцийн эрэлт өссөний зэрэгцээ манай орны томоохон уул уурхайн компаниудын олборлолтын болон тээвэрлэлтийн хүчин чадал сайжирснаар уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрс нэмэгдэв.

Шигтгээ 2. Валютын ханшийн хөдөлгөөн

Олон улсад ч мөн ханшийн хөдөлгөөн ихтэй байлаа. Зарим улсад ажилгүйдлийн түвшин өндөр байгаагаас шалтгаалан дотоодын үйлдвэрлэлээ дэмжих, экспортоо нэмэгдүүлэхийг гол зорилго болгон өөрийн орны валютыг зориуд сулруулах, хамгаалах бодлого хэрэгжүүлэх стратеги баримталж байгааг шинжээчид онцолж байв.


2010 онд экспортын өсөлтийн нөлөөгөөр гадаад валютын дотогшлох урсгал ихээр нэмэгдэж, манай улсын гадаад валютын цэвэр албан нөөц хоёр тэрбум ам.долларыг давсан байна.

Дүрслэл 3. Валютын ханшийн хөдөлгөөний тойм зураг, байршлаар



Эх үүсвэр. Bloomberg Businessweek

Дүрслэл 4. Ам.долларын эсрэг хамгийн их чангарсан валютууд, 2010 он



Шигтгээ 3. Блүүмберг бизнесийн сэтгүүл


Блүүмбергийн бизнес долоо хоног сэтгүүлийн 2010 оны сүүлийн дугаарт 2010 онд ам.долларын эсрэг хамгийн их чангарсан болон суларсан валютын жагсаалтыг гаргажээ. Уг жагсаалтаас харахад 2010 онд ам.долларын эсрэг хамгийн ихээр чангарсан валютаар Монгол төгрөгийг нэрлэсэн байна.

Манай орны хувьд 2010 оны 1 дүгээр сард 1 ам.доллар 1455.7 төгрөгтэй тэнцэж байсан бол гадаад валютын дотогшлох урсгал нэмэгдэж, нийлүүлэлт их байгаагаас шалтгаалан төгрөгийн ханш чангарч, 2010 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1 ам.доллар 1257.18 төгрөгтэй тэнцэж 200 орчим төгрөгөөр буурав.

ГАДААД ХУДАЛДАА

Эдийн засагт гарсан гадаад болон дотоод эерэг өөрчлөлтийн нөлөөгөөр манай улсын гадаад худалдаа эрчимтэй нэмэгдэж, 2010 онд нийт бараа эргэлт өмнөх оны мөн үеэс 53 хувиар өсч, анх удаагаа 6.2 тэрбум ам.долларт хүрэв. Монгол Улс 2010 онд дэлхийн 132 оронтой худалдаа хийсэн бөгөөд эдгээр орнуудаас ОХУ, Япон, БНСУ, ХБНГУ-уудтай хийсэн худалдаанд хамгийн их алдагдлыг хүлээгээд байна. Эдгээр орнуудтай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаагаа цаашид сайжруулж, худалдааныхаа тэнцвэртэй байдлыг хангахад анхаарах шаардлагатай байгаа юм. Харин БНХАУ, Канад, Их Британи зэрэг улсуудтай хийсэн худалдаа ашигтай гарлаа.

Дүрслэл 5. Гадаад худалдаа
(2005-2010 он, сая ам.доллараар)



Эх үүсвэр: ГЕГ, Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл

Монгол Улсын экспортын бүтцийг 2010 оноор авч үзвэл, 98 хувь нь технологийн агууламжгүй болон нам технологитой бүтээгдэхүүн эзэлж байна. Технологийн агууламжгүй, боловсруулалт багатай уул уурхайн бүтээгдэхүүний экспорт жил бүр нэмэгдэж байгаа нь манай улсын экспортын орлого болоод нийт эдийн засгийг эмзэг болгож байна.

Монгол Улсын Засгийн газар гадаад худалдааны бараа эргэлт, ялангуяа нүүрсний экспортыг нэмэгдүүлэх, хилээр нэвтэрч байгаа аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Гашуун сухайт”, “Шивээ хүрэн”-гийн боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх тухай 2010 онд Засгийн газрын 6 дугаар тогтоолыг батлан гаргасан билээ. Үүний үр дүнд 2010 онд 16.6 сая тонн нүүрс экспортлож, өнгөрсөн оны мөн үеэс 2.3 дахин нэмэгдэж, мөнгөн дүнгээр зэсийн баяжмалын экспортын орлогоос давсан байна.

Хүн амын орлого, худалдан авах чадвар дээшилж байгаатай уялдан авто машин, тээврийн хэрэгслийн импортын хэмжээ 2009 онтой харьцуулахад бараг 2.3 дахин өссөн байна.

Уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт ихээр орж, олборлолт, тээвэрлэлтийн хүчин чадал нэмэгдэж байгаа нь уул уурхайн салбарын бүтээгдэхүүний экспорт, импортыг огцом нэмэгдүүлж байна. Тухайлбал, төмрийн хүдрийн экспортын хэмжээ 2010 онд өнгөрсөн оныхоос 2.2 дахин өсч, газрын тосны бүтээгдэхүүний импорт 1.3 дахин нэмэгдлээ.

Ийнхүү 2009 онд манай орны эдийн засгийн дотоод, гадаад орчин эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөөлж байсан бол 2010 онд бараг бүх салбарт нааштай өөрчлөлт гарч байна. Монгол Улс эдийн засгийн хөгжлийн эрчимтэй өсөлтийн шинэ гараан дээр ирээд байна. Энэ нь Монголын хөгжлийн түвшинд дорвитой ахиц гаргах шинэ боломжийг бүрдүүлж байгаа юм.





ЗОРИЛГО НЭГ

ЯДУУРАЛ, ӨЛСГӨЛӨНГ БУУРУУЛАХ

ЗОРИЛГО 1 ЯДУУРАЛ, ӨЛСГӨЛӨНГ БУУРУУЛАХ

ЗОРИЛТ 1. АМЬЖИРГААНЫ ДООД ТҮВШНЭЭС ДООГУУР ОРЛОГОТОЙ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ ХЭМЖЭЭГ 1990 ОНТОЙ ХАРЬЦУУЛАХАД 2015 ОН ГЭХЭД ХОЁР ДАХИН БУУРУУЛАХ

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ:

Мянганы хөгжлийн зорилтод ядуурлын түвшинг 2015 он гэхэд 18.0 хувь, ядуурлын гүнзгийрэлтийг 6.0 хувьд хүргэх зорилт дэвшүүлсэн билээ. Өрхийн нийгэм, эдийн засгийн 2010 оны судалгааны дүнгээр ядуурлын түвшин нь нийт хүн амын 39.2 хувь болсон нь 2009 оноос 0.5 нэгжээр, 2008 оныхоос 4.0 нэгжээр тус тус нэмэгдсэн байна. Энэ нь 1090.1 мянга орчим хүн ядууралд өртөж, 100 хүн тутмын 39 нь зайлшгүй нэн хэрэгцээний зүйлсээ худалдан авах чадваргүй байгаа гэсэн үг.

Ядуурлын хамралт Баруун бүсэд 48.7-51.1 хувь болж өссөн бол Зүүн бүсэд 43.9-40.6 хувь, Хангайн бүсэд 55.2-51.9 хувь болж буурсан. Харин төвийн бүсэд ядуурлын түвшин 2009 оны түвшиндээ байна. Зарим аймаг, сумдын төвөөр ядуурлын түвшин буурсан байхад Улаанбаатарт 29.8 болж 2009 оноос 3.1 нэгжээр, хөдөөд 54.2 болж 1.0 нэгжээр тус тус нэмэгджээ.

Ядуурал ийнхүү нэмэгдэхэд сүүлийн жилүүдэд тохиолдсон байгалийн гамшигт үзэгдэл ихээхэн нөлөөлсөн байна. Ган зудын улмаас малгүй болсон иргэд хөдөө, орон нутгаас хот руу олноор шилжин ирж, эзэмшсэн боловсрол, мэргэжил нь хөдөлмөрийн зах зээлийн шаардлагыг тэр бүр хангахгүйгээс ажил олж чадахгүй ядуучуудын эгнээнд шилжих тохиолдол гарсаар байна. Тэд нийгмийн үйлчилгээнээс хүртэж чадахгүй үлдэх, цалин хөлс багатай, хүнд хөдөлмөр албан бусаар эрхэлж амьдралаа дээшлүүлж байна.

Мөн дэлхий нийтийг хамарсан 2008-2009 оны санхүү, эдийн засгийн хямралаас шалтгаалан олон салбарт сул зогсолт гарч иргэд ажилгүй болох, мөн 2008 онд инфляци ихээхэн нэмэгдсэн зэрэг нь Монгол Улсад ядуурлын түвшин өсөх нэг үндэс болов.

Шигтгээ 4. Монгол Улсын ядуурлын түвшин

Монгол Улсын Үндэсний статистикийн хороо ядуурлын түвшинг дараахь байдлаар тооцож байна. Нийт хүн амын дунд ядуурлын шугамаас доогуур орлоготой хүн амын эзлэх хувийг ядуурлын түвшин гэж үзэх бөгөөд ядуу хүнийг ядуу бус хүнээс ялгасан хамгийн бага хэрэглээг хангах орлогын дүнг ядуурлын шугам гэж тодорхойлдог. Өрхийн орлого (хэрэглээ) түүний хуваарилалтыг өрхийн түүвэр судалгааг үндэслэн тооцдог. Бүтцийн хувьд ялгаатай орлого, хэрэглээг тооцсоны үндсэн дээр тэдгээрийг ядуурлын шугамтай харьцуулж, ядуу өрхийн тоог тодорхойлно. түүвэр судалгааны үр дүнг тархаах онолын дагуу ядуурлын шугамаас доогуур орлоготой / хэрэглээтэй/ өрх, хүн ам болон нийт өрх, хүн амын тоог тодорхойлно.

Ядуурлын шугам нь тухайн улс орны онцлог, хөгжлийн түвшингээс хамааран ядуурлыг нарийвчлалтайгаар тооцох боломжийг олгодог ч олон улсын түвшинд харьцуулалт хийх боломжгүй байдаг бөгөөд ядуурлын шугам нь тухайн улс орны хүн амын худалдан авах чадвар, орлогын дундаж түвшин нэмэгдэхийн хирээр өснө. Ядуурлын шугамыг нэг өрхөд ногдох орлогын (хэрэглээний) хэмжээгээр тогтооно.

Дэлхийн банкны хувьд Монгол Улсын 2007/2008 оны ядуурлын түвшинг 2002/2003 оны Өрхийн орлого зарлагын судалгааны ядуурлын шугамыг суурь болгон хэрэглээний үнийн индексээр засварлаж тооцсон.

Дэлхийн банкны тооцоогоор 2010 онд ядуурлын түвшин 14.8 гарсан байна.

Хүснэгт 1. Ядуурлын түвшин, гүнзгийрэлт, хэрэглээ, нэг хүнд ногдох ДНБ

Үзүүлэлт	2007	2008	2009	2010	2015*
Ядуурлын түвшин, хувь	29.3	35.2	38.7	39.2	18.0
Ядуурлын гүнзгийрэлт, хувь	8.8	10.1	10.6	11.3	6.0
Үндэсний нийт хэрэглээнд хамгийн бага хэрэглээтэй хүн амын хэрэглээний эзлэх хувийн жин	6.4	7.2	8.5	7.8	11.0
Нэг хүнд ногдох ДНБ (оны үнээр, мян.төг)		2465.1	2232.3	3059.4	6800.0

Эх үүсвэр: ҮСХ, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
*-Зорилтод түвшин

Ядуучуудын хэрэглээний дундаж түвшин ядуурлын шугамаас дунджаар хэдэн хувь доогуур байгааг илэрхийлдэг ядуурлын гүнзгийрэлтийн индекс 2010 онд өмнөх оныхоос 0.7 нэгжээр нэмэгдэж 11.3 хувь болсон байна. Баруун болон Хангайн бүсэд ядуурлын гүнзгийрэлт хамгийн өндөр түвшинд буюу 16.0 хувь байгаа бол Зүүн бүсэд 12.3 хувь, Төвийн бүс болон Улаанбаатар хотод 7.7 хувь байна. Үндэсний нийт хэрэглээнд хамгийн бага хэрэглээтэй хүн амын эзлэх хувийн жин 2009 онд 8.5 хувь болж, 2008 оны түвшингээс нэмэгдсэн боловч 2010 онд 7.8 хувь болж буурсан байна.

АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Ядуурлыг бууруулах чиглэлээр хууль эрх зүйн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын эрх зүйн шинэтгэлийн хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүллээ:

- “Нийгмийн халамжийн багц хууль болон “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хуулийн төслийг боловсруулан УИХ-д өргөн барив.
- “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахдаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хамрах хүрээг оновчтой тогтоох, нийгмийн зүгээс дэмжлэг туслалцаа шаардлагатай зорилтот бүлэгт чиглэсэн нэмэгдэл үйлчилгээг бий болгох, зохион байгуулалтыг орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн өөрчилж төвлөрлийг сааруулах, нутгийн захиргааны болон хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын үүрэг, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын

оролцоог нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зэрэг асуудлыг тусгав.

- Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөлд нийгмийн халамжийн дэмжлэг туслалцааг ядуу, орлогогүй хэсэгт түлхүү хандуулах зорилгоор ядуу өрхийн тэтгэмжийг шинээр бий болгох, уг тэтгэмж авч байгаа өрхийн хөдөлмөрийн чадвартай гишүүдийг ажилтай болох явдлыг дэмжих, түүнчлэн ядуу өрхэд чиглэсэн хүнсний, эрүүл мэндийн, боловсролын болон бусад дэмжлэг үзүүлэх зэрэг салбар дундын үйл ажиллагааг сайжруулах асуудал тусгагдсан. Уг хуулийн төсөл батлагдсанаар ядуу өрхийн хэрэглээ, амьжиргааг дээшлүүлэх, ядуурлыг бууруулахад томоохон дэмжлэг болно.


Зохион байгуулалттай арга хэмжээний хүрээнд

Монгол Улсын Засгийн газраас 2009-2010 онд хүн амын амьжиргааг дэмжих, ядуурлыг бууруулахад чиглэсэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна:

- Санхүү, эдийн засгийн хямралын эсрэг авах арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, ОУВС, Дэлхийн банк, АХБ, ЖАЙКА болон бусад донор байгууллагуудтай хамтран ажиллаж, хямралын нөлөөллөөс ядуу, эмзэг бүлгийн иргэдийг хамгаалах, нийгмийн суурь үйлчилгээний хүрсэн түвшин, эмзэг хэсэгт очих тусламж дэмжлэгийг хадгалах зорилгоор санхүүгийн дэмжлэг олж, “Хүүхдийн мөнгө”, “Хүүхэд – хөгжил” хөтөлбөрийг 2009 оныг дуустал үргэлжлүүлэв.
- Ашигт малтмалын томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн

баялагаа ашиглах, олсон орлогоосоо иргэдэд тэгш хүртээх зорилгоор УИХ-аас 2009 онд батлан гаргасан Хүний хөгжил сангийн тухай хуулийн дагуу 2010 онд хүн бүрт 120.0 мянган төгрөгийн хишиг, хувь хүртээв.


Дүрслэл 6. Нэг хүнд ногдох ДНБ ба дундаж цалингийн хэмжээ



- Хямралын үед ажилгүй болсон иргэдийн орлогыг хамгаалах, шинэ ажил олоход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж, мэргэжлийн сургалтын зардал авах нөхцөл болзлыг даатгуулагчид ашигтайгаар өөрчилж, тэтгэмж авах хугацаа ажлын 76 өдөр байсныг 126 болгож уртасган 2011 оны 1 дүгээр сарын 1-нийг хүртэл мөрдүүлэв.
- Эдийн засгийн хямралын нөхцөлд жижиг үйлдвэрчлэгчдийг дэмжих, уул уурхай, барилга, тээвэрзэрэг өсөлттэй салбарт эрэлттэй ажилчдыг бэлтгэх зорилгоор Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Үйлдвэрлэл дээрх сургалтын хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл зэрэг зорилтот хөтөлбөр, төслийг туршилтын журмаар хэрэгжүүлэв.
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулж 0-5 насны хүүхдээ эмнэлэгт сахисан эцэг, эхэд өвчтөн асарсны тэтгэмж олгох заалтыг 2011 оны 1-р сарын 1-нийг хүртэл мөрдүүлэв.

- АХБ-ны дэмжлэгтэйгээр “Нийгмийн эмзэг бүлэгт хоол, тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, уг хөтөлбөрийн хүрээнд нийгмийн эмзэг бүлгийн 25.3 мянган иргэнд 2009 оны 11 дүгээр сараас 2010 оны 8 дугаар сар хүртэлх хугацаанд сар бүр 14000 төгрөгийн хүнсний талон олгох, орон гэргүй, тэнэмэл иргэдийг халуун хоол, түр хоноглох байраар хангав.

Дүрслэл 7. Амьжиргааны доод түвшин (АДТ), ХХДХ, бүрэн, хувь тэнцүүлсэн тэтгэврийн хэмжээ (2009-2010 он, мян.төг)



Эдийн засаг, санхүүгийн хямралын үед инфляци нэмэгдсэний улмаас буурсан худалдан авах чадварыг нөхөн сэргээх зорилгоор төрийн албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын болон халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг 2010 оны 10 дугаар сарын 1-нээс 30 хувиар нэмэгдүүлэв. Ядуу айл, өрхийг тодорхойлж, орон нутгийн түвшинд амьжиргааг нь дэмжих арга хэмжээ зохион байгуулж жил бүр 12.5 мянган өрхийг хамруулж, 2010 онд 10.3 мянган өрхийн 82.3 хувийн амьжиргаа дээшилсэн байна.

Тулгамдаж буй асуудал

2009 оныг эс тооцвол сүүлийн жилүүдэд манай улсын эдийн засгийн өсөлт харьцангуй өндөр байгаа хэдий ч ядуурал буурахгүй байна. Эдийн засгийн өсөлтөд салбар бүрийн оруулж буй хувь нэмэр харилцан адилгүй, тэр дундаа ядуурлыг бууруулахад салбар бүрийн гүйцэтгэх үүрэг тодорхойгүй, түүнд чиглэсэн бодлого, үйл

ажиллагааны уялдаа холбоо, нэгдсэн зохицуулалт сул байна. Иймээс ядуурлыг бууруулахад салбаруудын өсөлт хэрхэн нөлөөлж байгааг үнэлж дүгнэх, тэдний бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах салбар дундын механизм чухал байна.

Салбаруудын үйл ажиллагаа, ялангуяа нийгмийн үйлчилгээний салбарт нийгмийн эмзэг, өртөмхий хэсэгт зориулсан үйлчилгээ дутагдалтай байна. Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ гол төлөв нийтлэг шинж чанартай явагдаж, хот хөдөөгийн ялгаатай байдал болон хүн амын тодорхой бүлгүүдийн эрэлт хэрэгцээнд нийцэхгүй байгаагаас ядуус, алслагдсан нутгийнхан болон эмзэг бүлгийнхэн үйлчилгээний үр шимийг хүртэж чадахгүй үлдэж энэ нь улам бүр ядуурах шалтгааныг бий болгож байна. Аливаа эдийн засаг, нийгмийн арга хэмжээ, нийгмийн суурь үйлчилгээнд ядуус, эмзэг хэсгийнхнийг хэрхэн хамруулах тодорхойлсон бодлого гаргах эсвэл энэхүү арга хэмжээ, үйлчилгээний үр дүн, үр нөлөөг судалсны үндсэн дээр төрийн бодлогын төлөвлөлт, хэрэгжилт, уялдаа холбоог сайжруулах тогтолцоонд шилжиж, үр дүнг дээшлүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Дэлхийн банкнаас хийсэн үнэлгээгээр ядуурал буурсан байх магадлалтай гэсэн дүгнэлтийг дэвшүүлж байхад ҮСХ-ноос гаргасан мэдээгээр ядуурлын түвшин нэмэгдсэн дүнтэй гарч байна. Тиймээс ядуурлын түвшинг тодорхойлж буй арга зүйг эргэн хянаж, нэг мөр жигдлэн сайжруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Ядуурал, ажилгүйдлийг бууруулахад нутгийн захиргааны байгууллагын үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх, үүний тулд тэдэнд төсвийн эрх мэдлийг нь шилжүүлэх явдал нэн тэргүүний чухал асуудал болж байна.

Цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ

- Нийгмийн халамжийн хууль, эрх зүйн орчинд өөрчлөлт оруулж ядуу өрх, шилжин суурьшигчид, орон гэргүй тэнэмэл амьдралтай, согтуурах, мансуурах донтой, хорихоос суллагдсан болон асрамжийн газраас гарсан зэрэг аж амьдралын онцлог бэрхшээл хүндрэлтэй бүлэг, иргэдийг

нийгмийн халамжид хамруулах талаар эрх зүйн зохицуулалтын арга хэмжээг авах.

- Хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт, нийлүүлэлтийн бодлогыг уялдуулж, бага орлоготой, мэргэжил, боловсрол багатай иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлэх.
- Ядуурлыг бууруулах чиглэлээр салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулах зохистой механизмыг бүрдүүлэх замаар зарцуулж буй хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх.
- Томоохон төсөл, бүтээн байгуулалтын ажилтай уялдуулан ЖДҮ-ийг хөгжүүлж, ажлын байр олноор бий болгох.
- Иргэдийн оюуны ядууралтай тэмцэх арга хэмжээнд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх.
- Өсөлтийг илүү хүртээмжтэй, хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмжтэй болгох, эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэнцвэрт байдлыг хангах, хот хөдөөгийн ялгаатай байдлыг багасгахад чиглэсэн төлөвлөлт хийх үндэсний институцийн чадавхийг бэхжүүлэх.
- Ядуурлыг бууруулах бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах салбар дундын механизмыг шинэчлэн сайжруулж, эрх мэдэл, үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх.
- Ядуурлын түвшинг тодорхойлох аргачлалыг судалж, ялгаа зөрөөгүй нэгдмэл аргачлалаар ядууралтай холбоотой мэдээллийг сайжруулах, мэдээллийн бааз бүрдүүлж ашиглалтыг сайжруулах.
- Алслагдсан хөдөө нутгуудад Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хувийн хөрөнгө оруулалтыг татвар, зээлийн механизмаар дэмжиж тэдгээрийг эдийн засгийн сул хөгжилтэй орон нутгуудад чиглүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлж ажлын байр бий болгон орон нутгуудын хөгжлийн ялгааг багасгах.
- Жижиг, дунд үйлдвэрийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, менежментийг сайжруулахад

эрч нь суларсан байна. Хэрэв энэ хандлагаар үргэлжилбэл 2015 он гэхэд уг зорилтыг хангах бүрэн боломжтой юм. Гэвч энэ үзүүлэлт бүс бүрт харилцан адилгүй байгаа бөгөөд уг үзүүлэлт Баруун бүсэд 33 хувь буюу хамгийн өндөр байгааг анхаарах нь зүйтэй.

Тав хүртэлх насны туранхай хүүхдийн эзлэх жин 2000-2006 онд 3.3 хувиар буурсан бол 2006-2010 онд 0.5 хувиар буурч эрч нь суларсан байна. Энэ байдлаар үргэлжилбэл 2015 оны зорилт биелэхгүйд хүрч болзошгүй тул улсын дунджаас дээгүүр үзүүлэлттэй байгаа Хангай болон Баруун бүсэд энэ чиглэлийн арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Дээрх судалгааны дүнгээр улсын хэмжээнд сургуулийн насны (7-11нас) хүүхдийн өсөлтийн хоцролт 11.7 хувь, туранхай хүүхдийн эзлэх жин 3.5 хувь байгаа бөгөөд эдгээр үзүүлэлт Баруун болон Зүүн бүсэд улсын дунджаас дээгүүр байна. Хоол тэжээлийн дутагдал насанд хүрсэн эмэгтэйчүүдийн дунд 6.0 хувь, насанд хүрсэн эрэгтэйчүүдэд 7.7 хувь, жирэмсэн эмэгтэйчүүдэд 2.1 хувь байна. Сүүлийн жилүүдэд халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн нэг болох хоол тэжээлийн буруу хэрэглээ, хөдөлгөөний хомсдолоос шалтгаалсан таргалалт, жингийн илүүдэл нийт хүн амын дунд нэмэгдэх хандлагатай байгаа нь анхаарал татсан асуудлын нэг болж байна. 2010 оны судалгаагаар 15-64 насны хүн амын 31.6 хувь нь илүүдэл жинтэй буюу тарган байна.

2010 оны статистик мэдээгээр нэг хүний хоногт хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний илчлэг хотод 2603.6 ккал, хөдөөд 3040.7 ккал, улсын дунджаар 2798.3 ккал байгаа нь жишсэн дундаж хүний хоногт хэрэглэх илчлэг (2500 ккал)-ээс өндөр байна.² Мөн нэг хүнд сард ногдох хүнсний хэрэглээ дунджаар 58 308 төгрөг бол ядуу хүмүүсийн хувьд 31 374 төгрөг байгаа нь хүнсээр авбал зохих илчлэгээ бүрэн авч чадахгүй байгааг харуулж байна.

Авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 246 дугаар тогтоолоор “Халдварт бус өвчнөөс

² *Áýá± ð¿i àííí àì ùæèðàààíí ò¿áøèò ýé öýëáóóèíàì 2010 ïíí ñò äòèíðèé ÿý áýýáýð ð¿i àííí ýà òðèíí ò¿áøèì ð ìðì à 32.2 òááí, ò°á°á 47.8 òááí, ó èííì à òíááæ 39.2 òááí ò àé ààð±ýý.*

сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөр, 2009 оны 239 дүгээр тогтоолоор “Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги”, 2010 оны 32 дугаар тогтоолоор “Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөр, “Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Эрүүл мэнд, ХХААХҮ-ийн сайдын хамтарсан 283/207 тушаалаар тус тус батлан, мөн хүнсний зохистой хэрэглээний тусламжтайгаар хүний бие махбодийн хэвийн өсөлт хөгжлийг дэмжих, халдварт бус өвчний эрсдлийг бууруулах, хоол хүнснээс үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Эрүүл хоол”-ны удирдамжийг хэрэгжүүлж байна.

Эх, хүүхдийн хоол тэжээлийг сайжруулах зорилгоор “Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн найрлага, хэрэглэх заавар”, “Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн хэрэглэх журам”-ыг боловсруулж 6-24 сартай хүүхэд, жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүдийг ОНББ-ээр үндэсний хэмжээнд хангах үйл ажиллагааг НҮБ-ын Хүүхдийн сан, “Дэлхийн зөн-Монгол” олон улсын байгууллага, АХБ-ны “Эрүүл мэндийн хөгжил-3” төслүүдийн санхүүжилтийн тусламжтайгаар зохион байгуулж байна. ОНББ-ийг ХӨЦМ-ийн сургалттай холбож үндэсний хэмжээнд түгээж, цогцоор зохион байгуулж байна.

НҮБ-ын ХХААБ болон ЕХ-ны санхүүжилтээр “Эмзэг бүлгийн хүн амын хүнсний баталгаат байдлыг сайжруулах” (2010-2013) төслийг 8 аймгийн 15 сум, Улаанбаатар хотын 2 дүүрэгт, НҮБХС-аас өмнөх 3 удаагийн үндэсний судалгааны дүнд үндэслэн 5 хүртэлх насны хүүхдийн дунд хоол тэжээлийн дутал өндөр тархалттай байсан баруун бүсийн Баян-Өлгий, Увс, Ховд, зүүн бүсийн Дорнод аймгуудад хоол тэжээлийн байдлыг сайжруулахад чиглэсэн төслийг, “Бага насны хүүхдийн хоол тэжээлийн архаг дутагдлыг бууруулах JEP9131-MON” төслийг АХБ-ны дэмжлэгтэйгээр 2013 оны 04 сар хүртэл Архангай, Говь-Алтай, Дундговь, Сүхбаатар, Төв аймгууд болон Улаабаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт тус тус хэрэгжүүлж эхлээд байна.

Хүн амыг бичил тэжээлийн дутлаас сэргийлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан “Хүнсний бүтээгдэхүүнийг баяжуулах удирдамж”-ийг үндэслэн “Хүнс баяжуулах

тухай” хуулийн болон “Баяжуулсан хүнс” дэд хөтөлбөрийн төслийг тус тус боловсруулаад байна.

Монгол Улсын төсвөөс цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг бүрэн хариуцдаг болсон.

Тулгамдаж буй асуудал

“Хүн амын хоол тэжээлийн байдал” судалгааг 1999-2010 онд Олон Улсын байгууллагын дэмжлэгтэйгээр 3 удаа, “Халдварт бус өвчин, осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын үндэсний 2 дугаар судалгаа”-г 2009 онд тус тус явуулжээ. 2010 онд явуулсан үндэсний 4 дүгээр судалгааны дүнгээр зорилтыг хэмжих бүх шалгуур үзүүлэлтийн улсын дундаж буурсан хэдий ч бүс бүрд харилцан адилгүй байгаа тул буурсан хэмжээгээрээ улсын дунджаас дээгүүр үзүүлэлттэй байгаа бүсүүдэд түлхүү анхаарах шаардлагатай байна. Хүн амын хүнсний хэрэглээнд мах, гурилан бүтээгдэхүүн зонхилж жимс, хүнсний ногооны хэрэглээ өдөрт дунджаар 250 гр буюу ДЭМБ-ын зөвлөмжөөс бараг 2 дахин бага байгаа нь бичил бодисын дуталд өртөх магадлалыг нэмэгдүүлж байна. Иймд хүн амын хүнсний хэрэглээний нэр төрлийг нэмэгдүүлэх, хангамж хүртээмжийг сайжруулах шаардлагатай байна.

Хүүхдэд зориулсан хоол тэжээлийн үйлдвэрлэл байхгүйгээс тухайн насанд нь шаардлагатай шим тэжээлийг бүрэн олгох боломжгүй байна.

Хүн амын хоол тэжээлийн байдалд үнэлэлт өгөхдөө ашиглаж буй статистик мэдээ нь хоорондоо ихээхэн зөрүүтэй байдаг учраас өөр өөр дүгнэлт гарахуйц байгаа нь нэгдсэн аргачлал шаардлагатай байгааг илтгэж байна.

Амьдралын хэв маяг өөрчлөгдөхийн хирээр хоол, тэжээлийн дутагдлаас гадна буруу хооллолт, хөдөлгөөний дутагдалтай холбоотой нийгмийн эрүүл мэндийн асуудлууд шинээр бий болж байна. 4-р судалгаагаар 15-64 насны хүн амын 31.6 хувь нь илүүдэл жинтэй болон тарган байгааг тогтоосон бөгөөд хоол тэжээлийн дуталтай тэмцэхийн зэрэгцээ илүүдэл жин, таргалалтыг бууруулах талаар тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байна.

Хоол тэжээлийн байдлыг сайжруулах талаар тодорхой хөтөлбөр, төслүүд хэрэгжиж байгаа хэдий ч санхүүжилт хангалтгүй, салбар хоорондын хамтын ажиллагаа сул зэргээс шалтгаалан үр дүн бага байна.

Цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ

- Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан “Хүн амын хоол тэжээлийн физиологийн норм”-ын дагуу хоол хүнсээр авбал зохих илчлэгээ бүрэн авч байгаа эсэхийг нийт хүн амын төлөөллийг хамруулсан үндэсний хэмжээний суурь судалгаагаар тогтоож хоол хүнсний дутагдлыг нөхөх арга хэмжээ авах хэрэгтэй.
- Хүүхдийн хоол болон илчлэг ихтэй тэжээлийн төрөлжсөн үйлдвэрлэлийг бий болгож, бодлогоор дэмжиж ажиллах шаардлагатай байна.
- Бичил тэжээлийн дутлаас сэргийлэх хамгийн үр дүнтэй арга нь өдөр тутмын хэрэглээ болсон гол нэрийн хүнсийг шаардлагатай эрдэс бодисоор баяжуулах явдал юм. Иймд үйлдвэрлэгч, хэрэглэгч, төрийн байгууллага энэ асуудалд анхаарлаа хандуулж шийдвэрлэх нь зүйтэй.
- Зохистой хооллолт, дасгал хөдөлгөөнийг дэмжих, хүн амд энэ талын мэдлэгийг олгоход бүх шатны боловсрол, эрүүл мэндийн байгууллага, иргэний нийгэм, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх хэрэгтэй.
- Бүс нутгийн хэмжээнд хоол тэжээлийн дутагдлыг арилгах талаар орон нутгийн удирдлага санаачилгатай ажиллах шаардлагатай байна. Ялангуяа, улсын дунджаас ихээхэн зөрүүтэй үзүүлэлттэй байгаа бүс, аймгууд өөрсдийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх нь зүйтэй.

ЗОРИЛТ 3. ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИНГ ДЭЭШЛҮҮЛЖ, ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛД ШИЛЖИЖ БҮЙ ЗАЛУУЧУУДЫН АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИНГ БУУРУУЛАХ


ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсын нийт хүн ам 2010 онд 2 сая 780.8 мянга байгаагийн 549.8 мянга буюу 19.8 хувийг 15-24 насны залуус эзэлж байна. Эдгээр залуусын 52.3 хувь нь ЕБС болон их дээд сургууль, коллежид суралцаж, 27 хувь нь ажил эрхэлж, 1.3 хувь буюу 7.1 мянга нь хөдөлмөрийн чадваргүй байгаа бөгөөд үлдсэн 106.6 мянга буюу 19.3 хувь нь тодорхой бус шалтгаанаар ажил хөдөлмөр эрхлээгүй байна.

Монгол Улсын хөдөлмөрийн насны нийт хүн ам 2010 онд 1863.4 мянга болж, өмнөх онтойгоо харьцуулахад 8.5 хувь буюу 159 мянгаар нэмэгдсэн байна. Ажиллах хүчний оролцооны түвшин 2008 онтой харьцуулахад 1.9 нэгжээр, 2009 онтой харьцуулахад 5.2 нэгжээр буурч, 61.6³ хувьд хүрсэн байна. Сүүлийн 10 жилд тогтвортой өсөх хандлагатай байсан энэ үзүүлэлт огцом буурсан нь цаашид МХЗ-д тусгасан түвшинд хүрэхгүй байж болзошгүй юм. Үүнд 2008 оны дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал, 2009 оны өвөл манай улсад тохиолдсон зудын гамшиг голлон нөлөөлсөн.

Засгийн газраас авсан хямралын эсрэг арга хэмжээний хүрээнд ажлын байрыг хадгалах, иргэдийн орлого буурахаас хамгаалах, тогтвортой нэмэгдүүлэх, эмзэг бүлгийн иргэдийн амьжиргааг дэмжих чиглэлээр хууль эрх зүйн болон зохион байгуулалт, санхүүгийн тодорхой арга хэмжээ

Дүрслэл 8. 15-24 насны залуусын нийгмийн байдал, 2010 он



Эх үүсвэр: ХХҮХ

авч хэрэгжүүлсний үр дүнд аймаг, нийслэлийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд хандаж бүртгүүлсэн ажилгүйчүүдийн тоо 2009 онд өмнөх оноос 21.7 хувиар өсч 38.1 мянгад хүрсэн боловч 2010 онд энэ түвшиндээ тогтвортой байна. Түүнчлэн 2009-2010 онд улсын хэмжээнд жилд дунджаар 53.3 мянган ажлын байр шинээр бий болсон нь ажилгүйдлийн түвшин нэмэгдэхгүй байхад нөлөөлсөн байна. Улсын хэмжээний ажилгүйдлийн түвшин 2009 онд 11.6 хувь, 2010 онд 9.9 хувь байна⁴.

Хөдөлмөрийн насны нийт хүн амын 31.4 хувийг 15-24 насны залуучууд эзэлж байна. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн насны гурван хүн тутмын нэг нь энэ насны бүлэгт хамаарагдаж байгаа юм⁵.

Хүснэгт 3. Ажиллах хүчний оролцоо, 15-24 насны залуучуудын ажилгүйдэл, 2007-2010 он

	Ажиллах хүчний оролцооны түвшин /хувь/					15-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин /хувь/				
	2007	2008	2009	2010	2015*	2007	2008	2009	2010	2015*
Улсын дундаж	64.2	63.5	66.8	61.6	70.0	3.2	3.0	22.0	19.5	2.5

Эх үүсвэр: Ажиллах хүчний судалгаа 2010 он, ҮСХ
*- зорилтод түвшин


3 Ажээгээ адо дүгчээгээ нэвдээдээ 2010 ий , ҮСӨ

4 Ажээгээ адо дүгчээгээ нэвдээдээ 2010 ий , ҮСӨ

5 Мийдэи э Угнэи ндо адоёндөөдөөи үгдөөи э, 2010, ҮСӨ

Гэтэл 15-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин 2009 онд 22.0 хувь, 2010 онд 19.5 хувь буюу улсын дунджаас 2 дахин өндөр байна. Энэ насныхны ажилгүйдлийн түвшин өндөр байгаа нь хүүхэд, залуучуудыг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх, тэдэнд мэргэжлийн чиг баримжаа олгох ажил дутагдалтай, МСҮТ, их дээд сургуульд элсэгчдийг ажил олгогчийн захиалга, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан төлөвлөдөггүйгээс сул чөлөөтэй болон шинээр гарсан ажлын байранд эзэмшсэн мэргэжил нь таардаггүй, ажлын туршлага, ур чадвараар гологддог зэрэгтэй холбоотой байна. Тухайлбал, 2010 онд ажилд зуучлагдсан иргэдийн 21 хувь нь 15-24 насны залуучууд байгаа бол ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалгын дөнгөж 0.5 хувьд 15-24 насны залуусыг ажилд авсан байна. Хөдөлмөрийн зах зээл дээрх ийм хандлага нь энэ насны залуусын ажил хайх идэвхид сөргөөр нөлөөлдөг байж болзошгүй юм. 2010 онд тодорхой шалтгаангүйгээр хөдөлмөр эрхлээгүй энэ насны бүлгийн 117.1 мянган хүнээс 9.2 мянга буюу 8 орчим хувь нь ажил хайж Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд бүртгүүлсэн нь нийт бүртгэлтэй ажилгүйдлийн 24 хувийг эзэлж байна.

Дүрслэл 9. 15-24 насны ажил эрхэлдэг хүн ам (мян.хүн ам)



Эх үүсвэр: ХХҮХ

Хэрэгжүүлсэн арга хэмжээ

Засгийн газраас дэлхий нийтийг хамарсан эдийн засаг, санхүүгийн хямралын нөхцөлд ажлын байрыг хадгалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг хамгаалах, ажилгүй болсон иргэдийг түр ажлын байраар хангахад зориулж улсын төсвөөс зарцуулах хөрөнгийг нэмэгдүүлэх, хууль эрх зүйн хүрээнд зарим өөрчлөлт оруулж, ажилгүйдлийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч

мэргэжлийн сургалтад хамрагдах, урьд нь ажилгүйдлийн тэтгэмж авсан даатгуулагч дахин ажилгүй болж, тэтгэмж авах хугацааг уртасгах зэрэг түр арга хэмжээ авч хэрэгжүүлсэн нь зохих хувь нэмэр оруулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд давхардсан тоогоор 2009 онд 284.5 мянган иргэнийг хамруулж 21.5 тэрбум төгрөг, 2010 онд 233.6 мянган иргэнийг хамруулж 19.6 тэрбум төгрөг зарцуулсан нь 2008 оныхтой харьцуулахад хамрагдсан хүний тоо 9.7-25.8 хувиар, санхүүжилт 21.0-28.0 хувиар тус тус өссөн байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дээрх нийтлэг үйлчилгээ, арга хэмжээнээс гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэд, малчид, оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгайлсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, малын сэг устгах болон үерт автсан гудамж, талбайг цэвэрлэхэд нийтийг хамарсан ажил зохион байгуулж, гамшигт өртсөн иргэдийг орлогожуулах арга хэмжээ авлаа.

Эдийн засгийн өсөлттэй салбаруудын эрэлтэд нийцсэн ур чадварыг ажилгүй иргэдэд эзэмшүүлэх, ажлын байраар хангах зорилгоор “Үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулах туршилтын хөтөлбөр”-ийг шинээр боловсруулан хэрэгжүүлсэн байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд уул уурхай, зам, барилгын чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг 180 аж ахуйн нэгж, байгууллага 19 мэргэжлээр нийт 6821 залуусыг мэргэжил эзэмшүүлсэн бөгөөд эдгээр залуусын 80 хувь нь ажлын байртай болсон байна. Түүнчлэн 2010-2011 оны хичээлийн жилээс эхлэн “Оюу толгой” ХХК-ий хөрөнгө оруулалтаар 3300 ажилгүй залуусыг барилгын түгээмэл мэргэжлүүд, уул уурхайн ашиглалт, хүнд машин механизмын засварчин, оператор зэрэг хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгтэй 11 мэргэжлээр МСҮТ-д сургахаар төлөвлөснөөс 975 хүнийг сургаж эхэлжээ.

Тулгамдаж буй асуудал

Эдийн засгийн өсөлт тогтвортой бус, хөдөлмөрийн зах зээлийн багтаамж бага, хөдөлмөрийн насны хүн амын өсөлт өндөр байгаа энэ үед ажлын

байрны баталгааг хангах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах бодлогыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хүрээнээс өргөжүүлж, салбар дундын бодлогын зохицуулалтаар хангах шаардлага гарч байна.

2009-2025 онуудад нийт хүн амын 61 орчим хувийг хөдөлмөрийн насныхан эзэлнэ. Эдийн засгийн өсөлт тогтвортой бус үед “хүн ам зүйн цонх үе” тохиож байгаа нь манай улсын хувьд ажлын байрыг олноор нэмэгдүүлэх, ажиллах хүчний шингээлтэй, хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмж сайтай эдийн засгийн өсөлт бий болгохыг зүй ёсоор шаардаж байна.

Ажлын байрны хомсдлоос шалтгаалан хүн амын насны зарим бүлгийн хөдөлмөр эрхлэлтэд нэмэлт саад бэрхшээл тулгарч байна. Ялангуяа сургуулиас ажилд шилжиж байгаа ажлын туршлагагүй залуус, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахимаг насныхан, эдгээр бүлгийнхний эрэлт, хэрэгцээ, давуу тал дээр суурилсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Сүүлийн 20 жилийн хугацаанд эдийн засгийн бүтэц нь хүн амын ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, байнга өсч буй хөдөлмөрийн нөөцийг зохистой шингээх чадвар муутай явж иржээ. Үүний улмаас хөдөлмөрийн зах зээл дээр ажиллах хүчний илүүдэл бий болж, хөдөө аж ахуй, албан бус салбарт түлхүү шингэж, мөн гадаад зах зээл рүү чиглэж байна. Иймд залуучуудын ажлын байр олноор бий болгодог боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх, ажилгүйдэл, ядуурал, цөлжилт ихтэй, алслагдсан бүс нутгийг эхний ээлжинд сонгож, уг бүс нутгийн нөөц бололцоонд түшиглэсэн үйлдвэр барьж байгуулах замаар хөдөөд ажлын байр бий болгох, хөдөлмөр зохион байгуулалтын хувьд хоршооллыг эрчимжүүлэх, гадаад улс оронд хөдөлмөрийн гэрээгээр ажиллах залуу гэр бүлийн тогтвортой байдлыг хангах нөхцөл боломжийг бүрдүүлэх явдал юм.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн ажилчдад бүтээмжтэй ажиллах, мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшүүлэх, дахин мэргэшүүлэх, давтан сургах тогтолцоог хувийн хэвшил, ажил олгогчдын шууд оролцоо, дэмжлэг туслалцаатайгаар бий болгох, ялангуяа сургалтын дадлагын бааз аж

ахуйн нэгжүүдийг бий болгох, том үйлдвэр, аж ахуйн газруудын дэргэд МСҮТ байгуулах, тэдгээр аж ахуйн нэгжид татварын хөнгөлөлт үзүүлэх, дээд, дунд боловсролтой мэргэжилтэн бэлтгэж байгаа өнөөгийн тогтолцоог зах зээлийн эрэлт, шаардлагад нийцүүлэн өөрчлөх асуудал тулгарч байна.

Эзэмшсэн мэргэжил нь шаардлага хангахгүйгээс сул чөлөөтэй болон шинээр гарсан ажлын байранд гологдож байгаа олон хүн байгаа бөгөөд дээд, дунд мэргэжилтэй хүмүүсийн дунд ажилгүйдэл өндөр байна. Энэ нь дотооддоо ажил олох найдваргүй хүмүүс гадаад руу явах, дотоодоос хангагдах боломжгүй мэргэжлийн хүмүүсийг гадаадаас авах хэрэгцээг бий болгож, хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэргүй байдал үүсгэн, гадаад шилжих хөдөлгөөнийг идэвхжүүлж байна. Иймээс мэргэжилтэй ажилчин бэлтгэх, давтан сургах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтын нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх, агуулгын хувьд шинэчлэх нь хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтийг дэмжихэд чухал ач холбогдолтой юм.

Гадаад хөдөлмөр эрхлэлтийн үр шимийг иргэдийнхээ болон улс эх орныхоо хувьд эерэгээр ашиглах талаар төр, нийгмийн түншүүд хүч хавсран ажиллах хэрэгцээ, шаардлага гарч байна. Гадаадад байгаа иргэдийнхээ хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, гадаадын улс оронд ажиллаад эх орондоо буцаж ирж байгаа иргэдийнхээ олж авсан мэдлэг, мэргэжил, ур чадварыг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, гэрчилгээжүүлэх замаар тэднийг дотоодын хөдөлмөрийн зах зээл дээр үр бүтээлтэй ажиллахад нь чиглэсэн арга хэмжээг авч эхлээд байгаа бөгөөд цаашид ч энэ чиглэлээр холбогдох яамд, агентлагууд нийгмийн түншүүд идэвхитэй хамтран ажиллах шаардлагатай байна.

Хүрэн эдийн засгийн үр ашгаар ногоон эдийн засаг бий болгох судалгаа тооцоо одоогоор хангалтгүй байна. Энэ нь тогтвортой эдийн засаг, тогтвортой ажлын байрны тухай чухал асуудал бөгөөд энэ чиглэлээр томоохон суурь судалгааг хийж бодлого боловсруулах хойшлуулашгүй хэрэгцээ бий болжээ.

Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд тулгардаг нийтлэг бэрхшээл нь тогтвортой бус орлого,

хөдөлмөрийн муу нөхцөл, эрсдэлд өртөмтгий байдал болон нийгмийн даатгалд хамрагдаж чадахгүй байгаа явдал юм. Албан салбарыг өргөжүүлэх хэрээр малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо буурах магадлалтай боловч ойрын хугацаанд өргөн хүрээтэй хэвээр байх төлөвтэй тул тэдний ажлын байраа тогтвортой хадгалах, орлогоо нэмэгдүүлэх, хоршоо, нөхөрлөл байгуулах санаачилгыг дэмжиж албан салбарт шилжүүлэх нь бодлогын тэргүүлэх чиглэлүүдийн нэг болж байна.

Хөдөлмөрийн статистикийн мэдээлэл цуглуулах, цуглуулсан мэдээлэлд шинжлэх ухааны үндэслэлтэй дүн шинжилгээ хийх чадавхи сул байна. Үүний тулд Хөдөлмөрийн зах зээлийн судалгааны төв байгуулах, эсвэл Үндэсний статистикийн хорооны бүтцэд хөдөлмөрийн статистикийн бие даасан нэгж байгуулах боломжийг судалж хойш тавилгүй хийх хэрэгтэй байна.

Цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ

- Хүүхэд, залуучуудыг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх асуудлыг ЕБС-ийн сургалтын хөтөлбөртэй уялдуулан мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээгээр дамжуулан хэрэгжүүлэх, МСҮТ, их дээд сургуульд элсэгчдийг ажил олгогчийн захиалга, санхүүжилтээр суралцуулах тогтолцоонд шилжүүлэх асуудлыг судлан шат дараатайгаар шийдвэрлэх;
- Сургуулиас хөдөлмөрт шилжиж байгаа залуус, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахимаг насныхан зэрэг хүн амын зарим бүлгийнхний хөдөлмөр эрхлэлтийг тэдний чадамж, боломж, ажил олгогчийн эрэлтэд нийцсэн хэлбэрээр дэмжих, хүүхдийн хөдөлмөр, ялангуяа түүний тэвчишгүй хэлбэрийг устгах зорилтот хөтөлбөрийг бүс, орон нутаг, төр, олон нийтийн байгууллага, нийгмийн түншүүдийн идэвхитэй оролцоотойгоор хэрэгжүүлэх;
- Хөдөлмөрийн зах зээлийг тэлж, ажиллах хүчний шингээлтийг нэмэгдүүлэхийн тулд аж ахуйн нэгж, ялангуяа ХАА-н салбарын малын гаралтай түүхий эдэд боловсруулалт хийж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг үйлдвэрийг хөрөнгө оруулалт, зээлийн хүү, татвар зэрэг эдийн засгийн хөшүүрэг, бусад арга

хэрэгслээр дэмжих цогц бодлогыг үндэсний хөгжлийн төлөвлөлт, санхүү төсвийн болон хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллагууд хамтран боловсруулж хэрэгжүүлэх;

- Ажилгүйдэл, ядуурал, цөлжилт ихтэй, алслагдсан бүс нутгийг эхний ээлжинд сонгож, уг бүс нутгийн нөөц бололцоонд түшиглэсэн үйлдвэр барьж байгуулах замаар хөдөөд ажлын байр бий болгох, энэ зорилгод хувийн болон гадаадын хөрөнгө оруулалтыг татах тааламжтай орчин бүрдүүлэх, шинээр байгуулагдсан аж ахуйн нэгжийг бий болгосон ажлын байрны тооноос нь хамааруулан тодорхой хугацаанд зээлийн хүүгийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, зээлийн хугацааг сунгах, зээл олгохдоо оюуны өмчийг барьцаалах, зээлийн баталгааны сан байгуулах зэргээр дэмжих асуудлыг судлан боловсруулж шийдвэрлүүлэх;
- Ажлын байр цомхотгох зайлшгүй шаардлага гарч буй аж ахуйн нэгжүүдийн захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн саналыг үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас тодорхой дэмжлэг үзүүлэх замаар ажилгүй болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
- Ажлын байр өөртөө бий болгож байгаа малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ажлын байраа тогтвортой хадгалах, орлогоо нэмэгдүүлэх, хоршоо, нөхөрлөлийн зохион байгуулалтад орох санаачлагыг дэмжих, аж ахуй эрхлэх ур чадвар эзэмшүүлэх, жижиг зээл, санхүүжилт олгох, мэдээлэл зөвлөгөөгөөр хангах, хоршооны сургагч багш, менежерүүдийг бэлтгэх, давтан сургах, загвар хоршоо бий болгож туршлагыг нь дэлгэрүүлэх зэргээр төрөөс тусгайлан дэмжих ажлыг төв орон нутагт өргөн хүрээтэй зохион байгуулах;
- Албан бус хөдөлмөр эрхлэгчдийг жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн нэгэн адил бүртгэлжүүлж албан ёсны болгох, эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр үйл ажиллагааг нь өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Хөдөлмөрийн зах зээлийн хэтийн эрэлт хэрэгцээтэй уялдуулан үндэсний мэргэжилтэн бэлтгэх урт хугацааны төсөөлөл гаргах, хөдөлмөрийн зах зээлийн барометрийн судалгааг жил тутам тогтмол хийж байх.

ЗОРИЛТ 4: ХҮН АМЫН ТӨВЛӨРӨЛ, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНТЭЙ ХОЛБОГДОН ГАРЧ БУЙ СӨРӨГ ҮЗЭГДЛИЙГ БАГАСГАХ, ШИЛЖИН СУУРЬШИГЧДЫГ НИЙГМИЙН СУУРЬ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРУУЛАХ.

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсын хүн амын 60.8 хувь нь ямар нэгэн хот, суурин газарт оршин сууж байгаагаас хот, суурингийн хүн амын 60 хувь нь Улаанбаатар хотод, 10 орчим хувь нь Дархан, Эрдэнэт хотод, 30 орчим хувь нь аймгийн төвүүд болон бусад суурин газарт амьдарч байна.

Хот, суурин газруудын хүн амын өсөлт цаашид нэмэгдэх хандлагатай байгаа нь нутаг дэвсгэр ихтэй

нүүдэлчдийн соёлын өв уламжлалаа хадгалсан манай орны хувьд харьцангуй өндөр үзүүлэлт юм. Энэ нь Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжсэн 1990-ээд оноос эхлэн хөдөө орон нутгаас хот, суурин газарт шилжин суурьшигчид нэмэгдсэнтэй холбоотой. Шилжин ирэгсэд нь зам, тээвэр, мэдээлэл, холбоо, орон сууцны хангамж, нийгэм, соёлын үйлчилгээ харьцангуй сайтай, гадаад зах зээлд ойр дөт байрласан Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотод зонхилон суурьшиж байна.

Хүснэгт 4. Хүн амын шилжих хөдөлгөөн, 2006-2010 он

Улаанбаатарт шилжин ирэгсдийн хувь	Он				
	2006	2007	2008	2009	2010
Бүртгэгдсэн нийт шилжин ирсэн хүний тоо	45259	46266	56561	52634	74041
Үүнээс: Улаанбаатарт шилжин ирсэн хүний тоо	29633	29112	33407	28337	39701
Нийт шилжин ирсэн хүний дотор Улаанбаатарт шилжин ирсэн хүний эзлэх хувь	65.5	62.9	59.0	53.8	51.1

Эх үүсвэр: УБЕГ

Улаанбаатар хот руу хүн амын шилжих хөдөлгөөн өндөр түвшинд байгаа нь Монгол Улсын бүс нутгуудын хөгжлийн ялгаатай байдалтай шууд холбоотой юм. Хөдөлмөрийн насны хүн амын хурдацтай өсөлт, ажлын байр, хүн амын амьжиргааг дээшлүүлэхэд зарцуулагдах орон нутгийн төсөв санхүүгийн хангалтгүй байдал, улам гүнзгийрч буй ядуурлын түвшин, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар сул, дэд бүтцийн хөгжил муу, зах зээлээс алслагдсан байдал, байгалийн доройтол, цаг уурын хүндрэлийн давтамж ихэссэн зэрэг олон хүчин зүйлс хөдөө орон нутгаас хүн амыг хот суурин газар руу шилжих гол шалтгаан болж байна.

Үүний улмаас хот сууринд үүссэн хэт төвлөрөл нь хотын эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний байгууллагуудад хүчин чадлаас давсан ачаалал бий болгож, үйлчилгээний чанар, хүртээмж буурах, албан бусаар шилжиж ирсэн иргэд үйлчилгээний гадна үлдэхэд нөлөөлж байна.

Хүн амын бүртгэл, мэдээлэл сайжирснаар шилжин суурьшигчдийн нийгмийн суурь болон төрийн бусад үйлчилгээнд хамрагдах боломж сайжирсан

байна. “Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чиг хандлага, үр дагавар 2009” судалгааны дүнгээс үзвэл шилжин суурьшигч өрхийн хүүхдийн сургалтын асуудалд эерэг хандлага гарсан, хөдөө орон нутагтай харьцуулахад ажлын байрны олдоц хот суурин газарт илүү байдаг нь шилжих хөдөлгөөн нэмэгдэхэд нөлөөлдөг байна.

Авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ

Шилжих хөдөлгөөнийг сааруулах, түүнээс үүдэлтэй сөрөг үр дагавруудыг багасгах, нийгмийн суурь үйлчилгээг шилжин ирэгсдэд хүргэх зорилгоор дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна:

- Хөдөөгийн сумдыг төвийн эрчим хүчний системд холбох, малчдыг сэргээгдэх эрчим хүчээр хангах, радио телевизийн сувгийг өргөжүүлэх, авто зам барих арга хэмжээг авахад улсын төсвөөс хийх хөрөнгө оруулалт болон гадаадын зээл, тусламжийг нэмэгдүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар дурдсан чиглэлд хөрөнгө оруулалт хийх;
- Хот суурин дахь нийгмийн суурь үйлчилгээний

байгууллагуудын ачааллыг бууруулах зорилгоор дотоодын хөрөнгө оруулалт, гадаад орон, олон улсын тусламжаар ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг байгуулах, засварлах, өргөтгөх;

- Улсын бүртгэлийн байгууллагын техник технологийг шинэчлэх, хүний нөөцийг бэхжүүлэх, хүн амын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;
- Улаанбаатар хотод Хөдөлмөрийн бирж ажиллуулж, ажилд зуучлах үйлчилгээг хаягийн харьяалал харгалзахгүйгээр үзүүлэх.

Тулгамдаж буй асуудал

Хүн амын шилжих хөдөлгөөн нь эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих, улмаар орон нутгийн хөгжлийн ялгааг багасгах нэг арга хэрэгсэл байдаг ч манай улсын хувьд хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн хүн амын хэт төвлөрлийг Улаанбаатар хотод бий болгож, хөдөө орон нутгийн хүн амын тоог цөөрүүлж, улмаар тухайн аймаг суманд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх боломж, орон нутагт эдийн засгийн болон нийгмийн үйлчилгээ эрхлэх боломжийг хомсдуулах, хот хөдөөгийн хөгжлийн ялгаа, тэнцвэрт бус байдал ихсэхэд нөлөөлж байна.

Хотуудын төлөвлөлт, зохион байгуулалт, үйлчилгээний өнөөгийн түвшин бий болоод байгаа хүн амын төвлөрлийг гүйцэхгүй, ер нь төлөвлөлт хийхэд хүндрэлтэй байгаагаас шалтгаалсан сөрөг үзэгдэл маш их гарч байна. Тухайлбал, Улаанбаатар хотод эмнэлэг, сургууль, авто замын ачаалал, нийгэм, соёлын үйлчилгээ, ус хангамж, инженерийн шугам сүлжээ, орон сууцны хангамжийн асуудлуудыг шийдвэрлэхэд бэрхшээлтэй болж, хотын агаар, хөрс, усны бохирдол байвал зохих хэмжээнээс хэтэрхий их нэмэгдэж, оршин суугчдын эрүүл мэндэд муугаар нөлөөлж байна.

Хүн ам нь нийслэл болон бусад томоохон хотуудад шилжин суурьшсанаас шалтгаалж орон нутгийн хот, аймгийн төв, хот маягийн бусад суурингуудад байнга оршин суугчдын тоо цөөрч, нийгэм соёл, ахуйн үйлчилгээний хөгжил зогсонги байдалд орж байна. Нөгөө талаас энэ бүхэн нь аймаг, сумын төвүүдийн тохижилт, үйлчилгээ нь орчин үеийн

хот, тосгоны хөгжлийн түвшинд хүрээгүй, оршин суугчдын өнөөгийн шаардлагыг хангаж чадахгүй, хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих таатай орчин бүрдэж чадаагүйтэй ч бас холбоотой юм.

Одоогоор олонхи аймаг, сумдын төв нь улс орон, бүс нутгийн эдийн засгийн хөгжилд тодорхой гүйцэтгэх үүрэггүй, оновчтой бүтэцтэй болж чадаагүй, зөвхөн засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүд төдий байдлаар оршин тогтнож байна. Монгол орны хот байгуулалтын үйл явцыг орчин үеийн дэлхийн хот байгуулалтын чиг хандлагатай зэрэгцүүлж үзэхэд, хөгжлийн “Нэг төв”-өөс голлон хамаарсан нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын төдийлөн оновчтой бус “загвар” буй болж байна. Манай орны хот байгуулалтын энэхүү загвар нь хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгаж, бүс нутаг бүрийг цогц хөгжүүлэх байдлаар улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэнцвэрт байдлыг хангах өнөөгийн шаардлагад нийцэхгүй, харин нь ч энэ үйл явцыг сааруулах хүчин зүйл болж байна.

Хөдөөд, ялангуяа суманд эрүүл мэндийн болон боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар сайжрахгүй байна.

Хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгах, дагуул хот, бүсийн тулгуур төвүүдийг түшиглэн орон нутагтаа суурин амьдрах боломжийг бүрдүүлэх, бүсийн төвүүдийн хөгжлийг дэмжих чиглэлээр ихээхэн арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа хэдий ч тэр бүр үр дүнд хүрэхгүй байна.

Шилжих хөдөлгөөний улмаас хөдөө орон нутаг, алслагдсан бүсэд хүн амын суурьшил сийрэгжиж, нийгмийн суурь үйлчилгээний зардал болон бараа бүтээгдэхүүний үнэ өндөржиж хүн амын амьжиргааны өртгийг нэмэгдүүлж байна.

Хот суурингийн хүн амын өсөлтөөс дэд бүтэц, ундны ус, орон сууцны хүртээмж хоцрогдсон хэвээр байна. Хот суурингийн хүн амын ердийн болон механик өсөлтийн улмаас хотод газар олголт, эзэмшил, өмчлөлтэй холбоотой бэрхшээл тулгарч, хот суурингийн зохион байгуулалт, байгаль орчны бохирдолд сөрөг нөлөө үзүүлсээр байна.

Хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгах, дагуул хот, бүсийн тулгуур төвүүдийн хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнд тодорхойгүй байна.


Цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ

- Төв сууринд нэгэнт шилжин ирсэн иргэдэд туслах, хотын соёлд сургахад чиглэсэн төрийн үйлчилгээг хөгжүүлэх;
- Шилжих хөдөлгөөний асуудлыг зохицуулсан бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх ингэхдээ, хот хөдөөгийн хөгжлийн болон соёл, ёс заншлын онцлог байдлыг сайтар судалж тусгах;
- Хот суурин газарт шилжих хөдөлгөөний улмаас үүсч буй сөрөг үр дагаврыг арилгах, орон байрны асуудлаа шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор түр амьдрах нийтийн байр, халамжийн орон сууц барих асуудлыг Хот байгуулалт, төлөвлөлтийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх;
- Аймаг, орон нутгийн эрэлт, хэрэгцээнд тулгуурласан жижиг, дунд үйлдвэр, үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулж, орон нутгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар шилжих хөдөлгөөнийг сааруулах;
- Төвөөс алслагдсан, хөгжлөөр бусдаас сул бүс нутаг, аймгуудын иргэдэд бүс нутгийн нэмэгдэл олгох, банк, санхүү, татвар, зээлийн бодлогоор дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Хөдөөгийн хөгжилд анхаарч сумыг хот суурин газрын эзэмшилд хүргэн хөгжүүлэх, хөдөөд дэд бүтцийг бий болгох, хөдөөгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Бүтээн байгуулалтын төслүүд хэрэгжиж байгаа бүс нутгуудад хүн ам шилжин суурьших таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх ажлыг эхлүүлэх;

- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг эргэн хянаж, бүсийн төв, тулгуур төвүүдэд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, нийгмийн дэд бүтцийг сайжруулах;
- Хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөнийг зохистой удирдах зорилгоор суурьшлийн шинэ хороолол, бүсүүдэд эрчим хүч, зам, ундны ус, ариун цэврийн байгууламж, сургууль, цэцэрлэг, өрхийн эмнэлэг барьж байгуулах асуудлыг эхлүүлэх;
- Хот сууринд, ялангуяа захын хороололд хүн амын өсөлтийг харгалзан нийгмийн суурь үйлчилгээний байгууллагуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэх;

Ядуурал, өлсгөлөнг бууруулах мянганы хөгжлийн нэг дэх зорилгын хүрээнд дэвшүүлсэн 4 зорилтын хэрэгжилтийн байдал нь жигд биш, нэгтгэж үзвэл 2015 он гэхэд бүрэн биелэх бололцоо тун бага харагдаж байна. Ялангуяа, ядуурлыг хоёр дахин бууруулах, ажилгүйдлийн түвшинг эрс багасгах, шилжин ирэгсдэд нийгмийн суурь үйлчилгээ үзүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд онцгой хүчин чармайлт гаргах шаардлагатай байна. Энэ хүрээнд манай улсын хувьд МХЗ-уудаас хэрэгжилт тааруу, зорилтод түвшиндээ хүрэхээргүй байгаа ядуурлын түвшинг 2015 оны зорилтод түвшинд нь хүргэх чиглэлээр бусад улс орны туршлагаас суралцан НҮБ-ын Хөгжлийнхөтөлбөрийн санхүүжилт, дэмжлэгтэйгээр МХЗ-уудын хэрэгжилтийг түргэсгэх Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр бүхий бодлогын баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлэх хэрэгтэй юм. Ядуурлыг бууруулах зорилт хэрэгжихгүй байгаа гол шалтгаан, цаашид анхаарах асуудлуудын талаар уг бодлогод нарийн авч үзэх шаардлагатай байна. Тиймээс хэрэгжилтийг эрчимжүүлэх бодлогын хүрээнд эрдэмтэн, судлаачдын багаас бүрдсэн зөвлөхүүдийн тусламжтайгаар судалгаа тооцоо хийн, Засгийн газрын холбогдох байгууллагуудыг хамарсан ажлын хэсэг гарч ажиллах нь зүйтэй юм.





ЗОРИЛГО ХОЁР

*БҮХ НИЙТЭЭР АНХАН ШАТНЫ
БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ*

ЗОРИЛГО 2

БҮХ НИЙТЭЭР АНХАН ШАТНЫ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ

ЗОРИЛТ 5. 2015 ОН ГЭХЭД БҮХ ХҮҮХДЭД БАГА БОЛОВСРОЛ ОЛГОХ

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсад 1990-ээд онд тохиолдсон шилжилтийн үеийн хямрал нь хүн амын боловсролд таагүй нөлөө үзүүлсэн хэдий ч сүүлийн жилүүдэд байдал сайжрах хандлагатай байна.

Бичиг үсэг тайлагдалтын түвшингээр Монгол Улс нь бусад улс оронтой харьцуулахад нэлээд дээгүүр байр эзэлдэг ч сүүлийн жилүүдэд буурах хандлага ажиглагдах болов. Хүн ам, орон сууцны 1989 оны тооллогын дүнгээр 15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын түвшин 99.0 хувь байсан бол 2009 оны байдлаар 97.7 хувь болж буурсан байна.

Хүснэгт 5. Бага боловсролын хамран сургалт, 1-5 дугаар анги хүртэл суралцагчид, бичиг үсэг тайлагдалдалтын хувь

Шалгуур үзүүлэлт	2006	2007	2008	2009	2010	2015*
Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин	91.4	92.7	91.5	94.3	94.7	100.0
Нэгдүгээр ангид элсэн ороод 5 дугаар анги хүртэл суралцагчдын хувь	88.1	89.9	92.8	89.9	92.9	100.0
15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын хувь	97.7	97.7	97.7	97.7		100.0

Эх үүсвэр: ҮСХ

1. Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин

Монгол Улсын бага боловсролын хамран сургалтын цэвэр жин харьцангуй тогтвортой хадгалагдаж байна. 2007 онд 92.7 хувьтай байсан бол 2008 онд 91.5 болж буурсан ч, 2009 онд 94.3 хувь, 2010 онд 94.7 хувь болж өссөн байна. Орхон, Дархан-Уул, Говьсүмбэр, Баянхонгор, Увс, Дорнод, Завхан аймгийн бага боловсролын хамран сургалтын цэвэр жин 2010 оны байдлаар хамгийн их буюу 98.0 хувиас дээш байгаа бол Дундговь, Булган, Төв аймагт хамгийн бага буюу 86.6-88.3 хувь байна. Ийнхүү нэгдсэн дүнгээрээ бага боловсролын хамран сургалтын цэвэр жин 2009-2010 онд өссөн нь Засгийн газраас бага ангийн сурагчдыг сурах бичгээр үнэ төлбөргүй хангах, дотуур байрны хангамжийг сайжруулах, “Үдийн цай” хөтөлбөрийг үргэлжлүүлэх зэрэг бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүн юм.

2. Нэгдүгээр ангид элсэн ороод 5 дугаар анги хүртэл суралцагчдын хувь

Нэгдүгээр ангид элсэн ороод 5 дугаар анги хүртэл суралцагчид 2007 онд 89.9 хувь, 2008 онд 92.8 хувь, 2009 онд 89.9 хувь, 2010 онд 92.9 хувь болж өмнөх оныхоос 3 нэгжээр өсчээ. 2010 оны байдлаар Говьсүмбэр, Өмнөговь, Сэлэнгэ аймгийн нэгдүгээр ангид элсэн орсон суралцагчдын 98.0-аас дээш хувь нь 5 дугаар анги хүртлээ боловсрол эзэмшсэн байна. Харин Увс, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Дундговь, Завхан, Дархан-Уул аймгийн нэгдүгээр ангид элсэн суралцагчдын 82.2-89.0 хувь нь 5 дугаар анги хүртлээ боловсрол эзэмшсэн байна.

Энэ нь зах зээлийн эдийн засгийн харилцаатай нийгэмд боловсрол чухал болохыг манай иргэд ойлгож, хүүхдүүддээ боловсрол олгохыг чухалчилдаг болсонтой холбоотой юм.

Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин, 1 дүгээр ангид элсэн ороод 5 дугаар анги хүртэл суралцагчдын хувь нэмэгдэхэд бодлогын арга хэмжээ чухал нөлөө үзүүлсэн байна:

1. 2008-2009 оны хичээлийн жилээс Монгол Улсын боловсролыг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэн 6 настай хүүхдийг 1 дүгээр ангид элсүүлэн суралцуулав. 2008 онд 6 настай нийт хүүхдийн 79.3 хувь нь сургуульд элссэн бол 2009 онд 6 настай 44,906 хүүхэд 1 дүгээр ангид элссэн нь тухайн насны хүүхдийн 91.1 хувь болж байна. Зургаан настай хүүхдийг сургуульд элсүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас 12 жилийн сургалттай нэгдүгээр ангийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, ном, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, ширээ, сандал бэлтгэх, багшийг мэргэшүүлэн сургах зэрэг олон арга хэмжээ авч, хэрэгжүүлсний дүнд 6 настай хүүхдийн сургуульд хамрагдалт өмнөх оноос 11.8 нэгжээр өссөн байна.

Бага насны хүүхдийн хөгжилд анхаарч, тэднийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулах зорилт тавин ажиллаж байгаа нь бага боловсролын хамран сургалт нэмэгдэх гол хүчин зүйл болж байна.

Монгол Улсын Их Хурал 2008 онд “Сургуулийн өмнөх боловсролын тухай” хуулийг баталж хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулах эрх зүйн орчинг бүрдүүлсэн юм. Цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа малчдын болон нийгмийн эмзэг бүлгийн өрхийн хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах, адил тэгш боломжоор хангах зорилгоор нүүдлийн гэр цэцэрлэг, явуулын багш, ээлжийн бүлэг зэрэг хувилбарт сургалтын үйл ажиллагааг төрөөс санхүүжүүлж, баг бүрт гэр цэцэрлэг байгуулах бодлогыг 2009 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Одоогийн байдлаар 3 баг тутмын нэгд буюу 400 гаруй гэр цэцэрлэгийг хандивлагчдын тусламжаар ажиллуулж байна. 2010 оны байдлаар нийт багийн 60 хувь нь гэр цэцэрлэгтэй болжээ.

Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтад 2007 онд 30.3 мянга, 2008 онд 28.2 мянга, 2009 онд 32.6 мянган хүүхэд тус тус хамрагдлаа. Хөдөөгийн алслагдсан сум,

багийн малчдын хүүхдүүдээс сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтад 2007 онд 15739, 2008 онд 11533, 2009 онд 15269 хүүхэд хамрагдсан байна.

2009-2010 оны хичээлийн жилд 32.6 мянган хүүхэд хувилбарт сургалтад хамрагдсаны 11.6 мянга нь ээлжийн бүлэгт, 5.7 мянга нь явуулын багшийн, харин 15.3 мянга нь нүүдлийн гэр цэцэрлэгийн сургалтад хамрагджээ.⁶

Өмчийн хэлбэрийг харгалзалгүй нэг хүүхдэд ногдох нормативт зардлыг явуулын багш, ээлжийн болон нүүдлийн бүлгийн сургалтад улсын төсвөөс олгож байгаа нь сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, үйлчилгээний хамрах хүрээ өргөжих боломжийг бүрдүүлсэн байна.

Ийнхүү сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах хүүхдийн тоо өсч байгаа нь төрийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 2009 оны 1 дүгээр сараас эхлэн төрөөс бүрэн хариуцаж эхэлсэнтэй холбоотой. Засгийн газраас авч хэрэгжүүлсэн энэхүү арга хэмжээ нь эмзэг бүлгийн өрхийн хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдах боломжийг өргөжүүлж, өрхийн амьжиргааг дэмжих, бага насны хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшин хөгжих боломжийн хувьд ялгаатай, тэгш бус байдлыг багасгахад чухал ач холбогдолтой болсон.

Ийнхүү сургуулийн өмнөх боловсролоор дамжуулан бага насны хүүхдүүдийг сургуульд бэлтгэж байгаа нь 1 дүгээр ангид элсэгчдийн тоог нэмэгдүүлэх төдийгүй бага боловсролын хамран сургалт өсөхөд ч нөлөөлж байна.

2. Ерөнхий боловсролын сургууль завсардалт сүүлийн жилүүдэд багасч байна. 2007 онд нийт 647, 2008 онд 706, 2009 онд 543 хүүхэд сургуулиас завсарджээ⁷. 2009-2010 оны хичээлийн жилийн статистикийн мэдээгээр сургууль завсардагчдын 40.5 хувь нь амьдралын гачигдлаас, 31.1 хувь нь өвчний улмаас, 5.8 хувь нь ажил эрхлэх шалтгаанаар сургуулиас завсардсан байна.

⁶ *Би ёйа нди ёйи ндээддүй 2009-2010 ийи дө-үүддэй аеддэй нд аоддөддэй ий аүүддэй үиддэй ё (I)*

⁷ *Би ёйа нди ёйи ндээддүй 2007-2008, 2008-2009, 2009-2010 ийи дө-үүддэй аеддэй нд аоддөддэй ий аүүддэй үиддэй ё*

Сургууль завсардагчдаас сургуульд буцаж орох хүүхдийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдлээ. Тухайлбал, 2007 онд 401, 2008 онд 203, 2009 онд 475 хүүхэд тус тус сургуульд буцаж орсон байна. Тэдгээрээс 2007 онд 255, 2008 онд 126, 2009 онд 319 хүүхэд бага ангид орсон нь 2009-2010 онд 5 дугаар анги хүртэл суралцагчдын хувь өсөхөд тодорхой хэмжээгээр нөлөөлөв.

Бага боловсролын хамран сургалт нэмэгдэх, сургууль завсардалт буурахад дараах арга хэмжээ чухал нөлөө үзүүлээ.

2008 оны 1 дүгээр сараас бага ангийн бүх хүүхдийг “Үдийн цай” хөтөлбөрт хамруулах ажлыг зохион байгуулснаар бага боловсролын хамрах хүрээ жил тутам нэмэгдэж байна. Тухайлбал, 2007 онд 1-4 дүгээр ангийн 187.9 мянга, 2008 онд 1-5 дугаар ангийн 252.6 мянга, 2009 онд 280.4 мянга хүүхэд тус хөтөлбөрт хамрагдсан бөгөөд хөтөлбөрийн санхүүжилтэд улсын төсвөөс 2007 онд 9.6, 2008 онд 15.0, 2009 онд 15.8 тэрбум төгрөг зарцуулжээ⁸.

Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээр бага насны хүүхдийн сурах идэвхийг дээшлүүлж, тэдний эрүүл мэндийг хамгаалах, бага боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх, сургууль завсардалтыг бууруулах, өрхийн амьжиргааг дэмжих зэрэг олон талын нааштай үр дүн гарч байна. Энэ нь сургууль завсардсан болон сургуулийн гадна байгаа хүүхдийг сургуульд ороход ихээхэн түлхэц болсон юм.

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтад ашиглагдах сурах бичиг нь хувилбаргүй, үндсэн сурах бичигтэй байх, сурах бичгийн агуулгыг төр тодорхойлж байх бодлогыг 2009-2010 оны хичээлийн жилээс баримтлан, төрөөс сурагчдыг сурах бичгээр үнэ төлбөргүй хангах ажлыг үе шаттайгаар авч эхэлсэн нь 5 дугаар анги хүртэл суралцагчдын хувь нэмэгдэхэд нөлөө үзүүлэв.

Авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ

“2009-2010 онд шинээр зохиох, хэвлэх сурах бичгийн жагсаалт” болон “Сурах бичиг зохиох, эх бэлтгэх, хэвлэх, түгээх ажлын график,

төлөвлөгөө”-г БСШУ-ы сайдын 2009 оны 129 дүгээр тушаалаар батлан хэрэгжүүлж байна.

2009-2010 оны хичээлийн жилд 12 жилийн сургуулийн 2 дугаар ангийн 6, 11 жилийн сургуулийн дунд, ахлах ангийн 14, нийт 20 нэрийн сурах бичгийг шинээр, 12 жилийн сургуулийн 1 дүгээр ангийн 6 нэрийн сурах бичгийг шинэчлэн, 2005-2008 онд хэвлэсэн 11 жилийн сургуулийн дунд, ахлах ангийн 7 нэрийн сурах бичгийг дахин, казах хэл дээр сургалтын үйл ажиллагаа явуулдаг сургуулийн бага ангид хэрэглэх 7 нэрийн сурах бичгийг шинээр хэвлэж, ерөнхий боловсролын сургуулийн номын сангаар дамжуулан суралцагчдад олгожээ. Дээрх 40 нэрийн 2.4 тэрбум төгрөгийн өртөг бүхий 940.5 мянган ширхэг сурах бичгийг улсын төсөв, Азийн Хөгжлийн Банкны “Боловсролын салбарын шинэчлэл-4”, “Боловсролын үйлчилгээг бэхжүүлэх” төслийн хүрээнд санхүүжүүлээ. Төрөөс 11 жилийн сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдын 40 хүртэл хувийг сурах бичгээр хангах шийдвэрийн дагуу шинээр (20) болон дахин хэвлэгдсэн (6) сурах бичгийг 12 жилийн сургалтын сургуулийн бага ангийн сурагчдад 100 хувь, 11 жилийн сургууль /төрийн өмч/-ийн дунд, ахлах ангийн суралцагчдын 40 хувийг төрөөс сурах бичгээр хангахаар тооцож нийлүүлсэн бөгөөд 2009-2010 оны хичээлийн жилийн суралцагчдын тооноос үзэхэд 12 жилийн сургуулийн нэгдүгээр ангийн сурагчдын 98.5 хувь, хоёрдугаар ангийн сурагчдын 97.0 хувь, төрийн өмчийн дунд, ахлах ангийн сурагчдын 37.3-42.5 хувь нь төрөөс сурах бичгээр хангагджээ. Харин 11 жилийн сургуульд ашиглах 2005-2008 онд хэвлэсэн 7 нэрийн сурах бичгийг төрийн өмчийн сургуулийн сурагчдын 20 хувьд ногдохоор нийлүүлэлт хийсэн⁹. Ийнхүү сурагчдын сурах бичгийг төрөөс хангах бодлогыг хэрэгжүүлснээр ядуу, эмзэг бүлгийн өрхийн хүүхдүүдийн сурах бичгийн хангалт баталгаатай болохын зэрэгцээ боловсролын чанарын баталгааг хангахад чухал хувь нэмэр болж байна.

“Хүүхэд бүрт компьютер” хөтөлбөрийн хүрээнд 2008 онд 10088, 2009 онд 5704 компьютерийг сургуулиудад нийлүүлэв. Харин 2010 онд сургуулиудад компьютер нийлүүлэгдээгүй.

8 Би ёиáñдiе, ñ ёё, өеiтөөү õ õõááиü ýáиü 2009 иü ¿éё àæёё àáàáиü ò àéёàì, УБ, 2009.

9 Би ёиáñдiе, ñ ёё, өеiтөөү õ õõááиü ýáиü 2009 иü ¿éё àæёё àáàáиü ò àéёàì, УБ 2009 иü

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын орчинг сайжруулах ажлын хүрээнд сургуулиудыг хөгжим, биеийн тамирын хичээлийн хэрэгслээр үе шаттай хангаж байна. Тухайлбал, 2009 онд хот, хөдөөгийн 19 сургуульд 105.0 сая төгрөгийн өртөг бүхий даралтат хөгжмийн иж бүрдэл, 9 сургуульд 25.0 сая төгрөгийн өртөг бүхий биеийн тамирын хичээлийн зарим хэрэгслийг нийлүүлэв.

Төрөөс ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сургуулийн номын сангаар дамжуулан сурах бичиг олгож эхэлсэн, “Хүүхэд бүрт компьютер” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн, нийгмийн эмзэг бүлгийн болон 4 буюу түүнээс дээш хүүхэд нь ерөнхий боловсролын сургуульд суралцдаг өрхийн 62,500 хүүхдийг хичээлийн хэрэглэлээр хангахад 602.6 сая төгрөгийг зарцуулж, хичээлийн хэрэглэлийг үнэ төлбөргүй олгосон, ерөнхий боловсролын сургуулийн суудлын тоог 4620-оор нэмэгдүүлсэн¹⁰ зэрэг олон арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь сургууль завсардалт буурах, хамран сургалт нэмэгдэхэд нөлөөлөв.

Дэлхийн Банкны “Үрдүнд түргэн хүрэх санаачилгын түншлэл” хөтөлбөрийн хүрээнд 30 сургуульд дотуур байрны тоног төхөөрөмж нийлүүлэхээр худалдан авах ажлыг зохион байгуулсан бөгөөд мөн НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгээр 6 настай хүүхдийн амьдрах 50 дотуур байрын өрөөг тохижуулахад нийт 10.0 гаруй мянган ам.долларын өртөг бүхий тоног төхөөрөмжийг 6 аймагт нийлүүлэв.¹¹ 2009 онд Ерөнхий боловсролын сургуулийн шинээр ашиглалтад орсон 12 дотуур байранд 90.0 сая төгрөгийн тавилга, хэрэглэл нийлүүлж, орны тоог 600-аар нэмэгдүүлсэн.

2009-2010 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 505 дотуур байр үйл ажиллагаа явуулж байна. Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдаас 42,156 нь буюу нийт суралцагчдын 8.1 хувь нь дотуур байранд амьдарч байна.¹² Интернэтэд холбогдсон хөдөөгийн сургуулиудын шилэн кабелийн E1 2M-ийн урсгалын түрээсийн төлбөрт 503.5 сая төгрөг зарцуулсан нь хүүхдийн сурч боловсрох орчинг сайжруулах, орчин үеийн техник технологийн давуу талыг сургалтад ашиглах боломжийг бүрдүүлэв.

Хүснэгт 6. Дотуур байранд хамрагдаж байгаа хүүхдийн тоо

Шалгуур үзүүлэлт	2007	2008	2009
Дотуур байрны орны тоо	37 740	37 846	36 921
Дотуур байранд амьдарч буй хүүхдийн тоо	44 037	42 086	42 156
Дотуур байранд хамрагдалтын индекс	86.1	87.1	90.0

3. 15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын хувь

Бичиг үсэг үл мэдэгчдийг нэгдсэн бүртгэлтэй болгох зорилгоор Боловсролын хүрээлэнгийн судлаачид “Бичиг үсэг үл мэдэгч”-ийг тодорхойлох сорил боловсруулжээ. Энэхүү сорилыг 2000 оны хүн ам, орон сууцны тооллогын судалгааны асуултад оруулж туршилт тооллого хийлээ. Сорил нь бичиг үсэг үл мэдэгч болон бага мэдэгчдийг тогтоож, Албан бус боловсролын “Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөр”-өөр боловсрол нөхөн олгох сургалтад хамруулах, хүн амын

бичиг үсэг тайлагдалтын түвшинг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн ач холбогдолтой судалгаа боллоо.

Аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газраас бичиг үсэг үл мэдэгч хүүхэд залуус, насанд хүрэгчдэд зориулсан бичиг үсгийн анхан, дунд шатны сургалтыг танхимын болон явуулын хэлбэрээр зохион байгуулж, тэдний бичиг үсгийн чадварыг дээшлүүлэхэд анхаарч ажиллаж байна. 2009-2010 оны хичээлийн жилийн статистикийн мэдээгээр 2009 онд бичиг үсэг үл мэдэгч 4746 иргэний 3546 нь бичиг үсгийн сургалтад

10 *Bi eia ndi e, ni ee, oei aeey o ddaaii yaaii 2009 iiu zee aee ee aaii ai o ae eai, /NB 2009 ii /*

11 *Bi eia ndi e, ni ee, oei aeey o ddaaii yaaii 2009 iiu zee aee ee aaii ai o ae eai, /NB 2009 ii /*

12 *Bi eia ndi eai nae daai 2007-2008, 2008-2009, 2009-2010 iiu de-yuee ei aee ee ei no aoe no eee ei iy ayuee ei yidaay e*

хамрагдсан бөгөөд 2009 оны хувьд тэдний 2133 буюу 60.2 хувь нь бичиг үсэгт тайлагдсан байна¹³.

Иргэдийн бичиг үсэгт тайлагдсан байдлыг 2008 онтой харьцуулахад 20.9 хувиар өссөн нь бичиг үсэг үл мэдэгч иргэдийн тоо жил тутам буурч байгааг харуулж байгаа ч 1989 оны төвшинд хүрч чадахгүй байгаа юм. Хүн ам, орон сууцны тооллого нь 10 жилд нэг удаа хийгддэгээс 15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалттай холбоотой жил тутмын мэдээлэл дутмаг байдаг. Мэдээллийн дутмаг байдал нь зорилтын хэрэгжилтийн явц, үр дүнг харьцуулах, энэ талаар авах арга хэмжээг сайжруулахад муугаар нөлөөлж байна.

Тулгамдаж буй асуудал

- Зарим аймгийн сургуулийн дотуур байрын барилга шаардлага хангахгүй актлагдсан нь шинээр хөрөнгө оруулалт хийхийг шаардаж байна.
- Гадаад улс оронд сурч, амьдарч байгаа хүүхдүүдийн талаарх мэдээллийн сан хараахан бүрдээгүй байгаа нь зарим шалгуурыг тооцоход бэрхшээлтэй байна. Тухайлбал, гадаад улс оронд сурч байгаа хүүхдийн тоо ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа нийт суралцагчдын тоонд ордоггүй ч тухайн насны суурин хүн амын тоонд тооцогддог нь мэдээллийн бодит байдалд нөлөөлж байна.
- Хөдөө, орон нутгаас Улаанбаатар хот болон аймгийн төв, суурин газарт шилжин ирж буй иргэдийн тоо нэмэгдэж, зарим сургууль хүчин чадлаасаа илүү ачаалалтай ажиллаж байна. Энэ байдлаас болж хүүхэд сургуульд бүрэн хамрагдаж чадахгүй байх явдал байна.
- Иргэд тухайн Засаг захиргааны нэгжид шилжих хөдөлгөөний бүртгэлээ бүрэн хийлгэдэггүй, тухайн оршин суугаа газраа хаягийн бүртгэлд хамрагддаггүй нь хүүхдийг сургууль завсардахад хүргэж байна. Бүс нутгийн онцлог байдал, байгаль цаг уурын нөлөөллөөс

амьдралын хэв маяг хараат байгаа зарим сумдын хүүхдийн сургуульд хамрагдалтын хувь бага байна. Ажилгүйдэл, ядуурал их байгаагаас шалтгаалан олон хүүхэд сургуульд суралцаж чадахгүй байна. 2008-2009 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллээр сургуулийн гадна байгаа хүүхдийн 33.9 хувь, 2009 онд 40.5 хувь нь амьдралын гачигдлаас шалтгаалан сургуульд суралцаж чадахгүй байна.

- Сургуулийн гадна байгаа хүүхдийн тоо дорвитой буурахгүй байгаа нь бичиг үсэггүй залуучуудыг төрөн гарах үндэс болж байна.

Цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ

- Статистикийн мэдээллийн дутмаг байдлыг өөрчлөх, мэдээллийг тодорхой давтамжтайгаар шинэчлэн цуглуулж, нэгтгэн боловсруулалт хийх нөхцлийг бүрдүүлэх, боловсролын статистикийн мэдээллийн сан, нэгдсэн тогтолцоо бий болгох;
- Сургуульд огт ороогүй болон сургуулийн гадна байгаа, тухайн жилд сургууль завсардсан хүүхдийн тоон мэдээллийг цуглуулах, нэгтгэх, бодит мэдээлэлд тулгуурлан тэднийг сургуульд буцааж оруулах, энэ талаар сум, баг, хорооноос нэгдсэн удирдлагаар хангаж, хамтран ажиллах, энэ ажилд иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг уялдуулах, сургууль завсардалтыг бууруулахад тэдний үйл ажиллагааг чиглүүлж ажиллахад анхаарах;
- Хот суурин, төвлөрсөн газар, томоохон суманд суурьших иргэдийн шилжилт хөдөлгөөний улмаас сумдын сургуулийн хүүхдийн тоо цөөрч байна. Иймд хамран сургалтыг нэмэгдүүлэх, сургууль завсардалтыг бууруулах, хамран сургалт бага хувьтай байгаа сумдын сургуулийн ачааллыг харгалзан сургуулиудын бүтэц, хэв шинжийг оновчтой болгох, засаг захиргааны нэгжийн өөрчлөлттэй уялдуулан бодлогын төвшинд авч үзэх;

¹³ *Bi āiānǐēni nàdàdǎni 2009-2010 īni dè-yǔēdèi wèdèdèi nò àdèndèdèdèi iy àiyǔyè*

- Цэцэрлэгт хамрагдаагүй 5 хүртэл настай хүүхдийг сургуульд элсүүлэх бэлтгэлийг хангах, сумын төвд суралцах, амьдрах орчин бүрдүүлэх ажлыг эцэг эхийн санал, санаачилгад тулгуурлан зохион байгуулах.


Ийнхүү бүх нийтээр анхан шатны боловсрол эзэмших Мянганы хөгжлийн хоёр дахь зорилгын хэрэгжилт бүрэн хангагдах бололцоо бүрдэж байгаа боловч үлдэж байгаа богино хугацаанд судалгаа мэдээллээ нарийвчилж зарим тодорхой арга хэмжээг авах шаардлагатай байгаа юм.



ХҮСТ



БАКАЛАВРЫН
ДИПЛОМ



ЗОРИЛГО ГУРАВ

ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ДЭМЖИН
ХӨГЖҮҮЛЖ, ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ

ЗОРИЛГО 3

ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ДЭМЖИН ХӨГЖҮҮЛЖ, ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ

ЗОРИЛТ 6. 2009 ОН ГЭХЭД БАГА БОЛОН ДУНД БОЛОВСРОЛ ЭЗЭМШИГЧИЙН ДУНД, 2015 ОН ГЭХЭД БҮХ ШАТНЫ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГАД СУРАЛЦАГЧДЫН ХҮЙСИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦААГ ХАНГАХ

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Манай улс жендэрийн хөгжлийн индексээрээ дэлхийн 140 орноос 94 дүгээр байр, жендэрийн эрх мэдлийн хэмжүүрээр 76 орноос 65-д байгаа тухай Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаархи Засгийн газрын илтгэл 2010-д дурьджээ¹⁴. Жендэрийн тэгш байдлыг хөгжүүлэх, хүйсийн зохистой харьцааг хангах асуудлыг юуны өмнө боловсролын байгууллагад суралцагчдын хүйсийн зохистой харьцаанд үндэслэх учиртай.

1990-ээд оны эхэн үеийн эдийн засгийн шилжилт нь манай улсын боловсролын тогтолцоонд нөлөөлж эрэгтэй, эмэгтэй хүүхдийн сургуульд суралцах тооны харьцааг гажуудуулсан хэдий ч 2000 оноос хойш байдал сайжрах хандлагатай байна.


Дээд боловсрол эзэмшихээр 2000 онд суралцаж байсан оюутнуудын 36.8 хувь нь эрэгтэйчүүд байсан бол 2009 онд 39.6 хувь, 2010 онд 40.4 хувь болж өссөн байна.

Бага, дунд боловсрол эзэмшигчдийн дунд хүйсийн харьцаа тэнцвэржих нь дээд боловсрол эзэмшигчдийн дунд хүйсийн ялгаа багасахад нөлөөлж улмаар МХЗ-ууд биелэгдэх боломжтой болох юм. Анхан шатны боловсрол эзэмшиж буй эмэгтэй, эрэгтэй хүүхдүүдийн харьцаа 2009 онд 0.96, 2010 оны байдлаар 0.96, дунд боловсрол эзэмшиж буй эмэгтэй, эрэгтэй хүүхдүүдийн харьцаа 2009 онд 1.07, 2010 онд 1.07, дээд боловсрол

эзэмшиж байгаа эмэгтэй, эрэгтэйчүүдийн тооны харьцаа 2009 онд 1.52, 2010 онд 1.48 байна. Эндээс боловсролын шат ахих тусам суралцаж буй эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхээс илүү байгаа нь харагдаж байна.

Бүх шатны боловсролын байгууллагад суралцагчдын хүйсийн харьцааг 2009 оны байдлаар бүсээр авч үзвэл, Баруун болон Төвийн бүсэд бага боловсрол, Хангайн болон Баруун бүсэд ерөнхий боловсрол, Зүүн бүсэд дээд боловсрол эзэмшиж буй эмэгтэй, эрэгтэйчүүдийн харьцаан дахь зөрүү бусад бүсийн түвшнээс өндөр байна.

Дүрслэл 10. Бага, ерөнхий болон дээд боловсрол эзэмшигчдийн хүйсийн харьцаа



- Дээд боловсрол эзэмшиж байгаа эмэгтэй, эрэгтэйчүүдийн тооны харьцаа
- Ерөнхий боловсрол эзэмшиж байгаа охид хөвгүүдийн харьцаа
- Бага боловсрол эзэмшиж байгаа охид хөвгүүдийн харьцаа

Эх үүсвэр: БСШУЯ

14 *Miiāi ē Yēñ Azēēi idioo āāāñ āiō oāāā yōyāōyē, yiyāōyē+; z;ā oūāō yōdōyē āi ēi oūā o oioāāāe 1924 iū āāō āēñāi āiōiū Yīāñyī dōōēēdāā dōōēē+ēēe "āñ"i iū e eiā yōdēēi oūāō āāēēyūā dāiāāāā +ēēyūyī āiōiū āēōāi āāēñāi iōi .*

Хүснэгт 7. Бага, ерөнхий болон дээд боловсрол эзэмшигчдийн хүйсийн харьцаа (2010 он)

Шалгуур үзүүлэлт	2006	2007	2008	2009	2010	2015*
Бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа	0.98	0.97	0.97	0.96	0.96	1.0
Ерөнхий боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа	1.09	1.09	1.08	1.07	1.07	1.0
Дээд боловсрол эзэмшиж байгаа эмэгтэй, эрэгтэйчүүдийн тооны харьцаа	1.53	1.57	1.54	1.52	1.48	1.0

*- Зорилтод түвшин
Эх үүсвэр: ҮСХ

Бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн хүйсийн харьцаа сүүлийн жилүүдэд харьцангуй тогтвортой хадгалагдаж байна.

Бага ангиас сургууль завсардах хүүхдийн тоонд эрэгтэй хүүхдийн эзлэх хувь буурах хандлагатай байна. 2009 онд 966 хүүхдийн 594 буюу 61.5 хувь нь эрэгтэй хүүхэд байна. Бага боловсролд хөвгүүдийн тоо нэмэгдэж байгаа нь охид, хөвгүүдийн хүйсийн харьцааны тогтвортой байдалд нөлөөлж байна.

Ерөнхий боловсрол эзэмшиж байгаа хөвгүүдийн тоо жил ирэх тутам өсөх хандлагатай байна. 2005-2006 онд тухайн насны нийт суралцагчдын дунд хөвгүүдийн эзлэх хувь 36.8 байсан бол 2006 онд 47.7, 2007 онд 47.9, 2008 онд 48.1, 2009 онд 48.3 болсон байна.

Эндээс харахад 2009 он гэхэд бага болон дунд боловсрол эзэмшигчдийн дунд суралцагчдын хүйсийн зохистой харьцааг хангах талаар дэвшүүлсэн зорилт үндсэндээ хангагдах боломжтой гэж дүгнэж болохоор байна.

Мянганы хөгжлийн зорилтын “Хүйсийн тэгш байдлыг хангах” зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Элсэлтийг нэмэгдүүлэх тухай” 2006 оны 486 дугаар тушаал гарч, 2006-2007 оны хичээлийн жилээс ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр анги төгсөгчдийн 80-аас доошгүй хувийг 10 дугаар ангид элсүүлж, түүнд эрэгтэй суралцагчдын эзлэх хувийг улсын хэмжээнд 48.0 хувьд хүргэхээр заасан¹⁵ байна. 2006-2007, 2007-2008 оны хичээлийн жилд хүйсийн тэгш байдлыг хангах талаар өөрчлөлт гараагүй байна. Харин 2008, 2009 оны хичээлийн жилд ерөнхий боловсрол

эзэмшиж буй хөвгүүдийн эзлэх хувь 48.1, 48.3 болсон нь энэхүү тушаал зохих үр дүнгээ өгч охид, хөвгүүдийн хүйсийн харьцаанд өөрчлөлт гарах, хүйсийн ялгаатай байдлын зөрүү багасахад нөлөөлж байна.

Дээд боловсрол эзэмшиж буй эмэгтэй, эрэгтэйчүүдийн тооны харьцааны ялгаа сүүлийн жилүүдэд харьцангуй багасч байна. Дээд боловсрол эзэмшиж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2008 онд 0.03, 2009 онд 0.02, 2010 онд 0.04 нэгжээр буурч, тооны харьцаанд эрэгтэйчүүдийн эзлэх хувь аажмаар нэмэгдэж байна.

Дээд боловсрол эзэмшиж байгаа эмэгтэй, эрэгтэйчүүдийн тооны харьцаа нь тухайн жилд ерөнхий боловсролын сургууль төгсөгчид болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд элсэгчдийн тооны өсөлт, бууралтаас шууд хамааралтай юм.

Ерөнхий боловсролын сургуулийн 11 дүгээр ангийг 2009 онд 34.9 мянган сурагч төгсчээ. Тэдгээрээс 2009 онд 45.6 хувь нь эрэгтэй суралцагч байв. Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөөс 2009 онд 32.5 мянган суралцагч их, дээд сургуульд элсэн суралцжээ. Тухайн жилд суурь боловсрол эзэмшигчдээс 2009 онд 13952 хүүхэд мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвүүдэд тус тус элсэн суралцсан байна. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд суралцагчдад 2010 оноос эхлэн сар бүр 45000 төгрөгийн тэтгэлэг олгож урамшуулах болсон нь тус төвүүдэд суралцагчдын тоог нэмэгдүүлэх хөшүүрэг болов.

Ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр анги төгсөгчдийн тодорхой хэсэг нь мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд элсэн суралцдаг бөгөөд тэдний дийлэнх нь эрэгтэй хүүхэд байдаг нь дээд боловсрол эзэмшиж байгаа эрэгтэй, эмэгтэйчүүдийн тооны харьцаанд нөлөөлж байна.

15 “Энхүүдөөдээ үү үүдээгүү өр өддөө” БСШУ-ийн нэгдүүл 2006-ийн 12 нэгдүүл 29-төө “дддддд 486 дддддд өдддддд”

Тулгамдаж буй асуудал

Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын хувьд жендэрийн тэгш байдлыг хангах талаар баримтлах тухайлсан бодлого байхгүйгээс багш нарын хүйсийн харьцаа хэт алдагдсан байна. Тухайлбал, 2009-2010 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллээр ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа нийт 26.0 мянган багшийн 4750 буюу 18.2 хувийг эрэгтэй багш нар эзэлж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн нийт багш нарт эрэгтэй багшийн эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс харьцангуй бага байгаа нь багш бэлтгэх сургуулийн элсэлт, төгсөлтөд жендэрийн харьцаа алдагдсантай холбоотой юм. Тухайлбал, 2009 онд тус мэргэжлээр 3447 оюутан төгссөний 712 буюу 20.7 хувь нь эрэгтэй төгсөгчид байв.

Энэхүү тэнцвэргүй байдлаас үүдэн ерөнхий боловсролын сургуульд эрэгтэй багшийн үлгэр, дуурайлал дутагдаж байгаа юм.

Бүх шатны боловсролын байгууллагад суралцагчдын хүйсийн тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн төрийн нэгдсэн бодлого, арга хэмжээ

дутмаг хэвээр байна. Ялангуяа, дээд боловсрол эзэмшүүлэхэд мэргэжлийн онцлог, инженер техникийн ажилтан бэлтгэх ул суурьтай судалгаа, түүнд суурилсан нэгдсэн бодлого үгүйлэгдсээр байна.

Цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ

- Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн одоо, ирээдүйд шаардлагатай ажлын байр, мэргэжлийн хэрэгцээг иж бүрэн судалж, түүнд тулгуурласан жендэрийн мэдрэмжтэй бодлого боловсруулах;
- Ерөнхий боловсролын сургуульд одоо мөрдөж буй сургалтын хөтөлбөр, сурах бичгүүдийн агуулга, арга зүй нь жендэрийн тэгш байдлыг хангаж буй эсэхэд шинжилгээ хийх, түүнд тулгуурлан тодорхой бодлого боловсруулан хөтөлбөр, арга зүйг шинэчлэх ажлыг зохион байгуулах;
- Багш бэлтгэж буй мэргэжлийн байгууллагуудад жендэрийн мэдрэмжтэй элсэлтийн бодлого баримтлах;

ЗОРИЛТ 7: ЦАЛИНТАЙ АЖИЛ ЭРХЭЛЖ БАЙГАА ХҮН АМЫН ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 2007-2009 онд 62-63 орчим хувь байсан боловч 2010 онд 56.2 хувь болж буурсан байна. Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин эрэгтэйчүүдийнхээс 10 орчим хувиар доогуур байдаг. Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин буурахад эдийн засаг, хөдөлмөрийн зах зээлд гарч буй өөрчлөлт нэгэн адил нөлөөлж байгаа боловч хүүхэд асрах, гэрийн ажил хийх, тэтгэвэрт эрт гарах зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлдөг байна.

Хүснэгт 8. Хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь

Шалгуур үзүүлэлт	2007	2008	2009	2010	2015*
17. Хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь	53.1	53.0	48.8	48.4	50.0

*-Зорилтод түвшин
Эх үүсвэр: Хүн амын ажил эрхлэлтийн жилийн тайлан, 1990-2008;
ҮСХ. Ажиллах хүчний судалгаа, 2009-2010,

Эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 2010 онд 9.2 хувь болж өмнөх оныхоос 2.3 хувиар буурсан байна.¹⁶ Энэ үзүүлэлтийг хот, хөдөөгөөр авч үзэхэд эмэгтэйчүүдийн ажилгүйдэл хотод илүү өндөр байна¹⁷.

ХАА-аас бусад салбарт цалинтай ажил эрхлэгчдийн дотор эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин ойролцоо байгаа ч эмэгтэйчүүдийн цалин хөлсний түвшин эрэгтэйчүүдийн дундаж цалингаас 15.0 орчим хувиар доогуур байна. Эмэгтэйчүүд бөөний ба жижиглэн худалдаа, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, зочид буудал, зоогийн газар, санхүүгийн үйлчилгээ зэрэг биеийн хүчний хөдөлмөр бага шаардах салбарт голлож байгаа бол эрэгтэйчүүд уул уурхай, барилга, зам тээвэр зэрэг өндөр бүтээмжтэй салбарт зонхилж байгаа нь тэдний цалин хөлсний ялгаатай байхад нөлөөлж байна.

Авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ

Монгол Улсын Засгийн газраас Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн төслийг олон улсын хандивлагч байгууллагуудын санхүү, техникийн дэмжлэгтэйгээр боловсруулж УИХ 2011 оны хаврын чуулганаараа хэлэлцэн батлав. Уг хуульд эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсээр нь ялгаварлан гадуурхах явдлыг арилгах, улмаар улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хэвшүүлэх нөхцөл, бололцоог бүрдүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлсон байна. Энэ хуулиар хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн харилцаа, соёл, боловсролын салбар дахь эрх тэгш байдлыг баталгаажуулан, эрэгтэй, эмэгтэй хүмүүс ажлын байраа хадгалан үлдэх, мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх, хөдөлмөрийн шударга үнэлэмж бүхий цалин хөлс авах, сурч боловсрох, сургалтын тэтгэлэгт хамрагдах зэрэг нийгмийн харилцаанд хүйсээр алагчлахыг хориглосон олон заалт тусгагджээ. Түүнчлэн эх, хүүхдийн эрх ашгийг хамгаалах, сургуульд элсэгчдийн тооны хязгаар, зар мэдээнд аливаа ажилд иргэдийг авахдаа царай зүс, нас, хүйсээр ялгаварлахгүй байх, гэрийн ажил буюу хүүхэд өсгөх, хөгшдийг асрах зэрэг

ямар ч хөдөлмөрийн үнэлэмжгүй байдаг гэрийн хөдөлмөр эрхлэлтийг баялаг бүтээсэнд тооцох зэрэг өргөн хүрээтэй харилцааг зохицуулахаар тусгасан байна.

Тулгамдаж буй асуудал

- Хүүхэд асрах, гэрийн ажил хийх, тэтгэвэрт эрт гарах зэрэг хүчин зүйлсийн нөлөөллөөр эмэгтэйчүүдийн эдийн засгийн идэвхи эрэгтэйчүүдийнхээс дутуу байх явдал үргэлжилсээр байна.
- Хүн ам зүйн онцлогоос хамааран хөдөлмөрийн насны хүн амын өсөлт өндөр байгаа хэдий ч эдийн засгийн өсөлт нь хөдөлмөр шингээлт багатай хэвээр байна. Энэ нь эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль алиных нь хувьд ажиллах хүчний оролцооны түвшин буурахад нөлөөлж байна.
- Хөдөлмөр эрхлэлтийн тоон үзүүлэлтүүд харьцангуй сайжирч байгаа ч чанарын өөрчлөлт бага байна. Нийт хөдөлмөр эрхлэгчдийн дотор өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувийн жин харьцангуй өндөр байх хандлага үргэлжилж байна.
- Өрхийн цалингүй хөдөлмөрийг аль болохоор механикжуулж хөнгөвчлөх замаар цаг хэмнэж цалин хөлстэй салбарт шилжин ажиллах бололцоог нэмэгдүүлэх хэрэгтэй байна.
- Гэр бүлийн үүрэг хариуцлагыг илүү тэнцвэртэй хуваарилах чиглэлд нийгмийн зөв хандлага төлөвшүүлэхэд зохицсон хууль эрхзүйн механизм, соёлын бодлого үгүйлэгдэж байна.
- Хүүхдийн цэцэрлэг, хүүхэд асрах, саатуулах газруудын хүртээмж бага, энэ чиглэлийн үйлчилгээ хөгжих таатай орчин нөхцөл бүрдээгүй байна.

Хөдөлмөрийн зах зээлд болон хөдөлмөрийн харилцааны хүрээнд нас, хүйс, бусад үндэслэлээр ялгаварлан гадуурхах тохиолдол бодитой байгаа нь эмэгтэйчүүдийн цалин хөлстэй ажил хийхэд сөрөг нөлөө үзүүлж байна.

¹⁶ *Miitai ē Yēnūi nō ààèñòèèèéé yīdōōy ē, 2010, YCŌ*

¹⁷ *“Ōzī ài , īdū nōōyū 2010 īū ōēnūi ōū ēēīāī ”-ūī zīānyī zō āzī, YCŌ*

Цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ

- Хүн бүрийн эдийн засгийн эрхийг хэрэгжүүлж зохистой бүтээмжтэй, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд ажиллах, амьжиргаандаа хүрэлцэхүйц цалин хөлс, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх нь салбар дундын зохицуулалт шаардсан нарийн төвөгтэй асуудлыг шийдвэрлэх чиглэлээр Засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгмийн зүгээс хамтын хүчин чармайлт гаргах;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагааг нь эдийн засаг, нийгмийн болон байгаль орчны бодлоготой нягт уялдуулан төлөвлөх;
- Цалин хөлсгүй өрхийн хөдөлмөрт орчин үеийн техник, технологийн ололтыг нэвтрүүлэх, бусдад хөлс төлж хийлгэх замаар цалин хөлстэй салбар болгох зохион байгуулалт, эрх зүйн орчин нөхцөлийг бүрдүүлэх;
- Цаашид эдийн засаг, нийгмийн хүрээнд хийх томоохон өөрчлөлт шинэчлэлд жендэрийн мэдрэмжтэй хандаж, хүний аюулгүй байдлын болон жендэрийн тэгш эрхийн үүднээс дүн шинжилгээ хийсний үндсэн дээр хэрэгжүүлж байх;
- Цөөн хүн ам, өргөн уудам газар нутагтай, хот хөдөөгийн хөгжлийн ялгаа ихтэй зэрэг онцлог нөхцөл байдлаа хөгжлийн бодлого төлөвлөлтөд харгалзан үзэж, хөдөөгийн, ялангуяа алслагдсан бүс нутагт жендэрийн зохистой харьцааг хангасан хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр илүү их хүчин чармайлт гаргах. Үүнд олон улсын байгууллага, донор орнуудын дэмжлэг туслалцааг түлхүү чиглүүлэх;
- Хөдөлмөрийн зах зээлийг тэлж, ажиллах хүчний шингээлтийг нэмэгдүүлэхийн тулд аж ахуйн нэгж, ялангуяа ХАА-н салбарын малын гаралтай түүхий эдэд боловсруулалт хийж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг үйлдвэрийг хөрөнгө оруулалт, зээлийн хүү, татвар зэрэг эдийн засгийн хөшүүрэг, бусад арга

хэрэгслээр дэмжих цогц бодлогыг үндэсний хөгжлийн төлөвлөлт, санхүү төсвийн болон хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллагууд хамтран боловсруулж хэрэгжүүлэх, ингэхдээ эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөөллийг урьдчилан тооцох;

- Эмэгтэйчүүд, ялангуяа ажил олоход бэрхшээлтэй тулгарч буй ахимаг насны, ур чадвар доогуур, гэр бүлийн үүрэг хариуцлагын улмаас бүтэн цагаар ажиллах боломжгүй эмэгтэйчүүдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгайлсан хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлэх;
- Эмэгтэйчүүдийн өрхийн цалингүй хөдөлмөрт зарцуулж буй цагийг багасгах, жижиг бизнес эрхэлж, албан бус секторт ажиллагчдыг нөхөрлөл хоршооны хэлбэрт шилжихэд нь дэмжлэг үзүүлэх замаар цалин хөлстэй ажлын байрны хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Хөдөлмөрийн хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд эмэгтэйчүүдэд эрх тэгш боломж олгох зохицуулалт, механизмыг боловсронгуй болгох;
- Хөдөлмөрийн харилцааны хүрээнд гарч буй ялгаварлан гадуурхалтыг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлд нийгмийн түншлэлийн байгууллагуудын оролцоотойгоор ажил олгогчид болон ажилтнуудын дунд сургалт, сурталчилгаа зохион байгуулах, мэргэжил-арга зүйн зөвлөгөө өгөх;
- Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн нийгмийн үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх, түүний дотор хүүхдийн цэцэрлэг, сургуулийн өмнөх болон сургуулийн насны хүүхдүүдийг саатуулах үйлчилгээ, өдөр өнжүүлэх бүлэг зэргийн хүртээмжийг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Цагаар хөдөлмөрлөж хөлсөө авах тогтолцоог бүрдүүлж эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлэх;

ЗОРИЛТ 8: УЛС ТӨР, ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ.

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Сүүлийн жилүүдийн судалгаагаар эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү өндөр боловсрол эзэмших болсон хэдий ч удирдах болон шийдвэр гаргах түвшний албан тушаалд эмэгтэйчүүдийн төлөөлөл бага хэвээр байна. 1992 оны сонгуулиар эмэгтэйчүүд үндэсний парламентын нийт гишүүдийн 3.9 хувь, 1996 оны сонгуулиар 9.2 хувь, 2000 оны сонгуулиар 11.8 хувийн төлөөлөлтэй болж өсөх хандлагатай байсан ч 2004 оны сонгуулиар 6.6 хувь, 2008 оны сонгуулиар 3.9 хувь болж буурчээ.

Улсын Их хуралд нэр дэвшигчдийн дунд

эмэгтэйчүүдийн эзлэх хувь 1992 онд 8.0 байсан бол 1996 онд 9.3, 2004 онд 13.7, 2008 оны сонгуулиар 18.5 болж тасралтгүй өссөн байна.

2008 оны сонгуулийн дараа хамтарсан Засгийн газар байгуулагдсан бөгөөд түүний кабинетад 2 эмэгтэй сайд, 4 эмэгтэй дэд сайд томилогдсон нь 1992 оноос хойшхи Засгийн газар дахь эмэгтэйчүүдийн төлөөллийн хамгийн өндөр үзүүлэлт байв.

2010 оны байдлаар бүх шатны Засаг дарга, Засаг даргын орлогч нарын 17.3 хувь нь, Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нарын 28.1 хувь нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 9. Төрийн нийт албан хаагчдын дотор эмэгтэй, эрэгтэйчүүдийн эзлэх хувь

	Тоо	Эмэгтэй		Эрэгтэй	
		Тоо	Хувь	Тоо	хувь
Улс төр	2865	613	21.4	2252	78.6
Төрийн захиргаа	14420	7878	54.6	6542	45.4
Төрийн тусгай	28475	2585	9.1	25890	90.9
Төрийн үйлчилгээ	102463	73310	71.5	29153	28.5
Дүн	148223	84386	56.9	63837	43.1

Эх үүсвэр: Төрийн албаны зөвлөлөөс гаргасан төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний статистикийн 2010 оны тойм мэдээ

Дээрх хүснэгтээс харахад төрийн албанд ажиллагчдын 56.9 хувь нь эмэгтэйчүүд байгаагаас 71.5 хувь нь төрийн үйлчилгээ буюу боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал зэрэг салбарт ажиллаж байна. Харин улс төрийн албан

хаагчдын 21.4 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь улс төрийн болон бодлогын шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо эрэгтэйчүүдийнхээс бага байна гэсэн үг юм. Гэхдээ улс төрийн албан хаагчдын ажиллаж буй түвшинг авч үзэхэд дунд, доод шатанд эмэгтэйчүүд нэлээд байна.

Хүснэгт 10. Улсын Их Хуралд сонгогдсон, нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь

Шалгуур үзүүлэлт	1990	2007	2008	2009	2010	2015*
Улсын Их Хуралд сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь	24.9	6.6	3.9	3.9	3.9	30.0
Улсын Их Хуралд нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь	-	-	18.5	-	-	30.0

Эх үүсвэр: Төрийн албаны зөвлөлөөс гаргасан төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний статистикийн 2010 оны тойм мэдээ
*-Зорилтод түвшин

Улс төр, бодлогын шийдвэр гаргах түвшинд болон төрийн байгууллагын дээд шатны албан тушаалд эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй байгаагийн

шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлсийг зарим судалгаанд тодруулсан байна.

Хүснэгт 11. Эмэгтэйчүүдийн оролцоо дээшлэхгүй байгаагийн шалтгаан хувиар, (2010 он)

Өөрсдөөс нь шалтгаалж буй хүчин зүйлүүд	Хувь
Улс төрийн болон шийдвэр гаргах түвшинд ажиллах чадвар бүхий эмэгтэйчүүд цөөн байна	12.1
Эмэгтэйчүүдийн гэр орны болон албан ажлын үүрэг хариуцлага, ачаалал их байна	14.9
Тэд улс төрд орох сонирхол бага байна	8.8
Өөрсдийнх нь хичээл зүтгэл сул байна	8.7
Эвсэн нэгдэж зохион байгуулалтад орж чадахгүй байна	4.7
Тэд улс төрд өөрийн хүрээлэл, багийг бүрдүүлж чадахгүй байна	5.7
Бусад хүчин зүйл	45.1
Улс төрийн хүчнүүдэд эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд оролцуулах сонирхол бага байна	30.4
Эмэгтэйчүүдийг үнэлэх, дэмжих, нийгэм сэтгэл зүйн уур амьсгал доогуур түвшинд байна	14.3
Мэдэхгүй	0.4
Нийт	100.0

Эх үүсвэр: Төрийн албаны зөвлөлийн ажлын алба, Төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн, хөдөлгөөний статистикийн тойм, 2010. "Монгол дахь ардчилсан засаглалын төлөв байдал" Судалгааны тайлан, 2010.

Судалгааны дээрх мэдээллээс харахад нэгдүгээрт, эмэгтэйчүүдийн өөрсдийнх нь хүсэл сонирхол, хичээл зүтгэл сул байгаагаас, хоёрдугаарт, эмэгтэйчүүдийг улс төрд оруулах сонирхол

улс төрийн намуудад бага байдаг нь гол хүчин зүйл болж байна. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь ямар ач холбогдолтой болох тухайд судалгаанаас дараахь дүр зураг харагдаж байна.

Хүснэгт 12. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх шалтгаан

Зан чанар талаас нь үнэлсэн үнэлгээ	Хувь
Юмыг олон талаас нь бодож чаддаг ухаалаг, аливаад мэдрэмжтэй ханддаг	16.3
Амьдрал авч явах чадвартай байдаг	10.0
Шударга байж чадна	16.7
Эрэгтэйчүүдээс илүү боловсролтой	2.6
Эрэгтэйчүүдийн олж чадаагүйг харж чаддаг	4.1
Юманд дайчин, шийдэмгий ханддаг, шийдвэр гаргахдаа сайн	4.5
Хүнлэг	0.4
Эмэгтэйчүүд шийдвэр гаргахдаа зарчимч байдлаар ханддаг	3.7
Оролцоо талаас нь үнэлсэн үнэлгээ	Хувь
Улс төрд эмэгтэйчүүдийн оролцоо маш муу байна тиймээс нэмэгдүүлэх хэрэгтэй	12.6
Жендэрийн тэгш байдлыг хангах нь чухал	21.9
Эмэгтэйчүүд олон бол төр цэвэр байна	1.5
Улс орны хөгжилд хэрэгтэй	1.1
Иргэдийн төлөө ажиллах бол хэнийг ч дэмжинэ	0.4
Аль чадвартай нь сонгогдох боломжтой	0.4
Мэдэхгүй	0.4

Эх үүсвэр: "Монгол дахь ардчилсан засаглалын төлөв байдал" судалгааны тайлан. 2010.

Эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшинд оролцоо оролцоог нэмэгдүүлэхийг дэмждэггүй гэсэн байр суурийг судалгаанд оролцогчдын маш цөөн хувь буюу ердөө 5.7 хувь нь илэрхийлжээ.

Мөн судалгаанаас харахад, эмэгтэйчүүдийг төрийн дунд болон дээд шатны албан тушаалд ажиллуулах

боломжтой гэж судалгаанд оролцогчдын 66.5 хувь нь үзсэн байна.

Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог дээшлүүлэх тухай асуудлыг ихэнхи тохиолдолд парламент дахь тэдний хувь хэмжээгээр ойлгож, түүнийг нэмэгдүүлэхийн төлөө эмэгтэйчүүдийн

төрийн бус байгууллагууд идэвхитэй ажилладаг. Парламентад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлснээр нийгэм, улс төрийн ач холбогдол нь юу байх вэ гэдэг талаар судалгаанд оролцогчдоос 16.7 хувь нь шударга, найр тавихгүй ажиллана, 12.3 хувь нь хүйсийн тэгш байдлыг олгох шаардлага хангагдана гэсэн байна.

Авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ

“Монгол Улсын Үндсэн хууль”, “УИХ-ын сонгуулийн тухай”, “Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай”, “Төрийн албаны тухай” зэрэг холбогдох хуулиудад эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийг хэрэгжүүлэх, шийдвэр гаргах түвшний оролцоог нэмэгдүүлэх эрх зүйн орчин бүрдсэн гэж үзэж болно. Зорилт 7-д дурьдсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд квоттой холбоотой зарим заалтыг 2013-2016 онд үе шаттай хэрэгжүүлэхээр тусгасан байна. Тухайлбал, улс төрийн нам өөрийн удирдах байгууллагад хүйсийн тэгш байдлыг дор хаяж 75:25 гэсэн харьцаагаар зохицуулах, Төрийн албанд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 15-40 хүртэл шаталсан байдалтай байх, түүнчлэн Засгийн газрын танхимын бүрэлдэхүүн буюу улс төрийн албан тушаалтны 15 хувь нь эмэгтэйчүүд байх зэрэг эрх зүйн тодорхой зохицуулалт шаардлагатай байна.

Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуульд төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байна гэж хуульчлан тусгаснаар хөдөлмөрөө шударгаар үнэлүүлэх, шийдвэр гаргах эрх мэдэл бүхий удирдах албан тушаалд эрэгтэйчүүд давамгайлж буйг багасгаж жендэрийн тэгш байдлыг хангах хууль, эрх зүйн зохицуулалт бий болгох шаардлагатай байна.

Түүнчлэн “Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр”-ийн зорилтыг хэрэгжүүлэх 3 дугаар үе шатны /2009-2012/ үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдлаа.¹⁸ Төлөвлөгөөг Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтод тулгуурлан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”, салбарын хүрээнд хэрэгжүүлж байгаа бодлого үйл ажиллагаа болон бусад бодлого, хөтөлбөртэй уялдуулсан байна.

Одоо энэ хөтөлбөр, төлөвлөгөөг амьдрал дээр үр дүнтэй хэрэгжүүлэх ажил хойшлуулашгүй зорилт болж байна.

Тулгамдаж буй асуудал

Эмэгтэйчүүдийн улс төрийн тэгш эрх, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих хууль, эрх зүйн орчин гүйцэд бүрдээгүй байна. УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх сонирхол, улс төрийн хүсэл эрмэлзэл, мөн нийгмийн сэтгэл зүй хараахан бий болж чадаагүй байна.

Сонгуулийн, ялангуяа УИХ-ын сонгуулийн тогтолцоо боловсронгуй бус байна. Мажоритари тогтолцоонд суурилсан томсгосон тойргоор явагдсан сонгуулийн компани ажил 26 хоног үргэлжлэхэд санхүүгийн нөөц, хөрөнгө их шаардагддаг байна.

Цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан квотыг хэрэгжүүлэхэд бэлтгэл, цаг хугацаа хэрэгтэй учраас Засгийн газар 2016 он хүртэл хугацаанд эмэгтэй боловсон хүчин, хүний нөөцийн чадавхи бүрдүүлэхэд чиглэсэн тодорхой бодлого гарган хэрэгжүүлэх;
- “Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийн зорилтыг хэрэгжүүлэх 3 дугаар үе шатны (2009-2012) үйл ажиллагааны төлөвлөгөөнд¹⁹ гэр бүлийн болон нийгмийн амьдралд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гүйцэтгэж байгаа үүргийн талаар олон нийтийн хэвшмэл ойлголт, хандлагад нөлөөлөх, сэтгэл зүйг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;
- Эмэгтэйчүүдийг улс төрд оролцох сонирхлыг дээшлүүлэхийн тулд тэдний гэр орон, үр хүүхдүүд, гэр бүлийнхээ төлөө зарцуулах цагийг багасгах, нийгмийн үйлчилгээ үзүүлдэг үйлчилгээний байгууллагуудыг бий болгох, дэмжихэд чиглэсэн төрийн бодлого үйл ажиллагааг идэвхижүүлэх;

18 Занāāēēī āāāāī 2010 īīī 91 ā.ā.ā.ā.ā.ā.ā.ā.ā.ā. ā

19 Занāāēēī āāāāī 2010 īīī 91 ā.ā.ā.ā.ā.ā.ā.ā.ā.ā. ā

- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгмийн амьдралд тэгш оролцох хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийг батлуулж, хэрэгжүүлэх ажлыг эрчимтэй зохион байгуулах;
- Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийг хангах, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих зорилгоор “УИХ-ын сонгуулийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, сонгуульд нэр дэвшигчдийн дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь тогтоох, төрийн өндөр албан тушаалын томилгоонд эмэгтэйчүүдийг дэмжих механизм бий болгох;
- Олон нийтийн дунд түгээмэл байгаа жендэрийн хэвшмэл ойлголтыг даван туулахад чиглэсэн ухуулга, сурталчилгааг өргөжүүлэх, эмэгтэйчүүдийн улс төрд өрсөлдөх чадварыг сайжруулж, туршлагажуулах зэрэг алсдаа үр дүнд хүргэх үйл ажиллагааг тасралтгүй үргэлжүүлэх;
- Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд тэнд ажиллаж байгаа эрэгтэйчүүдийн хүчин чармайлтаас гадна иргэний нийгмийн болон эмэгтэйчүүдийн эвсэл хөдөлгөөнүүдийн нэгдмэл байр суурь, хамтын ажиллагааг хангах.

Жендэрийн тэгш байдлыг дэмжин хөгжүүлж шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх Мянганы хөгжлийн гурав дахь зорилгын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг Улсын Их Хурлаар баталсан бөгөөд энэ шалгуураар уг зорилго хэрэгжих бололцоо одоогоор харагдахгүй байна. Харин бодлого, эрх зүйн суурь орчин бүрдсэн гэж үзэж болох юм.



ЗОРИЛГО ДӨРӨВ

ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙГ БУУРУУЛАХ



ЗОРИЛГО 4

ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙГ БУУРУУЛАХ


ЗОРИЛТ 9. ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙГ 1990 ОНТОЙ ХАРЬЦУУЛАХАД 2015 ОН ГЭХЭД 4 ДАХИН БУУРУУЛАХ

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Тав хүртэлх насны хүүхдийн 1000 амьд төрөлт тутамд ногдох эндэгдэл 2000 оноос эхлэн тогтвортой буурч 2007 онд 22-т хүрсэн бол, 2008, 2009 онуудад 24, 2010 онд 26 болж бага зэрэг нэмэгдсэн байна. Нялхсын эндэгдлийн түвшин улсын хэмжээгээр 1000 амьд төрөлт тутамд

1990 онд 64 байсан бол 2010 онд 19.3 болж эрс буурсан байна. Харин 2008 онд 17.8, 2009, 2010 онд 20 болж өсчээ. Хангайн болон Баруун бүсэд тав хүртэлх насны хүүхдийн, нялхсын эндэгдэл улсын дунджаас харьцангуй өндөр байна. Улаан бурханы эсрэг вакцинжуулалтад хамрагдсан нэг хүртэлх насны хүүхдийн хувийн жин 2010 оны байдлаар 96.9 хувь байна. Энэ үзүүлэлт 1994 онд хамгийн бага буюу 80.1 хувьтай байсан юм.


Дүрслэл 11. Нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 1990-2010



Сүүлийн 20 жилийн хугацаанд Монгол Улсын нялхсын болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин тогтвортой буурч байгаа бөгөөд Мянганы Хөгжлийн Зорилтоо 2015 онд хангах боломж бүрэн байна.

Монгол Улсын Засгийн газар дээрх хүрсэн амжилтаа бататган МХЗ-ууд дахь тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 2015 онд 21.0, нялхсын эндэгдлийн түвшинг 15.0 хүртэл бууруулах зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Дүрслэл 12. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин



Хүүхдийн эндэгдлийг бууруулахад юуны өмнө бага насны хүүхдэд зонхилон тохиолддог урьдчилан сэргийлэх боломжтой бүх өвчнүүдийг бууруулах, эдгээрээс шалтгаалсан эндэгдлийг багасгахад төр засгаас нэгдсэн хөтөлбөр зохицуулалттай ажиллаж байна:

- 1990 оноос Эрүүл мэндийн яамнаас ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгээр амьсгалын цочмог халдвар, суулгалт өвчнийг хянах хөтөлбөрийг үндэсний хөтөлбөр болгон амжилттай хэрэгжүүлж, улмаар 2000 оноос “Хүүхдийн өвчний цогц менежмент” (ХӨЦМ) хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хэрэгжүүлж хандивлагч, түншлэгчдийн хүчийг төвлөрүүлэн, хамтын ажиллагааг зохистой өргөжүүлсний үр дүнд бага насны хүүхдийн эндэгдэлд зонхилох шалтгаан болж байсан цочмог суулгалт өвчнөөр эндэх эндэгдэл үгүй болж, хатгалгаа өвчнөөр эндэх нь 3 дахин буурсан байна.
- Дархлаажуулалтын хамралтыг сайжруулснаар хүүхдэд тохиолддог урьдчилан сэргийлэх боломжтой халдварт өвчин буурч, түүнээс шалтгаалдаг эндэгдэл эрс цөөрчээ. Улаан бурхны эсрэг дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн дундаж хувь 2010 онд 96.9 байгаа боловч хөдөө орон нутагт 93 орчим хувийн хамралттай байна.
- Хүүхдийг эхийн сүүгээр хооллох бодлогыг эрчимжүүлсний үр дүнд хоол тэжээлийн дутлыг бууруулж улмаар хүүхдийн тураал аажмаар буурч байгаа нь хүүхдийн эндэгдэл буурахад нөлөөлсөн бөгөөд хүүхдийг 6 сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллох хооллолтын түвшин 79 хувь²⁰ байна.

Хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ

Монгол Улсын Засгийн газраас 2002 онд батлан хэрэгжүүлсэн “Хүүхэд хөгжил-хамгаалал 2002-2010” Үндэсний хөтөлбөрт Мянганы хөгжлийн зорилгыг хангахад шаардлагатай хүүхдийн эсэн мэнд амьдрах, боловсрох, эрхийг хамгаалахад чиглэсэн олон талт асуудлыг тусгасан бөгөөд уг хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүллээ.

2000 оноос аймаг, дүүргийн хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн зөвлөгөөнийг жил бүр тогтмол зохион байгуулж, хүүхдийн эндэгдэлд нөлөөлж буй хүчин зүйл, шалтгаанд дүгнэлт хийж, цаашдын зорилтыг тодорхойлж хэвшүүлсний үр дүнд хүүхдийн эсэн мэнд амьдрахуйн шалгуур үзүүлэлтүүдийг тогтмол хянадаг боллоо.

2000 оноос “Хүүхдийн өвчний цогц менежмент” хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж байгаа бөгөөд хүүхдэд эрүүл мэндийн тусламж үзүүлэх ур чадвар болон эцэг, эх, гэр бүлийн гишүүдийн хүүхэд асран хамгаалах дадал зуршлыг сайжруулах, эрүүл мэндийн байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж ирснээр 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл тууштай буурч байна. Хүүхдийн өвчний цогц менежмент (ХӨЦМ) хөтөлбөрт эрүүл мэндийн байгууллагууд 100 хувь, хүүхдэд тусламж үзүүлдэг эрүүл мэндийн ажилтнуудын 85 хувь хамрагдсан байна.

ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр “Нярайн нэн шаардлагатай тусламж” төслийг аймаг, сум, өрхийн эмнэлгүүдэд хэрэгжүүлж, эх баригч, нярайн эмч, сувилагч, өрх сумын эрүүл мэндийн ажилтнуудыг хамруулжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Эрүүл эхээс эрүүл хүүхэд” зарчмыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүх шатанд хэрэгжүүлэхээр заасан бөгөөд эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн бодитой арга хэмжээнүүдийг авч байна. Тухайлбал: Эх, хүүхдийн тусламжид зайлшгүй шаардлагатай 2.0 тэрбум орчим төгрөгийн эм, багаж тоног төхөөрөмжийг эмнэлгүүд, амаржих газруудад олгосон байна.

2009 онд “Нярайн сэхээн амьдруулахуй” төслийн хүрээнд Монгол Улсын бүх сумын эмнэлэг болон амаржих газруудыг нярайн сэхээн амьдруулагч багажаар ханган, нярайн 72 эмчийг нярайн сэхээн амьдруулах арга барилд сургаж.

2010 онд “Хүүхдэд эрэмбэлэн ангилах, яаралтай тусламж үзүүлэх” сургалтыг бүх аймгийн эмч нарыг хамруулан зохион байгуулж, аймгийн нэгдсэн эмнэлэг, сумдын эмнэлгүүдийг нэн шаардлагатай багаж тоног төхөөрөмж, эмээр хангаад байна.

20 Н"Ү"Г Үндэсний үйлдвэр, үйлдвэрлэл, 2008

Монгол Улсын Засгийн газар 2010 оны 9 сард НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын “Эмэгтэйчүүд хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах глобал стратеги”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд эх, хүүхдийн эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг эрс нэмэгдүүлж, улсын төсвөөс шинээр амаржих газар байгуулахад 19 тэрбум төгрөг төсөвлөж түрүүчээс нь санхүүжүүлж байна.

Хүүхдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулахад Засгийн газар болон олон улсын байгууллагын санхүүжилтийг нэмэгдүүлсний үр дүнд 3 хүртэлх насны бүх хүүхдийг Д аминдэмээр, 5 хүртэлх насны хүүхдийг А аминдэмээр 100 хувь хангаж, олон найрлагат бичил тэжээлээр хангах асуудлыг үе шаттай шийдвэрлэн, 5 хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн архаг дутлыг 2 дахин бууруулах боломжтой болж байна.

Тулгамдаж буй асуудал

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж нь газар зүйн байрлал, шилжилт хөдөлгөөнөөс хамааралтайгаар харилцан адилгүй байна. Оршин суугаа газартаа бүртгэлгүйгээс эрүүл мэндийн даатгалаас зардал авч чадахгүй тохиолдол цөөн биш, дэд бүтэц сул хөгжсөн хөдөөгийн алслагдсан нутагт оршин суугчдын тусламж, үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал байна.

Хөдөөгийн сумдад амьдарч буй 1.0 сая гаруй иргэдийн 67.1 хувь нь малчид бөгөөд тэдний 35 хувь нь төв суурин газрын эрүүл мэндийн байгууллагаас 50-80 км, 65 хувь нь 14 км-ээс хол зайд амьдарч байна. Энэ нь хот, хөдөөд эрүүл мэндийн үйлчилгээний тэгш бус байдал гүнзгийрэхэд нөлөөлж байдаг. Хүн амын амьдралын түвшин, хот хөдөөгийн тэгш бус байдал, төвөөс хэт алслагдсан нөхцөл нь ялангуяа, хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг бууруулахад хүргэж байна.

Эмнэлгийн тусламж авч чадахгүй гэртээ нас барах явдал гарсаар байгаа бөгөөд үүнд төвөөс алслагдсан, дэд бүтэц хөгжөөгүй, яаралтай тусламжийн бэлэн байдал хангалтгүй болон гэнэтийн осол, гэмтэл, эцэг, эх, гэр бүлийн гишүүдийн хүүхэд асран хамгаалах дадал хэвшилийн дорой байдал нөлөөлж байна. Ийм

байдлаар нас барж буй 5 хүүхэд тутмын нэг нь эмнэлгийн тусламж авч амжихгүй байгаад дүгнэлт хийн онцгой анхаарах шаардлагатай байна.

Сүүлийн гурван жилийн хугацаанд нэг хүртэлх насны хүүхдийн нас баралтын шалтгаанд эрт нярайн эндэгдэл, амьсгалын тогтолцооны өвчин эхний байруудыг эзлэж байна. Нярайн эрт амлалтын хувь 81.0 байна. Нялхсын эндэгдлийн 12.4 хувийг төрөлхийн эмгэг согог эзэлж байна.²¹

Перинатал үеийн эндэгдэл 1000 амьд төрөлтөнд 16.91, нярайн эндэгдэл 12.64 байгаа ба эндэгдлийн шалтгаанд перинатал үеийн эмгэг 51.9 хувийг эзэлж, нярайн нийт нас баралтын 75 хувь нь амьдралын эхний 7 хоногт тохиолдож байна. Нярайн нас баралтын зонхилох шалтгаанд бүтэлт 53 хувь, халдвар 18.5 хувь, төрөлхийн гаж хөгжил 12.2 хувь байна.²² Нярайн төрөлхийн гажиг хөгжлийн шалтгаант эндэгдэл нэмэгдэж байгаа тул ураг нярайн оношлогоо, эмчилгээг орчин үеийн түвшинд гаргаж, эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах, перинатал тусламж, үйлчилгээний төв байгуулах шаардлага урьдын адил чухал хэвээр байна.²³

Төрөлт нэмэгдэж байгаа ч хүүхдийн эндэгдэл бага зэрэг өсөх хандлагатай байгаа нь нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг цогцоор нь хөгжүүлж, шаардлагатай арга хэмжээ авах ёстойг харуулж байна.

Байгалийн гамшиг, агаар, хөрсний бохирдол, ахуйн болон бусад осол гэмтэл, ариун цэвэр, эрүүл ахуйн хангамжийн сул дорой байдал зэрэг нь хүүхдийн эрүүл мэнд, тэдний эсэн мэнд амьдрахад сөргөөр нөлөөлж байна. Ядуу иргэдийн хувьд ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд амьдарч чадахгүй байна. Ариун цэврийн байгууламжийн хүрэлцээ хотод 64 хувь, хөдөө орон нутагт 31 хувьтай байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн бүртгэлээс үзэхэд осол гэмтлийн төрлүүдээс ахуйн осол голлож байгаа бөгөөд нийт осол гэмтлийн 28.2 хувьд 16 хүртэлх насны хүүхдүүд өртөж байна.

21 Child survival profile Mongolia, 2009, 15-p мал.

22 Эдгээр үйлдвэрлэлүүд нь 2009, 69-д өгөгдөлт.

23 МҮЯАИИ 5-аа өгөгдөл зиддөө өгөгдөл, Үйлдвэрлэл, 2009, 52-д өгөгдөл.

Бүс, аймгийн түвшинд нялхас, хүүхдийн эндэгдлийн түвшин харилцан адилгүй байна. Тухайлбал, Увс, Завхан, Говь-Алтай, Архангай, Өвөрхангай, Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар, Хэнтий аймгуудад улсын дунджаас дээгүүр байна.

Цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ

- Хөдөө, хот, суурин газарт үзүүлж байгаа эмнэлгийн тусламж, үйлчилгээний ялгаатай байдлыг багасгах ажлыг эрчимжүүлэх, эндэгдлийн зонхилох шалтгаан болж байгаа жирэмсний үеийн эмгэг, амьсгалын тогтолцооны эмгэг, төрөлхийн гажиг хөгжлийн эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, эрт үеийн оношилгоо хийх чадавхийг нэмэгдүүлэх;
- Нэн шаардлагатай тусламж үзүүлэх чиглэлээр бүх шатны эрүүл мэндийн байгууллагад орчин үеийн эмчилгээ оношилгооны техник, технологийг нэвтрүүлэх, тэдгээрийг ашиглах хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэхэд төр, эрүүл мэндийн байгууллага, олон улсын төсөл хөтөлбөрийн хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Сүүлийн жилүүдэд хүн амын төрөлт 15-18 хувь өссөн боловч төрөх эмнэлгийн барилга, ор, төсөв, төрөхийн эмч мэргэжилтнүүдийн орон тоо өмнөх онуудаас нэмэгдээгүй байгаад дүгнэлт хийж, ялангуяа төрөх эмнэлэг, эмч мэргэжилтэний тоог нэмэх хэрэгтэй;

- Жирэмсэн, төрөх, төрсний дараахь үеийн хүндрэл, нярайн болон ургийн гаж хөгжлийг эрт оношлох, эмчлэх орчин үеийн багаж төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх;
- Хот хөдөөгийн тусламжийн ялгаатай байдлыг арилгахын тулд хөдөөд ажиллах, эх хүүхдийн чиглэлээр хүний нөөцийг нэмэгдүүлж, техник дэд бүтцийг эрс сайжруулах;
- Хүүхдийн эсэн мэнд өсөн торниход зайлшгүй шаардлагатай багцыг хэрэгжүүлэхэд салбар дундын хамтын ажиллагааг өргөтгөх, үндэсний чадавхийг бэхжүүлэх олон улсын түншлэгчдийн менежментийг боловсронгуй болгох асуудал зүйн чиглэлээр бодлогын төвшинд шийдвэр гаргаж хэрэгжүүлэх;
- Хүүхдийн эмч нарыг бэлтгэх, сургах мэргэжил дээшлүүлэх асуудалд онцгой анхаарах.

Хүүхдийн эндэгдлийг бууруулах мянганы хөгжлийн дөрөв дэх зорилгын хэрэгжилтийг хянах гол шалгуур үзүүлэлт нь 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 4 дахин бууруулсан байх явдал юм. Одоогийн байдлаар энэ шалгуур үзүүлэлтийг 2015 он гэхэд хангах боломж байна. Үүний тулд дээр дурьдсан арга хэмжээг цаг алдахгүй авах хэрэгтэй байна.



ЗОРИЛГО ТАВ

ЭХЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ
САЙЖРУУЛАХ



ЗОРИЛГО 5

ЭХЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ САЙЖРУУЛАХ

ЗОРИЛТ 10. *НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ШААРДЛАГАТАЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮН БҮРТ ХҮРГЭЖ, ЭХИЙН ЭНДЭГДЛИЙГ 1990 ОНТОЙ ХАРЬЦУУЛАХАД 2015 ОН ГЭХЭД 4 ДАХИН БУУРУУЛАХ*

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Эхийн эндэгдэл 1990-2000 оны үетэй харьцуулахад сүүлийн жилүүдэд ихээхэн буурч, 100,000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 2008 онд 49.0, 2009 онд 81.0, 2010 онд 47.4 болж бууран, 1990 оны түвшингээс бараг дөрөв дахин бага болж, 2005 оны түвшинтэй харьцуулахад 2 дахин буурч, 2015 онд хүрэхээр төлөвлөсөн (50.0) Мянганы хөгжлийн зорилтын түвшинд хүрч, Монгол улс эхийн эндэгдэл өндөртэй орноос эхийн эндэгдэл дунд зэрэгтэй орны түвшинд шилжээд байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч НҮБ-ын Ерөнхий чуулганы индрээс “Монгол улс эхийн эндэгдлийг бууруулах зорилтоо хэрэгжүүлж, Мянганы хөгжлийн зорилтондоо хүрэх магадлал өндөртэй орон” гэж дүгнэсэн.

2010 оны эхийн эндэгдлийн шалтгааныг авч үзвэл 50.0 хувь нь эх барихын бус, 43.3 хувь нь эх барихын, 6.6 хувь нь бусад шалтгаант нас баралт байна. Эх барихын бус шалтгаанд халдварт өвчин, ялангуяа сүрьеэ, элэгний цочмог үрэвсэл, мөн зүрх судасны болон амьсгалын замын эмгэг, хорт хавдар өвчний улмаас нас барах тохиолдол өндөр байна.

Гэвч эхийн эндэгдэл 2009 онд огцом өссөн бөгөөд тус онд дэгдсэн H1N1 томуугийн цар тахлын тархалтын үеэр нийт 17 жирэмсэн эх амьсгалын дутагдлын хам шинжийн хүндрэлээр нас барж, эхийн эндэгдлийг нэмэгдүүлсэн байна. Эдгээр эхчүүдийн 4 тохиолдол нь лабораторийн шинжилгээгээр томуугийн A(H1N1) вирусн халдвар авсан нь нотлогджээ.

Хүснэгт 13. Эхийн эндэгдэл, эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлт

Шалгуур үзүүлэлт	2007	2008	2009	2010	2015*
Эхийн эндэгдлийн түвшин (100 мянган амьд төрөлт тутамд)	88	49	81.0	47.4	50.0
Эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь	99.8	99.8	99.8	99.8	99.8

*-Зорилтод түвшин
Эх үүсвэр: ҮСХ

Эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь манай улсад 2010 онд 99.8 хувь


байгаа нь өндөр үзүүлэлт бөгөөд 2015 онд хүрэх ёстой түвшиндээ хүрсэн байна.

Хүснэгт 14. 100000 амьд төрөлт бүрт нас барсан эхийн тоо, эхийн эндэгдлийн түвшин

Жил	Амьд төрөлт	Нас барсан эхийн тоо	Эхийн эндэгдлийн түвшин
2000	48721	81	158.5
2001	49684	82	169.3
2002	46922	57	124.8
2003	45723	49	109.5
2004	45501	44	98.8
2005	45326	42	93
2006	49092	33	69.7
2007	56636	50	89.7
2008	63768	31	49.9
2009	69167	56	81
2010	63270	30	45.5

Эхийн эндэгдэл буурч байгаа ч эхийн эндэгдлийн үзүүлэлтэд хот, хөдөөгийн болон баян, ядуугийн ялгаа их байна. Тухайлбал, эхийн эндэгдлийг газарзүйн бүсээр нь авч үзэхэд асар их ялгаатай, алслагдсан бүс нутгуудад харьцангуй өндөр байна. Эхийн эндэгдлийн сүүлийн таван жилийн дунджийг бүс нутгаар авч үзэхэд Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Ховд, Сүхбаатар, Хэнтий, Дундговь, Өмнөговь, Төв аймгуудад эндэгдлийн түвшин улс болон аймгийн дунджаас өндөр байна.

Дүрслэл 13. Эхийн эндэгдлийн түвшин



Эх үүсвэр: ҮСХ

Эхийн эндэгдлийн бүтцийг авч үзвэл эх барихын шалтгаантай нас баралт буурч байна. Энэ нь эх барихын гол хүндрэл болох цус алдалт, цусны даралт ихэсч татах зэрэг хүндрэлүүдийн үед үзүүлэх тусламж, үйлчилгээний стандарт, жишиг боловсруулан, улсын хэмжээнд мөрдүүлж, эмч мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулсны үр дүн гэж үзэж байна. Гэвч эх барихын бус шалтгаантай

нас баралт буурахгүй байгаа нь эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдал муу, жирэмсний хяналтын чанар сул байгаатай холбоотой байна. Ялангуяа эмэгтэйчүүдийн суурь өвчнийг эрт илрүүлж, эмчлэх, тэднийг жирэмслэхээс өмнө эрүүлжүүлэх асуудалд онцгой анхаарах шаардлагатай байна.

Эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах ажил дан ганц эрүүл мэндийн салбарын асуудал биш болоод байгаа нь улам тодорхой болж байна. Эхийн эндэгдэлд нөлөөлсөн хожимдлоор авч үзвэл “Эмэгтэй, түүний гэр бүлийн гишүүд жирэмсэн үеийн аюултай шинж тэмдгийг мэдэж, эрт таних, тусламж хайх мэдлэг дутагдах явдал” нийт нас баралтын 1/3-д нөлөөлж байгаа юм. Иймд энэ чиглэлээр их ажил хийх, уг үйл ажиллагаанд орон нутгийн шийдвэр гаргагчид идэвх санаачлагатай ажиллах, нийгмийн бүхий л нөөц, бололцоог дайчлах хэрэгцээтэй байна. Мөн “Зам харилцаа, холбоо, дэд бүтцийн байдал, цас зуд”-аас шалтгаалсан нас баралт нийт эндэгдлийн тав гаруй хувийг эзэлж байна. Иймд салбар хоорондын уялдааг хангах, дэд бүтцийг хөгжүүлэх, иргэний засаг захиргааны бүртгэлийг сайжруулах явдал чухал юм.

Манай улсын нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 46 хувь нь эрхтэн тогтолцооны ямар нэг суурь өвчтэй байгаа нь 10 жилийн өмнөхтэй харьцуулахад 40 хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм. Эрхтэн тогтолцооны хавсарсан өвчин нь эхэд жирэмсэн төрөлттэй холбоотой хүндрэл үүсэх эрсдлийг үлэмж нэмэгдүүлдэг ба 2009 онд 43 мянга гаруй эмэгтэйд жирэмслэл,

төрөлттэй холбоотой хүндрэл бүртгэгдсэн нь 1000 амьд төрөлт тутмын 634 нь ямар нэгэн байдлаар хүндэрсэн гэсэн үг юм.

Үр хөндөлтийн түвшин 2003 онд 1000 амьд төрөлтөнд 234 байсан бол 2010 онд 189 болж буурчээ. Гэвч үр хөндөлтийн шалтгааныг авч үзэхэд 24 хувь нь эрүүл мэндийн шалтгаанаар, бусад 76 хувь нь одоогоор хүүхэд төрүүлэх хүсэлгүй, санхүүгийн боломжгүй, нас ахьсан, олон хүүхэдтэйн улмаас зэрэг шалтгаанаар үр хөндүүлсэн байна. Өсвөр насны охидын 8.2 хувь нь хүүхэд төрүүлж байна²⁴.

2008 оны судалгаагаар (дараагийн судалгаа хараахан хийгдээгүй байгаа) эмнэлгийн яаралтай тусламжийг утсаар дуудлага дуудах хувь хотод 96 байхад хөдөөд 34.7 байна. Хөдөө орон нутагт эмнэлгийн яаралтай дуудлагын 38.8 хувийг машин, мотоциклаар, 6.5 хувийг ердийн хөсгөөр, 19.9 хувийг явганаар үзүүлж байна.

2010 онд жирэмсний хяналтанд байгаа эмэгтэйчүүдийн 93.0 хувь нь цус, шээсний шинжилгээнд, давхардсан тоогоор 61.8 хувь нь рентген шинжилгээнд, 68 хувь нь ХДХВ/ДОХ-ын шинжилгээнд, 88.2 хувь нь тэмбүүгийн сорилд тус тус хамрагджээ.

Авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ

Төрөлтийг дэмжих бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлсний дүнд сүүлийн жилүүдэд төрөлт нэмэгдэх хандлагатай байна. Эрүүл мэндийн сайдын 2010 оны 456 дугаар тушаалаар “Эх, нярайн эрүүл мэнд 2011-2015” Үндэсний стратегийг боловсруулан батлаж, эх, нярайн өвчлөл эндэгдэлд нөлөөлж буй тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагаануудыг төлөвлөн хэрэгжүүлж эхлээд байна.

НҮБ-ын Хүн амын сантай хамтран “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран “Эх, нярайн эрүүл мэнд”, ДЭМБ-тай хамтран “Аюулгүй жирэмсэлт” төслүүдийг хэрэгжүүлж байгаа нь Мянганы хөгжлийн зорилтыг хангахад тодорхой хувь нэмэр оруулж байна²⁵.

Эхийн амрах байруудыг сэргээн засварласан нь жирэмсний хүндрэлтэй, жирэмсэлт, төрөлтийн эрсдэл өндөртэй хөдөө орон нутгийн эхчүүд, аймаг, хотын эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлийн тусламж үзүүлэх чадавхитай эмнэлэгт ойр байж мэргэжлийн тусламж, үйлчилгээнд түшиглэн эсэн мэнд амаржих нөхцөлийг бүрдүүлэв. Сум, багт амьдарч байгаа эрсдэлтэй эхчүүдийг (60-80 хувь) аймаг, хотын амаржих газарт шилжүүлэн амаржуулж байгаа нь эхийн эндэгдлийг бууруулахад зохих хувь нэмрээ оруулж байна²⁶.

Эрүүл мэндийн үйлчилгээний стандарт, удирдамжуудыг бүх шатны тусламж, үйлчилгээ үзүүлэгч нарт хүргэж, сургалт зохион байгуулсан нь тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад ач холбогдолтой болов²⁷. “Амаржих газрын бүтэц, үйл ажиллагааны стандарт” MNS 2010/6188 үндэсний стандартыг батлан мөрдөж эхэлсэн нь эх, нярайд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг дээшлүүлэхэд чухал ахиц боллоо.

“Эхийн эндэгдлийг бууруулах нь” сэдэвт Үндэсний зөвлөлдөх уулзалтыг 2009 оноос эхлэн жил бүр зохион байгуулж, зөвлөмж гарган, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрууд эхийн эндэгдлийг бууруулах чиглэлээр орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газраас НҮЭМ-ийн үйлчилгээг нэн шаардлагатай эм, хэрэгслээр хангахад зориулж 2009 онд 85 сая, 2010 онд 100 сая төгрөгийг төсөвт тусган зарцуулав. Мөн НҮБ-ын Хүн амын сангийн шугамаар шаардлагатай тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан байна.

Эмзэг бүлгийн хүн амд шаардлагатай нөхөн үржихүйн эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоог хийж, НҮБ-ын Хүн амын сангаас жил бүр 300.0 мянган ам.долларын эм, хэрэгслийг авч байна. НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран “Эх, нярайн эрүүл мэнд” төслийн хүрээнд 2009-2010 онд эх,

24 НҮЭМ-ээйи нᠠᠶᠠᠳᠠᠳᠠ 2008, 29-30-᠔ ᠠᠶᠢᠰᠠ.

25 Мᠢᠶᠠᠳᠠᠳᠠ ᠰᠢᠳᠠᠳᠠ ᠠᠶᠢᠰᠠ ᠰᠢᠳᠠᠳᠠᠳᠠ, 2009, 55-᠔ ᠠᠶᠢ.

26 Эᠳᠠᠳᠠᠳᠠᠳᠠ ᠶᠠᠳᠠᠳᠠᠳᠠ ᠠᠶᠢ, ᠶᠢᠳᠠᠶᠢ ᠶᠢ ᠰᠠᠳᠠ ᠠᠶᠠᠳᠠᠳᠠᠳᠠ ᠠᠶᠢ ᠠᠶᠢᠶᠢᠶᠢᠶᠢ
ᠶᠢᠶᠢᠶᠢᠶᠢ ᠠᠶᠠᠶᠠᠳᠠᠳᠠ, ᠰᠢᠳᠠᠳᠠᠳᠠᠳᠠᠳᠠ ᠶᠢᠶᠢᠶᠢᠶᠢ, 2010, 24-᠔ ᠠᠶᠢ.

27 Эᠳᠠᠳᠠᠳᠠᠳᠠ ᠶᠠᠳᠠᠳᠠᠳᠠ ᠠᠶᠢ, ᠶᠢᠳᠠᠶᠢ ᠶᠢ ᠰᠠᠳᠠ ᠠᠶᠠᠳᠠᠳᠠᠳᠠ ᠠᠶᠢ ᠠᠶᠢᠶᠢᠶᠢᠶᠢ
ᠶᠢᠶᠢᠶᠢᠶᠢ ᠠᠶᠠᠶᠠᠳᠠᠳᠠ, ᠰᠢᠳᠠᠳᠠᠳᠠᠳᠠᠳᠠ ᠶᠢᠶᠢᠶᠢᠶᠢ, 2010, 24-᠔ ᠠᠶᠢ.

нярайн эрүүл мэндэд нэн шаардлагатай 200.0 мянган ам.долларын багаж, тоног төхөөрөмжийг зуд тохиолдсон аймгуудад хуваарилж, 12 аймгийн нэгдсэн эмнэлгийн эхийн амрах байрыг тохижуулав.

2010 онд ДЭМБ-тай хамтран богино хугацааны төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, бүсийн оношлогоо эмчилгээний төвүүд болон ураг, нярайн эндэгдэл өндөртэй аймгийн нэгдсэн эмнэлгүүдийг эх, нярайд нэн шаардлагатай 50 мянган ам.долларын үнэ бүхий багаж, хэрэгслэлээр хангалаа.

Хүсээгүй жирэмслэлт, аюултай үр хөндөлтийг бууруулах, үр хөндөлтийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор “Үр хөндөлтийн тусламж үйлчилгээг зохицуулах журам” мөрдүүлж эхэлсэн.

“Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамж” үндэсний стратегийг 2009 онд баталж, НҮЭМ-ийн эм, хэрэгслийн хангамжийг тогтворжуулах асуудлаар томоохон ахиц гарав. 2009 онд анх удаа улсын төсөвт НҮЭМ-ийн эм, хэрэгслийн зардалд 85 сая төгрөгийг батлуулж, жил дараалан нэмэгдүүлсээр 2012 онд 200,0 сая төгрөгийг тусгалаа.

“Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээний төв”-ийг байгуулж түүнд шаардагдах зардлыг төсөвт тусгасан нь Жендэрийн уламжлалт үзэл хандлага, зан үйлээс үүдэлтэй хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх цогц үйлчилгээг хөгжүүлэх асуудалд анхаарлаа хандуулсан чухал алхам боллоо.

Орон нутагт “Эх, нярайн эрүүл мэндийн сан” байгуулагдаж, сангийн хөрөнгийг дээд шатны эмнэлэгт явж эмчлүүлэх шаардлагатай нэн ядуу эхчүүд болон нярайд тусгай комиссын шийдвэрээр зарцуулдаг болсон нь орон нутгийн оролцоо дэмжлэг сайжирч байгааг харуулж байна.

Тулгамдаж буй асуудал

Эхийн эндэгдлийн түвшинг бүсээр авч үзвэл харилцан адилгүй, зарим аймагт өндөр байна. Баруун бүсийн Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд,

Завхан, Хангайн бүсийн Баянхонгор, Орхон, Өвөрхангай аймгуудад эхийн эндэгдэл улсын дунджаас өндөр байна²⁸.

Баруун бүс нутаг нь Монгол улсын нийт газар нутгийн 26.5 хувийг эзэлж, хүн амын 20-иод хувь нь оршин суудаг, төвөөс алслагдсан, дэд бүтэц, тээвэр, холбоо харилцаа сул хөгжсөн, байгаль цаг уур, эдийн засгийн байдал, шилжилт хөдөлгөөн, амьдрах нөхцөл, амьдралын хэв маяг, дадал хэвшилтэй холбоотойгоор тус бүс нутагт эх, хүүхдийн эндэгдэл харьцангуй өндөр байна²⁹.

Сүүлийн жилүүдэд төрөлт жил дараалан өссөн боловч улсын хэмжээнд амаржих газруудын барилга, ор, төсөв, хангамж, эмч, эх баригч, сувилагч, бусад ажилтны орон тоо бараг нэмэгдээгүй, орны хүрэлцээгүйгээс төрсөн эх, нярай амаржих газарт хэдэн цаг болоод эмнэлгээс гарч байна. Эрсдэл өндөртэй жирэмсэн эмэгтэйг аймгийн нэгдсэн эмнэлэгт шилжүүлэн төрүүлж байгаагаас аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх тасаг, эхийн амрах байрны ачаалал эрс нэмэгдсэн байна.

Шилжилт хөдөлгөөн, засаг захиргааны завсардал, хүн амын хэт төвлөрөл, ядуурал, уул уурхайн салбарын хөгжил, нэгдсэн мэдээлэл, бүртгэлийн тогтолцоо бүрдээгүй, хувь хүмүүс байгалийн эрдэс баялгийг хараа хяналтгүй олзворлож байгаа зэрэг нийгэм эдийн засгийн нөлөөгөөр тэгш бус байдал үүсч, нийгмийн нэн эмзэг бүлгийн хүн ам нөхөн үржихүйн тусламж үйлчилгээнд бүрэн хамрагдаж чадахгүй байгаа нь нөхөн үржихүйн эрүүл мэндийн байдалд нөлөөлж байна.

Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдал муу, тэдний 46 хувь нь ямар нэгэн архаг хууч өвчин эмгэгтэй байна.

НҮЭМ-ийн тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай эм хэрэгслийг тогтвортойгоор хангах төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэх хэрэгцээтэй байна. Өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг түлхүү явуулах шаардлагатай байна. хангалтгүй байсаар байна.

28 *Myyāāiū d°āe ēēēi zidēēō oōāiū dūyūāēēēō*, 2009, 54-д о аē.

29 *Bādōōi āzñ iōdāēēi* “Эд, йүдāēēi үд,цē йiā ” *ñyūyād āāā dōdēūi yūō yōāyē*, 2008, 8-д о аē.

Дийлэнх эмэгтэйчүүдийн умайн хүзүүний хорт хавдрын талаархи мэдлэг хангалтгүй, эрт илрүүлэлтийн хувь хэт доогуур байна. Мөн гэр бүлийн хүчирхийллийн улмаас цөөнгүй эмэгтэйчүүд, хүүхдүүд эрүүл мэнд, сэтгэл санааны хувьд ноцтой хохирч байгаа, гэрлэсэн эмэгтэйчүүд бие махбодын хүчирхийлэлд илүүтэй өртөж байна. Сургагдсан хүний нөөцийг зөв байршуулах, тогтвор суурьшилтай ажиллуулахад шат шатны байгууллагууд онцгой анхаарах, гэрээ хэлцлийг биелүүлэх шаардлагатай байна.

Нийлүүлэгдэж буй багаж, тоног төхөөрөмжийн чанар, цаашдын засвар үйлчилгээнд анхаарал хандуулах хэрэгтэй байна.

Цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ

Мянганы хөгжлийн зорилтыг биелүүлэх, 2015 онд эх, нярайн эндэгдлийг бууруулахаар дэвшүүлсэн зорилтод хүрэхийн тулд “Эх, нярайн эрүүл мэнд”-ийн талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй юм:

- Эх, нярайн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахад учирдаг саад бэрхшээлийг (унааны зардал, бүртгэл, даатгалд хамрагдалт, санхүүгийн болон ёс заншлын саад, алслалт) бууруулж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, нотолгоонд тулгуурласан анагаах ухааны дэвшилтэт шинэ арга технологийг нэвтрүүлэх;
- Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хангах, төрөлтийг зөв дэмжсэн бодлого хэрэгжүүлж, эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн

тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг бүрдүүлэх, шинэ болон сэргэж буй халдварт өвчин, гамшиг осол, онцгой тохиолдлын үед үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний байнгын бэлэн байдлыг хангах;

- Эх барих-эмэгтэйчүүдийн эмч, нярайн эмч, мэдээгүйжүүлэг-эрчимт эмчилгээний эмч нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх;
- Төрөх насны болон жирэмсэн эхчүүдийн суурь өвчнийг эртнээс оношлон эмчилж эрүүлжүүлэх цогц арга хэмжээ авч, жирэмсэн эхчүүдийг хяналтад эрт авах, ялангуяа, хөдөөгийн малчин, тариаланч өрхийн жирэмсэн эхчүүдийг хяналтанд эрт хамруулах, үзлэгийг тогтмол явж хийж байх, жирэмсний хяналтын чанарыг сайжруулах;
- Шинээр баригдаж буй эх, хүүхдийн эрүүл мэндийн төв, амаржих газруудад ажиллах хүний нөөцийг бэлтгэх, багаж тоног төхөөрөмжөөр хангах ажлыг жил бүр төсөвт тусган, төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, салбар хоорондын уялдааг сайжруулах;
- Эмч, эмнэлгийн мэргэжилтний цалин урамшууллын тогтолцоог боловсронгуй болгож, ажлын ачаалал, гүйцэтгэлтэй нь уялдуулах.

Эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах Мянганы хөгжлийн тав дахь зорилго нь үндсэн шалгуур үзүүлэлтээрээ дэвшүүлсэн зорилтыг хангах бололцоотой гэсэн дүгнэлт хийж болохоор байна.





ЗОРИЛГО ЗУРГАА

*БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН, ХДХВ/
ДОХ, СҮРЬЕЭТЭЙ ТЭМЦЭХ, БУСАД ӨВЧНИЙГ
БУУРУУЛАХ*

ЗОРИЛГО 6

БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН, ХДХВ/ДОХ, СҮРЬЕЭТЭЙ ТЭМЦЭХ, БУСАД ӨВЧНИЙГ БУУРУУЛАХ

ЗОРИЛТ 11. 2015 ОН ГЭХЭД ХҮНИЙ ДАРХЛАЛЫН ХОМСДЛЫН ВИРУС (ХДХВ), ДАРХЛАЛЫН ОЛДМОЛ ВИРУС (ДОХ) ӨВЧНИЙ ХАЛДВАРЫГ ХЯЗГААРЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ.

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол улсад 1992 онд ХДХВ-ийн халдварын анхны тохиолдол бүртгэгдсэнээс хойш 2010 оны байдлаар нийт 83 тохиолдол илрээд байна. Бүртгэгдсэн тохиолдлын 94 хувь нь 2005 оноос хойш бүртгэгдсэн байна.

Бүртгэгдсэн 83 тохиолдлын 11 нь нас барсан бөгөөд бүртгэгдсэн бүх тохиолдлууд нь ХДХВ-ийн халдварыг бэлгийн замаар авсан байна. 2010 оны байдлаар 16 хүнд ДОХ-ын шинж тэмдэг илэрч 14 нь ретровирусийн эсрэг эмчилгээнд хамрагджээ.

ХДХВ/ДОХ-той хүмүүсийг 2010 оны хувьд насны ангилалаар авч үзвэл 5.0 хувь нь 15-19 насны, 17.0 хувь нь 20-24 насны, 26.0 хувь нь 25-29 насны, 21.0 хувь нь 30-34 насны, 15.0 хувь нь 35-39 насны, 13.0 хувь нь 40-44 насны, 1.0 хувь нь 45-49 насны, 2.0 хувь нь 50-иас дээш насныхан байна. ХДХВ-ийн халдвартай хүмүүсийн 80.5 хувь нь эрэгтэйчүүд байгаа бөгөөд тэдний 86.4 хувь нь эрэгтэйтэй бэлгийн хавьталд ордог эрэгтэй байгаа бол 19.3 хувь нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд тэдний 62.5 хувь нь биеэ үнэлэгчид болон бэлгийн олон хавьтагчтай эмэгтэйчүүд байна. 2009 онд хийгдсэн харуулдан тандалтын судалгаагаар

Хүснэгт 15. Жирэмсэн эмэгтэйчүүд болон 15-24 насны залуучуудын дундахь ХДХВ-ын халдварын тархалт, хувь

Шалгуур үзүүлэлт	2007	2008	2009	2010	2015*
Жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд ХДХВ-ын халдварын тархалт /хувь/	0.001	-	-	0.003	<0.1
15-24 насны залуучуудын дунд ХДХВ-ын халдварын тархалт /хувь/	0.0007	0.0005	0.0005	0.0012	<0.1

*-Зорилтод түвшин

Эх үүсвэр: Халдварт өвчин судлалын үндэсний төв

ХДХВ-ийн халдвартай 3 тохиолдол илэрсэн нь эрэгтэйтэй бэлгийн хавьталд ордог эрэгтэй бөгөөд ЭБЭ-ийн дунд ХДХВ-ийн тархалт 1.8 хувьтай байгаа нь өмнөх онуудтай харьцуулахад нэмэгдэх хандлагатай байна. Үүнийг дээрхи хүснэгтээс бас харж болох бөгөөд 2010 оныг 2008 онтой харьцуулахад тоон үзүүлэлт нь өсчээ. Энэ нь ХДХВ-ийн эсрэг авч буй арга хэмжээг цаашид эрчимжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

ХДХВ-ийн халдвартай хүмүүсийн 65.8 хувь нь Монголдоо, 29.2 хувь нь гадаадад амьдарч байх хугацаандаа халдвар авсан, 4.9 хувь Монголд амьдарч байсан гадаадын иргэдээс халдвар авсан байна.

2010 онд 13,695 хүн сайн дурын зөвлөгөө, шинжилгээнд хамрагдсан байна. ХДХВ-ийн халдварын 48.8 хувийг идэвхитэй тандалтаар, 29.3 хувийг тохиолдол, сайн дурын шинжилгээгээр, 17.1 хувийг урьдчилан сэргийлэх үзлэгээр, 4.9 хувь нь өвчний улмаас эмнэлэгт хандсан хүмүүсээс илэрсэн байна.

2010 онд ХДХВ-ийн халдвартай 4 эх төрснөөс 3 тохиолдолд халдварыг эхээс хүүхдэд дамжихаас сэргийлэх арга хэмжээ авсан бөгөөд 4 хүүхэд ХДХВ-ийн халдваргүй болох нь шинжилгээгээр батлагджээ. ХДХВ/ДОХ-той хүмүүсийн гэр бүлд амьдарч байгаа 28 хүүхдийн 14 нь 15-аас доош насныхан байгаа бөгөөд ХДХВ/ДОХ-ын халдварын улмаас гурван хүүхэд бүтэн өнчин хоцорсон байна.

2010 онд бэлгийн замын халдварт өвчин нь нийт бүртгэгдсэн халдварт өвчний 35 хувийг эзэлж байгаа нь 2009 онтой харьцуулахад 16 хувиар буурсан байна. БЗДХ-ын 32.4 хувийг трихомониаз, 40.1 хувийг заг хүйтэн, 27.5 хувийг тэмбүү өвчин тус тус эзэлж байна. 2010 онд 70538 жирэмсэн эмэгтэйчүүдэд бэлгийн замын үзлэг шинжилгээ хийгдсэн.

Авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 43 дугаар тогтоолоор ХДХВ/ДОХ, БЗДХ-аас сэргийлэх үндэсний стратеги төлөвлөгөө (2010-2015)-г батлан хэрэгжүүлж байна.

ДЭМБ, ДЭМБ-ын Номхон далайн баруун эргийн бүсийн “БЗДХ-өөс урьдчилан сэргийлэх, хянах стратеги (2008-2012)”, ДЭМБ-аас гаргасан “ХДХВ/ДОХ-ын эмчилгээ, оношилгооны удирдлага” шинэчилсэн удирдамжийг боловсруулан гаргасантай холбогдуулан БЗДХ, ХДХВ/ДОХ-ын тусламж, үйлчилгээний удирдамжийг Эрүүл мэндийн сайдын 2009 оны 429 тоот тушаалаар батлан хэрэгжүүлж байна. Энэхүү тушаалаар БЗДХ, ХДХВ/ДОХ-ын чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгож энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 1-2 эмчтэй кабинетийг өргөжүүлж, 3-5 эмчтэй диспансер хэлбэртэйгээр өргөтгөн зохион байгуулж байна.

Мөн 2008 оноос Сайн дурын зөвлөгөө, шинжилгээний төвүүдийг нээж тэдгээрт ажиллах 100 гаруй эмч мэргэжилтнүүдийг сургалтанд хамруулж, 2009-2010 онд тус төвөөр 30-аад мянган хүн үйлчлүүлсэн байна. Ийнхүү сайн дурын зөвлөгөө шинжилгээний төвүүдийг байгуулснаар үйлчлүүлэгчдийн эрхийг хүндэтгэх, нууцлалыг хадгалах, ганцаарчилсан зөвлөгөө, шинжилгээг үйлчлүүлэгчид ойртуулсан нь ач холбогдолтой болов.

ХДХВ/ДОХ-той тэмцэх үйл ажиллагаанд зөвхөн эрүүл мэндийн салбар төдийгүй бусад олон талын оролцоо ихээхэн чухал бөгөөд энэхүү чиглэлээр олон төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагууд үйл ажиллагаа явуулж тэдгээрт багагүй хэмжээний хөрөнгө зарцуулсан байна. Гэвч үйл ажиллагааны санхүүжилтийн дийлэнх хувийг олон улсын

төсөл хөтөлбөрийн эх үүсвэрээс гаргаж байна. Тухайлбал: 2008, 2009 онд энэ чиглэлд зарцуулсан 8.3 тэрбум төгрөг буюу нийт санхүүжилтийн 68 хувийг олон улсын байгууллага, (Глобаль сан, ДЭМБ, Нэгдсэн үндэстний байгууллага, Азийн хөгжлийн банк, Германы техник туслалцааны төсөл) гадаадын хандивлагчдын санхүүжилт эзэлж байна.

Манай улсад ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх чиглэлээр томоохон төсөл хэрэгжүүлэгч Глобаль сангийн санхүүжилтээр дараахь ажлууд хэрэгжиж байна:

- “ХДХВ/ДОХ-ын эрсдэлт бүлгийнхэнд хандсан урьдчилан сэргийлэлт, эмчилгээ, тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж чанаржуулах, ХДХВ/ДОХ-той тэмцэх Эрүүл мэндийн салбарын чадавхийг бэхжүүлэх замаар бага тархалтыг тогтоон барих” - 7 төсөл /2008-2013 он, 2.9 сая ам.доллар/;
- “ХДХВ/ДОХ-оос сэргийлэх, тусламж үзүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх”-д 2 төсөл /2008-2014 он, 6.4 сая ам.доллар/;
- “ХДХВ/ДОХ-ын лабораторийн чадавхийг бэхжүүлэх”- 9 төсөл (2011-2015 он, 4 сая орчим доллар) хэрэгжиж байна.

Тулгамдаж буй асуудал

Сүүлийн жилүүдэд ХДХВ-ийн халдварын тохиолдол нэмэгдэж байгаа нь нэг талаас эрүүл мэндийн байгууллагуудын илрүүлэлтийн чадавхи нэмэгдэж байгаатай холбоотой байж болох хэдий ч ХДХВ-ийн халдвар тархах нийгэм-эдийн засгийн эрсдэл манай улсад өндөр байна. Тухайлбал, хүн амын гуравны нэг нь амьжиргааны баталгаажих доод түвшнээс бага орлоготой, хүн амын шилжилт хөдөлгөөн болон уул уурхай, дэд бүтцийн салбар хөгжиж байгаатай холбоотойгоор явуулын хүн ам эрс нэмэгдэж байгаа, хилийн чанадад зорчигчдын тоо нэмэгдсэн, залуучуудын дунд биеэ үнэлэх, архидан согтуурах байдал газар авч байгаа нь ХДХВ/ДОХ-ын тархалтыг хязгаарлан барихад ихээхэн бэрхшээл учруулж байна.

ХДХВ/ДОХ-ын эсрэг тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулахад зарим холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, ялангуяа

ЗОРИЛТ 12. 2015 ОН ГЭХЭД СҮРЬЕЭ ӨВЧНИЙ ТАРХАЛТЫГ БУУРУУЛАХ

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Сүрьеэтэй тэмцэх үндэсний анхны хөтөлбөрийн хүрээнд 1996 оноос шууд хяналттай богино хугацааны эмчилгээний стратеги (ДОТС)-ийг нэвтрүүлснээр сүрьеэгийн илрүүлэлт, эмчилгээний үр дүн сайжирч, эмчилгээний хугацаа богиноссон байна.

ДОТС-ийг нэвтрүүлснээр Монгол Улс түрхэц эерэг сүрьеэгийн тохиолдлын илрүүлэлтийг 83.5 хувь, эмчилгээний амжилтыг 89 хувьд хүргэж, илрүүлэлтийг 70 хувь, эмчилгээний амжилтыг 85 хувьд хүргэх ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн зорилтуудыг биелүүлж чадсан. Эмчилгээний үр дүн сайжирсны ачаар сүрьеэтэй өвчтөнүүдийн бүрэн эдгэрэлтийн түвшин нэмэгдэж, шинэ илэрсэн өвчтөний дотор нас баралтын эзлэх хувь буурчээ.

Ийнхүү эмчилгээний үр дүнг сайжруулах зорилгоор үр дүнтэй шинэлэг арга нэвтрүүлсэн нь Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгийн 340 гаруй сайн дурын идэвхтэн (СДИ)-ээр дамжуулан алслагдмал оршин суудаг сүрьеэтэй өвчтөнүүдэд үргэлжлэх шатны эмийг гэрээр нь хүргэж уулгах, мөн амьжиргааны түвшин доогуур өвчтөнүүдэд гэрээт зоогийн газруудаар өдрийн хоол өгөхийн зэрэгцээ эм уулгах арга юм. Сүрьеэтэй өвчтөнүүдийн 49 хувь нь сүрьеэгийн диспансерт өдөр бүр ирж шууд хяналттай эмчилгээнд хамрагддаг бол 39 хувь нь СДИ-ийн тусламжтай шууд хяналттай эмчилгээнд гэртээ хамрагдаж, 11 хувь нь гэрээт зоогийн газар хоол идсэний дараа СДИ-ийн хяналтан дор эмчилгээ хийлгэдэг байна.

Сүрьеэ өвчний тархалт (100 000 хүн тутамд) 1990 онд 435 байсан бол 1997 оноос эхлэн хоёр оронтой тоонд шилжиж, 2010 оны байдлаар 65 болж буурсан байна.

Хүснэгт 16. Сүрьеэ өвчний тархалт, өвчлөлийн түвшин, нас баралт, оношилгоо, эмчилгээний тохиолдлын хувь

Шалгуур үзүүлэлт	2007	2008	2009	2010	2015*
Сүрьеэ өвчний тархалт /100000 хүн тутамд/	72.6	72.0	70	65	82
Сүрьеэгийн өвчлөлийн түвшин /100000 хүн тутамд/	167	159	156	153	100
Сүрьеэгээс шалтгаалсан нас баралт /100000 хүн тутамд/	2.4	2.7	2.18	3.3	2
Оношилгоо, эмчилгээний олон улсын стандартын хүрээнд сүрьеэг илрүүлж, эмчилсэн тохиолдлын хувь	83.8	85.0	82.4	84.5	100.0

*-Зорилтод түвшин

Эх үүсвэр: Халдварт өвчин судлалын үндэсний төв

100,000 хүнд ногдох сүрьеэгийн өвчлөл 2007 онд 167, 2008 онд 159, 2009 онд 156, 2010 онд 153 болж бага боловч буурах хандлагатай байна.

Сүрьеэгийн өвчлөл бага зэрэг буурч байгаагийн зэрэгцээ сүрьеэ өвчний тархалт сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц буурч байна. Энэ нь сүрьеэ өвчний илрүүлэлт сайжирч, богино хугацааны шууд эмчилгээгээр эдгэрч байгаатай холбоотой байна.

Хүн амын ядуурал, шилжилт хөдөлгөөн, агаарын бохирдол, хүн амын дундах тамхины хэт хэрэглээний өсөлт зэрэг хүчин зүйл нь сүрьеэ өвчний тархалтад нөлөөлж байна.

2010 онд сүрьеэгийн нийт 4213 тохиолдол шинээр бүртгэгдсэн бөгөөд тэдгээрийн 72.5 хувь

нь уушигны түрхэц эерэг сүрьеэгийн тохиолдол байна. Бүртгэгдсэн сүрьеэгийн шинэ тохиолдлын 60.1 хувийг уушигны, 39.9 хувийг уушигны бус буюу бусад эрхтэний сүрьеэ эзэлж байна. Сүрьеэгээр өвчлөгсдийн 69.0 хувь нь 16-44 насны залуу, хөдөлмөрийн ид насны хүмүүс байгаа бөгөөд хүйсийн хувьд 52 хувь эрэгтэйчүүд, 48 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Хэдийгээр өвчлөлийн түвшин аажим буурч байгаа хэдий ч сүүлийн жилүүдэд олон эмэнд дасалтай сүрьеэгийн өвчлөл нэмэгдэх хандлагатай байна. 2010 оны байдлаар эмэнд дасалтай сүрьеэтэй 1075 хүн бүртгэгдэж тэдний 50-60 хувь нь эмчилгээнд бүрэн хамрагдаж, эрүүлжилтийн хувь 73.8 байна.

Авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ

Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэн өрхийн эмнэлгээр “Шууд хяналттай богино хугацааны эмчилгээ”-г хэрэгжүүлж байгаа нь үйлчлүүлэгчид эмнэлгийн чанартай тусламж, үйлчилгээг ойртуулах, хяналтыг сайжруулахад чухал арга хэмжээ болж байна.

Монгол Улсад сүрьеэгийн эмчилгээний орчин үеийн аргыг практикт нэвтрүүлэхэд олон улсын түнш, хандивлагч байгууллагуудын дэмжлэг, туслалцаа шийдвэрлэх үүргийг гүйцэтгэж ирсэн бөгөөд жилд дунджаар 336'000 ам. долларын үнэ бүхий эмийн хангамжийг олон улсын байгууллагаас хийж, өнөөгийн байдлаар оношлогдсон бүх өвчтөнд эмийг үнэ төлбөргүйгээр олгож байна.

Үүний зэрэгцээ манай улсын Засгийн газраас олон улсын стандартын шаардлага хангасан чанарын баталгаатай сүрьеэгийн эмээр найдвартай хангах арга хэмжээ авч, 2007 оноос эхлэн сүрьеэгийн эсрэг нэгдүгээр эгнээний эмийн санхүүжилтийн тодорхой хувийг төсвөөс гаргаж эхэлсэн нь сүрьеэтэй тэмцэх хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх юм.

“Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх” үндэсний стратеги (2010-2015)-ийг Эрүүл мэндийн сайдын 2009 оны 272 тоот тушаалаар батлуулан хэрэгжүүлж эхлээд байна. Энэхүү стратегийг хэрэгжүүлэхэд 2012-2015 онд нийт 20 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай юм.

Стратегийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сүрьеэтэй тэмцэх үйл ажиллагаанд салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх, сүрьеэгийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг эрс сайжруулах зорилгоор Сүрьеэгийн үндэсний VI зөвлөгөөнийг Улаанбаатар хотноо зохион байгууллаа.

Сүрьеэгийн лабораторийн оношилгооны чадавхийг сайжруулах зорилгоор үндэсний түвшинд сүрьеэгийн лабораторийн сүлжээ байгуулан цэрний түрхэцийн шинжилгээг 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн сүрьеэгийн диспансер, хорихын эмнэлэг, зарим сумын эмнэлгийн лабораторит хийж байна. Мөн сүрьеэгийн сорьц

тээвэрлэлтийн тогтолцоог нэвтрүүлэн ажиллаж байгаа нь сүрьеэ өвчнийг эрт илрүүлэн эмчилж эдгэрүүлэхэд чухал алхам болж байна.

Нийт хүн ам тэр дундаа хүн амын эмзэг бүлэгт мэдээлэл сургалт, сурталчилгаа явуулахад иргэд, сайн дурын идэвхитнийг татан оролцуулж, тэднийг чадавхижуулах чиглэлээр “Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг”, “Дэлхий зөн Монгол” зэрэг байгууллагууд идэвхитэй ажиллаж байна. Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгээс нийт 350 сүрьеэгийн сайн дурын идэвхитэн бэлтгэгдэж, сүрьеэтэй өвчтөнүүдийн 39 хувь нь тэднээр дамжуулан шууд хяналттай эмчилгээнд гэрээр хамрагдаж, тэдний хяналтын дор эмээ ууж байгаа бол, 11 хувь нь гэрээт зоогийн газраар өдрийн хоолтой эмчилгээнд хамрагдахын сацуу эмээ ууж, сургалт сурталчилгаа, зөвлөгөө авах хэлбэрээр тусламж, үйлчилгээнд хамрагдаж байна. Судалгааны дүнгээс харахад сайн дурын идэвхитнүүдээр дамжуулан хяналттай хийгдсэн эмчилгээний үр дүн 90-ээс дээш хувьтай байгаа нь энэхүү арга хэмжээ хүндээ хүрсэн ач холбогдолтой ажил болохыг харуулж байна.

Манай оронд 2010 оны байдлаар эмэнд дасалтай сүрьеэ өвчтэй 1075 хүн бүртгэгдэж тэдний 50-60 хувь нь эмчилгээнд бүрэн хамрагдаж, эмчилгээний үр дүн 73.8 хувь байгаа хэдий ч 7.2 хувь нь хоёрдугаар эгнээний эмийн эмчилгээнд үр дүнгүй байгаа нь цаашид олон эмэнд дасалтай сүрьеэгийн аюул байсаар байгааг харуулж байна.

Тулгамдаж буй асуудал

Сүрьеэтэй тэмцэх хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад олсон амжилтыг улам бататгах, сүрьеэгийн илрүүлэлт болон эдгэрэлтийн түвшинг нэмэгдүүлэхийн тулд цаашид шийдвэрлэх асуудлууд нь нийгмийн олон салбарын оролцоог шаардаж байна. Ядуурал, ажилгүйдэл, хүн амын шилжилт хөдөлгөөн өсөн нэмэгдэж байгаа нь сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх, хянах үйл ажиллагаанд бэрхшээл учруулж байгаа бөгөөд сүрьеэгийн тусламж үйлчилгээг орон гэргүй хүмүүс, хорих ангийн хүмүүжигчид, хөдөлгөөнт хүн амд үзүүлэхэд эрүүл мэндээс бусад салбар, орон нутгийн засаг захиргааны байгууллагын оролцоо нэн чухал байна. Хорих анги дахь сүрьеэгийн тусламж үйлчилгээний зохицуулалтыг сайжруулах,

хорих ангийн хүмүүжигчид, ядуу, орон гэргүй хүмүүсийг хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр хангах, хоолтой шууд хяналттай эмчилгээний цар хүрээг өргөжүүлэхэд хуульзүй, нийгмийн хамгааллын салбарын манлайлал үгүйлэгдэж байна.

Олон эмэнд дасалтай сүрьеэгийн (ОЭДС)-ийн эмчилгээний хамралт, үр дүнг сайжруулахын тулд ОЭДС-тэй өвчтөнийг эмчлэх, халдвар хамгааллын дэглэмийн шаардлага хангасан эмнэлгийн орны тоог нэмэгдүүлж, амбулаторийн өдрийн эмчилгээний цэгүүдийг шинээр байгуулах нь хойшлуулшгүй зорилт болж байна. Мөн ОЭДС-г эрт илрүүлэх лабораторийн чадавхийг бэхжүүлж, хөдөө орон нутагт ОЭДС-ийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор давтан эмчилгээнд хамрагдсан өвчтөнүүдийн сорьцыг аймаг, дүүргээс сүрьеэгийн лавлагаа лабораторид илгээх сорьц тээвэрлэх тогтолцоог бүрдүүлэх нь чухал байна. Ер нь, сүрьеэгийн тусламж үйлчилгээний хэвтүүлэн эмчлэх аргыг шүтсэн өнөөгийн тогтолцооны хэт төвлөрлийг сааруулж, тусламж үйлчилгээг хүнд ойр өрх, сумын эмнэлгийг түшиглэн амбулаториор хүргэх нь дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, үр ашигтай арга юм.

Үүний зэрэгцээ сүрьеэгийн эсрэг эмийг эмчийн жоргүйгээр худалдаалахыг хориглосон журмын хэрэгжилтийг хангахад онцгой анхаарч, сүрьеэгийн нэгдүгээр эгнээний эмээр тасралтгүй хангах, эм тасалдах эрсдлийг бууруулах зорилгоор сүрьеэгийн эмийн нөөц бүрдүүлэх замаар сүрьеэгийн эмийн менежментийг боловсронгуй болгосноор ОЭДС үүсэхээс сэргийлэх боломж бүрдэнэ.

Сүрьеэгийн тусламж үзүүлж байгаа эмч нарт тогтвортой ажиллах урамшууллын механизм, өөрсдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх боломж үгүйлэгдэж байна. Ер нь, хүний нөөцийн хүртээмж, ур чадвар хангалтгүй байх нь сүрьеэгийн тусламж, үйлчилгээг чанартай хүргэхэд сөргөөр нөлөөлөх бас нэг хүчин зүйл юм. Иймд сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлон, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг хангах хөшүүрэг бий болгох, сүрьеэгээр өвчилсөн сүрьеэгийн эмч, эмнэлгийн ажилчдыг нийгмийн халамжинд хамруулах зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн, олон улсын төсөл хөтөлбөрүүдээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс гаргах санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Олон эмэнд дасалтай сүрьеэг эмчлэх илрүүлэхэд анхаарч цаашид өдрийн эмчилгээний цэгүүдийг өргөжүүлэх, сүрьеэгийн мэргэжлийн хүний нөөцийг бэхжүүлэх чадавхийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ

- Бүх түвшинд сүрьеэг эрт илрүүлэх, оношлох лабораторийн чадавхийг нэмэгдүүлэх;
- Зарим эрүүл мэндийн байгууллага стандартын бус эмчилгээ хийх, өвчтөн өөрөө эмчилгээгээ бүрэн хийлгэхгүй дутуу орхих, эмчилгээний явцын хяналт хангалтгүй байх нь эмэнд дасалтай сүрьеэ үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байгаа учраас аймаг, дүүрэг, өрхийн түвшинд шууд хяналттай богино хугацааны эмчилгээний чанар, хяналт, үр дүнд онцгой анхаарал хандуулан ажиллах;
- Ямар ч тохиолдолд санхүүжилтийн найдвартай эх үүсвэр байх ёстой учраас цаашид төслийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний тогтвортой байдлыг хангах үүднээс Монгол Улсын Засгийн газраас гаргах санхүүжилт, ялангуяа эмзэг бүлгийн хүн амд үзүүлэх тусламж, үйлчилгээнд зориулсан санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх;
- Хүн амын дунд сүрьеэ өвчний талаарх сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх тэдний оролцоог нэмэгдүүлэх;
- Халдварт болон халдварт бус өвчний эмчилгээний тэргүүний арга технологи, боловсон хүчнийг бэлтгэн ажиллуулах, ялангуяа энэ чиглэлээр гадаадын улс оронд эмч нараа дадлагажуулах.

ЗОРИЛТ 13. ХҮҮХДИЙН ШҮД ЦООРОХ ӨВЧНИЙ ТАРХАЛТЫГ БУУРУУЛАХ

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Манай судлаачдын 2010 онд хийсэн судалгаагаар шүд цоорох өвчний тархалт 5-6 насанд 89,3 хувь, 12 насанд 65.3 хувь, шүд цоорлын эрчим 5-6 насанд 6.9, 12 насанд 2.3, 18 насанд 2,62, 18 настай бүх хүүхдийн дунд бүрэн шүдтэй хүүхдийн эзлэх хувийн жин 69.9 байна. Энэ нь 2004 онд хийсэн судалгааны дүнтэй харьцуулахад шүд цоорох өвчний тархалт 5-6 насанд 9.2 хувь, шүд цоорлын эрчим 5-6 насанд 2.3-иар нэмэгдсэн байна. Энэ нь бага насны хүүхдүүдийн дунд шүд цоорох өвчин их, өвчин хүндэрсэнээс болж шүд авахаас өөр эмчилгээгүй болж байгаатай холбоотой юм.

Хүснэгт 17. 5-6 настай хүүхдийн шүд цоорох өвчний тархалт (хувь)

Шалгуур үзүүлэлт	2004	2009	2010	2015*
5-6 настай хүүхдийн шүд цоорох өвчний тархалт /хувь/	80.1	...	89.3	75.0

*-Зорилгод түвшин

Эх үүсвэр: Улаанбаатар хотын хүүхэд, залуусын амны хөндийн судалгаа, 2011 он

Хүн амд үзүүлж буй амны хөндийн тусламж үйлчилгээг аймаг, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, нэгдсэн эмнэлгүүд болон орчин үеийн тоног төхөөрөмж, эм материалаар хангагдсан хувийн хэвшлийн эмнэлгүүд гүйцэтгэж байгаа бөгөөд эдгээр нь шүдний тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, чанартай тусламж үйлчилгээг хүн амд хүргэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэж байна.

Хүн амын дийлэнх хувь нь хот суурин газар шилжин амьдарч, амьдралын хэв маяг, үндэсний уламжлалт дадал заншил өөрчлөгдсөн, нийт аймгийн 47.7 хувь нь фторын агууламж багатай ундны ус хэрэглэж байгаагийн зэрэгцээ чихэрлэг, өтгөрүүлсэн, хийжүүлсэн ундааны хэрэглээ сүүлийн 20 гаруй жилд 2-3 дахин нэмэгдэж сүү, цагаан идээний хэрэглээ 40 гаруй хувиар буурсан, хүнсний бүтээгдэхүүний зөв сонголт, зохистой хэрэглээний талаарх хүн амын мэдлэг дадал хангалтгүй байгаа зэрэг нь шүд цоорох өвчин,

цоорлын бус гаралтай шүдний хатуу эдийн эмгэг, яс сийрэгжих өвчнийг үүсгэх гол шалтгаануудын нэг болж байна.

Авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ

Амны хөндийн эрүүл мэндийн талаар 2020 онд хүрэх дэлхий дахины зорилт, ДЭМБ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 150 дугаар тогтоолоор “Амны хөндийн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг батлан шүд цоорох өвчин, түүнд нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйлийн хяналт, тандалтыг сайжруулах, шүд амны хөндийн эрүүл мэндээ иргэд өөрсдөө хянаж, сайжруулах, эрүүл зан үйл төлөвшихэд дэмжлэг үзүүлэх орчин бүрдүүлэх, нийгэм хамт олонд тулгуурласан амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, хүн амын дунд шүд цоорох өвчний тархалтыг бууруулах зорилго тавин ажиллаж байна.

Амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна:

- Хөтөлбөрийн хүрээнд 5-12 настай хүүхэд, өсвөр насны хүүхдүүдийн шүдний цоорол, шүдний цоорлын эрчмийг тодорхойлох, өсвөр насны хүүхдүүдийн дунд бүрэн шүдтэй хүүхдийн эзлэх хувь, шүдний цоорол, цоорлын эрчимд нөлөөлж байгаа зарим эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлох судалгааг 2010 онд зохион байгуулав.
- Усан дахь фторын агууламж багатай орон нутагт фтортой бэлдмэлийн хэрэглээг нэмэгдүүлэх стандарт аргачлал, амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх зорилгоор нүүр амны эмчилгээний чиглэлээр шүд цоорлын үеийн эмчилгээ, шүдний зөөлцийг амьдаар нь хадгалах арга, шүдний зөөлцийг мэдээ алдуулалтын дор бүрэн авч эмчлэх арга, шүдний зөөлцийг мэдээ алдуулалтын дор тайрч эмчлэх арга, хүүхдийн нүүр амны өвчин судлал, урьдчилан сэргийлэлтийн чиглэлээр

хүүхдийн сүүн шүдний цоорлын эмчилгээ, азот мөнгөний хүчлээр сүүн шүдний цоорлын явцыг зогсоох арга, нүүр амны согог заслын чиглэлээр бүрэн шүдгүйдлийн согог заслын эмчилгээний стандартуудыг шинэчлэн батлуулсан.

- ЭМШУИС-ын “Нүүр амны эрүүл ахуйчийг бэлтгэх”, “Хүүхдийн нүүр амны өвчин болон урьдчилан сэргийлэлтийн чиглэлээр төрөлжсөн нарийн мэргэжлээр суралцах” сургалтын хөтөлбөр, стандарт, хөтөчийг шинэчлэн боловсруулсан.
- Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн “Эрүүл мэнд” хичээлийн стандартад амны хөндийн эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх аргыг тусгаж, багш нарын заах арга зүйг сайжруулах сургалт зохион байгуулж, гарын авлага материалаар хангаж байна.
- Хүн амын амны хөндийн эрүүл ахуйн мэдлэгийг дээшлүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлж, мэргэжлийн эмч нарын чадавхийг дээшлүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулж байна.

Тулгамдаж буй асуудал

- Шүдний эмчилгээ оношилгооны өртөг өндөр байгаагаас хүн амын эмзэг бүлэгт шүдний эмчилгээний зардлыг төлж чадахгүйд хүргэж байна.
- Бага болон өсвөр насны хүүхдүүдийн хийжүүлсэн ундааны хэрэглээ их, хийжүүлсэн ундааны сурталчилгааг хязгаарлах, уг бүтээгдэхүүнийг хүүхдийн байгууллагуудын ойр орчимд зарах, үдийн цай хөтөлбөрөөр олгохыг хориглох хууль эрх зүйн зохицуулалт байхгүй байна.
- Боловсролын байгууллагууд дахь эрүүл мэндийн сургалтын чанар сул, сургууль, цэцэрлэгт орон тооны эмч ажиллахгүй байна.

Цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ

- Хүн амын ялангуяа бага насны хүүхдийн шүд цоорох өвчин, түүнд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлийн судалгаа, хяналт, үнэлгээний тогтолцоо бий болгож, мэдээллийн сан бүрдүүлэх, үзлэг тогтмол зохион байгуулж, шүд цооролтын эрчмийг бууруулах ажлыг системтэй зохион байгуулах;
- Амны хөндийн эрүүл мэнд, шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар хүн амд зөв дадал, зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн ухуулга мэдээлэл, сургалт, сурталчилгааг өргөжүүлж эрүүл аж төрөх дадлыг хэвшүүлэх;
- Аймаг, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, нэгдсэн эмнэлгийн шүдний тусламж үйлчилгээний багаж, хэрэгслийг орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах;
- Бага насны хүүхдүүдийн ялангуяа хөдөө орон нутгийн хүүхдүүдийн дунд шүдний өвчлөл буурахгүй байгаа тул Монгол Улсыг бүсчилэн хөгжүүлэх тулгуур төвүүд болон нийслэлийн дүүргүүдэд “Хүүхдийн шүдний эмчилгээний кабинет” байгуулах ажлыг эрчимжүүлэх;
- Хийжүүлсэн ундааны сурталчилгаа болон уг бүтээгдэхүүнийг хүүхдийн байгууллагын ойр орчим зарах, үдийн цай хөтөлбөрөөр олгохыг хориглох, дотоодын үйлдвэрлэл, импортыг багасгах, хяналтыг чангатгах, нийгмийн хариуцлагыг бий болгох хууль эрх зүйн зохицуулалт бий болгох;
- Хүн амын фторын хэрэглээг зохицуулах ажлын хүрээнд ундны усан дахь фторын агууламжийн асуудлыг шийдвэрлэх;
- Хүүхдийн шүдний эмчилгээний зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тогтолцоог бий болгох;
- Бүх шатны боловсролын байгууллагад амны хөндийн эрүүл ахуйн мэдлэг, дадал эзэмшүүлэх сургалтыг тогтмолжуулах.





ЗОРИЛГО ДОЛОО

*БАЙГАЛЬ ОРЧНЫ
ТОГВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ*

ЗОРИЛГО 7

БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

ЗОРИЛТ 14. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАРЧМЫГ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРТ ТУСГАН ХЭРЭГЖҮҮЛЖ, ХОТ СУУРИН ЯЛАНГУЯА УЛААНБААТАР ХОТЫН АГААРЫГ ЦЭВЭРШҮҮЛЭХ

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Байгаль орчны бодлогыг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, МХЗ-уудад суурилсан Үндэсний хөгжлийн цогц (2021 он хүртэл) бодлогод тусган хэрэгжүүлж байна. Газар зүйн байрлал, уур амьсгалын онцлогоос шалтгаалан нийт нутгийн 90 гаруй хувийг нь хуурай, хагас хуурай, хуурайвтар, чийг дутмаг нутаг эзэлдэг. Ойгоор бүрхэгдсэн талбай 2010 оны байдлаар улсын хэмжээнд 12 сая га байгаа нь нийт нутгийн 7.7 хувийг эзэлж байна.

Хэдийгээр МХЗ-уудын байгаль орчны талаар зорилго 7-д дэвшүүлсэн үзүүлэлтүүд биелэгдэх төлөвтэй байгаа ч Монгол улсын нийт эдэлбэр газрын 0.06 хувийг эзэлдэг, хүн амын 40.7 хувь нь амьдардаг нийслэл Улаанбаатар хотод агаарын бохирдлын асуудал ноцтой хэмжээнд байна.

Хүснэгт 18. Ойт нутаг болон улсын тусгай хамгаалалтад авсан газар нутаг, нэг хүнд ногдох нүүрсхүчлийн хий, агаар дахь хүхэрлэг хий болон азот давхар ислийн агууламж

Шалгуур үзүүлэлт	2007	2008	2009	2010	2015*
Ойт нутгийн эзлэх хувь	7.7	7.7	7.7	7.7	9.0
Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн эзлэх хувь	13.4	13.4	13.4	13.4	30.0
Нэг хүнд ногдох нүүрсхүчлийн давхар ислийн ялгаралт /тонн/хүн/	5.70	6.02	6.05	...	4.0
Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн өвлийн хоногийн дундаж агууламж /мкг/м ³ /	38.0	34.0	39.0	52.0	30.0
Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн өвлийн дундаж агууламж /мкг/м ³ /	20.0	26.0	34.0	63.0	20.0

*-Зорилтод түвшин
Эх үүсвэр: УСХ

Нэг. Ойт нутгийн эзлэх хувь

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсын ойн сангийн нийт талбай 18565.5 мян.га, үүнээс ойн талбай 17629.7 мян.га буюу 94.6 хувь, ойн бус талбай 935.9 мян.га буюу 5.4 хувь байна. Ойн талбайн дотор ой модоор бүрхэгдсэн талбай нь 12917.5 мян.га буюу 73.3 хувь, бүрхэгдээгүй талбай 4712.2 мян.га буюу 26.7 хувь байна. Монгол орны ойрхог чанар 8.26 хувьтай байна.

Ой модоор бүрхэгдсэн талбайн 9993 мян.га буюу 77.4 хувийг шилмүүст, навчит ой, 2227.6 мян.га буюу 17.2 хувийг заган ой, 696,9 мян.га буюу 5.4 хувийг сөөг тус тус эзэлж байна.

Ойгоор бүрхэгдээгүй талбайн 2997.3 мян.га буюу 63.6 хувийг тармаг ой, 1190.4 мян.га буюу 25.26 хувийг шатсан ойн талбай, 249.1 мян.га буюу 5.3 хувийг мод бэлтгэсэн талбай, 169.6 мян.га буюу 3.6 хувийг ойжих талбай, 9.2 мян.га буюу 0.2 хувийг ойжуулсан талбай, 95.6 мян.га буюу 2.03 хувийг хөнөөлт шавьжинд устсан, 0.9 мян.га буюу 0.01 хувийг салхи, цасанд унасан ой мод тус тус эзэлж байна.

Хүснэгт 19. Ойт нутгийг ойжуулахад оруулсан хөрөнгө оруулалт (хувь)

Шалгуур үзүүлэлт	2006	2007	2008	2009	2010	Нийт
Хөрөнгө оруулалт /сая төг/	494.6	385.8	1003.0	750.0	930.0	3563.4
Талбай /мян.га/ / улсын төсвөөр/	2.1	4.2	6.9	4.9	4.2	22.3
Бусад эх үүсвэрээр ойжуулсан талбай	2.8	3.0	1.9	1.8	1.0	10.5
Бүгд	4.9	7.2	8.8	6.7	5.2	32.8

Эх үүсвэр: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Манай улсын ой нь байгаль цаг уурын, болон хүний үйл ажиллагаанаас шалтгаалан жил бүр хомсдон, доройтож байхад ойжуулсан талбайн хэмжээ сүүлийн 4-5 жилд нийт ойн талбайн нэг хүрэхгүй хувийг эзэлж байна. Энэ нь шинжлэх ухааны үндэслэлтэйгээр ойн нөөцийг хомсдуулж буй сөрөг нөлөөллийг тодорхойлж, түүнийг бууруулах, ойн нөхөн сэргээлтэнд зарцуулах хөрөнгө дутагдаж байгаагаас шалтгаалан үр дүн хангалтгүй байна.

2009 онд бүх нийтээр мод тарих хөдөлгөөнд улсын хэмжээнд 499 аж ахуйн нэгж, байгууллага, 70 гаруй мянган иргэн оролцож 1194.4 мянган ширхэг мод тарьсан байна.

2010 онд “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг гарч, цаашид энэ ажлыг хэвшүүлж иргэн бүр мод тарьдаг болгох зорилго тавин ажиллаж, мод тарьж, арчлан ургуулах арга зүй, технологийг эзэмшүүлэх, сургах, сурталчлах арга хэмжээг тусгайлан зохион байгуулсан байна. Үүний үр дүнд 2010 онд 7637 аж ахуйн нэгж, байгууллага, 190 гаруй мянган иргэн оролцож, 1744.6 мянган ширхэг мод тарьжээ.

2009 онд улсын хэмжээнд том, жижиг 146 мод үржүүлгийн газар бүртгэгдэн ажиллаж жилд дунджаар 25.0 сая орчим тарьц, суулгац бойжуулж, ойжуулалт ойн зурвас байгуулах, хот суурины

Хүснэгт 20. Монгол Улсын ойн сангийн нийт талбайн хэмжээ (мян.га)

Завсрын Үзүүлэлт	Газрын нарийвчилсан судалгаагаар				
	2006	2007	2008	2009	2010
Монгол орны газар нутгийн хэмжээ, мянга кв.км	1564.1	1564.1	1564.1	1564.1	1564.1
Ойн сангийн нийт талбай, мянган га	19166.1	19002.2	18849.3	18633.9	18565.6
Ойгоор бүрхэгдсэн талбай, мянган га	13448.1	13397.1	13301.1	13039.2	12917.5
Газар нутгийн ойрхог чанар, (хувь) /Загийг оролцуулснаар/	8.59	8.56	8.5	8.34	8.26

Эх үүсвэр: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

цэцэрлэгжүүлэлтийн ажилд нийлүүлж байсан бол 2010 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Архангай, Төв, Хөвсгөл, Булган, Увс, Дундговь, Завхан, Хэнтий аймгууд болон Улаанбаатар хотод байршилтай мод үржүүлгийн газруудыг өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээ авсны дүнд тарьц, суулгацын хангамжийг нэмэгдүүлэх бодит боломж бий болж, 32.6 сая ширхэг тарьц, суулгац ургаж байгаагийн 15.9 сая ширхэг нь 2011 оны тарилтанд нийлүүлэх боломжтой тарьц суулгац байна. 2010 онд улсын хэмжээгээр 167 мод үржүүлэх газар ажиллаж, тарьц суулгац үржүүлж байна.

Ойгоор бүрхэгдсэн талбай ийнхүү буурахад дараах хүчин зүйлүүд нөлөөлсөн байна. Тухайлбал,

1. 2009 онд 120 удаа ойн түймэр гарч, 161 мянган га, 2010 онд 104 удаагийн түймэр гарч 974 мянган га талбайгаар.
2. Мод бэлтгэлд 2009 онд 23.1 мянган га 2010 онд 25.1 мянган га талбай бүхий ойг ашигласан болон бусад шалтгаанаар ой бүхий талбай сүйтгэгдэж шинээр 19.5 мянган га талбайг ойжуулсан ч нийт ой бүхий талбайн хэмжээ буурчээ.

Хүснэгт 21. Нутгийн иргэд, нөхөрлөлд эзэмшүүлсэн ойн сангийн эзлэх хувь

Шалгуур үзүүлэлт	2008	2009	2010
Орон нутгийн иргэдийн хамгаалалтад авсан ой бүхий газрын хэмжээ /мян.га/ / өссөн дүнгээр/	761.7	764.5	1342.6
Нийт ойт нутагт эзлэх хувь	7.2	7.3	9.8
Хариуцах нөхөрлөлийн тоо	186	478	541

Эх үүсвэр: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Хамгаалалтанд авсан ой бүхий талбай болон ойг хамгаалах нөхөрлөлийн тоо нэмэгдсэн боловч, ой бүхий талбайн хэмжээ буурсан шалтгааныг цаашид нарийвчлан судалж, холбогдох арга хэмжээг авах шаардлагатай байна.

Авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ

2010 онд бүх аймаг, сум өөрийн ойн менежментийн төлөвлөгөөг батлуулан мөрдөн ажиллаж байна. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газарт Ой, усны хайгуул судалгааны төвийг нэгтгэж, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийж ажиллаж байна. Үүний үр дүнд Ойн хайгууль, судалгааны ажлыг хувийн хэвшил гүйцэтгэдэг шинэ тогтолцоонд шилжлээ. Үр дүнд нь:

- 2010 онд ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажлын хэмжээ өмнөх жилүүдийнхээс 4 дахин нэмэгдсэн бөгөөд голомт бүхий талбайн 80 орчим хувьд тэмцлийн ажлыг явууллаа.
- Улсын хэмжээнд гарсан ой, хээрийн түймрийн тоо өмнөх жилийнхээс 13.3 хувиар, түймэрт өртөн шатсан ойн сангийн талбайн хэмжээ 32.2 хувиар тус тус буурчээ.
- 2009 онд улсын хэмжээнд 27 сая ширхэг тарьц, суулгац бойжуулсан бол 2010 онд 32 сая ширхэг тарьц, суулгацын нөөцтэй болсон төдийгүй 762 кг модны үрийн нөөцтэй боллоо.
- Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэн ажилласны үр дүнд хууль бусаар бэлтгэсэн модны хэмжээ урд жилүүдийнхээс 62.3 хувиар буурлаа.
- Ой хамгаалах 63 нөхөрлөл шинээр байгуулагдаж 2011 оны эхний байдлаар улсын хэмжээнд нийт 541 нөхөрлөл 1.3 сая га ойн талбайг гэрээгээр эзэмшин хамгаалж байна.

- Нийт 12819.4 мян.га ойн талбайг Ойн сангийн зураглал газар зүйн мэдээллийн системд холбосон байна.
- Мэдээллийн санд тулгуурлан “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль”-ийг хэрэгжүүлэх боломжтой болсон.
- “Ойн мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх журам” баталж мөрдүүлж байна. Ойн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу 16 насанд хүрсэн иргэн бүр 1, аж ахуйн нэгж, байгууллага 5-аас доошгүй мод тарьж ургуулах, услах, арчлах бөгөөд өөрийн хүчээр гүйцэтгэх боломжгүй бол зардлыг хандивлана гэж заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж байгууллага зохих үүрэг хүлээх болсон юм.
- “Бүх нийтээр мод тарих өдөр”-тэй болох Ерөнхийлөгчийн зарлиг гарч амжилттайгаар хэрэгжиж байна.

Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрт аймаг бүр ИТХ-аар баталгаажуулсан цөлжилтийг бууруулах дэд хөтөлбөр боловсруулж, ажиллах асуудлыг тусгаж, хэрэгжүүлж эхлээд байна. Энэ хөтөлбөрт туссанаар говийн бүсийн цөлжилттэй тэмцэх үндсэн арга нь мод тарих, ой үржүүлэх, ойн зурвас байгуулах ажил байх юм.

Цөлжилтийн зэрэглэл, ангилалыг тодорхойлох аргачлалын зөрүүг арилгах нэгдсэн аргачлалыг боловсруулан мөрдүүлэв.

Засгийн газрын “Ногоон хэрэм” төслийн хүрээнд говь хээрийн бүсэд 2200 га-д ойн зурвас байгуулсаны дотор Улсын төсвөөс 2010 онд 116.5 сая төгрөгөөр зарцуулж 106 га талбайд 16-н аймгийн нутаг дэвсгэрт ойн зурвас байгуулжээ.

Ойжуулалтын сургалтын төвийг Төв аймгийн Лүн сум, Өмнөговь аймгийн Даланзадгад хотод тус тус ашиглалтанд оруулав.

Нидерландын Вант улсын засгийн газрын санхүүжилтээр “Хамтын оролцооны ойн менежментийн чадавхийг бэхжүүлэх” төсөл нь 12 загвар нөхөрлөлийг байгуулан ойн менежментийн төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар хийхэд шаардлагатай үе шатуудтай ажлуудыг гүйцэтгэсэн байна.

Ойн сангийн 64.48 хувийг газар зүйн мэдээллийн системд холбох ажил хийгдсэн. Харин 2011 онд Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Ховд аймгийн заган ойд ой зохион байгуулалтын ажил хийснээр ойн сангийн 23.5 хувийг нэмж газар зүйн мэдээллийн системд холбогдох юм.

Тулгамдаж байгаа асуудал

Ойн түймэр, мод бэлтгэл, ойн хөнөөлт шавьж, уул уурхайн нөлөөгөөр ойн талбай хумигдаж байна. Мөн талбайн хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр ойжуулалтанд зарцуулагдах төсөв бага, ойн арчилгаа тордолт муу байгаагаас уг ажлын үр дүн хангалтгүй байна.

Манай орны нийт нутгийн 90 гаруй хувь нь хуурай, хагас хуурай, чийг дутмаг нутагт хамрагдах бөгөөд нутаг дэвсгэрийн 44.7 хувийг говь, цөлийн бүс нутаг эзэлдэг. Энэ талбайн эзлэх хувь жилээс жилд нэмэгдэж байна. Үүнд дараахь хүчин зүйл голлон нөлөөлж байгаа болно. Тухайлбал,

- Бэлчээрийн даацыг хэтрүүлэн ашиглах, малын тоо толгойд ямаан сүргийн эзлэх хувь нэмэгдэх;
- Сөөг, бут, заг модыг түлшинд ихээр хэрэглэх;
- Ямар ч төлөвлөлтгүй дураараа салаа зам гаргах;
- Уул уурхайн зориулалтаар газар хөрсний бүтцийг гэмтээх, нөхөн сэргээлт хийхгүй орхих;

- Гүний ус хэт ихээр ашиглах;
- Ой модыг ахуйн хэрэгцээнд хэрэглэх;
- Газар тариалан эрхлэхдээ урьдчилан сөрөг нөлөөллийг тооцоогүй, ойн байгалийн нөхөн сэргээлтийг дэмжих үйл ажиллагаа дутмаг зэргээс цөлжилт, газрын доройтол нэмэгдэх;

Цаашид авах бодлогын арга хэмжээ


- Нийт газар нутагт ой бүхий газар нутгийн эзлэх хувийг 9 хувьд хүргэхийн тулд ойжуулалтын ажлын хүчин чадлыг нэмэгдүүлэх тарьц суулгацны чанар хангамжийг сайжруулахаас гадна түүний арчлалт, хамгаалалтын асуудлыг хариуцахад гарах зардалтай холбогдож төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх;
- Мөн ойд түймэр, хортноос учруулах сөрөг нөлөөллийг багасгах дэс дараатай арга хэмжээ авах, ой модыг ахуйн хэрэглээнд хэрэглэхийг багасгах, сэргээгдэх эрчим хүч болох нар, салхины хүчээр ажилладаг халаагуур суурилуулах асуудлыг судлан хэрэгжүүлэх;
- Улсын төсөв болон бусад эх үүсвэрээс жил бүр тодорхой хэмжээний санхүүжилтийг ойжуулах үйл ажиллагаанд зарцуулдаг ч сүүлийн 5 жилд нийт ойт нутгийн 0.176 хувийг шинээр ойжуулсан талбай эзэлж байна. Энэ нь ойжуулалтын ажилд зарцуулагдах төсөв зардал маш бага 1 га талбайд ойжуулалт хийх ажлын зардал маш доогуур байгаатай шууд холбоотой байна. Иймээс улсын төсөв болон бусад эх үүсвэрээс ойжуулах ажлын санхүүжилтийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ нөхөн сэргээгддэг баялагийн хувьд ойн тогтвортой ашиглалтыг бий болгох замаар ойг ургуулах, хамгаалах ажлын санхүүгийн эх үүсвэрийг ойгоос өөрөөс нь бүрдүүлдэг тогтолцоонд шилжүүлэх.

Хоёр. Улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн эзлэх хувь

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Улсын тусгай хамгаалалтанд авах газрын хэмжээг нэмэгдүүлэхэд ашигт малтмалын лиценз бүхий талбай гол бэрхшээл учруулдаг. Мөн гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газар, ойн сан бүхий газрын хамгаалалтын бүсэд ашигт малтмал хайх, олборлохыг хориглох тухай хуулийг хэрэгжүүлэх асуудал ихээхэн бэрхшээлтэй тулгарч байна.

Дүрслэл 14. Улсын тусгай хамгаалалтад тухайн онд авсан газар нутгийн хэмжээ, сая га.



Эх үүсвэр: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Хүснэгт 22. Улсын тусгай хамгаалалтанд авсан газар нутгийн хэмжээ, эзлэх хувь

Шалгуур үзүүлэлт	2009	2010
1 Улсын тусгай хамгаалалтад авсан нийт газрын хэмжээ, сая га	220.4	226.9
2 Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ, мянга.кв.км	1564.1	1564.1
3 Улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн эзлэх хувь	13.7	14.4

Эх үүсвэр: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Энэхүү зорилтыг ханган биелүүлэхийн тулд Монгол Улсын Засгийн газраас идэвхитэй ажиллаж байгаа бөгөөд ТХГН-ийн тоо 1990 онд 10 байсан бол 2010 оны байдлаар 71-д хүрч, нийт 253.5 сая га газар буюу улсын нийт нутаг дэвсгэрийн 16.2 хувь нь улсын тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээнд хамрагдсан байна.³¹ Одоо 16.31 сая га талбай бүхий 911 газар орон нутгийн тусгай хамгаалалтанд хамрагдаад байгаа нь Монгол Улсын нийт газар нутгийн 10.3 хувийг эзэлж байна.

Авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ

Хоёр улсын хил дамнан тусгай хамгаалалттай газар нутаг бий болгох талаар ОХУ-тай хэлэлцээр хийх, гэрээ байгуулахаар гэрээний төслийг хэлэлцэн дэмжиж, төслийг ОХУ-ын Байгалийн нөөцийн экологийн яаманд хүргүүлээд байна.

2010 оны байдлаар нийт 71 тусгай хамгаалалттай газрын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулдаг

24 хамгаалалтын захиргаанд 95 удирдах ажилтан, мэргэжилтэн, 225 байгаль хамгаалагч ажиллаж байна.³² Газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах үндэслэл, судалгааг хийх, боловсруулах ажлыг ШУА-ийн Геологи, газар зүйн хүрээлэнтэй хамтран гүйцэтгэж байна. Жил бүрийн улсын төсвөөр газар нутгийн судалгааг хийх ажлыг санхүүжүүлж байна.

Монгол Элс орчмын газар нутаг болон Улаагчны хар нуур түүний орчмын газар нутгийг байгалийн цогцолборт газрын ангиллаар, Алтан хөхий уул түүний орчмын газар нутгийг байгалийн нөөц газрын ангиллаар, Хүрэн бэлчир түүний орчмын газар нутгийг байгалийн дурсгалт газрын ангиллаар (600 мян.га орчим) улсын тусгай хамгаалалтанд авах асуудлыг УИХ-ын 2010 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 06 дугаар тогтоолоор шийдвэрлэв. Түүнчлэн Чойрын Богд уул, Бүрдэнэ булаг, Арван найман Богд уул, Дэлгэрхангай уул, Онгонтан булаг тэдгээрийн орчмын газрыг Байгалийн нөөц газрын ангиллаар, Бага газрын

31 БОАЖЯ-ий ТӨАН-дэй баяд аяаааи айзэд, 2011 ий 4 аяаааааа

32 БОАЖЯ-ий ТӨАН-дэй баяд аяаааи айзэд, 2011 ий 4 аяаааааа

чулууг Байгалийн дурсгалт газрын ангиллаар тус тус /150,0 орчим мян.га/ Улсын тусгай хамгаалалтанд авах асуудлыг УИХ-ын чуулганд хэлэлцүүлэхээр бэлтгэжээ.

ТХГН-ын санхүүжилтийн 90 хувийг улсын болон орон нутгийн төсвөөс, үлдсэн 10 хувийг өөрийн олсон орлогоор (хандив, тусламж, аялал жуулчлалын болон бусад ажил, үйлчилгээ, хохирлын нөхөн төлбөрийн орлого) бүрдүүлж байна.

Засгийн газрын 2006 оны 87 дугаар тогтоолоор ТХГН дахь хяналт шалгалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор ТХГН-ийн хамгаалалтын захиргааны нэг байгаль хамгаалагчийн хариуцан хамгаалах газар нутгийн хэмжээг байгаль газар зүйн бүсийн ялгавартайгаар багасган тогтоосон нь байгаль хамгаалагчдад хариуцан хамгаалж буй газар нутагтаа тавих хяналт, хамгаалалтыг сайжруулах ажилд боломж олгов.

Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын менежментийг олон улсын түвшинд хүргэх үүднээс Хамгаалалтын захиргааны бүтэц, орон тоог шинэчлэн боловсруулж БОАЖ-ын сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн сайдын А-100 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тулгамдаж буй асуудал

- Монгол улсын төр засгаас тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх, хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөж тэдгээрийн хамгаалалтын менежментийг орчин үеийн шаардлага, олон улсын түвшинд хүргэх, удирдлагын оновчтой

бүтцийг бий болгох, мэргэжилтэй боловсон хүчний хангамжийг сайжруулах, материаллаг баазыг бэхжүүлэх талаар нэлээд анхаарал тавьж шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

- Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын удирдлагыг сайжруулах, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд санхүүжилтийн асуудал ихээхэн бэрхшээлтэй байна. Хамгаалалтын захиргааны төсвийн одоогийн хэмжээг 2-3 дахин нэмэгдүүлж байж ТХГН-аа хамгаалах үйл ажиллагааг хэвийн хэмжээнд зохион байгуулах бололцоотойг олон улсын байгууллагаас хийсэн тооцоо судалгаа харуулж байна.
- Тусгай хамгаалалттай газар нутгийн үнэ, ач холбогдлыг үнэлэх экосистемийн үйлчилгээний үнэ цэнэ, үр өгөөжийг тогтоож, ТХГН-ийн хамгаалалтанд зарцуулах санхүүжилтийг нэмэгдүүлэх, эх үүсвэрийг өргөжүүлэх шаардлагатай байна.

Цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ

- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай болон Орчны бүсийн тухай хуулиудыг улс орны хөгжлийн өнөөгийн түвшин, олон улсын жишиг хандлагад нийцүүлэн өөрчлөх буюу шинэчлэн найруулах;
- Тусгай хамгаалалтад авах газар нутгийн судалгаа хийх, үндэслэл боловсруулах, дотоод бүсчлэл тогтоох, хяналт шалгалтын ажилд шаардагдах төсвийг нэмэгдүүлэх.

Гурав. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээ, нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулах боломж, тулгамдсан асуудал

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Монгол Улсад карбон худалдаа хийх зах зээлийн шинэ механизмийг бий болгох чадавхийг бэхжүүлэх зорилгоор Даян дэлхийн байгаль орчны стратегийн хүрээлэн (ДДБОСХ-Institute

for Global Environmental Strategies-IGES)-тэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төслүүдийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллахаар болсон. Даян Дэлхийн Байгаль Орчны Стратегийн Хүрээлэнгээс шинээр бий болж байгаа зах зээлийн механизм, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах болон агаарын бохирдлыг багасгах давхар үр ашигтай

төслүүдийг хэрэгжүүлэх боломж, нүүрсхүчлийн ялгарлыг бууруулах тооцооллын талаар мэдээлэл өгч хамтран ажиллаж байна.

Эрчим хүчний хэрэглээний өсөлт нь хүлэмжийн хийн ялгарлыг ихэсгэх гол хүчин зүйл болдог бөгөөд 2005 онд хүлэмжийн хийн ялгарлын нийт ялгаруулалт 14,519 Ггр байсан бол 2006 онд 15,628 Ггр болж 7.6 хувиар өссөн байна.

Хүлэмжийн нийт ялгаруулалт эрчим хүчний салбараас 65,4 хувь, газрын ашиглалтын өөрчлөлт хөдөө аж ахуй, ойн салбараас 41,4 хувь, ойн салбараас 13,3 хувь нь бүрдэж байна. Багахан хэмжээг нь үйлдвэрлэлээс 5.6 хувь, хог хаягдлаас 0.9 хувь ялгарч байгааг 2006 онд явуулсан хүлэмжийн хийн тооллогоор тогтоогдсон байна. Үүнд ойн салбар нь шингээгчийн үүргийг гүйцэтгэж хүлэмжийн хийн ялгаруулалтын 13.3 хувийг шингээж байна. Иймд нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг сааруулах аливаа арга хэмжээ нь ялгаруулагч болон шингээгч салбарын аль алиныг

нь харгалзан тооцож, ялгарлыг бууруулахын зэрэгцээ шингээлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг авах шаардлагатай.

Хог хаягдал боловсруулж эрчим хүч үйлдвэрлэн жилд 459,000 тн CO₂, барилгад эрчим хүчний хэмнэлттэй технологи нэвтрүүлж 1000 байшин дулаалахад 7800 тн CO₂, гэр хороололд дулаалгын нөхцөлийг сайжруулж гэрийн бүрээсээр хангаснаар жилд 80,000 тн CO₂ бууруулах боломжтой байна. Сайншандын салхин парк байгуулснаар жилд 174,000 тн CO₂, Салхитад салхин парк байгуулж жилд 180,000 тн CO₂, Чойрын салхин парк байгуулснаар жилд 180,000 тн CO₂, биогазын үйлдвэр байгуулж жилд 25,440 тн CO₂, Улаанбаатар хотын орон сууцны барилгын эрчим хүчний үр ашгийг сайжруулснаар жилд 100,000 тн CO₂, Оюутолгойн 250 МВт-ийн салхин цахилгаан станц байгуулснаар 1,411,964 тн CO₂ бууруулах боломжтой бөгөөд нийт тооцоогоор 983 сая ам.долларын хөрөнгө оруулалт зарцуулж, жилд 2,687,689тн CO₂ бууруулах боломжтой юм.

Хүснэгт 23: Түлшний шаталтаас үүсэх CO₂-ын ялгаралтын хэмжээ

Үзүүлэлт	2007	2008	2009	2010
Нүүрсхүчлийн хийн ялгаралтын хэмжээ, CO2 мян. тонн /Нүүрс/	8998.8	8915.5	9739.5	10393.9
Нүүрсхүчлийн хийн ялгаралтын хэмжээ, CO2 мян. тонн /газрын тос/	2447.9	2616.7	2395.1	2548.9
Түлшний шаталтаас үүсэх CO2 ын ялгаралтын хэмжээ, CO2 мян. тонн	11446.7	11532.2	12134.6	12942.8
Нэг хүнд ногдох нүүрсхүчлийн хийн ялгаралтын хэмжээ, тн /хүн	4.34	4.3	4.44	4.65

Эх үүсвэр: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Дээр дурьдсан үр дүнд хүрэх төслүүдийг хэрэгжүүлэхэд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай тул улсын төсөв, хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх техник эдийн засгийн нарийвчилсан судалгаа, өртөг үр ашгийн тооцоо хийж, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, дүгнэлт гаргах хэрэгтэй.

Цэвэр хөгжлийн механизм /ЦХМ/-ын хүрээнд дээрх төслүүдийг хэрэгжүүлэх боломжтой боловч хөрөнгө оруулалтын хэмжээ өндөр, ЦХМ-д хамрагдахад арга зүйн хувьд суурь ялгаралтыг тооцоолоход бэрхшээл тулгардаг. Салхин цахилгаан станцуудын хувьд эрчим хүчний сүлжээнд холбоход хүндрэлтэй байдаг учир нарийн шалгуур шаардлага тавигддаг. ЦХМ-ын зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нарийн

төвөгтэй. Мөн сэргээгдэх эрчим хүчний сангийн үйл ажиллагаа тогтворжоогүй нь бас бэрхшээл учруулж байна.

Цаашид авах арга хэмжээ

- Монгол Улс 2010 онд НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцид хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах Үндэснийхээ зохистой арга хэмжээний саналыг хүргүүлсэн. Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийг УИХ-аар хэлэлцэн батлах ёстой. Уур амьсгалын өөрчлөлтийн хөтөлбөрт Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах болон уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлого, стратеги, арга хэмжээний чиглэлийг тусгасан болно. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээ нь эдийн засгийн ногоон хөгжлийг

бүрдүүлэх тогтвортой хөгжлийн бодлогын чухал хэрэгсэл болох юм;

- Эрчим хүчний салбарт сэргээгдэх эрчим хүчний болон бусад цэвэр эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх, эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх, цэвэр түлшний үйлдвэрлэлийг дэмжих, уурын зуухны эрчим хүчний үр ашгийг сайжруулах, шинэ уурын зуух суурилуулах, эрчим хүчний хэрэглээний хувьд хэмнэх, тоолууржуулах, барилгыг дулаалах болон үйлдвэрүүдийн эрчим хүчний үр ашгийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэхийн хамт Эрчим хүчний хэмнэлтийн хуулийг боловсруулах;
- Зам, тээврийн салбарт үндэсний зам тээврийн системийг сайжруулах (төмөр замын тээврийг сайжруулах, цахилгаан тээврийг хөгжүүлэх, дамжин өнгөрөх ложистик төвүүдийг бий болгох), эко тээврийн стратеги (замын хөдөлгөөний үр ашигтай менежмент, нийтийн тээврийн хэрэгслийн төрлийг нэмэгдүүлэх,

түлшний үр ашигтай автомашины хэрэглээг дэмжих) зэрэг бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх;

- Хөдөө аж ахуйн салбарт малаас авах бүтээгдэхүүний өгөөжийг нэмэгдүүлэх, байгальд зохицсон мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлэх, газрын элэгдэл доройтлыг бууруулах;
- Ойн салбарын шингээлтийг нэмэгдүүлэхийн тулд ой, хээрийн түймрээс хамгаалах, ойн хортон шавьж өвчнөөс хамгаалах, түүнтэй тэмцэх, ойг нөхөн сэргээх, байгалийн сэргээн ургалтыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Хог хаягдлын менежментийг сайжруулах, хог хаягдлыг дахин боловсруулах, эргүүлэн ашиглах арга хэмжээг хэрэгжүүлэх.

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхэд салбар дундын зохицуулалт нэгдсэн бодлого чиглэл баримталж улсын болон гадаад орны төсөл, хөтөлбөрийг чиглүүлэх хэрэгтэй байна.

Дөрөв. Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн өвлийн нэг хоногийн дундаж агууламж NO_2 (мкг/м³) - Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн өвлийн улирал дахь нэг хоногийн дундаж агууламж SO_2 (мкг/м³) - ийн хэмжээг стандартын түвшинд хүргэх.

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Улаанбаатар хотын хэмжээнд 2009 он хүртэл агаарын чанарыг 4 цэг дээр 2 үзүүлэлтээр тодорхойлж байв. Хяналт шинжилгээний сүлжээг өргөжүүлэх, сайжруулах чиглэлээр авсан арга хэмжээний дүнд 2009 онд агаарын чанарын 2 харуул, 2010 онд БНФУ-ын Засгийн

газрын хөнгөлөлттэй зээлээр агаарын чанарыг хянах суурин 5, хөдөлгөөнт 1 харуулыг нэмж байгуулснаар Улаанбаатар хотын агаарын чанарыг нийт 11 цэгт 3-8 үзүүлэлтээр хоногийн турш тасралтгүй хянаж тодорхойлж байна.


Ингэснээр агаарын чанарын хяналтанд хамрагдах нутаг дэвсгэрийн хэмжээ ихсэж, хэмжлийн чанар сайжирлаа.

Дүрслэл 15. Улаанбаатар хотын агаарын чанарыг хянах суурин харуулуудын байршил зүйн зураг



Эх үүсвэр: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Дүрслэл 16. Агаар бохирдуулах бодис хүхэрлэг хий, азотын давхар ислийн жилийн дундаж агууламж




Эх үүсвэр: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Дүрслэл 16-оос харахад хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж 2009 онд 20 мкг/м³ байсан бол 2010 онд 27 мкг/м³ болж, өмнөх жилээс 7 мкг/м³-ээр өссөн байна. Азотын давхар ислийн жилийн дундаж агууламж 2009 онд 28 мкг/м³, 2010 онд 36 мкг/м³ болсон байна.

Шинжилгээний дүнгээс харахад АЧС дахь ХХХ-нээс давж бохирдох тохиолдлын тоо нилээд өсч байна:

- Хүхэрлэг хийн агууламж 2009 онд жилийн нийт ажиглалтын 33.7 хувь нь, 2010 онд 44.8 хувь нь, Азотын давхар ислийн агууламж 2009 онд 14.1 хувь, 2010 онд 28.3 хувь, 10 микроноос бага хэмжээтэй тоосонцорын агууламж 2009 онд 29.3 хувь, 2010 онд 52.3 хувь нь хүлцэх хэм хэмжээ (ХХХ)-нээс давсан байна.

Дүрслэл 17. Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн өвлийн сарын хоногийн дундаж агууламж, (2009 оны 11-дүгээр сараас 2010 оны 01-дүгээр сар)




Эх үүсвэр: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

2009-2010 оны өвлийн сард хүхэрлэг хийн дундаж агууламж 48 мкг/м³ байгаа нь АЧС дахь ХХХ (24 цагийн дундаж 20мкг/м³)-ээс 2.4 дахин их байна.

Өвлийн хугацаанд нийт 385 удаа хэмжилт хийснээс 362 удаа нь ХХХ-ээс давж, үүнээс 97.7 хувь нь 12, 1 дүгээр сард ажиглагдсан байна.

Дүрслэл 18. Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн өвлийн сарын хоногийн дундаж агууламж (2009 оны 11-р сараас 2010 оны 1-р сар)



Эх үүсвэр: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Дүрслэл 18-аас харахад 2009-2010 оны өвлийн сард азотын давхар ислийн дундаж агууламж 40 мкг/м^3 байгаа нь АЧС дахь ХХХ (24 цагийн дундаж 40 мкг/м^3) түвшинд байна. Өвлийн саруудад нийт 458 удаа хэмжилт хийснээс 207 удаа ХХХ-ээс давсан. Үүнээс 49 хувь нь 1 дүгээр сард ажиглагдсан байна.

Гэр хороолол орчимд, барилгын материалын зах байрладаг цэгүүдэд хамгийн их бохирдол ажиглагдаж байгаа нь хотын дэд бүтэц болон үйлдвэрлэл, үйлчилгээ, оршин суух бүсчлэлийг зааг тогтоож мөрдүүлээгүй, гэр хорооллыг төлөвлөлтгүй тэлсэнтэй холбоотой.

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээ

Агаарын бохирдлыг бууруулахад хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар нилээд анхаарч “Агаарын тухай” хуулийг шинэчлэн баталж, түүнийг хэрэгжүүлэхэд холбогдох журмыг батлан ажиллаж байна. “Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль” шинээр батлагдсанаар бохирдуулагч нь төлбөр төлөх зарчим хэрэгжиж эхлээд байна. Мөн “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр батлагдсанаар агаарын бохирдлыг бууруулах хэтийн бодлого чиглэл тодорхойлогдсон.

Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр дотоодын болон гадаадын олон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох, тухайн бүсэд мөрдөх журам боловсруулан ердийн бохирдол ихээр ялгаруулдаг зуухыг шаталт сайтай зуухаар солих, гэрийн дулаалгыг сайжруулах, үртсэн болон хагас кокжсон түлш, цахилгаан, хийн түлшийг хэрэглэх зэрэг төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газар, БНФУ-ын Засгийн газар хоорондын “Улаанбаатар хотын агаарын бохирдлыг хянах сүлжээ” төсөл БНФУ-н Засгийн газрын хөнгөлөлттэй зээл болох 1.57 сая еврогийн санхүүжилттэй төсөл хэрэгжиж, мэдээлэл хүлээн авах, хянах систем бүхий тоног төхөөрөмжтэй агаарын чанарыг хянах суурин 5, хөдөлгөөнт 1 харуулыг Улаанбаатар хотын 5 дүүрэгт 2010 оны 6 дугаар сард суурилуулан хяналт-шинжилгээний ажлыг эхлүүлсэн.

Тулгамдаж буй асуудал

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах талаар төр засгаас арга хэмжээ авч байгаа хэдий ч төдийлөн үр дүн гарахгүй байна. Энэ нь хөдөөнөөс хот руу чиглэсэн хөдөлгөөн жил бүр нэмэгдэж хүн амын хэт их төвлөрөлийг бий болгоод зогсохгүй улмаар хотруу ирэгсэдийн ихэнх нь галлагаатай гэрт амьдарч байгаатай холбоотой юм. Гэр хорооллын айл өрх агаар бохирдуулах бодис ихээр ялгаруулдаг түүхий нүүрснээс гадна бусад зориулалтын бус түлш /машины дугуй, тоосго, хуванцар материал, хуучин гутал хувцас г.м/ түлэх, нийт тээврийн хэрэгслийн ихэнх хувийг 7-аас дээш жил ашигласан автомашин эзэлж байгаа зэрэг нь агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

Мөн 100 кВ-аас дээш хүчин чадалтай усан халаалтын уурын зуухны технологи хуучирсан, агаарт ялгаруулж буй агаар бохирдуулах бодисыг шүүх төхөөрөмж байхгүйгээс агаарт бохирдуулах бодис ихээр ялгаруулж стандартын шаардлагыг хангахгүй байна.

Цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ

- Түүхий нүүрсний хэрэглээг багасгах зорилгоор гэр хороололд барих орон сууцны хэмжээг нэмэгдүүлэх;
- Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гэр хороололд бүрэн шаталттай зуух ашиглах, дулааны алдагдлын багасгах, түлшний бүтцийг сайжруулах, цахилгаан болон хийн түлш ашиглах зэрэг хийж буй ажлыг эрчимжүүлэх;
- Агаарын бохирдлыг нэмэгдүүлж буй тээврийн хэрэгслийг ашиглалтаас гаргах механизмыг нэвтрүүлэх;
- Агаарын чанарын албан хяналт шинжилгээний багаж тоног төхөөрөмж, зөөврийн болон шууд тодорхойлдог автомат багажуудаар хангах, агаарын чанарын харуулыг автомат хэмжлийн багаж тоног төхөөрөмжөөр тоноглох ажлыг нэмэгдүүлэх;

- Гэр хороолол, нийтийн эзэмшлийн талбайг зүлэгжүүлж ойжуулан 1 хүнд ногдох цэцэрлэгжсэн талбайн хэмжээг хот төлөвлөлтийн стандартад хүргэх;
- Газар зүйн мэдээллийн системийг ашиглан агаарын бохирдлыг тооцох арга технологийг нэвтрүүлэх.

ЗОРИЛТ 15. ГОЛ, ГОРХИНЫ УСНЫ ЭХИЙГ ХАМГААЛЖ, НӨХӨН СЭРГЭЭХ ЗАМААР ШИРГЭЛТИЙГ БАГАСГАХ

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хүн амыг хүрэлцээтэй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангах нь аливаа төрийн тулгуур бодлого, үндэсний аюулгүй байдлын нэн чухал асуудлын нэг билээ. Манай орон усны нөөцөөрөө тийм ч баян орны тоонд ордоггүй бөгөөд дэлхийн 186 орны 56 дугаар байрт байна.

Усны хэрэглээний 80 хувийг газрын гүний усаар хангадаг, ундны усны хангамж харилцан адилгүй, орон сууцны нэг оршин суугч хоногт 200-250 литр ус хэрэглэдэг бол гэр хорооллын нэг хүн хоногт 8-10 литр ус, хот суурины хүн амын 30-аад хувь хатуулаг, эрдэсжилт ихтэй ус хэрэглэж байна.

Дэлхийн уур амьсгалын дулаарлын нөлөөгөөр манай улсад сүүлийн жилүүдэд мөнх цэвдэг хурдацтай хайлах, гол, мөрний эх ширгэх, урсац багасах, тасрах, рашааны ундарга багасах, ширгэх зэргээр сөрөг үзэгдлүүд улам бүр нэмэгдэх боллоо.

Гадаргын ус ховордож байгаа өнөө үед уул уурхай хөгжил эрчээ авч, гүний усны эх үүсвэрийг ашиглах явдал нэмэгдэж байгаагаас гүний усны урсац доошлох, ус ховордох, газрын хөрс чийгээр тэжээгдэхгүй болж хөрсний үржил шим буурах, хөрс элэгдэж, ургамлын сан хөмрөг өөрчлөгдөхөд хүргэж байна. Гар аргаар алт олборлогчдын хууль бус химийн хорт бодисын хэрэглээ ихэссэн нь байгаль орчин, хүний эрүүл мэнд, удмын санд ноцтой аюул учруулж байна.

Хүснэгт 24. Хамгаалалтад авсан гол мөрний усны урсац бүрэлдэх ундаргын эхийн эзлэх хувь

Шалгуур үзүүлэлт	2007	2008	2009	2010	2015*
Хамгаалалтад авсан гол мөрний усны урсац бүрэлдэх эхийн ундаргын эзлэх хувь	30,0	35,4	35,4	39,76	80
Хамгаалалт барьж тохижуулсан усны эх үүсвэр, булаг шандын эхийн тоо	255	163	244	392	Нийт 1000
Завсарын үзүүлэлт	2007	2008	2009	2010	
Гол мөрний урсац бүрэлдэх ундаргын эхийн нийт талбай, км ²	144239.505	144239.505	144239.505	144157.608	
Хамгаалалтад авсан гол мөрний усны урсац бүрэлдэх эхийн ундаргын нийт талбай, км ²	-	51056.554	51056.554	57319.085	

*-Зорилтод түвшин
Эх үүсвэр: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Урсац бүрэлдэх эх нутгийг тусгай хамгаалалтанд хамруулах зорилгоор Тэнгис-Шишгэдийн голын ай сав газрын 869.1 мян.га, Зэд-Хантай-Бүтээлийн нурууны 611.3 мян.га газрыг шинээр, Мянган-Угалзатын нурууны байгалийн цогцолборт газрыг өргөтгөж 234.3 мян.га, Мөнххайрханы байгалийн цогцолборт газрыг өргөтгөж 191.5 мян.га, Улаан Тайгын байгалийн цогцолборт газрыг өргөтгөж 326.3 мян.га, Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрыг өргөтгөж 342.2 мян.га газрыг тус тус улсын тусгай хамгаалалтанд хамруулаад байна.

2009 онд нийт 244 булаг шанд, усны эх үүсвэрийг хамгаалалтанд авсан ба үүнээс улсын төсвийн хөрөнгөөр 145, төсөл хөтөлбөр, орон нутгийн болон иргэд, ААНБ-ын хөрөнгөөр 99 булаг шандын эхийг тохижуулжээ.

2010 онд Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутагт орших Балгасны улаан нуур, Увс аймгийн Чандмань Улаан уул, Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын Рашаантын 50 га, Алтай сумын Улаан хадын 45 га газрыг, Булган аймгийн Зэд-

Бүтээлийн нурууны Сэлэнгэ суман дахь 243465,2 га, Тэшиг суман дахь 320152,6 га газрыг тус тус орон нутгийн тусгай хамгаалалтанд авлаа. Нийт 387 булаг шанд, рашааны эхийг хашиж хамгаалан тохижуулжээ. Үүнээс улсын төсвөөр 145, орон нутгийн төсвөөр 32, гадаад дотоодын төсөл, хөтөлбөрөөр 173, иргэд аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгөөр 37 булаг шандын эхийг хамгаалан тохижуулсан байна.

Авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ

“Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2010 онд гол мөрний урсац бүрэлдэх эхийн 109 талбайг хамгаалалтанд оруулсан.

Усны сан бүхий газрын нийт 5677 объект 9090.1 мян.га талбайд хамгаалалтын бүс тогтоосон. Ийнхүү нийт усны сан бүхий газрын болон урсац бүрэлдэх эхийн 90 гаруй хувийг хамгаалалтанд авах боломж бүрдсэн.


Туул, Хэрлэн, Ерөө голуудын цутгалаг голуудын ойн санг түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх,

хамгаалах зорилгоор Төв аймгийн Мөнгөнморьт, Мандал сум Түнхэл тосгон, Эрдэнэ сум, Улаанбаатар хотын ногоон бүсэд нийт 4 ширхэг харуулын цамхагийг байгуулж, голуудын цутгалаг голуудын ойн санд багтдаг аймгуудад ой, хээрийн түймэртэй тэмцэхэд хэрэглэх багаж, тоног төхөөрөмжүүдийг хуваарилаад байна.


Монгол орны гадаргын усны нөөцийн 70 хувь бүрдэх эхийн ойн санд хөнөөлт шавж, өвчний тархалтыг тогтоох судалгааны ажлыг Архангай, Хөвсгөл, Завхан, Төв, Хэнтий зэрэг 13 аймгийн 78 сумын нийт 2000.0 мян.га ойн санд хийсний үр дүнг үндэслэн дээрхи газруудад ойн хөнөөлт шавж, өвчний голомтыг хязгаарлах, тархалтыг бууруулах тэмцлийн ажлыг 122.8 мян.га талбайд зохион байгуулсан.

Орхон, Хэрлэн голуудын урсац бүрэлдэх эхийн экосистемийн өнөөгийн төлөв байдалд үнэлгээ өгөх судалгааны ажлыг усны чиглэлийн үнэлгээний байгууллагаар, Ховд, Буянт, Онон, Туул голуудын урсац бүрэлдэх эхэд дээрх судалгаа болон цаашид хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төслийг нарийвчлан тодорхойлох ажлыг сав газрын зөвлөлүүдээр хийлгэхээр зөвлөмж, чиглэл өгч ажиллаж байна.

Дүрслэл 19. Гол мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн зураглал



Дүрслэл 20. Гол мөрний урсац бүрэлдэх эхийн хамгаалалтад авсан байдал (2010)



Туул голын сав дагуу үйл ажиллагаа явуулж буй байгууллага, аж ахуйн нэгж, ТББ-ууд Туул голыг хамгаалах аяныг дэмжиж, нэгдэн ажиллаж, гол доторх болон эрэг дагуух хогийг цэвэрлэж, 16 гаруй тонн хогийг ачуулсан байна.

Архангай, Ховд, Дорноговь аймгуудын Онцгой байдлын хэлтэс булгийн урсацыг нэмэгдүүлэх зорилгоор рашааны орчмын хог хаягдлыг цэвэрлэх, шандын эхийг хашаа татаж хамгаалах ажлыг иргэд, албан хаагчдын нөөц бололцоог ашиглан хийж гүйцэтгэв.

Тулгамдаж буй асуудал

- Гол мөрний урсац бүрэлдэх, эхийн хамгаалалтыг нэмэгдүүлэхэд байгаль орчныг хамгаалах, усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах талаар ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ойлголт, мэдлэг тааруу байна. Усны сан бүхий газар болон гол мөрний урсац бүрэлдэх эхийн орчимд эрдэс баялаг ашиглахтай холбоотой иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хайгуул, олборлолт хийх үйл ажиллагааны зөвшөөрөл олгох асуудлыг байгаль орчны нөлөөллийг тооцолгүй шийдвэрлэж байгаа нь ихээхэн бэрхшээл учруулж байна.
- Гол мөрний урсац бүрэлдэх эхийг хамгаалах, сав газрын хэмжээнд усны нөөцийн зохистой

ашиглалт, хэрэглээг бий болгох, усны нөөцийг бохирдох хомсдохоос хамгаалах арга хэмжээг орон нутагт хариуцан хэрэгжүүлэх хүний нөөц, чадавхи хангалтгүй байна. Иймд усны нөөцийн ашиглалт, хамгаалалтын асуудлаар шийдвэр гаргахад олон нийт, бүх оролцогч талуудын тэгш оролцоог хангах зорилгоор усны нөөцийн нэгдсэн менежментийг Монгол оронд хэрэгжүүлэх, усны нөөцийг орон нутагт хариуцах мэргэжлийн эзэнтэй болгох шаардлагатай байна.

Цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ


- Усны сан бүхий газар болон гол мөрний урсац бүрэлдэх эхийн орчимд хайгуул, олборлолт хийх үйл ажиллагааны зөвшөөрөл олгохыг хязгаарлах;
- Булаг шанд, голын эхэнд хог хаягдлын бөөгнөрлийг бий болгохгүй байх;
- Гүний усыг хэт их ашиглах болсонтой холбогдуулан гүний усны хэрэглээнд хязгаарлалт тавих эрх зүйн орчинг бүрдүүлэх;
- Урсгал гол, гол усны эргэн тойронд усыг бохирдуулах үйлдвэр, үйлчилгээ явуулах эрх олгохгүй байх.

ЗОРИЛТ-16. 2015 ОН ГЭХЭД БАТАЛГААТ УНДНЫ УСНЫ ХАНГАМЖГҮЙ, САЙЖРУУЛСАН АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИД ХАМРАГДААГҮЙ ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВИЙГ БУУРУУЛАХ.

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2005 оны байдлаар Монгол Улсын 2.5 сая хүн амын 39.2 хувь нь баталгаат ундны усны хангамжтай (үүнээс 22 хувь нь төвлөрсөн усан хангамжийн системээс, 8.5 хувь нь шугаманд холбогдсон ус түгээх байрнаас, 8.6 хувь нь хамгаалагдсан худгаас, 0.1 хувь нь хамгаалагдсан булгаас ундны усаа хэрэглэж байсан), 26.6 хувь нь сайжруулсан ариун цэврийн байгууламжинд хамрагдсан байлаа. Харин 2010 оны байдлаар Монгол Улсын 2.8 сая хүн амын 47.8 хувь нь баталгаат ундны усны хангамжтай /үүнээс 22.5 хувь нь төвлөрсөн ус хангамжийн системээс, 15.3 хувь нь шугаманд холбогдсон ус түгээх байрнаас, 9.9 хувь нь хамгаалагдсан худгаас, 0.1 хувь нь хамгаалагдсан булгаас ундны усаа авч хэрэглэж байна/, 30 хувь нь сайжруулсан ариун цэврийн байгууламжинд хамрагдаж байна.

Дүрслэл 21. Ус хангамж, сайжруулсан ариун цэврийн байгууламж



Авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ

Нийтийн аж ахуйн суурь үйлчилгээг сайжруулах төслөөр усны шинэ эх үүсвэр бий болгох, одоо байгаа ус түгээх байрыг төвлөрсөн цэвэр усны шугамд холбох болон ус түгээх байрыг нэмэгдүүлэх

замаар гэр хорооллын усан хангамжийн тоо, чанарыг сайжруулах, гэр хороололд байрлах зарим олон нийтийн байгууллагуудыг цэвэр, бохир усны шугаманд холбох, усны бие даасан холболт хийх нөхцөлийг бүрдүүлээ.

Хот суурин газрын хүн амын усны хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр олон төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэний хамт хөдөөгийн малчдын усны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор улсын төсвөөс 2006-2009 онд 14.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, 1899 ширхэг инженерийн хийцтэй худаг гаргасан байна. Үүний дүнд хамгаалагдсан худгаас усаа авдаг хүний эзлэх хувь 2005 оноос 1.3 нэгжээр өсч, 9.9 хувь болсон байна.

“40000 орон сууц” хөтөлбөр, “Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд 33,2 мянган өрх төвлөрсөн цэвэр, бохир усны шугам сүлжээтэй орон сууцанд амьдарч байна.

Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2010 оны 36-р тогтоолоор “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр, 2010 оны 24-р тогтоолоор “Ус” үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2008 оны 303-р тогтоолоор “Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөр”-ийг тус тус баталж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэл болон хөгжлийн баримт бичгүүдэд тусган, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Нийт 18 аймгийн төв, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн системтэй бөгөөд, салбарын инженерийн хангамжийн талаархи мэдээллийг дараахь хүснэгтээр харуулав:

Хүснэгт 25. Төвлөрсөн ус хангамжийн системд холбогдсон барилга байгууламжинд амьдарч буй хүний тоо, 2010 он.


Инженерийн хангамж	Хэмжих нэгж	Үзүүлэлт
1 Төвлөрсөн ус хангамжийн системд холбогдсон барилга байгууламжинд амьдарч буй хүний тоо	Мян.хүн	924.7
2 Зөөврийн усаар хангагддаг хүний тоо	Мян.хүн	801.0
3 Ус түгээх байр: Үүнээс шугаманд холбогдсон:	Ш	945 367
4 Гүний худгийн тоо	Ш	350
Усан сан	Ш	329
5 Цэвэр усны өргөх станцын тоо Хүчин чадал	Ш м.куб/хон	53 17770.16
Шугам хоолойн урт	Км	1886.6
6 Цэвэр усны Бохир усны	Км Км	1261.7 624.9
7 Цэвэрлэх байгууламжийн хүчин чадал	м.куб/хон	870

Эх үүсвэр: Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам

Сүүлийн жилүүдэд ус хангамж, ариун цэврийн байгууламжийг сайжруулахад оруулж буй улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж, 2006 онд 3.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн бол 2010 онд 13.02 тэрбум болж 4 дахин өссөн байна.

2005-2010 онд улсын төсвийн 70-аад тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хот, Увс аймгийн Улаангом, Завхан аймгийн Улиастай, Төв аймгийн Зуунмод, Говьсүмбэр аймгийн Чойр, Дундговь аймгийн Мандалговь, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Орхон-Хөтөл, Дорноговь, Говь-Алтай, Дорнод, Дархан-Уул аймгийн Шарын гол сум, Өвөрхангай аймагт цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээ, усан сан, цэвэрлэх байгууламж, гүний худаг, үерийн хамгаалалтын далан зэрэг барилга, байгууламжийг шинээр барьж ашиглалтад оруулав.

Дүрслэл 22. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ (2006-2010)



2005-2010 онд Дэлхийн банкны хөнгөлттэй зээлээр хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах 2 дахь шатны төсөл”-ийн хүрээнд 736.0 мянган ам.долларын хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотын 7 гэр хороололд 103 ус түгээх байр, АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр “Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйг сайжруулах төсөл”-ийн хүрээнд 300.0 мянган ам.долларын хөрөнгө оруулалтаар 8 аймгийн төвийн гэр хороололд 40 ус түгээх байр тус тус барьж шугаманд холбосноор 426800 хүн найдвартай ус хангамжийн эх үүсвэртэй боллоо. АХБ-ны дэмжлэгтэйгээр ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тоног төхөөрөмж, цэвэрлэх байгууламжийг шинээр барьж, шинэчлэх ажлууд хийгдсэн байна.

НҮБХХ-ийн санхүүжилтээр “Ус хангамж, ариун цэврийн байгууламжийг сайжруулах МОН/08/302 төсөл”-ийн хүрээнд Говь-Алтай аймгийн Баян-Уул, Бигэр, Тонхил, Төгрөг, Ховд аймгийн Дөргөн, Манхан, Мянгад, Зэрэг сумдад ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн систем, бага оврын цэвэрлэх байгууламж барьж байна.

Германы техник, хамтын ажиллагааны нийгэмлэг (GTZ)-ийн техникийн туслалцаатайгаар “Хотын хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд байгаль орчинд сөрөг нөлөөгүй, хуурай жорлонгийн шинэ технологийг (ЭКОСАН) нэвтрүүлж, Улаанбаатар хотод хэд хэдэн газарт суурилуулан ажиллуулж байна.

Испани Улсын Засгийн Газрын урт хугацааны, хөнгөлөлттэй зээлээр Улаанбаатар хотын Төв

цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийг шинэчлэх 2 үе шатны төсөл, Чехийн Засгийн газрын техникийн туслалцаагаар “Сум, суурин газрын ундны усны чанарыг сайжруулах” төсөл, Японы Засгийн газрын буцалтгүй тусламжаар “Дархан хотын ус хангамжийг сайжруулах төсөл”, АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр “Хот байгуулалтын салбарын төсөл”, Францын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр “Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл”-үүдийг хэрэгжүүлэв.

Дээр дурдсан төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэний үр дүнд цэвэр усны 300-аад км, бохир усны 200-аад км, дулааны 70-аад км шугам сүлжээг шинэчилж, 15 цэвэрлэх байгууламж, 150 ус түгээх байр барьж, 17 аймгийн 110 сумын худагт ус зөөлрүүлэх тоног төхөөрөмж суурилууллаа. Ингэснээр ус хангамж, ариутгах татуургын хүчин чадал 3 дахин нэмэгдэж, хот суурины 400-аад мянган хүний ажиллаж, амьдрах нөхцөл дээшилсэн байна.

Гэвч цаашид гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, ашиглагч байгууллагууд төсөл хэрэгжиж эхлэх үеэс суурь судалгааны ажилд оролцож, зайлшгүй шийдүүлэх асуудлаа зөв тусгах, төслөөр хийгдэж буй барилга угсралтын ажилд чанар, аюулгүй байдлын хяналтыг тогтмол тавьж ажиллахад анхаарах шаардлагатай байна.

Тулгамдаж буй асуудал

Сүүлийн жилүүдэд орон сууц олноор баригдаж байгаа боловч, нийслэл болон томоохон хотуудад хүн амын шилжин ирэх хөдөлгөөн ихэссэнтэй холбоотойгоор төвлөрсөн ус хангамжийн системээс ундны усаа хэрэглэдэг хүн амын эзлэх хувь төдийлөн өсөхгүй байна.

Хүн амын ихэнхи хувь оршин суудаг гэр хороолол болон зуслан, суурин газрын эмнэлэг, сургууль зэрэг нь бохир ус татан зайлуулах систем байхгүйгээс хөрс, ус болон байгаль орчныг ихээхэн бохирдуулж байна. Иймд байгаль орчинд сөрөг нөлөөгүй, ашиглалтын зардал хямд, шинэ дэвшилтэт техник, технологи бүхий бага оврын цэвэрлэх байгууламжийг олноор нь барих шаардлагатай байна.

Хот, суурин газруудын унд, ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг цэвэрлэх зориулалттай механик цэвэрлэгээтэй 5, биологи цэвэрлэгээтэй 35, нийт 40 цэвэрлэх байгууламж ашиглагдаж байгаагаас хэвийн ажиллагаатай 22, хэвийн бус ажиллагаатай нь 18 байгаа бөгөөд ихэнхи цэвэрлэх байгууламжууд нь технологийн дагуу ажилладаггүй, өртөг зардал, тоног төхөөрөмж нь хуучирсан тул байгаль орчныг бохирдуулан, хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.

Төв суурин газрын хүн амын нягтрал ихсэн, барилга, байгууламж олноор баригдаж, үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны цар хүрээ, цэвэр усны хэрэглээ, бохир усны хэмжээ нэмэгдсэнтэй холбогдон газрын доорх ба дээрх усны нөөц хомсдож, чанар нь доройтож, бохирдож байна.

Туул, Хараа, Ерөө зэрэг томоохон голуудын ус татарч, голын ай сав бохирдон, ой мод, хөрс ургамлын бүрхэвч доройтсоноос газрын доорхи усны тэжээл багасч байгаа нь Улаанбаатар хот болон хот, суурины ундны усны нөөц, хүрэлцээг нарийвчлан тогтоох, дахин үнэлэх, хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Байгалийн усны нөөцийн нөхөн сэргэх чадавхийг дээшлүүлж, нөөцийг үр ашигтай ашиглах, төвлөрсөн шугам сүлжээний ашиглалт, үйлчилгээг сайжруулах, шинэчлэн засварлах, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, усны алдагдлыг багасгах, ус хангамжийн үйлчилгээг эрхэлж буй байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, шинэ техник технологи нэвтрүүлэх, цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг сэргээх, гэр хорооллыг цэвэр, бохир усны сүлжээнд холбох, бага оврын цэвэрлэх байгууламж ашиглах зэрэг асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Ус хангамжийн салбарын норм норматив, стандартыг евро стандарт руу хөрвүүлэх, шинээр боловсруулах шаардлагатай байна.

Цэвэр, бохир усны чанарын хяналт, шинжилгээ хийх лаборатори байгуулах шаардлагатай байна.

Амины орон сууц, гэр хороолол, хотын захын эмнэлэг, сургууль, цэцэрлэгийг төвийн цэвэр, бохирын устай холбох хэрэгцээ, шаардлага өндөр байна.

Цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ

- Ус хангамжийн салбарын хууль эрх зүйн орчин, норм нормативыг боловсронгуй болгож, ус хангамж, ариутгах татуургын ажил, үйлчилгээ эрхэлж буй байгууллагуудын одоогийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, өөрчлөн байгуулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх;
- Хот суурины ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тоног төхөөрөмж, барилга байгууламжийг өргөтгөх, сэргээн засварлах, дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх замаар хэвийн найдвартай ажиллагааг хангах;
- Сумын төвийн ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээг шинэчлэх, шинээр бий болгох;
- Ус хангамж, ариутгах татуургын ажил, үйлчилгээг зохицуулах зөвлөлийг байгуулах, цэвэр, бохир усны чанарын хяналтын лабораториудыг байгуулах, усны чанарын хяналт, мониторингийн тогтолцоог боловсронгуй болгох;
- Ундны усны чанарыг сайжруулах зорилгоор ус зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх тоног төхөөрөмжийг шаардлагатай газруудад суурилуулах;
- Амины орон сууц, гэр хороолол, сумын төв, хотын захын эмнэлэг, сургууль, цэцэрлэгийг цэвэр, бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбох;
- Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй газарт цэвэрлэгээний түвшин өндөр, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, эрчим хүчний хэмнэлттэй, бага оврын цэвэрлэх байгууламж суурилуулах;
- Саарал усыг эргүүлэн ашиглах.

ЗОРИЛТ 17. 2015 ОН ГЭХЭД ХҮН АМЫН ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ


ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсын 2000 оны хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр нийт 541149 өрхийн 51 хувь нь гэрт, 49 хувь нь орон сууц (нийтийн зориулалттай орон сууц, сууцны тусдаа байшин, нийтийн байр)-нд, нийт хүн амын зөвхөн 22 хувь нь эрүүл ахуйн шаардлага хангасан, инженерийн шугам сүлжээнд

холбогдсон орон сууцанд амьдарч байсан бол хүн ам, орон сууцны 2010 оны ээлжит тооллогын дүнгээр Монгол Улсын нийт 713780 өрхийн 45.2 хувь нь гэрт, 53.6 нь орон сууцанд, 1.1 хувь нь зориулалтын бус байранд амьдарч байна.

Монгол Улсад 2000 онд нийт 541.1 мянган өрх амьдарч байсны 21.9 хувь нь инженерийн шугам

Дүрслэл 23. Ашиглалтад оруулсан орон сууцны тоо, нийт талбайн хэмжээ, орон сууцны фонд (2000-2010)



сүлжээнд холбогдсон орон сууцанд амьдарч байсан бол 2010 оны байдлаар нийт 742.3 мянган өрхийн зөвхөн 21.3 хувь буюу 158.4 мянган өрх инженерийн шугам сүлжээнд холбогдсон орон сууцанд амьдарч байна. Орон сууцны барилгууд ихээр баригдаж байгаа ч хүн амын эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй байна.

Орон сууцны талбайгаар тооцсон орон сууцны фонд 2000 онд 6474.4 мян.м² байсан бол 2010 онд 8 913.0 мян.м² болж 1.37 дахин нэмэгдсэн байна.

Мөн түүнчлэн шатах, тослох болон барилгын материалын зах зээлийн үнийн өсөлт, орон сууцны эрэлт, хэрэгцээ их, нийлүүлэлтийн хэмжээ бага зэргээс шалтгаалан орон сууцны нэг ам дөрвөлжин метр талбайн үнэ дунджаар 1.0 сая төгрөгт хүрсэн нь бага, дунд орлоготой иргэдийг орон сууцаар хангахад бэрхшээлтэй байна.


Хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ

Засгийн газраас 2002-2006 онд “Орон сууц” Үндэсний хөтөлбөр, 2003-2007 онд Азийн хөгжлийн банкны зээлээр Орон сууцны санхүүжилтийн төсөл, Японы Засгийн газрын ядуурлыг бууруулах сангийн буцалтгүй тусламжаар Гэр хорооллын нөхцөл сайжруулах төсөл, “40000 орон сууц” хөтөлбөр, “Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөр, “Шинэ бүтээн байгуулалт” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Дээрх төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хот, суурин газрын инженерийн шугам сүлжээ бүхий төвийн хэсэгт нийтийн зориулалттай орон сууц барих, хотын захын ашиглалтгүй нөөц газарт шинээр орон сууцны дэд бүтэц барих замаар шинэ хотхон, хороолол барих, гэр хорооллын нутаг дэвсгэрт газар зохион байгуулалт, төлөвлөлтийг дахин хийж, айл өрхүүдийг цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбох замаар орон сууцны нөхцөлийг нь сайжруулан, улмаар орон сууцны хороолол болгон хөгжүүлэх ажлыг эхлүүлээд байна.

2000-2010 онд нийтдээ инженерийн шугам сүлжээнд холбогдсон 39393 айлын орон сууцны барилгууд ашиглалтад орж, нэг хүнд ногдох сууцны талбайн хэмжээ 2000 онд 5.67 м² байсан бол 2010 онд 7.15 м² болж нэмэгдсэн байна.

Дүрслэл 24 нэг хүнд ногдох орон сууцны талбайн хэмжээ, м²



Тулгамдаж буй асуудал

Монгол Улсын Засгийн газраас хүн амыг орон сууцаар хангах хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлсний үр дүнд барилгын салбарын хөгжил эрчимжиж, барилга угсралт, хот байгуулалтын ажил өргөжиж байгаа хэдий ч амьдралын эрхээр хөдөө орон нутгаас хот руу шилжин ирэгчдийн тоо ихээхэн нэмэгдэж, Улаанбаатар хотын гэр хороолол хүрээгээ улам тэлж байгаа нь хот байгуулалт, төлөвлөлтийн бодлого боловсруулах болон хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулж байна.

Орон сууцны эрэлт, хэрэгцээ өндөр байгаа дунд болон бага орлоготой иргэдийн хувьд орон сууцтай болоход тулгарч буй гол бэрхшээл нь санхүүгийн чадвар бөгөөд тэдэнд орон сууцанд оруулах хөрөнгө, орлогын байнгын эх үүсвэр, хадгаламж байхгүй байна. Одоо байгаа орон сууцны зээлийн эх үүсвэр хязгаарлагдмал, зээлийн хүү өндөр, хугацаа богино, хүртээмж бага байна. Энэ нь орон сууцны санхүүжилтийн урт хугацааны зээлийн тогтолцоо бий болоогүй, орон сууцны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн санхүүжилтийн хямд эх үүсвэр байхгүй, түүнийг зах зээлийн аргаар бий болгох нөхцөл бүрдээгүй, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжих, зах зээлд суурилсан татвар, үнийн бодлого, эрх зүйн орчин дутагдаж байгаатай холбоотой байна.


Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хувийн болон гадаадын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжиж, нэмэгдүүлэх шаардлагатай байна. Иймээс орон сууцны эрэлтийг дэмжиж, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх бодлого баримтлан, хүн амын орон сууцны нөхцөл, хангамжийг сайжруулах дорвитой арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага чухал хэвээр байна.

Цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ

- “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд баригдах 100 мянган айлын орон сууцны хорооллуудыг инженерийн болон нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийн хамт цогцоор нь шийдвэрлэх, Засгийн газрын 2010 оны 343 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх;
- Орон сууцны зээлийн хямд эх үүсвэрийг бүрдүүлэх, хоёрдогч зах зээлийн тогтолцоог хөгжүүлэх;
- Бага болон дунд орлоготой иргэдэд орон сууцны хөнгөлөлт үзүүлэх;
- Орон сууцны барилгуудыг паспортжуулах, газар хөдлөлтийг тэсвэрлэхгүй барилгуудыг буулган шинээр орон сууц барих ажлыг зохион байгуулж эхлэх;
- Орон сууцны барилга барих ажлыг өргөжүүлэх зорилгоор барилгын материалын үйлдвэрийг хөгжүүлэх.

Мянганы хөгжлийн долоо дахь зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилт хангалтгүй, 2015 он гэхэд бүрэн биелэх бололцоо тун бага байна. Иймээс манай улсын хувьд МХЗ-уудаас хэрэгжилт тааруу, зорилтод түвшиндээ хүрэхээргүй байгаа зорилгуудыг 2015 оны зорилтод түвшинд нь хүргэх чиглэлээр бусад улс орны туршлагаас суралцан, НҮБ-ын санхүүжилт, дэмжлэгтэйгээр МХЗ-уудын хэрэгжилтийг түргэсгэх Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр бүхий бодлогын баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна. Байгаль орчны тогтвортой байдлыг хангах зорилго хэрэгжихгүй байгаа гол шалтгаан, цаашид анхаарах асуудлуудыг уг бодлогод нарийн авч үзэх хэрэгтэй юм. Тиймээс ядуурлыг бууруулах зорилгын хэрэгжилтийг эрчимжүүлэх бодлогын адилаар эрдэмтэн, судлаачдын багаас бүрдсэн зөвлөхүүдийн тусламжтайгаар судалгаа тооцоо хийн, Засгийн газрын холбогдох байгууллагуудыг хамарсан ажлын хэсэг гарч ажиллах нь зүйтэй юм.





An aerial photograph of a city, likely Ulaanbaatar, showing a dense urban landscape with numerous multi-story apartment buildings and commercial structures. The city is situated in a valley, with a wide river or plain visible in the background. A blue rectangular box is overlaid on the right side of the image, containing white text.

ЗОРИЛГО НАЙМ

*ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ДЭЛХИЙ
НИЙТИЙН ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ*

ЗОРИЛГО 8

ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ДЭЛХИЙ НИЙТИЙН ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

ЗОРИЛТ 18: ХУДАЛДААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЭХ ЗАМААР МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДЫГ ХАНГАХ ТААТАЙ НӨХЦӨЛ БҮРДҮҮЛЭХ


ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Сүүлийн 10 жилийн байдлаар экспортын ДНБ-д эзлэх хэмжээ 46-49.6 хувьтай байгаа бөгөөд 2009 онд 41.5 хувьтай байсан бол 2010 онд өмнөх оноос 6.2 нэгжээр өсч 47.7 хувийг эзэлж байна. Манай улс 2009 онд дэлхийн 126 оронтой, 2010 онд 132 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 6108.6 сая ам.доллар болж, үүнээс экспорт 2899.2 сая ам.доллар, импорт 3277.9 сая ам.долларт хүрчээ. Гадаад худалдааны тэнцэл 2009 онд 252.3 сая ам.доллар, 2010 онд 387.7 сая ам.долларын алдагдалтай гарчээ. Гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх онохоос 2154.0 сая ам.доллар буюу 53.5 хувиар, үүний дотор экспортын хэмжээ 1013.8 сая ам.доллар буюу 53.8 хувиар, импортын хэмжээ 1140.2 сая ам.доллар буюу 53.3 хувиар тус тус өсчээ. Экспортын үнийн дүнгийн 98.0 хувийг зөвхөн эрдэс бүтээгдэхүүн, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос, болон нэхмэл бүтээгдэхүүн, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэл эзэлж байна.

Гадаад худалдааг нэмэгдүүлэх чиглэлээр Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Гаалийн шинэчлэлийн төсөл хэрэгжиж байна. Бусад төсөл, арга хэмжээ нь оролцогч талуудын бодлогын зөвлөгөө, хэлэлцүүлгийг дэмжих, институцийн чадавхийг бэхжүүлэх чиглэлийн бодлогын зөвлөмж өгөх техник туслалцаа байсан байна. 2009 онд зээлийн ашиглалт, тусламжтай харьцуулахад өндөр гарсан нь 2008-2009 онд үргэлжилсэн санхүү, эдийн засгийн хүндрэлийн үед төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор Дэлхийн банкны шугамаар “Хөгжлийн бодлогын зээл”-ийн хөтөлбөр, Азийн хөгжлийн банк, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын шугамаар “Нийгмийн салбарыг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зээл авсантай холбоотой юм.

Харин 2010 онд экспортын хэмжээ 2009 оноос 54 хувиар, 2008 оноос 14 хувиар өссөн байна. Экспорт болон ДНБ-ий харьцааг 2009 оны түвшинээс өсгөж чадсан ч, 2008 оны түвшинд хүрээгүй байна.

Дүрслэл 25. Экспортын хэмжээ, сая ам.доллар



Сүүлийн жилүүдэд манай улсын экспортын бүтцэд эрдэс бүтээгдэхүүний эзлэх хувь тасралтгүй өссөөр 2010 онд 81 хувьд хүрээд байна. Цаашид өсөлт улам нэмэгдэх хандлагатай байна. Энэ нь уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүн болох зэсийн баяжмал болон чулуун нүүрсний их хэмжээний олборлолттой холбоотой.

Дүрслэл 26. Экспортын барааны бүтэц, хувь, 2010 он.



Хүснэгт 26. Экспортын барааны бүтэц

Барааны бүтэц	Хэмжээ, эзлэх хувь	2008	2009	2010
Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	мянган ам.доллар	31,641.50	45,808.85	69,384.26
	Эзлэх хувь	1.3	2.4	2.4
Эрдэс бүтээгдэхүүн	мянган ам.доллар	1,529,401.00	1,251,766.73	2,354,476.00
	Эзлэх хувь	60.3	66.4	81.0
Арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	мянган ам.доллар	41021.0	29,043.85	32,532.40
	Эзлэх хувь	1.6	1.5	1.1
Нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн	мянган ам.доллар	226,542.80	192,166.58	216,340.84
	Эзлэх хувь	8.9	10.2	7.4
Сувд, үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	мянган ам.доллар	600,172.60	308,525.20	178,351.47
	Эзлэх хувь	23.7	16.4	6.1
Бусад	мянган ам.доллар	105,687.51	58,073.93	57,417.21
	Эзлэх хувь	4.2	3.1	2.0

Эх үүсвэр: Статистикийн эмхтгэл, 2010

Хүснэгт 27. Худалдааны хүчин чадлыг бий болгоход ХАЁТ-ын үзүүлсэн хувь

Эзлэх хувь	1990	2000	2006	2009	2010	2015*
Худалдааны хүчин чадлыг бий болгоход туслахаар үзүүлсэн ХАЁТ-ийн эзлэх хувь	-	0.0293	0.0198	0.05	0.03	10.0
Нийгмийн суурь үйлчилгээнд үзүүлсэн ХАЁТ –ийн эзлэх хувь	-	11.9	18.2	54.0	19.5	5.0
Дотоодын нийт бүтээгдэхүүнд экспортын эзлэх хувь	34.7	51.2	59.4	50.3	54.7	70.0
Санхүүгийн гүнзгийрэл: Дотоодын нийт бүтээгдэхүүн, нийт мөнгөний харьцаа	15.7 (1995)	21.1	38.1	43.7	56.7	65.0

*-Зорилгод түвшин

Эх үүсвэр: Статистикийн эмхтгэл 2010

Монгол Улс олон улсад болон бүс нутагтаа, хөрш орнуудтай хийх худалдааны хүчин чадлыг бий болгох, худалдааг хөнгөвчлөх, худалдаа хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор 2009-2010 онд Засгийн газраас гадаад түнш орон, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, буцалтгүй тусламж, техник туслалцааны хүрээнд бодлогын шинэчлэл хийх, хэрэгжилтийг уялдуулах, зохицуулалтын механизмуудыг сайжруулах, шинээр бий болгох, түүнийг дагалдсан институци, биет дэд бүтцийг байгуулах чиглэлээр тодорхой төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр Монгол Улс, Азербайджан, Афганистан, БНХАУ, Казахстан, Киргиз, Тажикстан, Узбекистан улсуудтай хамтран Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр, худалдаа,

эдийн засгийн өсөлтийг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлж байна.

Монгол Улс хөрш улсуудтай болон бүс нутагт худалдааг хөнгөвчлөх чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнүүд нь худалдааны коридор (Транзит Монгол)-ыг бий болгох дэд бүтцийг хөгжүүлэх, хил, гаалийн үйл ажиллагааг жигдрүүлэх, үр ашгийг дээшлүүлэх, нэвтрүүлэх хүчин чадлыг сайжруулахад төвлөрч байна. Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллаж байна. Хөрөнгө оруулалтын төслүүдээр гаалийн үйл ажиллагааг шинэчилж боловсронгуй болгох, худалдааны чөлөөт бүс З-ыг байгуулах, техник туслалцааны төслүүдээр олон улсын шинэ нисэх онгоцны буудал, Цагааннуур, Замын-Үүдийн боомтын дэргэд ложистикийн парк байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг зохион байгуулж байна.

Монголын гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлж, түүнийг хөнгөвчилөхөд чиглэсэн гаалийн үйлчилгээ болон удирдлагын үр ашиг, ил тод байдал, тогтвортой байдлыг бий болгох зорилго бүхий төслийг АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд Гаалийн мэдээллийн автоматжуулсан системийг нэвтрүүлж, 2010 оны 7 сард албан ёсоор Монголын талд хүлээлгэн өгч, гаалийн мэргэжлийн байгууллагуудыг шинжилгээний тоног төхөөрөмжөөр хангах замаар гаалийн бүсийн лаборатори байгуулах, рентген төхөөрөмжийг зарим боомтод суурилуулах замаар хяналтын орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах, мэдээ, мэдээллийн төв (тоног төхөөрөмж ба програмыг оруулахгүйгээр)-ийг ГЕГ-ын төв байранд байгуулах, Замын-Үүдийн авто тээврийн терминалыг өргөтгөх зэрэг ажлуудыг хийв. Түүнчлэн худалдааг хөнгөвчлөх, худалдааны эргэлтийг сайжруулах үүднээс хоёр улсын гаалийн баримт бичгийг ижил болгох, хил дээр гарах баримт бичгийн бүрдлийг ханган, харилцан мэдээлэл солилцох зэрэг ажлуудыг хийж байна.

Замын-Үүдийг хөгжүүлэх цогц төлөвлөгөөг боловсруулж, Замын-Үүдийн ложистикийн паркийг байгуулах төсөлд шаардлагатай 45 сая ам.долларын санхүүжилтийг 2010 онд шийдвэрлэв.

Улаанбаатар хотын ачаа шилжүүлэн ачих, тээвэрлэх ложистикийн паркийн техник, эдийн засгийн үндэслэл, Цагааннуурын худалдааны чөлөөт бүсийг байгуулах төлөвлөгөө, Бүс нутгийн ложистикийг хөгжүүлэх судалгаа боловсруулах техник туслалцааны төслүүдийг эхлүүлэхээр ажиллаж байна. Бүс нутгийн ложистикийг хөгжүүлэх төслийн бэлтгэл судалгааны ажлын явцын дунд хугацааны тайланг боловсруулаад байна.

Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Монгол Улс урьд хөрштэй хамтран санаачилж 2007 оноос Монгол Улс, БНХАУ-ын бүс нутгийн хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлж байна. Энэ төслийн хүрээнд хоёр орны түвшинд шийдвэрлэхээр тусгагдсан худалдаа, тээврийг хөнгөвчлөх, эрчим хүч, тээврийн салбарт хамтран ажиллах, хил орчмын дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлийг

тодорхойлж, бодлогын хэлэлцээ, зөвлөгөө, судалгаа хийж байна.

Төслийн эхний үе шат 2010 оны 4 дүгээр сард дуусч хойд-өмнөдийн чиглэлийн хос төмөр зам тавих, цахилгаанжуулах, Чойбалсан-Архан чиглэлийн төмөр зам тавих, төмөр замыг оролцуулан тээврийн салбарыг хөгжүүлэх төлөвлөлтийн институцийг хөгжүүлэх, хоёр орны худалдаа болон дамжин өнгөрөх тээврийн урсгалд тулгарч буй голлох саад бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэх хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг “Транзит Монгол” Үндэсний хөтөлбөрт нарийвчлан тодорхойлж Худалдаа, тээврийг эрчимжүүлэх, хөнгөвчлөх Монголын Үндэсний хороог байгуулан ажиллаж байна.

Эдгээр бодлогын зөвлөгөө, зохицуулалтын механизмыг бүрдүүлэх зорилгоор явуулсан хэлэлцээ, хамтын ажиллагааны үр дүнд 2009-2010 онд Замын-Үүд, Эрээний боомт хоорондын ачаа тээврийн бичиг баримтын бүрдүүлэлтийг ижил болгох, жигдрүүлэх асуудлыг шийдвэрлэв. Мөн мэргэжлийн хяналтын байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлд хилийн мэргэжлийн хяналтын хүрээнд хоёр талын хорио цээрийн стандартыг бий болгох, нэгтгэх асуудлыг шийдвэрлэх зорилготой хамтарсан хороо байгуулахаар тогтоод байна.

Монгол Улс, БНХАУ, БНСУ, ОХУ зэрэг улсуудын гишүүнчлэлтэй “Их түмэн санаачилга” бүс нутгийн хамтын ажиллагааны хөтөлбөрөөр эрчим хүч, худалдаа хөрөнгө оруулалт, зам тээвэр, аялал жуулчлал зэргийг хөгжлийн хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлээр тодорхойлж, салбар салбараар бодлогын зөвлөлүүдийг байгуулан тогтмол уулзаж асуудлаа хэлэлцэн шийдвэрлэж байна.

“Их түмэн санаачилга” хөтөлбөрийн хүрээнд худалдааг хөнгөвчлөх чиглэлд олон талт хэлэлцээг явуулж 2010 оны 9 дүгээр сард зохион байгуулагдсан 11 дэх Зөвлөлдөх хорооны уулзалтын үеэр “Худалдааг хөнгөвчлөх хороо”-ны техник, эдийн засгийн үндэслэлийг батлав.

МҮХАҮТ НҮБ-ын Ази, Номхон далайн Эдийн засаг, нийгмийн комисс (АНДЭЗНХ/UNESCAP), НҮБ-ын Европын Эдийн засгийн хороо (ЕЭЗХ/UN-ECE), Азийн хөгжлийн банкны туслалцаатайгаар

тээвэр, худалдааг хөнгөвчлөх, цахим нэг цонхыг нэвтрүүлэх асуудлаар 2009 оны 9, 12 дугаар сард сургалт, семинар зохион байгуулж ажилласны дүнд холбогдох зөвлөмжийг гаргав.

Дээрх зөвлөмжийн дагуу НҮБ-ын Цаасгүй худалдааны шинжээчдийн сүлжээ, НҮБ-ын АНДЭЗНК, АХБ-ны шинжээчдийн тусламжтайгаар Монгол Улсад гадаад худалдааг хөнгөвчлөх Цахим нэг цонх нэвтрүүлэх мастер төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Улмаар 2010 оны 10 дугаар сард Малайз улсын Куалалампур хотноо болсон Ази, Номхон далайн орнуудын Худалдааг хөнгөвчлөх форумын үеэр мастер төлөвлөгөөний төслийг танилцуулж санал, зөвлөмж авсны үндсэн дээр төлөвлөгөөний төслийг шинэчлэн сайжруулж 2010 оны 12 дугаар сард олон улсын шинжээчдээр дахин хэлэлцүүлцээд байна.

Хүснэгт 28. Худалдааны хүчин чадлыг бий болгоход туслахаар үзүүлсэн ХАЁТ-ийн эзлэх хувь (ДНБ-т эзлэх хувиар, сая ам.доллар)

	2009	2010
ДНБ	4 586.5	6 079.3
ХАЁТ	170.83	49.18
Хувь	3.72	0.81

Эх үүсвэр: Сангийн яам 2011 он

САНХҮҮГИЙН САЛБАР

Монгол Улсын санхүүгийн салбар бүтцийн хувьд харьцангуй энгийн бөгөөд сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлттэй зэрэгцэн хурдацтай хөгжиж байна. Монгол Улсын санхүүгийн салбар нь:

- Банкны салбар
- Банк бус санхүүгийн байгууллага
- Хадгаламж, зээлийн хоршоод
- Үнэт цаасны мэргэшсэн компаниуд болон зуучлагчид
- Даатгалын компаниудаас бүрддэг.

Хүснэгт 29. Санхүүгийн салбарын актив хөрөнгийн бүтэц (2010)

№	Санхүүгийн салбарын ангилал	Тоо	Актив хөрөнгө /тэрбум төгрөг/	Актив хөрөнгөд эзлэх хувь
1	Банк	14	6245.6	95.9
2	Банк бус санхүүгийн байгууллага	182	128.6	2.0
3	Даатгалын компани	16	56.8	0.9
4	Хадгаламж, зээлийн хоршоо	179	48.8	0.7
5	Үнэт цаасны компани	336	32.7	0.5

Эх үүсвэр: Монголбанк, 2010

БАНКНЫ СИСТЕМ

Монгол Улсын санхүүгийн салбарт бусад хөгжиж буй улсуудын нэгэн адил банкны салбар давамгайлах байр суурийг эзэлдэг. 2010 оны эцсийн байдлаар банкны салбарын нийт актив хөрөнгө нь санхүүгийн салбарын нийт активын 96 орчим хувийг бүрдүүлж байна. 2010 оны эцсийн байдлаар 14 арилжааны банк үйл ажиллагаа явуулж, тэдгээрийн нийт актив нь 6.2 их наяд төгрөгт хүрч, ДНБ-ий 76 хувийг эзэлж байна. Энэ нь Монгол Улсын санхүүгийн системд банкны салбар давамгайлсан өрөөсгөл бүтэцтэй байгааг харуулж байна. Санхүүгийн бусад институцийн хөгжил сул хэвээрээ байна. Банкны салбарын гүнзгийрэлтийн индекс нь 2000 онд ДНБ-ий ердөө 23 хувийг эзэлж байсантай харьцуулахад өнгөрсөн 10 жилийн хугацаанд 3.3 дахин өсчээ.

Банкны шуурхай, чанартай цогц үйлчилгээ өндөр түвшинд хүрч, банкны салбар хөгжихийн хэрээр банкны үйлчилгээнд хамрагдах харилцагчдын хүрээ тэлж, хувийн хэвшилд олгох зээл, санхүүжилтийн хэмжээ мөн нэмэгдэж байна. Тухайлбал, 2000 онд банкны салбарын зээлийн хэмжээ 67.7 тэрбум төгрөг байсан бол 2010 оны 4 дүгээр улирлын байдлаар зээлдэгчдийн тоо 500 орчим мянга, нийт хадгаламж эзэмшигчдийн тоо 1.4 сая, нийт харилцах данс эзэмшигчдийн тоо 2.7 саяд хүрч, зээлийн өрийн үлдэгдэл 3.3 их наяд төгрөг байна.

2010 оны жилийн эцсийн байдлаар нийт зээлийн үлдэгдэл 3.3 их наяд төгрөгт хүрсэн нь 2009 онтой харьцуулахад 609.8 тэрбум төгрөг, 2008 онтой харьцуулахад 629.2 тэрбум төгрөгөөр тус тус их байна. 2010 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт зээлийн үлдэгдлийн 11.5 хувийг чанаргүй зээл эзэлж байгааг 2009 онтой харьцуулахад 87.9 тэрбум төгрөг (17.4 хувь)-өөр буурч, 2008 онтой харьцуулахад 185.7 тэрбум төгрөгөөр (7.2 хувь)-өөр өссөн байна.

2010 оны жилийн эцсийн байдлаар харилцах, хадгаламж нийт пассивын 71 орчим хувийг эзэлж 4.2 их наяд төгрөг байгаа бөгөөд үүнээс харилцах 36 хувь, хадгаламж 64 хувийг эзэлж байна. Нийт харилцахын 50.1 хувийг валютын харилцах, 49.9 хувийг төгрөгийн харилцах, нийт хадгаламжийн 27.8 хувийг валютын хадгаламж, 72.2 хувийг төгрөгийн хадгаламж, 66.4 хувийг хугацаатай хадгаламж, 33.6 хувийг хугацаагүй хадгаламж тус тус эзэлж байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУД

2010 оны байдлаар нийт 182 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 128.6 тэрбум төгрөгийн актив хөрөнгөтэй болсон нь банкны салбарын нийт активтай харьцуулахад 2.1 хувийг эзэлж байна. 2010 оны эцсийн байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарт ажиллагчдын тоо 880, салбар нэгжийн тоо 63, харилцагчдын тоо 158.5 мянга, хувь нийлүүлэгчдийн тоо 582 байна. Банк бус санхүүгийн байгууллагууд нь 78.1 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байгаа нь банкны салбарын зээлийн үлдэгдэлтэй харьцуулахад 2.4 хувийг, 80.0 тэрбум төгрөгийн дүрмийн сантай байгаа нь банкны салбарын дүрмийн сантай харьцуулахад 33.0 хувийг тус тус эзэлж байна.

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООД

2010 оны байдлаар нийт 25990 гишүүнтэй 179 хадгаламж, зээлийн хоршоо үйл ажиллагаа явуулж, 48.8 тэрбум төгрөгийн актив хөрөнгөтэй байгаа нь банкны салбарын нийт активтай харьцуулахад 0.8 хувийг эзэлж байна. Салбарын дүнгээр 34.9 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэйгээс 3.5 тэрбум төгрөгийн зээл чанаргүй зээлийн ангилалд бүртгэгдсэн нь нийт зээлийн 10.0 хувийг эзэлж байна. Улаанбаатар хотод 2010 онд нийт 74 хадгаламж, зээлийн хоршоо, хөдөө, орон нутагт 105 хадгаламж, зээлийн хоршоо үйл ажиллагаагаа явуулж байна. Системийн хэмжээгээр 1.5 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ.

Даатгалын компаниуд, давхар даатгалын үйл ажиллагаа

2010 оны байдлаар даатгалын салбарт 16

даатгалын компани үйл ажиллагаа явуулж байна. 2010 оны 12 дугаар сард даатгалын компаниудын төвлөрүүлсэн даатгалын нийт хураамжийн орлого нь 2.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 546.8 сая төгрөгөөр, олгосон даатгалын нөхөн төлбөр 588.7 сая төгрөгт хүрч, 33.3 сая төгрөгөөр өсч, давхар даатгалд төлсөн хураамж 84.4 сая төгрөгөөр буурсан байна.

ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИУД

2010 онд хөрөнгийн зах зээл дээр бүртгэлтэй нийт 336 хувьцаат компаниас 19 компани 361.7 сая төгрөгийн үнийн дүн бүхий ногдол ашгийг хуваарилсан бөгөөд 2009 онтой харьцуулахад хуваарилсан ногдол ашгийн үнийн дүн 31 хувиар буурсан байна.

2010 оны байдлаар нийт 336 ХК-ийн 2.7 тэрбум ширхэг хувьцаа бүртгэлтэй байгаагаас төрийн өмчит хувьцаат компанийн 1.8 тэрбум ширхэг хувьцаа, 4 компанийн 353 мянган ширхэг бонд бүртгэлтэй байна. 2009 онтой харьцуулахад хөрөнгийн зах зээл дээр бүртгэлтэй компанийн тоо 17-гоор буурч хязгаарлагдмал хариуцлагатай компани болж хэлбэрээ өөрчилсөн байна.

Хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ

- Банк, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангаж, иргэдийн банкинд итгэх итгэлийг бууруулахгүй байх зорилгоор банкинд дахь мөнгөн хадгаламж, харилцахад 4 жилийн хугацаанд төрөөс баталгаа гаргах тухай хуулийг баталсан байна.
- Базелийн банкны хяналт шалгалтын хорооноос батлан гаргасан “Базелийн банкны үр ашигтай хяналт шалгалтын үндсэн зарчим”-ыг банкны салбарт хэрэгжүүлэх, олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлэх, эдийн засаг дахь санхүүгийн зуучлалын үйлчилгээг тэлэх үүднээс “Төв банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль, “Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ыг УИХ баталсан байна.
- Төлбөрийн чадваргүй зарим банкны зээлийн багцын чанарыг бууруулахгүйгээр авч үлдэх, банкны харилцах, хадгаламж эзэмшигчдийг

хохироохгүй байх зорилгоор төрийн өмчит “Төрийн банк”-ийг “гүүр банк”-ны зарчмаар байгуулах ажлыг зохион байгуулжээ.

- Хадгаламж, харилцах дансанд даатгалын орчинг бий болгосонтой холбоотойгоор санхүүгийн салбарт “далимдуулах, буруугаар ашиглах” үзэгдлийг гаргахгүй байх, татвар төлөгчдийн мөнгийг эрсдлээс хамгаалах зорилгоор банкуудаас хураасан шимтгэлээр бүрддэг хадгаламжийн даатгалын сонгодог тогтолцоог нэвтрүүлж байна.
- Стратегийн өндөр ач холбогдолтой эдийн засгийн дэд бүтцийг бий болгох, үндэсний хөгжлийг тодорхойлохдэд бүтцийн салбаруудыг хөгжүүлэх, экспортын орлогод тулгуурласан эдийн засгийг дэмжих, уул уурхайн салбарын орлогыг стратегийн ач холбогдолтой үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтад ашиглах зорилгоор Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилго бүхий Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль батлагдаж, Хөгжлийн банкыг байгуулав.
- Хямралтай тэмцэх, банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зорилгоор Монгол Улсын Засгийн газар үнэт цаас арилжаалах замаар бүрдүүлсэн тодорхой эх үүсвэр, Засгийн газрын тусгай сангууд болон төрийн сангийн чөлөөт эх үүсвэрийн тодорхой хэсгийг арилжааны банкуудад харилцах болон хадгаламж хэлбэрээр байршуулан ажиллаж байна. Тухайлбал, олон улсын санхүүгийн зах зээл дээр Монгол Улсын Засгийн газар 75.0 сая ам.долларын нэрлэсэн үнэтэй бондыг хямдруулан худалдаж, 66.24 сая ам долларын хөрөнгийн эх үүсвэрийг татан төвлөрүүлж, уг эх үүсвэрээс Худалдаа хөгжил, Зоос, Голомт, Капитрон, Чингис хаан зэрэг банкуудад тус тус байршуулан, алтны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд дамжуулан зээлдүүлж, алт олборлох үйлдвэрлэлийг дэмжихийн зэрэгцээ Монгол банкин дахь гадаад валютын нөөцийг нэмэгдүүллээ.
- Төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах, барилгын салбарыг зогсонги байдлаас гаргах зорилгоор 4000, 40'000 орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлж, уг хөтөлбөрийг

санхүүжүүлэх Засгийн газрын бондыг 2010 онд үе шаттайгаар арилжаалав.

Монгол Улсын Засгийн газар санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор шаардлагатай бодлогын арга хэмжээнүүдийг цаг хугацаанд нь холбогдох байгууллагуудтай хамтран шат дарааллан авч хэрэгжүүлж ирлээ. Тухайлбал,

- Банкны санхүүгийн чадвар, эрсдэлийн түвшинг илүү бодитой тодорхойлдог болох, банкуудын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлэх, санхүүгийн хямралын үед гарч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 475/182 тоот хамтарсан тушаалаар шинэчилэн батлан хэрэгжүүлж эхэлсэн.
- “Банкны тухай хууль” шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг томилон ажиллуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох үүднээс “Банкны хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, сонгох, чөлөөлөх журам”-ыг 2010 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 434/113/167 тоот хамтарсан тушаалаар баталсан. Энэ нь банкны удирдлагын зохистой засаглалын зарчмууд дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахад чухал ач холбогдолтой болох юм.
- Барилгын салбарт зээл олгосон банкуудыг дэмжих, нөгөө талаас төрийн албан хаагчдад олгох орон сууцны урт хугацаат зээлийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор нийт 30.0 тэрбум төгрөгийн 7.8 хувийн хөвөгч хүүтэй Засгийн газрын үнэт цаасыг гаргасан. Засгийн газрын үнэт цаасны эх үүсвэрээс 926 иргэнтэй зээлийн гэрээ байгуулж, орон сууцны санхүүжилт олгосон байна.
- Ипотекийн хоёрдогч зах зээлийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, банкнаас олгосон орон сууцны урт хугацаат зээлийн хөрөнгийг

эргэлтэнд оруулах зорилгоор “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны” тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж, 2010 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хурлаар батлуулсан. “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль”-ийн төслийн үйлчлэх хүрээ, зорилгын хувьд ипотекийн хоёрдогч зах зээлийн үндсэн хэрэгсэл болох хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны эрх зүйн орчныг бүрдүүлж, уг

үнэт цаасыг тодорхойлон, түүнийг эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, гаргах, арилжаалах, уг харилцаанд оролцогч этгээдийн эрх зүйн байдал болон үнэт цаасны зах зээлд оролцогч бусад этгээдээс ялгагдах онцлогийг тогтоох, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч татан буугдах, дампуурахтай холбоотой болон бусад нарийвчилсан зохицуулалтыг тусгаж өгсөн.

Хүснэгт 30. Мөнгөний нийлүүлэлтийн ДНБ-д эзлэх хувь



	1990	2000	2006	2009	2010	2015*
M2/ДНБ	18.5 (1995)	25.4	41.4	43.7	56.7	65.0

*-Зорилтод түвшин
Эх үүсвэр: Монголбанк

- Мөнгөний нийлүүлэлтийн ДНБ-д эзлэх хувь 2010 онд 56.7 хувьтай байна. Энэ нь 2000 оныхоос 2.2 дахин, 2006 оноос 1.4 дахин өсчээ.
- Манай улсын мөнгөний нийлүүлэлт (M2) 1995 онд 0.1 их наядар хэмжигдэж байсан

бол 2010 оны байдлаар 4.7 их наяд болж 45 дахин нэмэгдсэн байна. Энэ хугацаанд 2007 оныг хүртэл мөнгөний нийлүүлэлт тасралтгүй эрчимтэй өсч байсан бол 2008 онд инфляцийн огцом өсөлттэй холбоотойгоор анх удаа 5 хувиар буурчээ. Түүнээс хойш 2009 27 хувиар, 2010 онд 62 хувиар өссөн байна.

Дүрслэл 27. Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц, динамик



Эх үүсвэр: Монголбанк

- М²-ийн бүтцийг харахад 1995 оноос хойш банкаас гадуурх мөнгөний М²-т эзлэх хувь эрс буурч, иргэдийн хадгаламж болон харилцах дансны эзлэх хувь өсч байгаа нь иргэд, байгууллагуудын банкинд итгэх итгэл нэмэгдэж байгааг, мөн бэлэн бус төлбөр тооцоог илүүд үзэж байгааг харуулж байна.
- Мөнгөний нийлүүлэлт энэ хандлагаар үргэлжилвэл 2015 онд М² болон ДНБ-ний харьцаа 65 хувьд хүрэх бүрэн боломжтой байна.

Авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ

Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, иргэдийн мөнгөн хадгаламжийг баталгаажуулах, арилжааны банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих, хөрш зэргэлдээ орон болон хамтран ажилладаг олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас авах хөнгөлөлттэй зээл, тусламжийг нэмэгдүүлэх талаар тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байв.

Түүнчлэн, эдийн засгийн бодит салбарыг Хөгжлийн банкаар дамжуулан дэмжих, Засгийн газрын өмнөөс шаардлагатай арилжааны эх үүсвэрүүдийн ашиглалтыг тус банкаар дамжуулан оновчтой шийдэх, жижиг дунд үйлдвэрлэлийг хямд, урт хугацааны санхүүгийн эх үүсвэрээр хангах, олон улсын хөрөнгийн зах зээлд компани хувьцааг арилжаалах замаар хөрөнгө татах ажлуудыг хийж байна. Хөрөнгийн зах зээлд олон улсын шилдэг менежмент, туршлагыг нэвтрүүлэх замаар хөрөнгийн зах зээлийн хууль, эрх зүйн зохицуулалтыг төгөлдөржүүлэх, хөрөнгийн зах зээлд оролцогчдын хяналт, зохицуулалтыг боловсронгуй болгох ажлууд хийгдэж байна.

Төрөөс банкин дахь мөнгөн хадгаламжид гаргаж байгаа нийтлэг баталгаанаас хадгаламжийн даатгалын сонгодог тогтолцоонд аажмаар шилжих хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор “Иргэдийн мөнгөн хадгаламжийн даатгалын тухай” хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 640/239 тоот хамтарсан тушаалаар байгууллаа. Ажлын хэсэг нь Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон

бусад холбогдох байгууллагуудын төлөөллөөс бүрдэж байна. Хадгаламжийн даатгалын сонгодог тогтолцоог манай улсад нэвтрүүлснээр банк санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах эрх зүйн орчин илүү боловсронгуй болно гэж үзэж байгаа бөгөөд энэ нь иргэдийнхээ эдийн засгийн аюулгүй байдлыг хангах төрөөс хүлээсэн үүргийг биелүүлэхэд чухал алхам болж байна.

Зээлийн хүүг бууруулах эдийн засгийн зохистой орчныг бүрдүүлэх зорилгоор 2010 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр Засгийн газар, банкууд, санхүүгийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүд болон олон нийтийн дунд “Зээлийн хүү буурах зах зээлийн орчинг бүрдүүлэх нь” сэдэвт зөвлөлгөөнийг нээлттэй хэлбэрээр зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд Сангийн яам, Монголбанк, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, банкууд, их, дээд сургуулиуд зэрэг төрийн болон хувийн нийт 15 байгууллагуудын 150 орчим зочид төлөөлөгчид оролцож, зээлийн хүүд голлон нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар илтгэл тавьж, санал солилцон, нэгдсэн ойлголтод хүрэв. Мөн Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хурлаар зээлийн хүү буурах эдийн засгийн болон хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх хөтөлбөрийг хамтран боловсруулж, хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг гаргах үүрэг бүхий Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, банкны төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг байгуулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсний дагуу хөтөлбөрийн төслийг эцэслэн боловсруулаад байгаа бөгөөд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, баталгаажуулахаар ажиллаж байна.

Тулгамдаж буй асуудал

а. Худалдааны салбарт:

Жижиг, дунд үйлдвэр, өрхийн болон хувиараа эрхлэх аж ахуйд бий болсон бүтээгдэхүүнийг гадаад, дотоодын зах зээлд борлуулах, худалдааны болон биржийн сүлжээг бий болгох.

Уул уурхайн салбар манай оронд эрчимтэй хөгжиж байгаа энэ үед уул уурхайг дагасан жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжиж, худалдаалах орчинг бүрдүүлэх хэрэгцээ өсч байна.

Худалдааны харилцаан дахь зарим ойлголт, хэлбэр, төрөл, худалдаа эрхлэн явуулах арга, үндэсний эдийн засаг, нийгмийн хөгжлийг худалдаагаар дэмжих төрийн бодлого, зохицуулалт, олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд гадаад худалдаанд хэрэглэх хамгаалалтын арга, гадаад болон дотоод худалдаанд тавигдах шаардлага, худалдаа эрхлэгчийн эрх, үүрэг зэрэг асуудлыг хамарсан хуулийн тодорхой нэгдсэн зохицуулалт үгүйлэгдэж байна.

Худалдааны хяналтын чиглэлээр хийсэн мэргэжлийн байгууллагын судалгаанаас үзвэл: Монгол Улсын хэмжээнд нийт худалдааны газрын 45.7 хувь нь зориулалтын бус ажлын байртай, 39.8 хувь нь хадгалалтын онцгой нөхцөл шаарддаг барааг технологийн горимын дагуу хадгалдаггүй, 26.0 хувь нь хүнсний болон түргэн гэмтэх барааг ТҮЦ, чингэлэг, илзадгай талбайд худалдаалдаг, 50.5 хувь нь барааг тээвэрлэх зориулалтын тээврийн хэрэгсэлгүй байгаа нь бараа, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна. Мөн хүнсний барааг ганзгаар нийлүүлэх асуудлыг таслан зогсоож чадахгүй байгаагаас импортын хүнсний барааны 30 орчим хувь нь эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын шаардлагад тэнцэхгүй байгаа гэсэн судалгааны дүн гарчээ.

Худалдааны салбарын мэдээлэл, статистик хангалтгүй байгаа нь энэ салбарын бодлогыг тодорхойлох, гарах шийдвэрийг удаашруулах нөхцөлийг бүрдүүлж байгаа юм. Иймээс худалдааны бүртгэл, мэдээллийг төрөлжүүлэх, нэгтгэн төвлөрүүлэх, бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим сан үүсгэх, судалгаа шинжилгээ, төрийн бодлого шийдвэрт оновчтой ашиглах шаардлагатай байна.

Монгол Улсын олон улсын гэрээ тухайлбал, ДХБ-ын хэлэлцээрүүд, дүрэм, журамд нийцүүлэн гадаад худалдаатай холбоотой ойлголт, зохицуулалтыг үндэсний хууль тогтоомжид нутагшуулах, цаашид олон талт чөлөөт худалдааны хэлэлцээрт нэгдэх асуудал яригдах нөхцөлд дотооддоо худалдааг зохицуулсан нэгдсэн хуулийн хүрээнд зохицуулах гарцаагүй нөхцөл тавигдаж байгаа юм.

Даяаршиж байгаа өнөө үед олон улсын тогтсон хэм хэмжээний хүрээнд гадаад орнуудтай худалдаа хийх, үндэсний эдийн засгаа хамгаалах, дотоод

худалдааг цэгцтэй хөгжүүлэх, эрх зүйн орчинг бүрдүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Түүнчлэн, далайд гарцгүй байдлыг саармагжуулах, хил, гаалийн боомтын хүчин чадал, дэд бүтцийн хөгжлийг гадаад худалдааны бодлогоор зангидан хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

б. Санхүүгийн салбарын хүрээнд

Цаашид эдийн засгийн хямралаас улбаатай санхүүгийн салбар тэр дундаа банкны салбарт үүсээд буй чанаргүй зээлийн хэмжээг бууруулах, актив-пассивын удирдлагыг бэхжүүлэх, санхүүгийн байгууллагуудын засаглалын орчинг сайжруулах нь чухал байна.

Зээлийн мэдээллийн болон зээлийн баталгааны санг байгуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх замаар бизнесийг хөхиүлэн дэмжих хэрэгцээ өсч байна. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, бүх төрлийн институциональ хөрөнгө оруулагчдийг төрүүлж урт хугацааны санхүүгийн хэрэгслүүдийг санхүүгийн зах зээлд нэвтрүүлэх, боловсронгуй болгох шаардлагатай байна. Ялангуяа хөрөнгө оруулалтын сангуудыг бий болгох, түүний хууль эрх зүйн орчинг нэн яаралтай бүрдүүлэх нь чухал байна.

Даатгалын тогтолцоог шинэ шатанд гаргаж, томоохон компаниудын (гадаадын хөрөнгө оруулалттай) даатгалыг бий болгох, давхар даатгалын тогтолцоог бий болгох хэрэгтэй байна.

Цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ

а. Худалдааны салбарт

- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжсэн бодлого боловсруулах;
- Жижиг, дунд үйлдвэр, өрхийн болон хувиараа эрхлэх аж ахуйд бий болсон бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх орчинг бий болгох;
- Жижиг, дунд үйлдвэрлэлийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон улсад худалдаалахад дэмжлэг үзүүлэх;

- Худалдааг хөнгөвчлөх, дэмжих эрх зүйн зохицуулалтыг энгийн, ойлгомжтой, ил тод болгохын үүднээс Гадаад харилцааны яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хамтран боловсруулсан “Худалдааны тухай хууль”-ийн төслийг УИХ-аар батлуулж, хууль, эрх зүйн зүйн орчинг боловсронгуй болгох;
- Дотоодын үйлдвэрлэгчдийг гадаад худалдаанаас гарч болзошгүй хохирлоос хамгаалах, экспорт, импортын зохистой харьцааг дэмжих эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор боловсруулсан “Гадаад худалдааны хамгаалалтын арга хэмжээний тухай хууль”-ийн төслийг УИХ-аар батлуулах;
- Худалдааны бодлогыг харилцан уялдаатай, дотоодын эдийн засагт оруулах үр шимийг нь улам нэмэгдүүлэх зорилгоор боловсруулсан “Монгол Улсын төрөөс гадаад худалдааны талаар баримтлах бодлого”-ын төслийг УИХ-аар батлуулах;
- Гадаад харилцааны яам, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаас хамтран боловсруулсан “Экспортыг дэмжих хөтөлбөр”-ийн төслийг Засгийн газраар батлуулах;
- Монгол Улс худалдааны томоохон түнш зарим улс оронтой эдийн засгийн түншлэлийн болон чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах

хүрээнд судалгааны ажил хийх, энэ талаар санал, дүгнэлт гаргуулах;

- Европын Холбооны “Зах зээлийн бус эдийн засагтай орнуудын жагсаалт”-аас Монгол Улсыг хасуулах;
- Монгол Улсын гадаад харилцааны эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, гадаад харилцааны арга хэрэгслээр дамжуулан улс орны хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор дунд хугацаанд баримтлах чиглэл болох “Монгол Улсын гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх.

б. Санхүүгийн салбарт

- Хөрөнгийн биржийг хөгжүүлж, 2 дахь зах зээлийг бий болгох;
- Зээлийн мэдээллийн болон зээлийн баталгааны санг байгуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх;
- Санхүүгийн төрөл бүрийн эх үүсвэрийг бүрдүүлэх судалгаа хийх;
- Давхар даатгалын тогтолцооны эрх зүйн орчинг бий болгох.

2015 он хүртэл хугацаанд 8 дугаар зорилго болон холбогдох зорилтыг хэрэгжүүлэхэд 5.8 тэрбум төгрөг шаардагдахаар байна.

ЗОРИЛТ 19: *ДАЛАЙД ГАРЦҮЙ МОНГОЛ УЛСЫН ОНЦГОЙ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ ХАРГАЛЗАН ИЛҮҮ ТААЛАМЖТАЙ НӨХЦӨЛӨӨР ДАЛАЙД ГАРЦТАЙ БОЛОХ, ГАДААДАД ДАМЖИН ӨНГӨРӨХ ТЭЭВРИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ, МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРЭЭР ДАМЖИН ӨНГӨРӨХ ТЭЭВРИЙГ ӨРГӨЖҮҮЛЭХ*

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсын нийт ачаа эргэлтийн 90 гаруй хувийг төмөр замаар тээвэрлэж байгаа бөгөөд 2010 онд төмөр замаар нийт 16,8 сая тн ачаа тээвэрлэснээс экспорт 4,6 сая тн, импорт 1,5 сая

тн, дамжин өнгөрөх тээвэрлэлтийг төмөр замын тээврээр гүйцэтгэж байгаа бөгөөд 2010 онд нийт 2314.6 мянган тонн ачаа дамжин өнгөрсөн бөгөөд үүнд ОХУ-БНХАУ болон БНХАУ-ОХУ гэсэн чиглэлээр Монголоор дамжин ачаа тээвэрлэж байна.

Хүснэгт 31. 2003-2010 оны дамжин өнгөрөх тээвэрлэлт (мян.тонн)

Он	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010
ОХУ-аас БНХАУ-д	3 453	4 643	5 028	4 003	2 944	1 964	1 959	1797
БНХАУ-аас ОХУ-д	191	176	360	465	529	367	337	517.6
Бүгд	3 644.8	4 824.6	5 388.4	4 468.9	3 473.3	2 331.0	2296.6	2314.6

Эх үүсвэр: Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам

Уул уурхайн салбарын хөгжилтэй холбогдуулан 2010 онд авто тээврээр 16.9 сая тн нүүрс тээж экспортлосон бөгөөд импортоор 0.99 сая тн ачаа тээвэрлэжээ.

Төмөр замын ачаа тээвэрлэлтэд дамжин өнгөрөх ачааны эзлэх хувь сүүлийн жилүүдэд тасралтгүй буурсаар 2010 онд 13.8 хувь болжээ.

НҮБ-ын Худалдаа тээврийг хөнгөвчлөх хороо байгууллагын дэмжлэгтэйгээр ОХУ, Монгол, БНХАУ-ын гурван орныг хамарсан дамжин өнгөрөх тээврийн хэлэлцээрийг 10 гаруй жилийн өмнөөс хэрэгжүүлж эхэлсэн боловч, тодорхой үр дүнд хүрч чадаагүй байна.

Манай улс зүйн хойд Ази болон Европын улс орнуудад ачаа хүргэхийн тулд ОХУ-ын өргөн уудам нутгаар 4000 км, Зүүн өмнөд болон бусад улс орнуудад ачаа хүргэхийн тулд БНХАУ-ын нутгаар Тянь-жин боомт хүртэл 1700 км замыг туулж өндөр тарифаар дамжин өнгөрөх тээврийн хөлс төлсөөр байна.

Хүснэгт 32. Төмөр замын дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтийн эзлэх хувь (2007-2010)

Шалгуур үзүүлэлт	2007	2008	2009	2010*	2015**
Төмөр замын ачаа тээвэрлэлтэд дамжин өнгөрөх ачааны эзлэх хувь	24.7	16.0	16.2	13.8	40.0

** - Зорилтод түвшин
Эх үүсвэр: Сангийн яам, МХХТГ; * Урьдчилсан гүйцэтгэл

Төмөр замын тээврийн хувьд Европоос Ази руу тээвэрлэх ачааны төрөл, хэмжээ хомс байдгаас дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтийг тогтмол явуулах боломжгүй байна. 2008 онд 6 орны төмөр замын байгууллагууд хамтран ХБНГУ-аас БНХАУ руу, мөн эсрэг чиглэлд 14 хоногийн хугацаанд буухиа галт тэрэг аялуулжээ. Ингэхдээ далайн тээврээс даруй 30 хоногоор бага хугацаа зарцуулсан ба мөн тээврийн өртгийн хувьд хямд байсан юм.

Авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ

Монгол Улс газар зүйн байршлаа ашиглаж дамжин өнгөрөх тээвэрлэлтийг нэмэгдүүлэхийн тулд “Транзит Монгол” үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2008 оны 183 дугаар тогтоолоор

батлан хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөрийн зорилт нь Монгол Улс өөрийн газар зүйн байрлалын давуу талыг ашиглан, зах зээлийн бодит хэрэгцээнд суурилсан, хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулагчдын идэвхитэй оролцоотой транзит тээвэр, ложистикийн салбарыг дэмжин хөгжүүлэхэд чиглэгдсэн болно.

2009 оны 6 сард “Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр /АРТА/-т Монгол Улс нэгдэж орох боломж” сэдвээр НҮБ-ын АНДЭЗНК-тай /ESCAP/ хамтран Үндэсний семинар зохион байгуулсан бөгөөд нэгдэн орох боломж, эдийн засгийн үр өгөөжийн судалгааг хийж байна. Солонгос Улсаас Монгол Улсад суугаа ЭСЯ-тай хамтран Чөлөөт Худалдааны Хэлэлцээр /ЧХХ/ байгуулах боломжийг бий болгох асуудлаар уулзалт зохион байгуулав.

2009 оны 9 сард Япон Улстай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр /ЕРА/ байгуулах асуудлаар санал солилцож, уг хэлэлцээрийг байгуулах боломжийг хамтран судлах судалгааны баг байгуулахаар тохиролцоод байна.

Одоогоор гадаад худалдаа, олон улсын тээвэр, ложистикийн үйлчилгээний чиглэлийн олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орох ажил судалгааны түвшинд байна. НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс гишүүн орнуудын хүрээнд Транс Азийн Төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт Монгол Улс нэгдэн орсон бөгөөд уг хэлэлцээр албан ёсоор 2009 оны 6 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн.

Тулгамдаж буй асуудал

Европоос Ази руу чиглэсэн ачаа тээвэрлэлтийг нэмэгдүүлэхэд тарифын асуудал хүндрэлтэй тул нэн даруй шийдвэрлэх шаардлагатай байна. Хил, гаалийн үйл ажиллагааг хялбаршуулах нь дамжин өнгөрөх тээвэрлэлтийг нэмэгдүүлэхэд ихээхэн чухал үүрэгтэй.

Дамжин өнгөрөх улс орнуудтай хамтарсан гэрээ хэлэлцээрийг хийх, ачааны аюулгүй байдлыг хангах нь чухал юм. Төмөр замын тээх, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ

- Монгол Улсад байгуулж байгаа Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын Олон улсын судалгааны төвийн үйл ажиллагааг дэмжих;
- Далайд гарцгүй орнуудын “Улаанбаатарын тунхаглал”-ын үзэл санааг хэрэгжүүлэх чиглэлээр идэвхитэй ажиллах;
- Дамжин өнгөрөх тээврийн тухай гурван талт Хэлэлцээрийг байгуулах үйл явцыг эрчимжүүлэх;
- “Транзит Монгол” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд тавьсан зорилтуудыг хэрэгжүүлэх;
- Азийн авто замын сүлжээнд орсон АН-3, АН-4 замуудыг барьж дуусгаж, ашиглалтад оруулах;
- Төмөр замын Сүхбаатараас Замын-Үүд хүртэлх шугамын хүчин чадлыг нэмэгдүүлэх, хоёр дахь замыг зэрэгцүүлэн барих арга хэмжээ авах;
- “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийн 1 ба 2 үе шатанд баригдах төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг хамтад нь тусгах;
- БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын “Хувь нийлүүлсэн “УБТЗ” нийгэмлэгийг байгуулах тухай” 1949 оны хэлэлцээрийг шинэчлэх хүрээнд “УБТЗ” ХНН-ийг Хувьцаат компани болгож, Монголын талын хувь хэмжээг 51 хувь, Оросын холбооны улсын талын хувь хэмжээг 49 хувь байхаар өөрчилж, Хэлэлцээрийг шинэчлэх асуудлыг эцэслэн шийдвэрлэх;
- “УБТЗ” ХНН-ийн замын байгууламж, дохиолол холбооны техник технологийг шинэчлэх, хөдлөх бүрэлдэхүүний паркийг сайжруулснаар замын тээх, нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлэх;
- “УБТЗ” ХНН-т бүтцийн өөрчлөлт хийж, суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгчийн үйл ажиллагааг тусгаарлах;
- Монголын нутгаар дамжин өнгөрөх ачааны хэмжээг нэмэгдүүлэх талаар хийгдэж буй судалгааг түргэвчилж олон улсын гэрээ хэлэлцээрийг байгуулах талаар санаачлагатай ажиллах;
- Монгол Улсын экспортын ачааг Оросын Холбооны Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан төмөр замаар тээвэрлэхэд ашиглах Төмөр замаар дамжин өнгөрөх, ачаа тээвэрлэх, нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулах.

ЗОРИЛТ 20: *УРТ ХУГАЦААНД ГАДААД, ДОТООД ӨРИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮҮДНЭЭС ӨРИЙН СТРАТЕГИЙГ БИЙ БОЛГОХ, ҮНДЭСНИЙ БОЛОН ОЛОН УЛСАД ХЭРЭГЛЭЖ БАЙГАА АРГА ХЭРЭГСЛИЙГ СУДАЛЖ, МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВ, ЭДИЙН ЗАСАГТ ХҮНДРЭЛ УЧРУУЛАХГҮЙГЭЭР ӨРИЙГ ЗОХИЦУУЛАХ, ШИЙДВЭРЛЭЖ БАЙХ.*

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсын Засгийн газар хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагаас 2010 онд 91.2 тэрбум төгрөгийн гадаад зээл авч ашигласан бөгөөд гадаад зээлийн үндсэн төлбөрийн эргэн

төлөлтөд 157.8 тэрбум төгрөгийг төлж, Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл 2010 оны жилийн эцсийн байдлаар 2,209.6 тэрбум төгрөг байна. Энэ нь ДНБ-ий 20.3 хувьтай (өнөөгийн үнэ цэнээр) тэнцэж байна.


Хүснэгт 33. Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл (2010 оны гүйцэтгэл), тэрбум төгрөг

Гадаад зээлийн ангилал	2010 оны эхний үлдэгдэл	Ашиглалт	Гадаад зээлийн үндсэн төлбөр	Ханшийн өөрчлөлт	Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх хувь	2010 оны эцсийн үлдэгдэл
Төслийн зээл	1,683.3	74.4	47.8	-265.2	65.1%	1,444.7
Авто замын зээл	294.2	16.8	5.1	-53.3	11.4%	252.6
Санхүүгийн зээл	512.0	0.0	7.3	-2.6	23.0%	502.1
ОУВС-гийн зээл	19.8	0.0	6.5	-3.1	0.5%	10.2
ОУ-ын бонд	95.6		91.1	-4.4	-	-
НИЙТ ЗЭЭЛ	2,604.9	91.2	157.8	-328.6	100%	2,209.6

Эх үүсвэр: Сангийн яам 2010,

Дүрслэл 29-д үзүүлсэнээр нийт гадаад өрийн үлдэгдлийн 35 хувийг Азийн хөгжлийн банк, 23 хувийг Дэлхийн банк, 23 хувийг Япон улсад төлөх өрийн үлдэгдэл эзэлж байгаа бол үлдсэн 19 хувийг бусад улс, олон улсын байгууллагаас авч ашигласан зээлийн үлдэгдэл эзэлж байна. Нийт гадаад өрийн багцын валютын бүтцийг авч үзвэл 62 хувийг ЗТЭ/Зээлжих тусгай эрх/, 19 хувийг Японы иен, 10 хувийг евро эзэлж харин бусад валютууд 9 хувийг эзэлж байна.

Дүрслэл 28. Засгийн газрын гадаад зээлийг санхүүжүүлэгч байгууллагууд



Өрийн эдийн засаг, төсөвт үзүүлэх дарамтын шинжилгээг ОУВС, Дэлхийн банкны аргачлалын дагуу хийдэг бөгөөд манай улсын хувьд энэхүү үзүүлэлтүүдийг дараахь хүснэгтэд харуулсан.

Хүснэгт 34. Өрийн тогтвортой байдлын шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт	2010	Сэрэмжлэх түвшин	Тайлбар
Өр/ДНБ	20.3	40.0	Тогтвортой
Өр/Экспорт	57.7	150.0	Тогтвортой
Өр/ЗГ-ын орлого	55.2	250.0	Тогтвортой
Өрийн үйлчилгээ/ Экспорт	6.3	20.0	Тогтвортой
Өрийн үйлчилгээ / ЗГ-ын орлого	6.1	30.0	Тогтвортой

Эх үүсвэр: Сангийн яам

ДНБ-д эзлэх Засгийн газрын гадаад өрийн хэмжээ 2010 онд (өнөөгийн үнэ цэнээр) 20.3 хувь байгаа нь ОУВС, Дэлхийн банкнаас тогтоодог өрийн тогтвортой байдлын шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд “гадаад өрийн эрсдэл бага” гэсэн ангилалд багтаж байна.

Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын Их Хурлын 2009 оны 97 дугаар тогтоол, Засгийн газрын 2009 оны 378 дугаар тогтоолоор 100.0 тэрбум төгрөгийн үнэт цаас гаргаж, арилжаалахыг Засгийн газарт зөвшөөрсөн. Үүний дагуу 2010 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр нийт 67.0 тэрбум төгрөгийн Засгийн газрын бондыг Төрийн банкинд, мөн оны 3 дугаар сарын 25-ны өдөр 33.0 тэрбум төгрөгийн Засгийн газрын бондыг Монголбанкнд арилжаалсан байна.

Улсын Их Хурлын 2009 оны 77 дугаар тогтоол, Засгийн газрын 2009 оны 372 дугаар тогтоолоор УИХ-аас олгосон 250.0 тэрбум төгрөгийн үнэт цаасны эрхээс улсын төсвийн алдагдалд 170.0 тэрбум, төрийн албан хаагчдын орон сууцны зээлд зориулан 80.0 тэрбум төгрөгийн үнэт цаас

арилжаалахыг зөвшөөрчээ. Энэ ажлын хүрээнд 2010 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөс 2010 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр хүртэл 1-5 жилийн хугацаатай, 7.2-7.8 хувийн хүүтэйгээр Монголбанк, Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгон уг үнэт цаасыг арилжаалсан. Үнэт цаас арилжаалсан эх үүсвэрийг Орон сууц санхүүжилтийн корпорацид дамжуулан зээлдүүлэх гэрээгээр зээлдүүлжээ.

Монгол Улсын Засгийн газар ОУВС-гийн хооронд 2009 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр байгуулсан “Тогтворжуулах хөтөлбөр”-ийн хүрээнд валют харилцан солилцох зорилгоор тус хөтөлбөрийн 5 дахь санхүүжилт болох 15.3 сая зээлжих тусгай эрхтэй тэнцэх 32.7 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаасыг 2010 оны 3 дугаар сард Монголбанкин дахь ОУВС-гийн дансанд байршуулсан байна.

Хүснэгт 35. Засгийн газрын үнэт цаас арилжаалсан байдал (2006-2010)

Он	УИХ-аас олгосон эрх / тэрбум төгрөг/	Арилжаалсан дүн / тэрбум төгрөг/	Дундаж хүү
2006	80	49.4	1.43%
2007	150	40.8	6.61%
2008	0	1.4	9.48%
2009	2,380	732.8	5.47%
2010	0	212.7	6.06%

Эх үүсвэр: Сангийн яам 2010

Төсвийн урсгал тэнцэл ашигтай байгаа нь дотоод өрийн тогтвортой байдлыг хангахаар байна. 2010 оны эцэст урсгал зардлын хувьд санхүүжилт дутуу гарсан өр үндсэндээ байхгүй байна. Төсвийн тэнцэл 2010 онд 5.5 тэрбум төгрөгийн ашигтай гарсан нь дотоод өрийн дарамтгүй байсан гэж үзэж болно.

Авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ

Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны (2007-2009 оны) стратегийг анх удаа боловсруулан Сангийн сайдын 2007 оны 5 дугаар сарын 24-ны өдрийн 144 дүгээр тушаалаар баталжээ. Гэхдээ 2010 оны Засгийн газрын хуралдааны 51 дүгээр тэмдэглэлийг үндэслэн “Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны (2010-2012 оны) стратеги”-ийг Сангийн сайдын 2010 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 219 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан байна. Өрийн удирдлагын стратегийн баримт бичиг нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон 2011-2013 оны төсвийн хүрээний мэдэгдлийн хүрээнд, тэдгээрт дэмжлэг үзүүлэх бодлогын баримт бичиг юм.

2008-2009 оны санхүү, эдийн засгийн хямралаас шалтгаалж ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй Стэнд-бай хөтөлбөрийн хүрээнд авч ашигласан гадаад валютуудыг 2012-2014 онд эргэн төлөлт хийхээс үүдэн ирэх жилүүдэд эргэн төлөлтийн төлбөр эрс өсөхөөр байна.

Цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ


- Өрийн удирдлагын бүртгэлийн систем болох өрийн удирдлагын санхүүгийн шинжилгээний системийг шинэчлэх;
- Олон улсын жишгийн дагуу Засгийн газрын өрийн удирдлагын 2010 оны тойм хэвлүүлэн Засгийн газрын өрийн талаар нийтэд мэдээлэх;
- Засгийн газрын Өрийн удирдлагын дунд хугацааны зорилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрсдлийн боломжит түвшинг тодорхойлсны үндсэн дээр дунд болон урт хугацаанд Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээг хамгийн бага зардлаар цаг хугацаанд нь хангах болон Засгийн газрын дотоод өрийн зах зээлийг хөгжүүлэх.

ЗОРИЛТ 21. МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ШИНЭ ТЕХНОЛОГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, “МЭДЭЭЛЭЛЖСЭН НИЙГЭМ БАЙГУУЛАХ”

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Суурин холбоо нийслэл хот, аймаг, сумдын түвшинд хөгжиж шинэ техник, технологи, шинэ үйлчилгээг нэвтрүүлэх ажил эрчимжив.


Дүрслэл 29. Суурин телефон утасны цэгийн тоо (1000 хүн тутамд)



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Дэлхий нийтэд үүрэн телефон буюу гар утасны хэрэглээ эрчимтэй өсч түүнээс шалтгаалан суурин телефон хэрэглэгчдийн тоо буурсаар байна. Манай улсад ч энэ байдал ажиглагдаж байгаа бөгөөд 2006 оноос суурин телефон хэрэглэгчдийн тоо буурч 2010 оны байдлаар 143.2 мянга буюу мянган хүнд ноогдох телефон цэгийн тоо 52 болсон байна.

Дүрслэл 30. Суурин телефон холбооны хэрэглэгчдийн тоон үзүүлэлт




Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Гэвч “Өргөн зурвасын сүлжээ” /Broadband/ хөтөлбөр, дэлхий нийтэд нэвтэрч буй суурин холбооны гурвалсан үйлчилгээ /Triple play/ шинэ технологийг нэвтрүүлснээр суурин холбооны хэрэглэгчдийн тоо өсөх хандлагатай байна.


Манай улс 2004 он хүртэл интернэтийн нэг гарцтай, 78 Мб/с багтаамжтай байсан бол одоо 6 гарцтай болж 11.2 Гб/с буюу 14 дахин нэмэгдсэн өндөр хурдаар дэлхийн мэдээллийн сүлжээнд холбогдож байна.

Дүрслэл 31. Интернэт байнгын хэрэглэгчийн тоо (1000 хүн тутамд)



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Дүрслэл 32. Интернэтийн байнгын хэрэглэгчдийн тоон үзүүлэлт (мянган ширхэгээр)



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Интернэтийн үйлчилгээний чиглэлээр 77 байгууллага үйл ажиллагаа эрхэлж интернэт байнгын хэрэглэгчдийн тоо 2010 оны жилийн эцсийн байдлаар 199.8 мянгад хүрчээ.


Интернэтийн байнгын хэрэглэгчдийн тоо 2009-2010 онд огцом өсч 1000 хүнд ногдох хэрэглэгчийн тоо 72.4 хүрсэн нь интернэтийн гадаад гарцын хүчин чадал нэмэгдэж, үйлчилгээний үнэ тариф буурч, хөдөө орон нутагт дамжуулах сүлжээ, үйлчилгээ хүрээгээ тэлсэнтэй холбоотой байна. Энэ үзүүлэлт цаашид эрчимтэй өсөх хандлагатай байна.

Үүрэн телефон холбоо Монгол Улсад нэвтэрсэн цагаас хойш хэрэглэгчдийн тоо жил бүр өсөн нэмэгдсээр өнөөгийн байдлаар бүх сумдад үйлчилгээ нэвтэрч, хүн амын 70 хувь нь үүрэн телефон холбоо хэрэглэж байна.

Үүрэн холбооны хэрэглэгчдийн тоо 2010 оны эцэст 2,5 сая болжээ. Үүрэн холбооны операторууд өөрийн хөрөнгөөр техник, технологи доо шинэчлэлт хийж, сүлжээгээ өргөтгөн 3G технологийг 31 сум, суурин газарт нэвтрүүлснээр хэрэглэгчдийн тоо 171 мянга болжээ.


Энэ салбарын зах зээлийн өрсөлдөөний явцад “Card PLUS”, “Be brand”, “3,5G”, “Doping”, “ID”, “My Phone”, “G10” зэрэг хэрэглэгчдэд шинэ шинэ үйлчилгээ нэвтэрч, үнэ тариф нь буурсаар байна.

Дүрслэл 33. Үүрэн телефон холбооны хэрэглэгчдийн тоон үзүүлэлт (мянган ширхэгээр)



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Дүрслэл 34. Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо (1000 хүн тутамд)



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Энэ үзүүлэлт нь зорилтот түвшиндээ эрт хүрсэн бөгөөд өнөөгийн үйлчилгээ эрхэлж байгаа 4 оператор компанийн зах зээлийн өрсөлдөөний явц дахь багц үйлчилгээ, үнэ тарифын хямдралаас хамаарч өсөх хандлагатай байна.

Авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ

Засгийн газрын мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг малчдад хүргэх зорилтын хүрээнд “Хөдөөг холбоожуулах” төслийг Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар 82 сумын 184 багт малчдын холбооны үйлчилгээний цэг байгуулж, багийн түвшинд суурин телефон ашиглах боломжийг бүрдүүлэв. “Хөдөөг холбоожуулах” төслийн үр дүнд 114 мянган малчин телефон холбооны үйлчилгээ авч 1 сард 34645 удаа ярьдаг болсон байна.

Салбарын үнэ тарифын бодлогын хүрээнд 2010 онд цахилгаан холбооны сүлжээ хоорондын харилцан холболтын үнэ тарифыг газар зүйн ялгаваргүй болгох шийдвэр гарснаар үүрэн холбооны хэрэглэгчдийн хот хоорондын ярианы үнэ тариф 1.7-2.1 дахин, суурин телефон холбоо хэрэглэгчдийн хот хоорондын ярианы үнэ тариф 1.6-2 дахин буурлаа.

Мэдээлэл, холбооны дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр 265 сум сууринг /давхардсан тоогоор/ холбосон 8400 км урт тоон радио сүлжээ, 160 сум, суурин газрыг холбосон 13762 км урт өндөр хурдны шилэн кабелийн сүлжээ байгуулснаар нийт сумдын 48.3 хувь нь шилэн кабелийн сүлжээнд холбогдоод байна.

Бүх салбарын хөгжилд мэдээллийн технологи чухал үүрэгтэй болж төрийн байгууллагууд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлж, татвар, гаалийн байгууллагуудад албан бичиг хөтлөлтийн онлайн систем бүрэн нэвтэрлээ.

Улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн ангилал болон кодчиллыг боловсронгуй болгож, мэдээллийн системийн нэгдмэл байдлыг үүсгэн, төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох орчныг бий болгох, төрийн үйлчилгээг хялбар, шуурхай, ил тод, болгох зорилготой “Төрийн мэдээлэл солилцооны харилцан холболтын дэд бүтцийг байгуулах төсөл”-ийг хэрэгжүүлж,

Үндэсний дата төв дээр тоног төхөөрөмжийг суурилуулж Улсын бүртгэлийн Ерөнхий газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, банкуудыг холбон туршиж байна.

Мэдээллийн технологийн гадаад аутсорсинг хөгжүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөрийг 2010 оноос эхлэн улсын төсвөөс санхүүжүүлэн хэрэгжүүлж байна.

Интернэтийн орчны Андроид маркет, Apple AppStore-т монгол программ хангамжийн инженерүүдийн 20 гаруй бүтээл тавигдаж, 2010 оны 11 дүгээр сарын байдлаар 2 сая удаа үнэгүй татагдсан байна.

Мэдээлэл, шуудан харилцаа холбоо, технологийн газар нь Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамтай хамтран мэдээллийн технологийн төвлөрөл буюу “Силикон вaley” байгуулах их бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлээ. Монголын Интернэтийн Харилцан Холболтыг шинэчлэх төслийг 2010 онд Үндэсний дата төвд хэрэгжүүлж, интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг холбосноор дотоодын интернэтийн урсгалын багтаамж өмнөхөөсөө 10-100 дахин нэмэгдэж, 1G болон 10G холболтоор үйлчилгээ эрхлэгч байгууллагууд Үндэсний дата төвтэй холбогдож гадаад гарцаас хамааралгүйгээр урсгалыг шуурхай, найдвартай, аюулгүй дамжуулах боломжийг бүрдүүлэв.

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотоос Ази тивийг дамжсан 10 Гб, Европ тивийг дамжсан 5 Гб, бие биеэсээ үл хамаарах чиглэлтэй интернетийн урсгалыг нээснээр Монгол Улс дэлхийн түвшинд хүрсэн интернэтийн сүлжээнд холбогдсон төдийгүй байнгын тасралтгүй найдвартай ажиллах боломжтой болж хүчин чадал буюу хурд багтаамжийг нь дээшлүүлээ.

Дээр дурдсан төслүүдийн үр дүнд интернэтийн хэрэглээ өссөн бөгөөд аймаг сумдад шинэ технологийн өндөр хурдны дамжуулах, түгээх сүлжээ, мэдээлэл холбооны нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах арга хэмжээг 2016 он хүртэлх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ. Ингэснээр хөдөө орон нутагт интернэтийн хэрэглээ өсөх, үйлчилгээний үнэ тариф буурах боломж нэмэгдэнэ.

Радио, телевизийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр 2010 онд зохицуулалтын томоохон арга хэмжээ авч шинэ шинэ бодлогын чиглэлүүд гарлаа.

Телевизийн дамжуулах системийг сансрын холбооны “Кю” давтамжийн зурваст шилжүүлж орон даяар 6-18 сувгийн нэвтрүүлгийг дамжуулах, хүлээн авах техникийн нөхцөлийг бүрдүүлэв.

Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газраас “Монгол Улсад хөдөлгөөнт телевизийн үйлчилгээг нэвтрүүлэхэд баримтлах чиглэл”, “Интернэт протоколд суурилсан телевиз, хөдөлгөөнт телевизийн үйлчилгээ нэвтрүүлэхэд баримтлах чиглэл”-ийг тус тус батлан хэрэгжүүлж байна.

Засгийн газрын 2010 оны 275 дугаар тогтоолоор “Монгол Улсын радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн системийг тоон технологид шилжүүлэх үндэсний хөтөлбөр” батлагдан хэрэгжиж эхэллээ. Энэ хүрээнд “Монгол Улсын радио телевизийн өргөн нэвтрүүлгийг аналогид системээс тоон систем рүү шилжүүлэх” төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг /ТЭЗҮ/ хийсэн бөгөөд 2015 онд тоон системд бүрэн шилжүүлэхээр ажиллаж байна. Мөн Монгол Улс 2015 онд сансарт хиймэл дагуул хөөргөх асуудлаар судалгаа хийж, Япон, Хятад зэрэг гадаад улс орнуудтай хамтран ажиллаж байна.

Тулгамдаж буй асуудлууд

Мянган хүнд ногдох суурин телефон утасны цэгийн тоог 2015 онд хүрэх түвшинг хангахын тулд ирэх 4 жилийн хугацаанд хоёр дахин өсгөх шаардлагатай байна. Суурин телефон цэгийн тоог зорилтот түвшиндээ хүргэхийн тулд тулгамдаж буй дараахь асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай байна:

- Өргөн зурвасын өндөр хурдтай сүлжээг сум, багийн түвшинд байгуулах, өргөтгөх;
- Өнөөгийн хөгжлийн хурд, нөхцөл байдалд тохирсон уян хатан тогтолцоо бүхий мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээг салгах концепци гаргах, хэрэгжүүлэх;
- Сүлжээний давхардлыг арилгах;

- Гадаадын зээл, тусламжийн эргэн төлөлт, дамжуулан зээлдүүлэх өрийн асуудлыг хөнгөвчлөх.

Цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ

- Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, салбарыг хөгжүүлэх Засгийн газрын хөтөлбөр, төслүүдэд туссан өндөр ач холбогдолтой мэдээлэл, холбооны өндөр технологийн инновацийн кластер (Силикон валий) байгуулах, мэдээллийн технологийн хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, малчдыг холбоожуулах, стратегийн ач холбогдол бүхий суурин газруудыг (томоохон уул уурхай, хилийн боомт, худалдааны чөлөөт бүс) хамарсан өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ байгуулж цогц удирдлага, хяналтын систем хөгжүүлэх, радио телевизийг тоон технологид шилжүүлэх зэрэг зорилт, арга хэмжээнүүд тусгагдсан бөгөөд дунд хугацаанд (2010-2015 он) үе шаттай хэрэгжүүлэх;
- Түүний зэрэгцээ “Бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох” үндэсний хөтөлбөрийн хүрээнд орон зайн мэдээллийн нэгдсэн дэд бүтэц, мэдээллийн сан бий болгох, тэдгээрт суурилсан хаягжилтын нэгдсэн системтэй болох, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хөдөө, орон нутагт нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах, сумдад интернэт протоколд суурилсан өгөгдөл дамжуулах, түгээх сүлжээ байгуулах, шилэн кабельд хамрагдаагүй сумдыг шилэн кабелийн сүлжээнд холбох, төрийн байгууллагуудын өндөр хурдны сүлжээ, Улаанбаатар хотын метрополитан сүлжээг тус тус байгуулах зэрэг дэд бүтцийг хөгжүүлэх зорилт, арга хэмжээнүүдийг эрчимтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хөгжлийн бодлого дэлхий нийтийн түншлэлийг хөгжүүлэх мянганы хөгжлийн 8 дахь зорилгын 4 зорилтуудын хэрэгжилт харилцан адилгүй байна. Иймээс УИХ-аар баталсан шалгуур үзүүлэлт бүрээр хэрэгжилтийн байдлыг тооцож биелэхээр байгаа зорилтуудыг бататгах, удаашралтай байгаа зорилтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай юм.



ЗОРИЛГО ЕС

*ХҮНИЙ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ,
АРДЧИЛСАН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ*



ЗОРИЛГО 9

ХҮНИЙ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ, АРДЧИЛСАН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ

ЗОРИЛТ 22. ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛЫГ ХҮНДЭТГЭН САХИЖ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАЖ, ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЛИЙГ ЧӨЛӨӨТЭЙ ОЛЖ АВАХ БОЛОМЖ ОЛГОХ

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

“Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр” батлагдсанаас хойш 8 жил өнгөрч байна. Хүний эрхийн үндэсний комиссоос жил бүр “Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал” үндэсний илтгэлийг гаргаж олон нийтийн хүртээл болгодог. Хүний эрх, эрх чөлөөний бодитой хэрэгжилтэд Засгийн газарт мэргэжлийн үүднээс зөвлөх, хамтран ажиллах хөндлөнгийн хяналтын байгууллагууд чухал үүрэгтэй. Үндэсний илтгэлүүд болон хүний эрхийн төлөв байдлын талаар хийсэн судалгаанаас үзэхэд “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт тайлан” сайн биш байна.

Мянганы хөгжлийн энэхүү зорилтын хүрээнд хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүндэтгэн сахиж буй байдлыг үнэлэх 6 багц шалгуур үзүүлэлтийг УИХ-аар баталсан. Түүний хэрэгжилтийн байдлыг дараахь хүснэгтээр үзүүлэв.

2008 он хүртэл төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцааны зардалд улсын төсвөөс 15 сая төгрөгийг зарцуулдаг байсан бол 2012 онд 240 сая төгрөгийг зарцуулахаар төсөвлөөд байна.


Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт нийт 243 зорилт дэвшүүлсэн бөгөөд Хүний эрхийг хангах үндэсний механизмийг бэхжүүлэх чиглэлээр нийт 71 зорилт, Хүний эрх, эрх чөлөөг хангах чиглэлээр нийт 43 зорилт, Хүний улс төрийн эрх, эрх чөлөөг хангах чиглэлээр нийт 36 зорилт, Хүний эдийн засгийн эрхийг хангах чиглэлээр нийт 20 зорилт, Хүний нийгэм, соёлын эрхийг хангах чиглэлээр нийт 43 зорилт, Олон улсын гэрээний биелэлт ба хяналт үнэлгээг эрчимжүүлэх хангах чиглэлээр нийт 20 зорилт, Хөдөлмөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилтийн чиглэлээр 36 зорилтыг тус тус дэвшүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 36. МХЗ-9-ын хэрэгжилтийн хяналт-шинжилгээний шалгуур үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2007	2008	2009	2010	2015*
Хүний хөгжлийн индекс	0.737	0.745	0.750	0.763	0.83
Монгол Улсын хууль тогтоомж олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцэд нийцэж буй талаархи шинжээчдийн үнэлгээ /хувь/	...	3.4
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт /хувь/	68.2	73.4	70.8	51.9	64.5
Төлбөрийн чадваргүй иргэдэд үйлчилгээ үзүүлж буй өмгөөлөгчдийн тоо	518	431	340	471	...
Улс төр, эдийн засаг, санхүүгээс хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хараат бус байдлын талаархи иргэдийн төсөөлөл	...	28.5	28.5
Төсөв, түүний зарцуулалтын тайланг вэб хуудсандаа тогтмол байрлуулдаг төрийн байгууллагын тоо	...	70	83	88	...

*-Зорилтод түвшин
Эх үүсвэр: Хууль зүй, дотоод хэргийн яам; Үндэсний статистикийн хороо

Дүрслэл 35. Хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн байдал, хувиар



Хөтөлбөрийн нийт зорилтын хэрэгжилтийн байдлыг ерөнхийд нь авч үзвэл 9 хувь нь бүрэн хэрэгжсэн, 55 хувь нь хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч, ахиц гарсан, 10 хувь нь хэрэгжиж эхэлсэн байна. Харин 26 хувийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч эхлээгүй гэсэн дүн гарч байна. Өөрөөр хэлбэл, 74 хувь нь хэрэгжиж байна.

Монгол Улсын хүний хөгжлийн индекс сүүлийн жилүүдэд үндэсний болон бүс нутгийн хэмжээнд жил дараалан тасралтгүй өссөөр байгаа хэдий ч олон улсын түвшинд дундаж үзүүлэлттэй орнуудын тоонд багтаж байна. Энэ нь нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ харьцангуй бага байгаатай холбоотой байна.

Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон их, дээд сургуульд суралцагчдын 6-22 насны хүн амд эзлэх хувь 2010 онд 2009 оныхоос 1.1 нэгжээр, нэг хүнд ногдох ДНБ 907.9 ам.доллараар өссөн нь 2010 онд хүний хөгжлийн индекс 0.13 нэгжээр нэмэгдэж, 0.763-д хүрэхээр байна.

ХХИ нь хүний хөгжлийн ерөнхий түвшин, төлөв байдлыг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд түүний

зэрэгцээ жендэрийн тэгш байдлыг хэрхэн хангаж буйг судлах зорилгоор ялгаатай хоёр индексийг ашиглаж байна. Үүний нэг нь жендэрийн хөгжлийн индекс (ЖХИ) юм. Уг индексийн шалгуур үзүүлэлтүүд нь хүний хөгжлийн индексийг тооцох гурван үндсэн үзүүлэлттэй ижил бөгөөд ялгаа нь эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдтэй харьцуулан судлах боломж олгодгоороо онцлогтой. Хоёр дахь индекс нь эмэгтэй хүний нийгэмд эзэлж буй байр суурийг эрэгтэй хүнтэй харьцуулан илэрхийлэх жендэрийн эрх мэдлийн хэмжүүр (ЖЭМХ) юм.

Жендэрийн хөгжлийн индексийг тооцоход ашиглагдах гурван үзүүлэлтийг тус тусад нь авч үзэхэд зарим үзүүлэлтийн хувьд эрэгтэйчүүдийнх эмэгтэйчүүдийнхээс өндөр байна. Тухайлбал, 2010 онд 6-22 насандаа сургуульд хамрагдаж буй эрэгтэйчүүдийн хувь 86.3 байхад эмэгтэйчүүдийнх 77.2 хувь, худалдан авах чадварын паритетаар тооцсон нэг хүнд ногдох ДНБ эрэгтэйчүүдийнх 5680.4 ам.доллар байхад эмэгтэйчүүдэд 4061.6 ам.доллар байна. Харин Монгол эмэгтэй хүний дундаж наслалт 2010 онд 72.26 жил байхад эрэгтэйчүүдийнх 64.93 жил байна.

Жендэрийн эрх мэдлийн хэмжүүр 2010 онд 0.395 байгаа нь эдийн засаг, улс төрийн хүрээ болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй байгааг илэрхийлж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт 2005-2008 оны хооронд өсч, 73.4 хувьд хүрсэн ч, 2009 онд 70.8 хувь, 2010 онд 51.9 хувь болж буурчээ. Төлбөрийн чадваргүй иргэдэд үйлчилгээ үзүүлж буй өмгөөлөгчдийн тоо 2009 онд 340 байсан бол 2010 онд 471 болж өсчээ.

Дотоодын хууль тогтоомжийн хүрээнд хувь хүний халдашгүй эрх болон олон улсын гэрээ, конвенцитай шууд холбогдох хуулийг сонгон авч, үнэлгээ өгснийг доор хүснэгтээр харуулав.

Хүснэгт 37. Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтийн түвшинд өгсөн шинжээчдийн үнэлгээ

Д/д	Монгол улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээ, конвенци	Оноо
1	Хүүхдийн эрхийн тухай конвенци	3.3
2	Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол	4.1
3	Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол	2.9
4	Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцийн нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол	4.2
5	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенци	2.8
6	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт	4.4
7	Эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт	4.4
8	Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенци	4.4
9	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухайн олон улсын конвенци	4.2
10	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенци	4.3
	Нийт	39
	Дундаж дүн оноо	3.9

Эх үүсвэр: Хууль зүй, дотоод хэргийн яам; Үндэсний статистикийн хороо

Монгол Улсын дотоодын хууль тогтоомж Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцид нийцэж байгаа талаарх ерөнхий үнэлгээ 3.9 оноотой гарсан байна. Энэ нь манай улсын дотоодын хууль тогтоомжийн олон улсын хүний эрхийн гэрээтэй нийцэж буй байдал Монгол Улсын хувьд “дунд зэрэг”-ийн түвшинд буюу хууль тогтоомжийг шинэчлэн нийцүүлэх шаардлага байгааг харуулж байна.

Ажлын үр дүн 2008 онд хийгдсэн үнэлгээнээс 0.5 нэгжээр илүү гарсан бөгөөд энэ нь үндэсний хууль тогтоомжийг Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэх ажилд бага боловч ахиц гарч байгааг харуулж байна. Түүнчлэн 2 жилийн хугацаанд манай улс НҮБ-аас баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцийн нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол, Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протоколд тус тус нэгдэн орсон нь төр засгаас иргэдийнхээ эрхийг хангахад анхаарч байгааг харуулж байна.

Монгол Улсад 2010 оны 12 дугаар сарын 1-ний байдлаар 439 хууль, Монгол Улсын соёрхон

баталсан болон нэгдэн орсон 145 олон улсын гэрээ конвенци хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. 2010 оны судалгаагаар гол хуулиудын талаархи иргэдийн мэдлэг ойлголт ямар байгааг харьцуулж үзэхэд 2008 оны судалгааны дүнгээс бага зэрэг ахисан байна. Тухайлбал, хүний эрхтэй гол холбоотой Монгол Улсын Үндсэн хуулийн хувьд 2008 оныхоос 5.5 нэгжээр, сонгуулийн тухай хуулийн мэдлэг 1.0 нэгжээр тус тус дээшилсэн байна.³³

2009-2010 онд Харьяатын тухай хуульд өөрчлөлт оруулсан байна. Жендерийн тэгш эрхийн тухай хууль, Үндсэн хуульд нэмэлд өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг шинээр баталжээ. Нийгмийн байдлаар ялгаварлах байдал гарч байгаа нь Хүний эрхийн зөрчлийн гол байр суурийг эзэлж байна. Хот, хөдөө, насны болон ядуу баяны ялгаа, намын харьяалал, ажил албаны зиндаа, хүйсээр ялгаварлан гадуурхах байдал өмнөх онуудаас нэмэгдсэн байна. Ялгаварлан гадуурхалт төрийн захиргааны алба (2.63 хувь) боловсрол (2.64 хувь), эрүүл мэндийн (2.73 хувь) салбарт муу байна.³⁴

33 *Адä-еёнäи зäндäеёи ä“ä ääеäеä ääднäи өд -е“еö -2009-2010. УБ., 2010*

34 *Адä-еёнäи зäндäеёи ä“ä ääеäеä ääднäи өд -е“еö -2009-2010. УБ., 2010, 14-15-д ä äеöä*

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад өгсөн шинжээчдийн үнэлгээ өссөн үзүүлэлттэй байхад Хүүхдийн эрхийн тухай конвенци болон түүний нэмэлт протоколууд болох Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд татан оруулахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол, Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протоколуудад өгсөн үнэлгээ доогуур үзүүлэлттэй байна.

Хүний эрхийг сахин хамгаалах, бодлого тодорхойлох, олон улсын хүний эрхийн гэрээний биелэлт, УИХ, Засгийн газар, яам агентлагууд, орон нутгийн төр захиргааны байгууллагуудаас гарч буй хууль тогтоомжууд, шийдвэр нь хүний эрхийн үндсэн зарчим, олон улсын гэрээ конвенциудад хэрхэн нэгдэж буйг Монгол Улсын хүний эрхийн комисс хянан холбогдох судалгааг хийж, дүгнэлт гарган, жил бүр УИХ-д танилцуулж байна. Хүний эрх зөрчигдөж байгаа талаар иргэдийн гомдлыг хянан холбогдох байгууллага, удирдлагуудад шаардлага, зөвлөмж хүргүүлж биелэлтийг хянан ажиллаж байна. 2009 онд шаардлага 6, зөвлөмж 5-ийг хүргүүлж байсан бол 2010 онд шаардлага 6, зөвлөмж 8-ыг хүргүүлжээ, иргэдээс ХЭҮК-д ирүүлсэн гомдол 2009 онд 169 байсан бол 2010 онд 218 болж тус тус өссөн байна.

Хүний наймааны гэмт хэрэг голдуу бэлгийн мөлжлөг, боолчлол, хүний эд эрхтэний худалдааны хэлбэрээр илэрч байна. Сүүлийн жилүүдэд энэ төрлийн гэмт хэргийн гаралт нэмэгдэж, хохирогчдын тоо өссөөр байгаа нь энэ талаар төрийн бодлогын хүрээнд томоохон хэмжээний ажлуудыг зохион байгуулах шаардлагатайг харуулж байна.

Монголд 2001 онд хүн худалдаалах 2 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдаж байсан бол 2010 оны байдлаар 300 гаруй хэрэг бүртгэгдээд байна. Цагдаагийн газраас явуулсан судалгаагаар 1000 гаруй монгол охид Макао, Сингапур, Бээжин, Солонгост биеэ үнэлж, тэдний 300-500 орчим нь саун, массаж, шөнийн цэнгээний газарт ажиллаж, эдгээрийн 70 орчим хувь нь хүчирхийллийн золиос болж байна. Судалгаанаас харахад нийт хохирогчдын 9.7 хувь нь насанд хүрээгүй, 50 хувь

нь 18-21 насны, 34 хувь нь 21-26 насны, 6.3 хувь нь 26-30 насны эмэгтэйчүүд байна. Хохирогчдын 63.4 хувь нь бусдад итгэн хууртагдсан, 24.3 хувь нь хүчинд автсан, 7.3 хувь нь зар сурталчилгаанд итгэсэнээс хүн худалдаалах гэмт хэргийн золиос болжээ.³⁵

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн бодит хувь хэмжээ 2010 онд өмнөх оныхоос буурсан үзүүлэлттэй гарчээ.

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, сэтгүүлчид бусдын нөлөөнд далдуур орох боломжийг хааж зохицуулалт хийсэн хууль эрх зүйн зохицуулалт одоогоор байхгүй байна. Одоо УИХ-ын хэлэлцүүлгийн шатанд байгаа хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуульд энэ талын зохицуулалтыг тусгах шаардлагатай юм. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд төрөөс ямар нэг хэлбэрээр дарамт шахалт үзүүлэх нь багасч, харин төрийн бодлого, үйл ажиллагааг шүүмжлэх эрүүл саруул үзэгдлийн хажуугаар төрийн байгууллага, албан тушаалтнуудын нэр төрд халдах, гүтгэх, цуурхал тараах зэрэг зөрчил буурахгүй байна. Ялангуяа сонгууль дөхөөд ирэхээр энэ байдал улам их болдог.³⁶

Хүснэгт 37-аас харахад төрөөс хэвлэл мэдээллийн ажилд оролцдог гэсэн төсөөлөл иргэдийн дунд түгээмэл байна. Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нөлөөлдөггүй гэсэн иргэд 17.0 орчим хувийг эзэлж байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эдийн засаг, санхүү нь хараат байдаг гэсэн төсөөлөл судалгаанд хамрагдагсдын 40.0 гаруй хувийг эзэлж байна. Үндэсний хэмжээний хэвлэл мэдээллийн байгууллагуудад иргэдийн итгэх байдлыг дараахь хүснэгт 36-д нэгтгэн үзүүлээ.³⁷

35 *Адä-еёнäи зäндэеүйи д'е'ä ääéäëä ääднii өөд +е'еö -2009-2010. УБ., 2010, 29-30-д д äëöä*

36 *Адä-еёнäи зäндэеүйи д'е'ä ääéäëä ääднii өөд +е'еö -2009-2010. УБ., 2010, 137-д д äë*

37 *Адä-еёнäи зäндэеүйи д'е'ä ääéäëä ääднii өөд +е'еö -2009-2010. УБ., 2010, 138-д д äë*

Хүснэгт 38. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн улс төр, санхүү, эдийн засгийн хараат бус байдлын талаарх иргэдийн төсөөлөл (улсын дундаж хувиар)

Үзүүлэлт	Нийтлэгдээгүй		Нийтлэгдээгүй		Дунд зэрэг		Нийтлэгдсэн		Бүрэн нийтлэгдсэн		Мэдэхгүй	
	2009	2010	2009	2010	2009	2010	2009	2010	2009	2010	2009	2010
1 Хэвлэл мэдээллийн хэрэгслийн улс төрөөс хараат бус байдал	10.5	9.35	30.9	39.94	21.7	24.56	15.8	11.92	1.1	0.72	20.0	25.28
2 Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь эдийн засаг, санхүүгээс хараат бус байдаг	8.5	8.77	29.3	31.75	21.8	22.43	13.8	11.12	1.0	0.66	25.6	25.28
3 Монголчууд санал бодлоо чөлөөтэй илэрхийлдэг	5.3	6.0	18.5	17.12	31.0	29.15	35.0	38.66	6.7	3.82	3.6	5.25

Эх үүсвэр: Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт, 2009-2010. УБ. 2010

Сүүлийн жилүүдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд улс төр, эдийн засгийн тодорхой бүлэглэл, томоохон хувийн компани, мөнгөтэй хувь хүний нөлөөнд далдуур орох хандлага хүчтэй болов.

Хүснэгт 39. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэж буй иргэдийн төсөөлөл (хувиар)

Хэвлэл мэдээллийн байгууллага	Огт итгэдэггүй	Итгэдэггүй	Дунд зэрэг	Итгэдэг	Бүрэн итгэдэг	Мэдэхгүй
1 Үндэсний радио		1.11	4.37	21.13	52.99	9.93
2 FM радио		1.71	8.74	29.42	29.56	26.69
3 Монголын YOHТелевиз		0.83	2.82	17.06	56.8	2.38
4 Хувийн телевиз		0.97	7.16	32.8	45.13	7.49
5 Орон нутгийн телевиз		1.0	5.09	23.51	35.87	27.81
6 Өдөр тутмын хэвлэл		2.41	11.92	32.52	30.56	18.75
7 Шар хэвлэл		8.88	24.36	29.26	12.64	23.17

Эх үүсвэр: Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт, 2009-2010. УБ. 2010

Энэхүү хүснэгтээс харахад иргэд YOHТелевиз, Үндэсний радиод илүү итгэдэг байдал үргэлжилсээр байна. Бусад хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд итгэх иргэдийн итгэл ихээхэн доогуур байгаа нь тэд улс төрийн болон эдийн засаг санхүүгийн нөлөөлөлд далдуур орсон байдагтай шууд холбоотой юм.

Тулгамдаж буй асуудал

- Хууль боловсруулах, батлах явцад хуулийн төслийн агуулга, нэр томъёог олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх явдал дутмаг, судалгаа шинжилгээний байгууллага, мэргэжилтнүүдийг татан оролцуулах, санал дүгнэлтийг нь тусгах явдал хангалтгүй байна.
- Яам, агентлаг, орон нутгийн захиргааны гаргаж буй шийдвэр нь хүний эрх, эрх чөлөөг хангах хууль тогтоомж, олон улсын гэрээ конвенциудтай зөрчилдөх явдал байгааг

арилгах, үүнтэй уялдуулан тогтоол шийдвэрийг гаргах, хэрэгжүүлэх явцад хяналт тавих, шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтнуудын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх явдал чухал зорилт болон тулгарч байна.

- Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын нэгдсэн орсон олон улсын гэрээнд заасан агуулга, үзэл санааг тусгасан байдаг боловч салбар хуулиуд, тухайлбал, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль бусад хуульд хангалттай тусгаагүйгээс тухайн конвенцийн заалтын хэрэгжилт хангалтгүй байна.
- Хүний эрх, эрх чөлөөг хангах чиглэлээр гарсан хууль тогтоомжийг нарийвчлан тодорхой болгох явдал шаардлагатай байна. Тухайлбал, Үндэсний цөөнхийн эрх ашгийг хамгаалах, хүнийг улс төрийн үзэл бодлоор нь ялгаварлах, гадуурхах явдалтай хийх тэмцлийг эрх зүйн тодорхой зохицуулалтаар дэмжих нь чухал байна.

- Хүний наймаа, хүчирхийллийн эсрэг болон гадаадын иргэнтэй гэр бүл болж амьдрах иргэдэд зуучлах, хүүхдийн эрх ашгийг хамгаалах, бэлгийн мөлжлөгийг таслан зогсоох явдалтай хийх тэмцлийн хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгтэй.
- Эмзэг бүлгийн иргэдийн эрхийг зохицуулсан олон улсын гэрээнд нэгдэн орсон нь сайшаалтай хэдий ч тэдгээр иргэдийн нэр төр эмзэг байдлыг нь хүндэтгэх талаар тусгайлсан хуулийн зохицуулалт байхгүйгээс конвенцийн заалтыг хэрэгжүүлэх, олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд хүндрэл учирч байна.
- Хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг арилгах, мэдээлэл олж авах эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн шударга үйл ажиллагааг хангах ажлыг хуулиар нарийн зохицуулах ажлыг хойшлуулахгүй шийдэх шаардлага байна.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- Монгол Улсын хуулийг Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэхдээ судалгаа шинжилгээний байгууллага, мэргэжилтнүүдийг татан оролцуулж, санал дүгнэлтийг нь гаргуулан тусгах ажлыг тогтмолжуулах;
- Олон улсын гэрээ конвенцийн тайланг хугацаанд нь илгээх, НҮБ-ын хороодоос ирсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх явдлыг сайжруулах;
- Олон улсын гэрээ, конвенцийг олон нийтэд сурталчлах, төв болон орон нутгийн захиргааны байгууллагын ажилтнууд, удирдлагуудын мэргэжлийн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг байнга зохион байгуулах тогтолцоог бүрдүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид манай улс нэгдэн ороод 1 жил болж байгаа хэдий ч тухайн иргэдийн хувийн халдашгүй байдалтай холбоотой эрх зүйн зохицуулалтууд үндэсний хууль тогтоомжид нийтлэг байдлаар хуульчлагдсан гэж шинжээч нар үзжээ. Энэ нь нэг талаас эдгээр иргэдийн эрхийг баталгаажуулснаараа сайн талтай ч нөгөө талаас эмзэг бүлгийн иргэд нийтлэг зохицуулалтын “гадна үлдэх” эрсдэлтэй тул холбогдох зохицуулалтуудыг нарийвчилж тусгаж өгөх;
- Боолчлол, боолын худалдаа байхгүй ч, энэ талаар тусгайлан зохицуулсан үндэсний эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
- Арьс, үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенцийн 16 дугаар зүйлд холбогдох хууль тогтоомжийг нийцүүлэх, үүнтэй уялдуулан Захиргааны хариуцлагын тухай, Боловсролын тухай, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулиудад өөрчлөлт оруулах;
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцид заасан “эрүүдэн шүүх” гэсэн тодорхойлолттой үндэсний хуулийн тогтоомжийн агуулгыг нийцүүлэн нарийвчлах;
- Хүүхдийн эрхийн тухай конвенцийн заалтуудад үндэсний хууль тогтоомжийн зохицуулалтыг нийцүүлэхтэй холбогдуулан шинэчлэн найруулж буй гэр бүлийн хуулийн төсөлд конвенцийн 16, 19 дүгээр зүйлийн зохицуулалтыг тусгах;
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хараат бус байдлыг хангах, мэдээллийн эрх чөлөөг хангах эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
- Хүн бүрийн хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхийн асуудал манай улсын хувьд анхаарал татаж байна. Ажилгүй ядуу, нэн ядуучуудын зэрэгцээгээр “хөдөлмөр эрхэлдэг” ядуучуудын тоо их, төдийлөн буурахгүй, цалин хөлс нь “хувийн болон ам бүлийнхээ ахуй амьжиргааг хүний зэрэгтэй авч явахад хүрэлцэхүйц” хэмжээнд байж чадахгүй байгаа нь Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалаар баталгаажуулсан хүний суурь эрх зөрчигдөхөд хүргэж байна. Ялангуяа, Монгол Улсын эдийн засагт нааштай өөрчлөлт гарч байгаа өнөө үед хүн бүр “хүрэлцэхүйц амьжиргаатай байх” эрхийг баталгаажуулах арга хэмжээ авах;
- 2010 оны 11 дүгээр сард НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөл Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлыг хэлэлцэж, 126 зүйл бүхий зөвлөмж

- гаргасан бөгөөд үүний мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгах;
- Хүний эрхийн Үндэсний Комисс, иргэний нийгмийн байгууллагууд зэрэг хүний эрхийн хөндлөнгийн хяналтын байгууллагуудыг бэхжүүлэх;
- Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенциудыг эх хэлнээ орчуулдаг албыг Гадаад харилцааны яамны харьяанд байгуулах;
- Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенциудыг багтаасан тусгай цуврал боть гаргах;
- Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийг шүүхийн практикт хэрэглэх явдлыг өргөжүүлэх.

ЗОРИЛТ 23. *АРДЧИЛЛЫН ҮНДСЭН ЗАРЧИМ, ХЭВ МАЯГИЙГ АМЬДРАЛД ХЭВШҮҮЛЭХ*

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монголын ардчилал өнгөрсөн 20 жилд хэр урагшилсан ямар түвшинд хүрээд байгаа болон нийгэмд хэр төлөвшиж байгаа талаар судалгааны нэлээд ажил хийгдэж зохих дүгнэлтүүдийг өгч байна.

Монголын ардчиллын өнөөгийн хүрсэн түвшинг нэгтгэн цэгнэж үзвэл, ардчилалд шилжих төвөгтэй цаг үеийг ардаа орхиж, ардчиллыг төлөвшүүлэх, бэхжилтийг хангах хариуцлагатай үедээ ороод байгааг Монгол Улсын ШУА-ын философи, социологи, эрхийн хүрээлэнгээс гаргасан “Монголын ардчиллын төлөвшил” сэдэвт судалгааны бүтээлд дурджээ.

Ардчиллын гол зарчмуудын нэг болох “Ард түмэн төрийн эрх барих” асуудал төлөөллийн ардчиллын хэлбэрээр яаж хэрэгжиж байгаа нь ардчилсан төрийн байгууламжууд, тэдгээрийн тэнцвэр яаж хангагдаж байгаагаар буюу төрийн байгууллагуудын төлөвшил, үйл ажиллагааны талаарх иргэдийн үнэлгээгээр илэрхийлэгддэг байна. Үндэсний статистикийн хорооноос эрхлэн гаргадаг Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаанд “Ардчилсан засаглал” хавсралт модулийг 2008 оноос бий болгон жил бүр 3744 иргэнээс судалгаа авч байна. Энэ модулиар төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн төсөөллийг гаргадаг. Ардчиллын үндсэн зарчим, хэв маяг амьдралд хэвшүүлэх чиглэлээр хийсэн эхний судалгаанд иргэд нийгмийн даатгал, халамжийн байгууллагуудын үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай, харин улс төрийн байгууллага, иргэдийн төлөөллийн байгууллагуудын үйл ажиллагаанд сэтгэл дундуур байна гэсэн дүн

гарч байжээ. Төрийн болон орон нутаг, зарим агентлаг, байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн төсөөллийг 2009, 2010 оны судалгаагаар авч үзжээ.


Судалгааны дүнгээр иргэдэд үйлчилдэг улс төрийн удирдлагууд, зарим байгууллагуудын үйл ажиллагааг иргэд тааруухан, дунд зэрэг гэж үнэлсэн байна. Мөн төрийн байгууллагуудад итгэх олон нийтийн итгэл сүүлийн жилүүдэд буурж болзошгүй байгаа талаар дурьдсан байна.

Ардчиллын үндсэн зарчим хэрхэн хэрэгжиж буйг харуулдаг нэг гол үзүүлэлт бол улс төрийн намуудын төлөвшил юм. “Манай намууд өнгөрсөн 20 жилийн хугацаанд улс төрийн үйл ажиллагааны зохих туршлага хуримтлуулж алдаа, оноон дээрээ суралцан төлөвшин бойжих өсөлтийнхээ нэлээд хэсгийг туулсан нь тодорхой боловч улс төрийн нам хэмээх бүхэл амьд организмын хувьд бүрэн төлөвшин цэгцэрч амжаагүй байна. Өнөөдөр Монголд дэлхийн сонгодог улс төрийн намуудтай дүйх хэмжээний намууд хараахан бүрэлдэж амжаагүй, өөрийн орны улс төрийн амьдралын өнөөгийн өвөрмөц онцлогийг тусгасан намууд байгаа юм.”³⁸ гэжээ.

Сүүлийн жилүүдэд улс төрийн намуудад итгэх иргэдийн итгэл буурах хандлагатай байна. Энэ нь намуудын явуулж буй үйл ажиллагаа иргэдийн сэтгэлд хүрэхгүй, улс орноо хөгжүүлэх, аюулгүй байдлыг хангах, байгаль орчноо хамгаалах, ядуурлыг бууруулах талаар намуудаас төр засгийн шийдвэрт тусган хэрэгжүүлж буй ажлын үр дүнг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.

38 ШУА. ФСЭӨ. *Miiāi ēūi adā+ēēēūi d'ē'āōēē . Cōāāēāāiū āzōyū ē. УБ., 2011. 95-д өгөжээ*

Дүрслэл 36. Намд хандах иргэдийн итгэл ³⁹



“Намд хандах иргэдийн итгэл” судалгаа нь 2008 оноос хойш хийгдээгүй байгаад харин улс төрийн намын рейтингийн судалгаагаар намуудын нэр хүнд ихээхэн унаж буй дүр төрх харагдаж байна.

Дэлхийн олон орны хөгжлийн туршлагаас харахад иргэний нийгмийн үүрэг оролцоо нь ардчиллын нэг гол зарчим болдог байна. Иргэний нийгмийн талаар янз бүрийн судалгаа мэдээлэл байгаа боловч тэдгээрийн тоо баримт нилээд зөрөөтэй учир мэргэжлийн байгууллага болох Монгол Улсын ШУА-ын Философи, социологи, эрхийн хүрээлэнгээс хийсэн “Монголын ардчиллын төлөвшил” судалгааны бүтээлээс голлон авч энд орууллаа. Төр нь нийгмийн эрх ашгийг хамгаалдаг бол хувь хүний эрх ашгийг иргэний нийгэм хамгаалдаг бөгөөд энэ хоёр зөв зохицолдон хөгжсөнөөр ардчиллыг төлөвшүүлэхэд голлох үүрэгтэй. Иргэний нийгмийг хөгжүүлэх орчныг төр бий болгож өгдөг байна. Үүний дагуу төрийн бус байгууллагын (иргэний нийгмийн байгууллага гэсэн үг) Засгийн газартай хамтарч ажиллах журмыг батлан мөрдөж байгаа бөгөөд 2010 оны байдлаар 8329 ТББ ажиллаж байна. ТББ-ын 80 гаруй хувь нь нийслэл хотод байгаа бөгөөд үйл ажиллагааныхаа 90 гаруй хувийг гадаадын олон улсын байгууллагаас дэмжлэг авч санхүүжүүлж байна. Монгол Улсын Засгийн газраас ТББ-ыг санхүүгийн хувьд дэмжих явдал хөрөнгө санхүүгийн эх үүсвэрээс хамааран хязгаарлагдмал, цөөн байгууллагыг гэрээний дагуу санхүүжүүлж байна. Харин судалгааны ажлуудыг ТББ-аар гүйцэтгүүлэхэд зохих хэмжээний санхүүжилтийг олгодог. Сүүлийн жилүүдэд төрийн зарим чиг үүргийг ТББ-аар гүйцэтгүүлэх ажилд зарим ахиц гарч байна.

39 ШУА. ФСЭД. Мийтэй өүт адд+өөнэй д’өг’өө . Сöäääääи äç’öýý. УБ., 2011. 95-д ò äè

Хүснэгт 40. ТББ хэрхэн ажилладаг талаарх үнэлэмж, ⁴⁰ хувиар

	2005	2008	2010
1 Маш сайн ажилладаг	3.3	2.4	2.2
2 Сайн ажилладаг	7.9	8.2	9.5
3 Дунд зэрэг ажилладаг	35.2	33.8	34.6
4 Бага ажилладаг	17.6	25.2	21.1
5 Огт ажилладаггүй	11.3	0.0	9.9
6 Хариулж мэдэхгүй	23.0	30.4	22.8
7 Хариулаагүй	1.7	0.0	0.0
Нийт	100.0	100.0	100.0

Иргэдийн оролцооны хэлбэрүүдийг Монгол Улсын Үндсэн Хуульд үндсэнд нь тусгасан боловч хуулийн энэ заалтыг хэрэгжүүлэх механизмыг нарийвчлан заасан хууль тогтоомж эрх зүйн зохицуулалт дутагдаж байна. Доорхи хүснэгтээр ТББ-ын талаархи иргэдийн үнэлэлтийг үзэж болно.

Хүснэгт 40-өөс харахад, иргэний нийгмийн байгууллагуудын төлөвшил төгс сайнгүй байна. Ихэнхи ТББ нь хүн амын төвлөрөлөө дагаж нийслэл хотод байгаа, нүүдлийн соёл иргэншлийн өвөрмөц байдалд нийцэж бүтэц зохион байгуулалт нь төгөлдөржөөгүй, санхүүгийн хувьд хүндрэлтэй байгаа нь эндээс харагдаж байна. ТББ-ууд үндсэн чиг үүргээ хэр зэрэг биелүүлж байгааг иргэдээр үнэлүүлэхэд иргэдийн дуу хоолой болж ажиллах, үүргээ боломжийн биелүүлж буй байдал харагдаж байна.

Хүснэгт 41. ТББ-ууд үндсэн чиг үүргээ биелүүлж чаддаг гэж үзсэн оролцогчдын хариулт, ⁴¹ хувиар

Үзүүлэлт	Тийм		
	2005	2008	2010
1 Иргэдийн дуу хоолой болдог	25.0	28.3	34.1
2 Төр засгийн шийдвэрт нөлөөлдөг	17.1	22.6	25.2
3 Нутгийн удирдлагын шийдвэрт нөлөөлдөг	17.7	13.5	21.6
4 Нийгмийн эрх ашгийг хамгаалдаг	19.9	24.7	26.3
5 Гишүүдийн эрх ашгийг хамгаалдаг	31.4	22.7	26.2
6 Гадаадын тусламжаас мөнгө хүртэх арга	28.0	13.7	24.7

40 М03-9 ò’н’е . НУБ00 Адд+өөнэй занаааеүй д’өг’а ääéääèä ääðñи ò’è’èð - 2009/2010. УБ., 2010. 105-д ò äè

41 М03-9 ò’н’е . НУБ00 Адд+өөнэй занаааеүй д’өг’а ääéääèä ääðñи ò’è’èð - 2009/2010. УБ., 2010. 106 -д ò äè

Иргэд, байгууллагын улс төрийн соёл бол ардчиллын гол зарчмууд хэрхэн хэрэгжиж буйг харуулах нэг үзүүлэлт болдог. Улс төрийн соёлын төлөвшил хэр байгаа, түүнийг иргэд хэрхэн хэвшүүлж буй талаар хийгдсэн судалгаа сүүлийн жилүүдэд бага байна. Энэ асуудлыг хөндөж ярих нь иргэд, улс төрийн намуудын түвшинд төдий л хангалттай бус байна. Улс төрийн соёлд төр, улс төрийн нам гол үүрэгтэй бөгөөд мэдээж хэрэг соёл гэдэг нь хувь хүнтэй холбоотой. Иймээс төрийн өндөр албан тушаалтнуудын ёс зүй, улс төрийн соёл, улс төрийн намуудын төлөвшил нь улс төрийн соёлыг илүү тодорхой харуулдаг.

УИХ-ын гишүүний ёс зүйн дүрмийг 2009 оны 4 дүгээр сард хэлэлцэж баталсан бөгөөд уг дүрмэнд “Монгол Улсын Их Хурлын гишүүний төрийн албанд баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлж, төрийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулах нөхцөлийг бүрдүүлэх, хувийн ашиг сонирхолын нөлөөллөөс хамгаалах, төр олон нийтийн итгэлцлийг бэхжүүлэхэд энэ дүрмийн зорилго оршино” гэж заасан байна. УИХ-ын гишүүний ёс зүйн дүрэм нь Монголын төрийн хөгжилд парламентын доторх улс төрийн эрүүл соёл, зөв хандлагыг тогтооход эерэг нөлөө үзүүлэх зорилготой юм. Эндээс мөн бусад төрийн байгууллага, иргэд үлгэр жишээ авах сайн талтай.

Монгол дахь улс төрийн соёлын төлөвшлийн талаар судалгааны бүтээлүүдэд төлөвшлийн үйл явц удаан бөгөөд төвөг бэрхшээлтэй замыг туулж байна, зарим талаар олсон амжилтаасаа ухрах үзэгдэл ажиглагдаж байна зэргээр дүгнэжээ.

Иргэдийн улс төрийн соёл, ёс зүй нь нийгмийн хөгжлийн түвшин, нийгмийн харилцааны онцлогоос хамаардаг байна. Монгол Улсын хувьд улс төр, ардчиллын нийтлэг үнэлэмж сулавтар, иргэн бүрийн ахуй амьдралд хүрсэн эдийн засгийн хөгжлийн нэгдсэн бодлого дутмаг байгаа нь иргэдийн улс төрийн соёлын төлөвшилд сөргөөр нөлөөлж байна.

Тулгамдаж буй асуудал

- Монголын ардчилал, засаглалын төлөв байдал 2010 оны судалгаагаар 3.01 оноо авсан байгааг анхаарах;
- Хөгжлийн томоохон төслүүдийн ажил эхэлж, тэдгээрийг хэрэгжүүлэхдээ улс орон, тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангах асуудалд

онцгой анхаарах шаардлага тулгарч байна.

- Төрийн мэргэшсэн албан хаагчийг бэлтгэх, төрийн албаны шинэчлэлийн талаар нэгдсэн бодлогогүй байна.
- Төр засаг, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, ТББ-уудын үйл ажиллагааг идэвхижүүлэх механизмын хууль эрх зүйн зохицуулалт бий болгох шаардлагатай байна.
- Нийгэмд улс төрийн болон иргэний соёлыг дээшлүүлэхэд чиглэсэн эрх зүйн болон боловсрол, гэгээрлийн бодит үйл ажиллагааг идэвхитэй явуулах биеэ даасан бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх нь чухал байна.
- Нутгийн удирдлагын байгууллагуудын чадавхи сул, хөрөнгө санхүүгийн бодит эрх мэдэл хангалтгүй, төвлөрлийг сааруулах, орон нутагт эрх мэдэл шилжүүлэх ажил удаашралтай байна.

Цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ

- Төр засгийн байгууллагууд үйл ажиллагааны тэнцвэртэй байдлыг хуулийн хүрээнд сайжруулах шаардлагатай зарим хуульд цаг алдалгүй нэмэлт өөрчлөлт оруулах, ялангуяа, улс төрийн намуудын төлөвшилтэй уялдуулан улс төрийн намын тухай хууль болон сонгуультай холбоотой эрх зүйн зохицуулалтыг сайжруулах;
- Хууль тогтоох болон захиргааны шийдвэр гаргах үйл явцад иргэний нийгэм, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, энэ зорилгоор иргэний нийгмийн байгууллагуудыг чадваржуулах;
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл иргэдийн мэдээлэл олж авах эрх чөлөөг хангах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг сайжруулах;
- Төр, иргэний нийгмийн түншлэл, төрийн зарим үүргийг иргэний нийгмийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх болон тэдний оролцоог хангах механизмыг нарийвчлан заасан хууль гаргах;
- Төрийн албаны шинэчлэлийг түргэтгэх;
- Төвлөрлийг сааруулж, орон нутгийн төр захиргааны байгууллагын чадавхийг сайжруулах арга хэмжээ авах.

ЗОРИЛТ 24: АВЛИГЫГ ҮЛ ТЭВЧИХ УУР АМЬСГАЛЫГ НИЙГМИЙН БҮХ ХҮРЭЭНД БИЙ БОЛГОН ХЭВШҮҮЛЭХ

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Авлига бол Монгол орны хөгжилд саад тотгор учруулж ардчиллын үнэт зүйлс өөрчлөлт шинэчлэлийн үйл явцад чөдөр, тушаа болж байгаа үзэгдэл юм. Олон жилийн туршид хийсэн судалгаагаар Монгол Улсад авлига тодорхой хэмжээнд байгаа гэжээ.

Монгол дахь авлигын төлөв байдлыг үнэлэх судалгаа сүүлийн жилүүдэд тогтмолжиж, тайлан мэдээлэл нь сайн гардаг болсон гэж үзэж болно. 2008 оноос Үндэсний статистикийн хорооны ӨНЭЗС-нд төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын хүрээнд дэх авлигын талаар иргэдийн төсөөллийг “Ардчилсан засаглал” судалгааны нэг хэсэг болгон явуулж ирлээ.

Авлигатай тэмцэх газар хуулийн дагуу Авлигын индексийг гаргаж байна. Энэ хоёр суурь судалгаа мэдээлэл болон бусад холбогдох сурвалж хэрэглэгдэхүүнийг энэхүү илтгэлд ашиглав. Монгол Улсын Авлигын эсрэг хуульд үндэсний хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг хэрхэн авч хэрэгжүүлэхийг хуульчилсан юм.

Авлигын гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахад хүндрэл учруулж байсан Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.


Монгол Улсын авлигын эсрэг хуульд заасны дагуу авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг үндэсний хэмжээнд нэг бодлогоор хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Ерөнхий сайдын 2008 оны 9, 2009 оны 14 дүгээр захирамжаар АТГ-тай хамтарсан ажлын хэсэг байгуулан “Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлж байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй аргын нэг нь Төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэж, зөрчил гаргасан хүмүүст

хуульд заасан хариуцлагыг тооцох явдал мөн.

Хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбоотой мэдээллийн сан бүрдэж, ХОМ-ийг худал мэдүүлсэн, хугацаа хожимдуулсан зэрэг зөрчлийг зохих журмын дагуу шийдэж хариуцлага тооцож байна.

Дүрслэл 37. Хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдэлт



Эх үүсвэр: Авлигатай тэмцэх газар

Авлигатай тэмцэх газар 2009 онд 28 шүүгдэгчид холбогдох 17 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэнээс 11 хэргийн 15 шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон шийтгэж, 4 хэргийн 9 шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож 2009 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн Өршөөл үзүүлэх тухай хуулиар ялаас өршөөн хэлтрүүлж, 1 хэргийн 2 шүүгдэгчийн үйлдлийг хэрэгсэхгүй болгож, 1 хэргийн 2 шүүгдэгчийг үйлдлийг цагаатгасан байна.

2010 онд Мөрдөн шалгах хэлтсээс мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан хэргээс 39 шүүгдэгчид холбогдох 16 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэнээс 36 шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон шийтгэж, 12 шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож 2009 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн Өршөөл үзүүлэх тухай хуулиар ялаас өршөөн хэлтрүүлж, 16 шүүгдэгчийг хорих ялаар, 7 шүүгдэгчийг торгох ялаар, 1 шүүгдэгчийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн байна.


Монгол Улсын Авлигын индекс

Монгол Улсын Их хурлын 2008 оны 13 дугаар тогтоол, Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйл 18.1.3-т заасны дагуу Авлигатай тэмцэх газар Авлигын индексийн 2009 оны судалгааг явуулж, индексийг тооцон гаргаж, олон нийтэд мэдээлсэн.⁴²

Авлигын индексийг үндэсний түвшинд тооцоход 0.64 гарсан байна.⁴³ Өөрөөр хэлбэл, Монгол Улсын төрийн захиргаа, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, тэдгээрийн салбар, нэгжүүдийн үйл ажиллагааны авлигад өртөх эрсдэл байна. Авлигын индексийн бүрдүүлэгч үзүүлэлтүүд болох авлигын цар хүрээний үзүүлэлт 0.74, авлигын хэлбэрийн үзүүлэлт 0.54 гарсан байна.

Авлигын цар хүрээний үзүүлэлтүүдийг нэг бүрчлэн авч үзвэл, авлигын цар хүрээний талаарх олон нийтийн төсөөлөл, шинжээчдийн үнэлгээний үзүүлэлт 0.75 гарч байна.

Дүрслэл 38. Авлигын индекс, түүнийг бүрдүүлэгч үзүүлэлтүүдийн утга



Эх үүсвэр: АТГ. Монгол Улсын авлигын индексийн 2009 оны тооцооны үр дүнгийн тайлан.

42 *Miiāi ē Yēñūi Aāēēāūi ēiā eēñ iū āāēēāā ōyūyū ō āyūō yāāēūi çāō ōçōyū, ōyēāyūō, ōāēōāāāiūā ōi āiō diēē i ō ōñi āi ēñi +āiāōūi ççççēyēōççāēēi iēēē āyūō çāçç ā°ā°ā ōā ççyāāēēēi iōñi çāēi āi ēñi çāā ōōāçāāiūi °ō +ē°ēōēēā ēēōāyūi ōāōōēēāā Aāēēāūi ēiā eēñ iū 0-1 ōçōyū ēō ōōāiū āāāō ā°ā°ā ēiā eēñēēi ōōāā 1-ā iēō ōi ō ō òñāi āāēēāā āāāāñ- āāēiā āyē ççyū.*

43 *"Miiāi ē Yēñūi Aāēēāūi ēiā eēñēēi 2009 iū ōñi çñiū çō āçiāēēi ō āēēāi "* Aāēēāāō āē ōyū i çyō āçāāō, 2010 ii .

Хүснэгт 42. Авлигын цар хүрээний үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	Утга
Авлигын цар хүрээний талаархи олон нийт, шинжээчдийн төсөөллийн үзүүлэлт	0.75
Авлигын эдийн засгийн үр дагаврын үзүүлэлт	0.03
Авлигын хувь хэмжээ, шинжээчдийн төсөөллөөр	0.10
Олон нийтийн төрийн албан хаагчдад өгсөн хээл хахуулийн дундаж хувь хэмжээ	0.15
Авлигын цар хүрээний нэгдсэн үзүүлэлт	0.74

Эх үүсвэр: АТГ. Монгол Улсын авлигын индексийн 2009 оны тооцооны үр дүнгийн тайлан.

Авлигын эдийн засгийн үр дагаврын үзүүлэлт 0.03 гарч байгаа бөгөөд улсын нэгдсэн төсвийн жилийн зарлагын 2.7 хувьтай тэнцэх хэмжээний хохирол авлигын гэмт хэргийн улмаас учирч байна. Түүнчлэн шинжээчдийн үнэлгээгээр авлигын хувь хэмжээ 0.1 гарч байна.

Авлигын хэлбэрийн үзүүлэлт 0.54 байгаа бөгөөд тэдгээрийг бүрдүүлэгч үзүүлэлтүүдийн хувьд давхар объекттой авлигын гэмт хэргийн эзлэх хувь 0.31, хоёр болон түүнээс дээш давталттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь 0.30, зохион байгуулалттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь 0.42, авлигын гэмт хэргийн ангиллын үзүүлэлт 0.37, авлигын гэмт хэргийн шунахай сэдэлтийн үзүүлэлт 0.91 байна.

Хүснэгт 43. Авлигын хэлбэрийн үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	Утга
Давхар объекттой авлигын гэмт хэргийн эзлэх хувь	0.31
Хоёр болон түүнээс дээш давталттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь	0.30
Зохион байгуулалттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь	0.42
Авлигын гэмт хэргийн ангиллын үзүүлэлт	0.37
Авлигын гэмт хэргийн шунахай сэдэлтийн үзүүлэлт	0.91
Авлигын хэлбэрийн нэгдсэн үзүүлэлт	0.54

Эх үүсвэр: АТГ. Монгол Улсын авлигын индексийн 2009 оны тооцооны үр дүнгийн тайлан.

Монгол Улсын Авлигын индексийг үндэсний түвшинд тооцсоны зэрэгцээ салбараар болон аймаг, нийслэлээр тооцон гаргасан нь салбар болон аймаг, нийслэлийн авлигад өртөх эрсдлийн харьцуулсан үнэлэлт дүгнэлт хийх боломжийг олгож байгаа юм.

Авлигын индексийг аймаг, нийслэлээр тооцож үзэхэд 0.47-0.71 хооронд гарч байна.

Хүснэгт 44. Авлигын индекс, аймаг нийслэлээр


ДД	Аймаг, нийслэл	Авлигын индекс
1	Төв	0.71
2	Говьсүмбэр	0.67
3	Дундговь	0.66
4	Дорноговь	0.66
5	Булган	0.66
6	Завхан	0.64
7	Сэлэнгэ	0.64
8	Улаанбаатар	0.60
9	Өвөрхангай	0.60
10	Дархан-Уул	0.60
11	Дорнод	0.59
12	Говь-Алтай	0.59
13	Сүхбаатар	0.58
14	Баянхонгор	0.58
15	Хэнтий	0.56
16	Хөвсгөл	0.55
17	Өмнөговь	0.55
18	Баян-Өлгий	0.54
19	Увс	0.54
20	Орхон	0.49
21	Ховд	0.49
22	Архангай	0.47

Эх үүсвэр: АТГ. Монгол Улсын авлигын индексийн 2009 оны тооцооны үр дүнгийн тайлан.

Авлигын индексийн утга бага гарсан буюу судалгаагаар авлигад өртөх эрсдэлтэй гэж тодорхойлогдсон зарим салбар, байгууллага, аймгуудын авлигын индексийн судалгааны үр дүнд нарийвчилсан шинжилгээ хийж, авлигын эрсдлийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авах чиглэл өгсөн байна.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлига

Дүрслэл 39. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн үзүүлэлт



Эх үүсвэр: АТГ. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчдийн үнэлгээ, судалгааны тайлан

Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх үзүүлэлт 4.13, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи үзүүлэлт 3.98 байна.


Улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлигын талаарх үнэлгээнд дараахь хүчин зүйл нөлөөлсөн байна:

- Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааны давхардал, чирэгдэл, үр өгөөжгүй болон хяналтгүй байдал, албан хаагчийн ёс зүй, хариуцлага тооцох механизмын дутагдалтай байдал, шийдвэр гаргах ажиллагааны дүрэм журмын иж бүрэн хуульчлагдаагүй байдал, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил зэрэг авлигыг үүсгэгч хүчин зүйлсийг дурдсан байна.

Судалгаанд оролцсон шинжээчдийн үнэлгээгээр 2010 оны байдлаар улс төрийн хүрээн дэх тархацын үнэлгээ 4.50 буюу “ихээхэн түгээмэл” гарсан боловч 2009 оныхоос 0.04 нэгжээр буурсан байна.


Улс төрийн институцуудын авлигад өртөмтгий байдлын 2010 оны дундаж үнэлгээ 3.87 байна.

Дүрслэл 40. Төрийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтнуудын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ



Эх үүсвэр: АТГ. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн судалгаа.

Дүрслэл 41. Хууль хяналтын байгууллагын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ (салбараар)



Эх үүсвэр: АТГ. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн судалгаа.

Шүүхийн хувьд хяналтын (авлигад өртөх эрсдлийн үнэлгээ 3.75), давж заалдах шат (3.67), прокурорын байгууллагын хувьд аймаг, нийслэлийн прокурор (3.92), сум (сум дундын), дүүргийн прокурорын (3.75) байгууллага авлигад өртөх эрсдэлтэй байна.

Харин цагдаагийн байгууллагын хувьд замын цагдаа (3.83), мөрдөн байцаагч (3.75), шүүхийн шийдвэр байгууллагын хувьд аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба (3.70) байгаа нь авлигад өртөх эрсдэлтэй байна.

Хүснэгт 45. Хууль хяналтын байгууллага дахь авлигад өртөх эрсдлийн үнэлгээ, байгууллагын түвшин шатлалаар

Түвшин	2009	2010	Өсөлт, бууралт (2010-2009)
Анхан шатны шүүх	3.64	3.58	-0.06
Хяналтын шатны шүүх	3.45	3.75	0.30
Давж заалдах шатны шүүх	3.44	3.67	0.23
Дээд шүүх	3.44	2.85	-0.59
Шүүхийн байгууллагын дундаж үнэлгээ	3.49	3.46	-0.03
Сум /сум дундын/, дүүргийн прокурор	3.18	3.75	0.57
Аймаг, нийслэлийн прокурор	3.27	3.92	0.65
Улсын Ерөнхий прокурорын газар	2.91	3.58	0.67
Прокурорын байгууллагын дундаж үнэлгээ	3.12	3.75	0.63
Мөрдөн байцаагч	3.82	3.75	-0.07
Хэрэг бүртгэгч	3.55	3.50	-0.05
Эрүүгийн цагдаа	3.82	3.50	-0.32
Хэв журмын цагдаа	2.91	3.45	0.54
Замын цагдаа	3.82	3.83	0.01
Цагдаагийн ерөнхий газар	3.09	2.82	-0.27
Цагдаагийн байгууллагын дундаж үнэлгээ	3.50	3.48	-0.03
Аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	3.45	3.70	0.25
Хорих ял эдлүүлэх алба	3.36	3.20	-0.16
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	2.82	3.00	0.18
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дундаж үнэлгээ	3.21	3.30	0.09

Эх үүсвэр: АТГ. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн судалгаа.

Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааны давхардал, чирэгдэл, үр өгөөжгүй, хяналтгүй байдал, албан хаагчийн цалин хангамж, ажиллах нөхцөлийн хангалтгүй байдал, албан хаагчийн ёс

зүй, хариуцлага тооцох механизмийн дутагдалтай байдал зэрэг хүчин зүйлсийн энэ хүрээн дэх авлига үүсэхэд нөлөөллийн үнэлгээ өндөр байна. Эдгээр хүчин зүйлс нөлөөлж байна гэсэн үнэлгээ 4.00 байна.

Хүснэгт 46. Хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн нөлөөллийн үнэлгээ

Хүчин зүйлс / нөлөөлөл	2008	2009	2010	Өсөлт, бууралт (2010-2009)
Хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	-	3.64	3.75	0.11
Хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах ажиллагааны журмын иж бүрэн хуульчлагдаагүй байдал	-	3.42	3.64	0.22
Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааны давхардал, чирэгдэл, үр өгөөжгүй, хяналтгүй байдал	-	3.67	4.00	0.33
Хууль хяналтын байгууллагын албан хаагчийн цалин хангамж, ажиллах нөхцөл хангалтгүй	3.64	4.00	4.00	0.00
Хууль хяналтын байгууллагын албан хаагчийн ёс зүй, хариуцлага тооцох механизм дутагдалтай	4.20	3.73	4.00	0.27
Дундаж үнэлгээ	3.92	3.69	3.88	0.19

Эх үүсвэр: АТГ. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн судалгаа.

Төрийн захиргаа болон үйлчилгээний байгууллагын хүрээн дэх авлигын талаарх иргэдийн төсөөлөл

Судалгаанд оролцсон иргэдээс сүүлийн 12 сард тухайн төрлийн үйлчилгээг авсан эсэх, авсан тохиолдолд авлигын асуудлыг анзаарсан эсэхийг

тодруулсан болно.⁴⁴ Судалгаанд оролцсон иргэдийн дунджаар 15.7 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд доор дурдсан 22 төрлийн үйлчилгээг авсан бөгөөд үйлчилгээг авах үедээ дунджаар тэдний 3.0 хувь нь авлига байгааг анзаарсан байна.

Хүснэгт 47. Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын хүрээнд авлига байгаа эсэх талаарх иргэдийн төсөөлөл

д/д	Үйлчилгээ	Хариулт, хувь		Авлига ажигласан / ажиглаагүйн тооны харьцаа ⁴⁵
		Сүүлийн 12 сард үйлчилгээ авсан иргэдийн хувь	Үйлчилгээ авах үед авлигын асуудлыг анзаарсан иргэдийн хувь	
1	Ажилд оруулах /өөрөө болон бусдыг төрийн албанд/	17.4	6.9	0.2
2	Хүүхэд сургуульд оруулах	24.2	4.6	0.3
3	Курс болон мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах	12.1	2.0	0.1
4	Сургалтын дүн тавиулах	10.1	3.4	0.1
5	Тээврийн хэрэгсэлтэй холбоотой асуудлуудыг шийдэх (Автын үзлэг, оношлогоо гэх мэт)	22.0	4.9	0.3
6	Эмнэлгийн үйлчилгээ авах	57.3	10.2	1.3
7	Баг, хорооны Засаг даргын тодорхойлолт авах	50.6	2.9	1.0
8	Цэргийн албанаас чөлөөлөгдөх	8.5	2.5	0.1
9	Нийгмийн халамж, тусламж, үйлчилгээ авах	34.1	3.9	0.5
10	Төсөл, зээл, тусламжид хамрагдах	13.2	3.0	0.2
11	Банкнаас зээл авах	30.4	3.1	0.4
12	Газрын зөвшөөрөл авах	16.7	4.9	0.2
13	Гаалийн татвараас хөнгөлөх, чөлөөлөх	2.6	1.2	0.0
14	Татвараас хөнгөлөх, чөлөөлөх/гаалийн татвараас бусад/	2.9	0.9	0.0
15	Шүүхээр хэрэг шийдвэрлүүлэх	4.2	1.8	0.0
16	Хилээр их хэмжээний бараа оруулах, гаргах	2.7	1.2	0.0
17	Паспорт авах /дотоод, гадаад/	16.4	1.8	0.2
18	Виз авах	4.4	1.1	0.0
19	Хэргийг аль нэг шатанд хэрэгсэхгүй болгох	2.6	1.3	0.0
20	Тусгай зөвшөөрөл лиценз авах	3.3	1.2	0.0
21	Тендерийн шалгаруулалтад нөлөөлөх	2.2	0.9	0.0
22	Үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ хийлгэх	8.0	1.8	0.1
	Дундаж үзүүлэлт	15.7	3.0	0.2

Эх үүсвэр: YCX. ӨНЭЭС-ны хавсралт модуль 'Ардчилсан засаглал' судалгаа, 2009 он.

44 YCÖ. ӨНЭЭС-ий даалгавард ий авей, Ада-еёнай занаварейи 2009 ийи ноааеаа

45 Ааеаааааеа ёаай /ааеа ёаааааеа оийи дадйицааиу цзззёёө 0-2 ийиуу йдүйа йдөё

Судалгааны дүнгээс үзэхэд гаалийн болон бусад татвараас хөнгөлөх, чөлөөлөх, шүүхээр хэрэг шийдвэрлүүлэх, хилээр их хэмжээний бараа оруулах гаргах, гадаад улсад зорчих виз авах, хэргийг аль нэг шатанд хэрэгсэхгүй болгох, тусгай зөвшөөрөл лиценз авах, тендерийн шалгаруулалтад нөлөөлөх зэрэг үйл ажиллагааны хувьд авлига харьцангуй бага ажиглагдсан байна.

Харин эмнэлгийн үйлчилгээ авах (10.2), ажилд оруулах (өөрөө болон бусдыг төрийн албанд) (6.9) зэрэг үйлчилгээ авах үед авлига байгааг анзаарсан иргэд харьцангуй олон байна. Тухайлбал, судалгаанд оролцогчдын 57.3 хувь нь эмнэлгийн үйлчилгээнд хамрагдсан бөгөөд тэдгээрийн 10.2 хувь нь эмнэлгийн үйлчилгээ авахад авлига нөлөөлсөн гэж үзжээ.

“Монгол улсад авлигыг хянах үнэлгээ буурч, Авлигатай тэмцэх газарт итгэх олон нийтийн итгэл буурахад Монгол Улсын авлигатай тэмцэх газарт харьяалуулсан авлигын гэмт хэргийн бүртгэлд хэрэг бүртгэх, мөрдөн байцаалт явуулах явцад эрх зүйн орчны зарим хүндрэл бэрхшээл нөлөөлж байна гэж үзэж болно.

Тухайлбал,

1. НҮБ-ын авлигын эсрэг конвенцид Үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэн өөрчлөх ажил удааширалтай байна.
2. АТГ авлигын бүх гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулдаггүй.
3. АТГ-ын харьяаллын гэмт хэрэг нь хэлбэрийн бус материаллаг бүрэлдэхүүнтэй байдаг. Өөрөөр хэлбэл 5400001 болон түүнээс дээш төгрөгийн хохирол учирсан тохиолдолд л эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болдог. Харин материаллаг бус хохирол учирсан (хууль тогтоомж зөрчиж бусдад давуу байдал олгосон) болон хохирлын хэмжээ хүрээгүй тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэслэлгүй.
4. Хээл хахууль авах гэмт хэргийн зүйлчлэлийн хувьд албан тушаалтан өөрт албан үүргийн хувьд олгогдсон үйлдлийг хийсний төлөө бусдаас мөнгө, эд хөрөнгө авсан тохиолдолд

эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй.

5. Албан тушаалтан албан үүргээ хэрэгжүүлэх явцдаа хээл хахууль өгөхийг шаардсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар хуульчлаагүй.
6. Өршөөл үзүүлэх тухай хуульд хамрагдан шүүхийн өмнөх шатанд буюу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хэрэгсэхгүй болгож буй эрүүгийн хэргийн сэжигтэн, яллагдагчийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай гэж тооцох хуулийн үндэслэлгүй учраас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, цаашид төрийн албанд ажиллахыг хориглох хууль үйлчлэх боломжгүй байсан зэргийг дурдаж болох юм.⁴⁶

Авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ

Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх чиглэлээр 2009-2010 онд дараахь гол гол үйл ажиллагааг авч хэрэгжүүлсэн байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр

1. Авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд нэгдсэн бодлогоор зохицуулах зорилгоор Засгийн газрын байгууллагын түвшин /аймаг нийслэлийн ЗДТГ, яам, агентлаг, төрийн өмчит компани/-д “Авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, үнэлж дүгнэх” цогц арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд нийт 74 төрийн байгууллага авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөтэй болсон.
2. Орон нутаг дахь Төрийн бус байгууллагуудын авлигатай тэмцэх чадавхийг дээшлүүлэх, үйл ажиллагааг идэвхжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Орон нутагт төрийн бус байгууллагын сүлжээний чадавхи сайжирч байна.

46 МДЗ-9 0-н-е . НҮБДӨ Адв-еенai зайаааеii 0-е"а ааеааеа аадии 00д +-е"еò 2009-2010. УБ., 2010, 81-82-ò 0 àë

3. Бизнесийн харилцаанд тулгарч буй стандартуудтай холбоотой саад бэрхшээлийг арилгах чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудыг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийг Засгийн газар болон холбогдох бусад байгууллагуудад хүргүүлжээ. Зөвлөмжийн мөрөөр Стандартчилал, хэмжил зүйн газрын техникийн 43 хороонд мэргэжлийн холбоодыг тухайн салбарын хувийн хэвшлийн төлөөллийг оролцуулан шинэчилж, нийт 173 стандартыг хүчингүй болгох, сорьцийн дээж авах ажиллагаа 50 ширхэг бүтээгдэхүүн тутамд байсныг 100 ширхэг бүтээгдэхүүн тутамд авахаар өөрчилсөн болно. Ийнхүү төрийн тодорхой чиг үүргийг ТББ, хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэхэд ахиц гарсан.
4. Авлигатай тэмцэх газар олон нийтийг авлигын эсрэг соён гэгээрүүлэх чиглэлээр 2009-2010 онд 11367 төрийн албан хаагч, иргэдэд сургалт зохион байгуулжээ. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзэл болон төрийн албаны ёс зүйг төлөвшүүлэх, шударга ёс, амьдралын зөв хэв маягийг хэвшүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд энэ сургалт зохих хувь нэмэр болсон гэж үзэж байна.
5. Жил бүрийн 12 дугаар сарын 9-ний өдөр буюу Авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан “Шударга ёсны төлөө” арга хэмжээг зохион байгуулж ирсэн бөгөөд шударга ёсны сэдэвтэй гар зураг, зохион бичлэг, илтгэл, нийтлэлийн уралдаан зарлах, шударга ёсны төлөө буухиа хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг олон нийтийг хамарсан арга хэмжээг тогтмол зохион байгуулж хэвшээд байна. Өсвөр үе, хүүхэд, залуучуудыг авлигын эсрэг соён гэгээрүүлэх чиглэлээр сургагч багш бэлтгэх, хичээлийн хөтөлбөр, гарын авлага бэлтгэх арга хэмжээг хэрэгжүүлсэн. Шударга зан үйлийг төлөвшүүлэх, авлигыг үл тэвчих үзэл бодлыг хүүхдүүдэд төлөвшүүлэх үйл ажиллагааны эхлэл тавигдсан.
6. Өсвөр үе, хүүхэд, залуучуудыг авлигын эсрэг соён гэгээрүүлэх чиглэлээр сургагч багш бэлтгэх, хичээлийн хөтөлбөр, гарын авлага бэлтгэх арга хэмжээг хэрэгжүүлсэн. Шударга

зан үйлийг төлөвшүүлэх, авлигыг үл тэвчих үзэл бодлыг хүүхдүүдэд төлөвшүүлэх үйл ажиллагааны эхлэл тавигдсан.

7. 2009-2010 оны хугацаанд авлига, албан тушаалын гэмт хэрэг, гомдол, мэдээллийг шалгах явцад гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар бичсэн мөрдөн байцаагчийн 67 мэдэгдлийн мөрөөр ажиллаж, холбогдох зөрчлийг арилгуулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлт, хяналт шалгалтын чиглэлээр

1. “Тайлангийн хугацаанд хөрөнгө, орлогоо цаг хугацаанд нь, үнэн зөв мэдүүлэх талаарх сургалтыг хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагч 5237 албан хаагчдыг хамруулан зохион байгуулав. Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт шалгалтаар 3009 албан тушаалтны мэдүүлгийг шалгаж, хөрөнгө, орлогоо худал мэдүүлсэн 58 албан тушаалтанд хариуцлага тооцсон. 2009-2010 онуудад хөрөнгө, орлогоо мэдүүлэх үүрэгтэй нийт албан тушаалтнуудын 99.8 хувь нь хөрөнгө, орлогоо хугацаанд нь мэдүүлсэн байна. Монгол Улсын Авлигын эсрэг хуульд заасны дагуу албан тушаалтнууд хөрөнгө, орлогоо хуулийн хугацаанд бүрэн гаргаж хэвшиж байна.
2. Хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягыг шинэчлэх, улмаар хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажилд мэдээллийн технологийн дэвшлийг ашиглах ажлыг 2009 оноос санаачлан хэрэгжүүлж эхэлжээ. Хөрөнгө, орлогын мэдүүлэгийн шинэ маягтын загварыг боловсруулан Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцүүлж, УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхээр болов. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг оруулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх портал сайт, програм хангамжийг бий болгох ажлыг Дэлхийн банкны Засаглалыг дэмжих төслийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байна.

Авлигатай тэмцэх, авлигын гэмт хэрэг, зөрчлийг хянан шалгах чиглэлээр

Авлигатай тэмцэх газар нь 2009, 2010 онуудад иргэн, аж, ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй 1148 гомдол, мэдээллийг хүлээн авч, өмнөх оны үлдэгдэл 25 гомдол, мэдээллийн хамт нийт 1173 гомдол, мэдээллийг хуульд заасан үндэслэл журмын дагуу шалгаж, шийдвэрлэсэн байна.

Монгол Улсын Авлигатай тэмцэх газар 2009 онд 2651.4 сая төгрөг, 2010 онд 2753.9 сая төгрөгийн төсвийн хөрөнгийг зарцуулан үйл ажиллагаагаа санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 48. Авлигатай тэмцэх газрын батлагдсан төсөв, түүний зарцуулалт, сая төгрөг

Төсөв / онууд	2009	2010
Батлагдсан төсөв	2 837.2	3 014.5
Төсвийн гүйцэтгэл	2 651.4	2 753.9

Эх үүсвэр: АТГ-ын мэдээлэл.

Олон улсын хандивлагч байгууллагууд, хөгжлийн хамтын ажиллагааны байгууллага, иргэний нийгмийн байгууллага болон төрийн бусад байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зүгээс авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны санхүүжилтийн талаарх нэгдсэн мэдээлэл одоогоор байхгүй байна.

Тулгамдаж буй асуудал

Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд хэвшүүлэх Монгол Улсын Мянганы хөгжлийн 24 дэх зорилтын шалгуур үзүүлэлтүүд, тэдгээрийг тодорхойлох судалгааны үр дүнгээс үндэслэн дараахь асуудлыг шийдвэрлэх шаардлага тулгарч байна.

- Дээд түвшинд тухайлбал, төрийн захиргааны төв байгууллага болон улс төр, хууль хяналтын хүрээнд авлига ихээхэн тархсан, бизнес эрхлэгчид, төрийн албан хаагчид улс төрийн хүрээнд авлига түгээмэл байна гэж иргэд үзэж байна. Түүнчлэн төрийн захиргаа, яам, агентлагуудын дунд, салбарын доод түвшинд ажиллаж байгаа төрийн албан хаагчид тухайн

салбарын дээд түвшний албан хаагчдаас илүү авлигад өртдөг гэдэг төсөөлөл байдаг. Цаашдаа авлигын судалгааг илүү өргөн хүрээтэй тогтмол хийж, төлөв байдлыг нарийвчлан тодруулж байх нь авлигатай тэмцэхэд чухал ач холбогдолтой болж байна.

- Иргэд, олон нийт төрийн үйлчилгээний талаар мэдлэг, мэдээлэл муутай байдгаас тухайн асуудлыг дүрэм журмынх нь дагуу шийдвэрлүүлэх шат дарааллыг төдийлөн сайн мэддэггүй, мэдсэн ч цаг алдаж хүндрэл, бэрхшээлтэй тулгардаг учраас танил талдаа хандах, эсвэл хээл хахууль өгч асуудлаа шийдвэрлүүлэх явдал гарч байна.
- Тухайн салбарын үйл ажиллагаа нь улс төрийн намын нөлөөнөөс ихээхэн хамааралтай, улс төрийн намын нөлөөгөөр мэдлэг чадвар дутмаг хүмүүсийг төрийн албан тушаалд томилдог, тэдгээр хүмүүс нь ажилдаа хариуцлагагүй хандаж, хүнд суртал гарган, хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэх хандлагатай, тэр хэмжээгээр салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашиггүй болж, авлигын түвшин өсөх үзэгдэл бодит үзэгдэл болж болзошгүй байна.
- Гадаадын хөрөнгө оруулалттай болон гадаадтай хамтарсан аж ахуйн нэгжүүдийн хувьд төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагад хандив, дэмжлэг үзүүлэх хандлага ихсэж байна. Энэ бүхнийг хээл хахууль, авлига дагалдах магадлалтай тул энэ чиглэлийн мэдээллийг ил тод болгох шаардлагатай байна.
- Улс төрийн нам, улс төрчдөд төрийн өмчийн аж ахуйн нэгжийн хөрөнгөөр дэмжлэг, туслалцаа үзүүлдэг, үүнийхээ ачаар тухайн аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалд үлдэх сонирхол төрийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлагуудад байдаг. Тэгэхээр төрийн өмчийн аж ахуйн нэгжийн удирдлага, төлөөлөн удирдах зөвлөлийн бүтцийг оновчтой байдлаар, дээрх нөхцөл байдлаас ангид байлгах нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй байна.
- Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд, ялангуяа, уул уурхай, барилгын

салбарт ажиллаж буй аж ахуйн байгууллагууд Монгол Улсад үйл ажиллагаа явуулахдаа төрийн албан хаагчид, улс төрчдөд хээл хахууль өгөх явдал түгээмэл байдаг гэсэн иргэдийн санаа бодолд дүгнэлт хийж нарийвчлан судлах хэрэгтэй.

- Салбарын авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чадахгүй байгаа шалтгааныг шинжээчид төлөвлөгөө нь нэр төдий, түүнийг ажил хэрэг болгох хүсэл эрмэлзэл удирдлагуудад дутдаг, төлөвлөгөөний зорилго чиглэлийг сайтар сурталчилж үр дүнг танилцуулдаггүй, үр дүнг нь үнэлэх шалгуур байдаггүй, хариуцах эзэн тодорхойгүй, хөрөнгө мөнгө төсөвлөдөггүй, албан хаагчдаас санал авдаггүй, бодит боломжоос давсан зүйлсийг төлөвлөдөг, удирдлагын зүгээс дэмжлэг муутай байдаг, стратеги төлөвлөгөө нь нэгждээ хүрдэггүй, энэ талаар сурталчилгаа хийдэггүй, хэрэгжүүлэх арга зам нь тодорхой бус байдгаас нь уг төлөвлөгөө нь үр дүнд хүрдэггүй гэж үзэж буйг үндсээр нь өөрчилж сайжруулах шаардлага тулгарч байна.
- Амьдрал дээр ашиг сонирхлын зөрчлөө мэдүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна. Салбарын болон байгууллагын ажилтан албан хаагчдын ёс зүйн дүрэмд авлига, хээл хахуультай холбоотой заалт оруулах, бэлэг дурсгал, давхар ажил эрхлэлт, харилцагч байгууллага, хувь хүмүүстэй хувийн харилцаа тогтоох зэрэг асуудлуудыг зохицуулах, төрийн байгууллагуудаас аж ахуйн нэгж бусад талуудтай байгуулж буй гэрээнд авлигатай холбоотой зүйл заалт оруулах зэрэг асуудлууд төрийн байгууллагуудад хангалтгүй байгааг зохицуулах хууль, журмын зохицуулалт хэрэгтэй байна.
- Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналт шалгалт хангалтгүй, зарим сангууд удирдах болон хяналтын зөвлөлөгч байгаа, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар сангийн хөрөнгийг захиран зарцуулах эрх зүйн зохицуулалт тодорхой бус байгаа зэрэг нь төлбөр, хураамж болон сангийн хөрөнгөөр зохион байгуулсан арга хэмжээний орлогыг санд төвлөрүүлэхгүй

байх, авлага барагдуулах ажил хангалтгүй, сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, зориулалт бусаар зарцуулах нөхцөл бүрдүүлж байгааг өөрчлөх хэрэгтэй.

- Төрийн байгууллагуудын хоорондын уялдаа, холбоо хангалтгүй, аливаа үйл ажиллагааны төсвийн төлөвлөлтийг бодитой тооцоо судалгаанд тулгуурлан хийдэггүй нь бодит гүйцэтгэлээс давсан санхүүжилт хийгдэж, зарцуулагдаагүй үлдэгдлийг бүртгэх, тайлагнах, төсөвт эргэн төвлөрүүлэх хууль эрх зүйн зохицуулалт боловсронгуй бус нь төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, ашиглах нөхцөлийг бүрдүүлж байгааг өөрчлөх шаардлагатай тулгарч байна.
- Засгийн газрын агентлаг, төвүүдийн төлөвлөлт бодитой бус, түүнд тавих хяналт сул байгаагаас орлогыг бага төлөвлөж өндөр хувиар давуулж биелүүлсэн болох, зардлыг их төлөвлөж хэмнэсэн болж харагдах, давуулж биелүүлсэн орлого, хэмнэгдсэн зардлыг байгууллагыг бэхжүүлэх, ажиллагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, машин техник худалдан авах зэрэгт зарцуулж байгаа нь байгууллагын дарга, албан тушаалтнууд дээрх хөрөнгийг хяналтгүйгээр зарцуулах нөхцөлийг бүрдүүлж байна. Яамдын зарим зардлыг агентлаг, төв нь санхүүжүүлдэг дутагдал байсаар байгааг өөрчлөх хэрэгтэй.
- Тендэр зарлах хугацааг хожимдуулснаас зарим худалдан авах ажиллагаа зарлагдаж амжихгүй, он дамжин сунжрах, тендер шалгаруулах журмыг өөрчлөн зарлах зэрэг тохиолдол гарч байгаа нь худалдан авах ажиллагаанд авлига үүсгэж болзошгүй байгааг өөрчлөх шаардлагатай.
- Гүйцэтгэгч сонгон шалгаруулах аргыг буруу сонгож, шууд гэрээ байгуулсан зөрчил зарим төрийн байгууллагуудад байна. Гэрээ байгуулсан байдал, түүний хэрэгжилт, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих, дүгнэлт хийх ажил хангалтгүй байгаагаас гэрээний хэрэгжилт жигд бус, гэрээний нөхцөл, эрх үүрэг хэт ерөнхий тусгагдснаас үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчтэй хариуцлага тооцох асуудал ч сул байгаа юм.

- Тендэрт оролцож байгаа аж ахуйн нэгжүүдийн мэдээллийн сан бий болгож, өмнө нь үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчийн жагсаалт гарган дараагийн тендэрт оролцох эрхийг хасах, хариуцлага тооцох ажил хангалтгүй байгаа нь гэрээний үүргээ биелүүлдэггүй, авлига хээл хахуулийн асуудалд холбогдож байсан аж ахуйн нэгж тендэрт дахин оролцох боломжийг олгож байна.
- Улс төрийн хүрээн дэх авлигад сонгуулийн санхүүжилтийн механизм, нам доторх болон төрийн албан дахь улс төрийн томилгоо, намын санхүүжилтийн механизм зэрэг хүчин зүйлс голлон хүчтэй нөлөөлж байна. Улс төрийн хүрээн дэх авлигын гол шалтгаан болсон сонгуулийн болон намын санхүүжилтийн механизм, түүнийг дагасан улс төрийн томилгоо нь энэ хүрээний үндсэн оролцогч болох улс төрийн намууд авлигад автагдах үндсэн хүчин зүйл болж байна.
- Хууль хяналтын байгууллагад холбогдох үйл ажиллагаануудаас прокурорын байгууллага эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох; хорих ял эдлэх хугацаанаас нь өмнө тэнсэн суллах, дэглэм бууруулах; прокурорын байгууллага эрүүгийн хэргийг хянах; эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах, ял хөнгөрүүлэх; өр барагдуулах зэрэг үйл ажиллагаа авлигад өртөх харьцангуй өндөр эрсдэлийг бий болгож байна.
- НҮБ-ын авлигын эсрэг конвенцийн үзэл санаатай адил орны хууль тогтоомжийг нийцүүлэн өөрчлөх ажлыг шуурхай хэрэгжүүлж, авлигын эсрэг хууль тогтоомжийг илүү тодорхой, боловсронгуй болгон зөрчилтэй зарим хуулийг нягтлан үзэж цэгцлэх хэрэгцээ байсаар байна.
- Авлигалын эсрэг НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийн байдалд хийсэн үнэлгээнд үндэслэн үндэсний хууль тогтоомжийг Авлигалын эсрэг НҮБ-ын конвенцид нийцүүлэх, өөрчлөх ажлыг шуурхай хэрэгжүүлэх;
- УИХ-аас 2002 онд батлан гаргасан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгч, Авлигатай тэмцэх үндэсний стратегийг шинээр батлан хэрэгжүүлэх;
- Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хараат бус байдлыг хангах, байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг хангах;
- Судалгаа шинжилгээний ажилд үндэслэн Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэвшүүлэх, хэрэгжилтэд мониторинг үнэлгээ хийх тогтолцоог боловсронгуй болгох;
- Авлигын талаарх сургалт сурталчилгааг өргөн хүрээтэй зохион байгуулах;
- Сонгуулийн болон улс төрийн намын санхүүжилтийн хяналтын тогтолцоо, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль эрх зүйн орчныг бий болгох, хэрэгжүүлэх;
- Иргэний нийгмийн байгууллагын чадавхийг сайжруулж, оролцоог нэмэгдүүлэх. Төрийн тодорхой чиг үүргийг тухайлбал, тусгай зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах үйл ажиллагааг мэргэжлийн холбоодод шилжүүлэх, тэдний хараат бус, шударгаар ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Бизнесийн байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм, компанийн засаглалын чиглэлээр гарч буй санал санаачлагыг дэмжин, үр дүнтэй хамтран ажиллах.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд хэвшүүлэх, авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна:

Дээрх үйл ажиллагааг авч хэрэгжүүлснээр Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болно гэж үзэж байна.

Хүснэгт 49. МХЗ-ын 24 дүгээр зорилтын шалгуур үзүүлэлтүүдийн хүрсэн түвшин болон төлөвлөж буй түвшин

Үзүүлэлтүүд / онууд	2009	2010	2015*
Авлигын индекс	0.64	-	0.70
Улс төр, хууль хяналтын хүрэн дэх авлигын төсөөлөл	3.95	4.07	3.90
Төрийн захиргаа болон үйлчилгээний байгууллагын хүрэн дэх авлигын талаарх иргэдийн төсөөлөл	3.0	-	2.70

Эх үүсвэр: АТГ-ын тооцоо. Тайлбар: * - Төлөвлөж буй түвшин

Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх 24 дэх зорилтыг хэрэгжүүлж, шалгуур үзүүлэлтүүдийг төлөвлөж буй түвшинд хүргэх, дээрх санал, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд дараахь хэмжээний хөрөнгийг улсын төсөв болон гадаадын тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх шаардлагатай гэсэн тооцоо гарч байна.

Хүснэгт 50. МХЗ-ын 24 дүгээр зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн тойм хэмжээ, тэрбум төгрөг

Санхүүжилтийн эх үүсвэр / онууд	2012	2013	2014	2015*
Улсын болон орон нутгийн төсвөөр	42.0	50.0	58.0	66.0
Гадаадын тусламжаар	55.0	50.0	45.0	35.0
Дүн	97.0	100.0	103.0	101.0

Тайлбар: * - Төлөвлөж буй түвшин

Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх Мянганы хөгжлийн 9 дэх зорилгын гурван зорилтуудын хэрэгжилт нь шалгуур үзүүлэлт бүрээрээ биелэгдэх магадлалтай гэж үзэж болохоор байна. Цаашдаа шалгуур үзүүлэлтүүдийг нарийвчлах, шалгуур үзүүлэлт бүрээр гаргаж байгаа мэдээлэл судалгааг тогтмолжуулан институтчилах хэрэгцээ шаардлага байгаа болно.

БҮЛЭГ 2

МХЗ-УУДЫН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ, СУРТАЛЧИЛГАА ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Дэлхий нийтээрээ хүн төрөлхтний өмнө тулгарч буй хүндрэл бэрхшээлийг гэтлэн гарах арга зам, зорилтуудыг дэвшүүлсэн “Мянганы тунхаглал”-ыг 2000 онд НҮБ-ын Дээд хэмжээний⁴⁷ уулзалтаар баталсан билээ. Энэхүү тунхаглалаар хөгжингүй болоод хөгжиж байгаа бүх улс орнуудыг өөр өөрийн бололцоо чадамждаа тулгуурлан ядуурлыг бууруулах, хүний нэр төрийг хамгаалах тэгш эрхийг баталгаажуулахад дэмжлэг үзүүлэх, энх тайван, ардчилал, байгаль орчны тогтвортой байдлыг эрхэмлэн сахих гээд нийтлэг зорилтуудад нэг бүрчлэн хүрэх асуудлыг дэвшүүлэн тавьсан юм.

Мянганы Тунхаглалын үзэл санаанаас урган гарсан Мянганы Хөгжлийн Зорилтууд (МХЗ-ууд)-аар орлогын ядуурал, өлсгөлөн, эрүүл мэнд, боловсрол, жендэрийн тэгш байдал болон байгаль орчны тогтвортой байдал гэсэн хэд хэдэн талаас нь хүний хөгжилтэй холбоотой өргөн хүрээтэй агуулгыг хэмжин тодорхойлж, тоон илэрхийлэл бүхий, хоорондоо тодорхой зааглагдаж тус бүрчлэн биеллээ олох хугацааны хязгаарыг тогтоосон зорилго зорилтуудыг томъёолон дэвшүүлсэн билээ. Уг зорилтууд нь олон улсын цар хүрээг хамарсан хөгжлийн бодлогыг чиглүүлэгч хөдөлгүүр нь болж, улмаар манай гаригийн хэт ядуурлын байдалтай амьдардаг миллиард гаруй хүн амын хувьд үр бүтээлтэй аж төрөхүй аргыг гэрэлтүүлэн зааж, бүх улс түмнүүдэд энх тайвныг сахин хамгаалах ирээдүйнх нь замналыг тодорхойлж байгаагаараа дэлхийн хамтын нийгэмлэгийн хувьд маш өндөр ач холбогдолтой зүйл байсан нь цаг хугацаа өнгөрөх тутам улам их тодорсоор байна.

Монгол Улс бусад орны нэгэн адил эл тунхаглалыг үндэслэн УИХ-ын 2005 оны 4 дүгээр сард 25 дугаар тогтоол⁴⁸ гаргаж Монгол Улсын Мянганы

хөгжлийн 1-8 зорилго дээр нэмж “Хүний эрхийг баталгаажуулж, ардчилсан засаглалыг бэхжүүлэх, авлигыг үл тэвчих уур амьсгалыг бүх нийтийн хүрээнд төлөвшүүлэх” 9 дэх зорилгыг санаачилан баталсан билээ. Мянганы хөгжлийн зорилтуудыг батлан гаргаснаас хойш мэдээлэл, сурталчилгааны ажил багагүй хийгдсэн боловч орон нутаг хоорондын түвшинд Мянганы хөгжлийн зорилтуудын үйл ажиллагааны талаарх мэдлэг зарим тохиолдолд хангалтгүй байна. Монгол Улсын хувьд МХЗ-уудын дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэн хүрэх томоохон алхамууд нь ардчилал, ардчилсан засаглалыг төлөвшүүлэх, ил тод нээлттэй иргэдийн оролцоот шударга төрийг хөгжүүлэхтэй шууд уялдах ёстой. Энэ ч утгаараа иргэд нь үгээ хэлдэг, төлөвлөлт нь олон нийтийн бодит идэвхитэй оролцоо, хэрэгцээнд тулгуурласан хүмүүнлэг, иргэний ардчилсан хөгжлийн зарчмыг баримталсан уян хатан байх нь бидний ямагт анхаарч байх үндсэн шаардлага билээ.

Мянганы хөгжлийн зорилтууд ба засаглал нь хоорондоо дараахь хоёр замаар шууд ба шууд бус байдлаар холбогдоно. Нэгд, тухай улс орны өсөлт хөгжлийн түвшинтэй засаглал ба МХЗ-уудын хэрэгжилт шууд холбоотой. Хоёрт, МХЗ-уудын шалгуур үзүүлэлтүүд ба засаглалын элементүүд хоорондоо нягт уялдаатай. Учир нь засаглалын бараг бүх байгууллагын үйл ажиллагаа нь орлогын бүрдүүлэлт төсвийн болоод хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаас шалтгаалж улмаар МХЗ-уудийн биелэлтийг хангах санхүүгийн эх үүсвэрийг ч нөхцөлдүүлдэг. Үүний сацуу МХЗ-уудыг амжилттай хэрэгжүүлснээр хүний нөөц капиталын төвлөрлийг сайжруулж хөгжлийн өндөр өсөлт илүү сайн засаглалд хүрэх бас нэгэн чухал нөхцөл нь болдог.

Энэ бүхнээс үндэслэн шууд утгаараа сайн засаглалыг бодитойгоор нэвтрүүлж, шууд бус утгаараа хүний нөөц болон дэд бүтцийн хөгжилд хөрөнгө оруулалт хийх замаар МХЗ-уудыг биелүүлэхэд чиглэгдсэн өргөн цар хүрээтэй

47 MDG-9 Project, UNDP, Millennium development goal-9 indicators and the State of Democracy in Mongolia. p.14. Ulaanbaatar, 2009.; www.mdg9.mn

48 www.legalinfo.mn

стратеги боловсруулан хэрэгжүүлэх нь олон талын ач холбогдолтой байдаг.

МХЗ-уудад хүрэх үйл явц ба эдийн засаг, улс төрийн засаглалын шууд холбоо нь сайн засаглалын гол шинжүүдээр буюу ядуучуудын эрх ашигт чиглэсэн бодлого, төрийн захиргаа, төрийн албаны үр нөлөө, төвлөрлийг сааруулах үйл явц, үйлчилгээний хүргэлт зэргээр илэрхийлэгдэнэ. МХЗ-уудын шалгуур бүх үзүүлэлтэд хамааралтай засаглалын шинжүүдэд хариуцлагатай ил тод байдал, хуулийг дээдлэх зарчим, хүний эрх, иргэний нийгмийн гүйцэтгэдэг үүрэг хамаарна. Туршлагаас үзэхэд МХЗ-уудыг амжилттай ханган биелүүлэхийн тулд хамгийн их шинэчлэл шаардагдах асуудал бол эдийн засгийн институциуд, төвлөрлийг сааруулах, үйлчилгээ хүргэлтийг тухайн салбарт тохируулан төгөлдөржүүлэхэд чиглэгдсэн алхамууд байх юм.

Ил тод байх, харилцан тайлагнах хариуцлагатай зэрэг засаглалын шинжүүдээр дамжуулан ядуурлыг бууруулах бодлогын зохих хүрээг нарийвчлах, мөн төрийн захиргаа, төрийн албаны чадавхийг бэхжүүлэх зэрэг асуудлын хүрээнд авлигатай тэмцэх асуудал аяндаа дэвшин гарч ирдэг. Энд олон нийтийн оролцоо, хяналт ихээхэн чухал болно. МХЗ-уудыг хэрэгжүүлэхтэй холбоотой бүх асуудалд нөлөөлдөг хүний эрхийг дээдлэх, хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх, иргэний нийгмийн үүрэг хариуцлагыг дэмжих чиглэлээр илүү үр дүнтэй ажиллах нь чухал ач холбогдолтой чиглэл болж байна.

Дээр дурьдсан анхаарал татсан гол чиглэлүүдээр хийх ухуулга, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх МХЗ-ыг хэрэгжүүлэх бүх үйл явцад иргэд, олон нийтийн оролцоог өргөжүүлэх нь тулгамдсан зорилтын нэг хэвээр байна.

ТУРШЛАГАД СУУРИЛСАН САНААЧИЛГУУД

Мянганы хөгжлийн зорилтуудыг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг өргөжүүлэх, тэр дундаа МХЗ-уудад суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод шингэсэн хөгжлийн асуудлууд нь улс орны хэмжээнд тухайлбал, орон нутгийн хөгжлийн зангилаа, хүний хөгжил, хүний эрх, аюулгүй байдлыг хангах тулгуур асуудлыг хөндөж байгаагаараа Мянганы хөгжлийн зорилтууд бол мөн чанартаа хүний хөгжил, дэвшлийн ойрын

ирээдүйн чиг баримжаа юм. Өөрөөр хэлбэл, хүн өөрөө хөгжлийн гол төв, гол ашиг хүртдэг болохын хувьд МХЗ-уудын хэрэгжилт нийслэл, аймаг бүрт харилцан адилгүй байгаа нь цаашид энэ үйл ажиллагаанд тодорхой төсөв, хөрөнгө хүчийг зорилт тус бүрээр нарийвчлан тодорхойлж, МХЗ-уудыг хангахад анхаарах шаардлагатай байна.

Шилдэг практик бол мэдлэг, туршлагаа хуваалцах ашиг тустай арга хэрэгсэл юм. Гадаад, дотоодын аливаа сайн туршлага нь шинэчлэлийн зарим нийтлэг асуудал болон өндөр түвшний улс төрийн дэмжлэг, улс орны нөөц баялаг зэрэг системийн шинжтэй хүчин зүйлс, түүнчлэн төрийн албаны шинэчлэлийн бүрдэл хэсгүүдийн хоорондын харилцааг тодруулж өгдөг. Ялангуяа МХЗ-ыг хэрэгжүүлсэн орнын сайн туршлага, шилдэг практикийн тухай мэдлэг нь үндэсний болон орон нутгийн практик ажилтнууд өөрсдийн нөхцөл, боломжит хувилбаруудыг шүүмжлэлтэйгээр авч үзэхэд тус нэмэр болно.

Өнгөрсөн хугацаанд орон нутгууд өөрийн онцлогийг тусгасан Мянганы хөгжлийн зорилтуудад суурилсан бүс нутаг, аймгийн Хөгжлийн бодлогыг тодорхойлон, тэдгээрийг хангах үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах болсон нь тухайн бүс нутгийн өмнө тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, орон нутгийн хөгжлийн гарцыг тодорхойлох, нутгийн өрөө удирдах ёсны байгууллагуудын бие даасан байдлыг хангах, орон нутгийн иргэдийн оролцоогоор дамжуулан харилцан зөвшилцөж боловсруулах, хэрэгжилтийг хангах, улмаар биелэлтийн байдлыг хянах тогтолцоог бүрдүүлэхэд чухал түлхэц боллоо.

Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн Үндэсний 3 дахь тайланг боловсруулах үед Сангийн яам, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дэргэд хэрэгжсэн “Ядуурал, МХЗ-уудын хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох” төслийн хүрээнд туршилтын 4 аймаг⁴⁹, нийслэлийн 2 дүүрэгт “Орон нутгийн МХЗ-уудын хэрэгжилт, тулгамдсан асуудлууд” бүсийн илтгэлийг бэлтгэж

49 *Аiäü - Aëò àé, Дидiü ä, Дидiüäiäü , Õ°äñ°e äéiäééi МÕЗ-óäiäü ñóðäééñäi Yüä yñiäé ä°äæéééi üiäü äi äéiäüi ö¿äyüiä äi äiä ñóðäéñäi “Õ°äæéééi äi äéiäi ”-üi äyëäyüiä¿é iy äyüéééä äàpàaxü <http://cabinet.gov.mn/files/ldp/LDPdornod1.pdf> - хаягаас авч ¿äü ¿¿.*

олон нийт, сурталчилах, бодлого боловсруулах, шийдвэр гаргах төвшинд ухуулан таниулах, сурталчлах ажлыг 2009-2010 онд зохион байгуулсан. Энэ туршилтын хүрээнд бусад аймаг, дүүргүүд МХЗ-уудад суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт үнэлгээ хийж, бүс нутгийн хөгжлийн гарцыг цогцоор нь үнэлж, түүнд үнэлэлт дүгнэлт өгөх оролдлого хийсэн нь чухал алхам юм.

МХЗ-уудад суурилсан орон нутгийг хөгжүүлэх үр өгөөж бүхий бодлогын баримт бичиг болох “Хөгжлийн бодлого” нь нутгийн захиргааны байгууллага, сонирхогч талуудын үйл ажиллагааны илүү сайн “хэвтээ” зохицуулалтад анхаарал хандуулсан нь чухал боллоо. МХЗ-уудад суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хүрээнд аймаг, орон нутгийнхны боловсруулсан хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэдээ цогц байдлаар хандах нь засаглалын ардчилсан шинжийг хадгалах гол хэрэгсэл болох ёстой. Өөрөөр хэлбэл, орон нутгийн засаглалын хүрээнд МХЗ-ын стратеги бол орон нутгийн хөгжлийн ерөнхий стратеги, бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаатай шууд уялдсан, тухайн аймаг орон нутгийн түвшинд төрийн үйлчилгээг илүү үр дүнтэй хүргэх, засаглалыг сайжруулах, хөгжийн стратегийн үр ашигтай уялдаа холбоог хангахад чиглэгдэж байна.

Улаанбаатар хотын Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийг хангах, дүүргүүдийн түвшинд МХЗ-ыг тодорхойлох ажлыг зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажлын хэсгийг Нийслэлийн Засаг даргын 2010 оны 3-р сарын 12-ны өдрийн 189 дүгээр захирамжаар байгуулсан байна. Энэхүү захирамж нь Улсын Их Хурлын 2008 оны 13 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2009 оны 83 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хэсгийг үр дүнтэй ажиллуулан, 2011 онд боловсруулах хэрэгжилтийн тайлангийн судалгаа, мэдээллийг цуглуулах, бодлогын зөвлөмж гаргахад анхаарч ажиллах талаар тусгасан баримт бичиг юм.

Нийслэлийн Засаг даргын 2010 оны 189 дүгээр захирамжийн дагуу 7 дүүрэгт Дүүргийн Засаг даргын орлогч болон Тамгын газрын дарга

нараар ахлуулсан “МХЗ-уудын хэрэгжилтийг хангах, илтгэл боловсруулах” дэд ажлын хэсгүүд байгуулагдан ажиллаж “Дүүргийн түвшинд МХЗ-уудыг тодорхойлох зөвлөмж” сургалт, “МХЗ-уудын хэрэгжилтийн үндэсний 3 дахь тайлан, дүүргийн түвшний МХЗ-уудын бодлогын хэлэлцүүлэг”-ийг зохион байгуулжээ. Эдгээр сургалт, хэлэлцүүлгийн үр дүнд дүүргүүдийн дэд ажлын хэсгүүд МХЗ-уудыг тодорхойлох талаар туршлага хуримтлуулж, дүүргийнхээ хөгжлийн онцлог нөхцөл байдал, цаашид дэвшүүлж буй зорилтуудын талаар санал бодлоо солилцсон хэлэлцүүлгүүдийг өрнүүлсэн байна.

СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

МХЗ-ууд, түүний хэрэгжилтийн явц байдлын талаарх мэдээллийг орон нутгийн иргэдэд хүргэх, сурталчлах, хэрэгжилтэд мэргэжлийн болон ТББ, иргэдийн идэвхи оролцоог хангах, санаачилгыг өрнүүлэх зорилгоор Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн Үндэсний 3 дугаар илтгэлийг боловсруулах ажлыг тогтмол хуваарийн дагуу зохион байгуулж ирсэн нь олон нийтийн дунд Мянганы хөгжлийн зорилтуудын үр нөлөө, хүний хөгжилд суурилсан хөгжлийн мөн чанарын талаар санаачилгыг өрнүүлсэн байна. Тухайлбал, 2009 оны 8 дугаар сард НҮБХХ-ийн Ази Номхон далайн бүсийн захирал ноён Ажай тэргүүтэй төлөөлөгчдийн Монгол улсад хийсэн айлчлалтай МХЗ-уудын хэрэгжилтийн Үндэсний III илтгэлийн үр дүнг танилцуулах арга хэмжээтэй давхцсан нь олон улсын болон үндэсний төвшиний хөгжлийн төлөөх санаачилгад ач холбогдолтой үйл явдал болов.

МХЗ-уудын хэрэгжилтийн Үндэсний 4 дэх илтгэлийг боловсруулахдаа орон нутгийн, салбар дундын болон иргэний нийгэм, төрийн бус байгууллага, иргэд олон нийтийн оролцоог хангаж, санал зөвлөмж авах ажлыг зохион байгуулсан. Энэ ажлын зохион байгуулахдаа МХЗ-уудад суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийн үнэлгээний үр дүн, хэтийн зорилт хандлагатай хослуулсан өргөн хүрээтэй нээлттэй хэлэлцүүлгийг орон нутагт сургалт, сурталчилгааны ажлыг нийгмийн бүлэг бүрийн ялгаатай байдалд тохируулан, хялбаршуулсан байдлаар боловсруулж, лекц, ярилцлага, уулзалт хэлбэрээр зохион байгуулсан нь илүү хүртээмжтэй, үр өгөөжтэй байна.

ИРГЭНИЙ НИЙГЭМ БОЛОН ХУВИЙН ХЭВШЛИЙН ОРОЛЦОО

МХЗ-уудыг хэрэгжүүлэхэд сонирхогч олон талыг татан оруулж, дэмжих нь чухал. Монгол Улсын МХЗ-уудыг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн болон төрийн байгууллагуудын идэвхитэй оролцоо, орон нутгийн байгууллага, нийтэд үйлчилдэг сонирхлын бүлгүүд, хувийн салбарынхан, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хүний эрхийн байгууллага зэргээс гарсан санаачилга хөтөлбөрийг төлөвлөх, боловсруулах, бодлого хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ хийхэд тэдний оролцоог нэмэгдүүлэх, тэдэнтэй хамтран ажиллах чиглэлээр багагүй туршлага хуримтлуулсан. МХЗ-уудын хэрэгжилтийг хангах зарим тодорхой бодлогын хэрэгжилтийг ханган биелүүлэхэд туршлагатай, нөхцөл байдлыг бодитоор харж үнэлж дүгнэж чадахуйц “төрийн бус салбарынхан”-ыг оролцуулах нь хэрэгжилтийн түргэн шуурхай, үр нөлөөтэй байдлыг сайжруулахад ач холбогдолтой болов.

Иргэний нийгэм нь аливаа шийдвэрлэгдээгүй асуудлуудыг илрүүлэн гаргаж, түүнд төрийн анхаарлыг чиглүүлэх, хүний эрхийг хамгаалах, улс төр, байгаль орчин, нийгмийн болон орон нутгийн олон асуудлаар иргэдийн ашиг сонирхлыг илэрхийлэх, зохих байгууллага, албан тушаалтанд дуу хоолойг нь хүргэхэд чухал үүрэгтэй билээ.

МХЗ-уудад хүрэхэд засаглалын ач холбогдлыг үндэслэхийн тулд төр засгийн ил тод байдал, хариуцан тайлагнах, бодлогын хэрэгжилтийн үр нөлөө иргэдийн санаачилга, идэвхи зүтгэл, иргэний нийгмийн шударга, бодит байдлыг соргогоор олж харах мэдрэмж, хувийн салбарынхны өрсөлдөөнт хичээл зүтгэлийн хоорондын уялдаа холбоог илүү нарийвчлан авч үзэх хэрэгтэй. Тийм ч учраас энэхүү дөрөв дэх илтгэлд судлаачид, ТББ-ынханы судалгааны дүнг ихээхэн оруулсан болно.

БҮЛЭГ 3

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ИНДЕКС

Орон нутгийг жигд хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын хуваарилалтыг боловсронгуй болгох, төсвийн хөрөнгө оруулалтыг аймаг, орон нутгийн хөгжлийн бодит түвшинд тулгуурлан оновчтой төлөвлөхөд ашиглах зорилгоор орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлал боловсруулж Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 88 дугаар тогтоолоор батлан мөрдөж байна.

Дэлхийн улс орнууд бүс нутгийнхаа хөгжлийн түвшинг янз бүрээр тодорхойлж, олон үзүүлэлтээр хэмжиж ирсэн бол өнөөдөр дэлхий нийтийн хандлага нь улс орны хүний хөгжил, дэд бүтцийн хангамж, хүрээлэн буй орчин, хөгжлийн нөөц, давуу тал болон ядуурлын байдал зэрэг олон хүчин зүйлсийг хамруулж, өргөн хүрээнд тооцоход чиглэх болжээ. Тухайлбал:

- Латви улс- Нутаг дэвсгэрийн хөгжлийн индекс;
- БНХАУ- Бүс нутгийн хөгжлийн индекс;
- Турк улс - Нийгэм, эдийн засгийн хөгжлийн индекс;
- Өмнөд Солонгос улс- Бүс нутгийн хоцрогдлын индексийг тооцож, хөгжлийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын бодлого, хөтөлбөрт ашиглаж байна.

Дээрх улсуудын хөгжлийн индекс тооцдог аргыг ерөнхийдөө (i) үзүүлэлтүүдийг 0 утгаас стандартчилах, (ii) бүх үзүүлэлтийг 0-1 хооронд индексжүүлэх гэсэн хоёр ангилдаг арга байдаг байна. Хөгжлийн түвшингээр дээгүүр болон газар нутаг багатай орнуудын хувьд цөөн үзүүлэлт ашиглан стандартчилах аргыг хэрэглэх нь илүү тохиромжтой байдаг бол хөгжиж буй орнуудын хувьд олон үзүүлэлт ашиглан, индексжүүлэх аргыг ашиглах нь оновчтой, бодитой тооцогддог байна.

Манай орны хувьд орон нутгийн хөгжлийн түвшинг үндсэн 9 бүлгийн 65 үзүүлэлтийн тусламжтайгаар олон улсад түгээмэл ашигладаг 0-1 хооронд индексжүүлэх аргыг ашиглан тооцож байна. Энэ нь:

- Дэд бүтцийн хангамж;
- Боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар;

- Соёл, урлагийн байдал;
- Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж;
- Хүрээлэн байгаа байгаль орчин;
- Нийгэм, эдийн засгийн байдал;
- Санхүүгийн үзүүлэлт;
- Хөгжлийн нөөц, давуу тал;
- Хөдөө аж ахуй гэсэн 9 бүлгээр тооцож байна.

ХӨГЖЛИЙН ИНДЕКСИЙН ҮР ДҮН

2009 оны статистикийн гүйцэтгэлд үндэслэн 65 үзүүлэлтийн тусламжтайгаар хөгжлийн индексийг 21 аймаг, Улаанбаатар хотын дүнгээр тооцож гаргалаа. 2010 оны мэдээлэл бүрэн гараагүй тул уг тайланд тусгаж чадаагүй болно.

2009 оны хөгжлийн индексийг харахад Өмнөговь, Орхон, Дархан-Уул, Улаанбаатар, Говьсүмбэр, Төв зэрэг аймаг, нийслэл нь хөгжлийн түвшингээр тэргүүлж байна. Үүнд уул уурхайн үйлдвэрлэлийн хөгжил, дэд бүтэц харьцангуй давуу тал, зах зээлд ойр зэрэг шалтгаанууд нөлөөлж байна.

Улсын дундаж индекс 0.39057 байгаа бөгөөд Архангай, Хэнтий, Завхан, Дорноговь, Хөвсгөл, Дорнод, Говь-Алтай, Ховд, Увс, Өвөрхангай, Баянхонгор, Баян-Өлгий зэрэг аймгуудын хөгжлийн индекс улсын дунджаас доогуур байна. Энэ баримт баруун бүсийн аймгууд хөгжлийн хувьд хоцрогдонгуй байгааг харуулж байгаа бөгөөд баруун бүсийн аймгуудын дэд бүтцийн хөрөнгө оруулалтад нэн тэргүүнд анхаарах шаардлагатай гэдэг нь хөгжлийн индексийн үр дүнгээс харагдаж байна. Дэд бүтцийн асуудлаа шийдвэрлээгүй, олон аймаг байгаа нь үйлдвэрлэл хөгжих, хөрөнгө оруулагчид бизнесээ өргөжүүлэхэд бэрхшээл болж байна.

2009 оны гүйцэтгэлээр тооцсон хөгжлийн индексийн дүнгээс харахад Баян-Өлгий, Ховд, Булган зэрэг аймгуудын бага боловсролын хамрагдалт муу байгаа бол Баян-Өлгий, Хөвсгөл, Булган, Хэнтий, Өвөрхангай, Сэлэнгэ зэрэг аймгууд ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн хангалт доогуур, мөн Хөвсгөл аймагт

нялхасын эндэгдэл өндөр, дундаж наслалт хамгийн бага, эмнэлгийн ор дутагдалтай бол Орхон аймагт урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалт бага, Дундговь, Дорноговь, Баянхонгор, Дорнод, Баян-Өлгий, Завхан зэрэг аймагт эхийн эндэгдэл өндөр, Говь-Алтай, Баянхонгор, Дорноговь аймагт нялхасын эндэгдэл их, Увс аймагт эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалт муу, Дорнод аймагт сүрьеэ өвчний нас баралт өндөр байгаа дүн гарсан тул цаашид бодлого боловсруулах, хөрөнгө оруулалт, төсвийг төлөвлөхөд анхаарах шаардлагатай байна.

Нийслэл хотын хувьд дэд бүтцийн хөгжил, нийгэм, эдийн засгийн байдал, боловсролын түвшин зэрэг ихэнхи салбарт хөгжлийн түвшингээр тэргүүлж байгаа хэдий ч байгаль орчин, эрүүл мэндийн салбарын хөгжлийн индексээр доогуур байна. Иймээс Улаанбаатар хотод шинээр төрөх газар болон нэгдсэн эмнэлэг барих, Улаанбаатарын утааг арилгахад гол анхаарлаа хандуулан ажиллах шаардлагатай байгаа юм.

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХӨГЖИЛ

МХЗ-уудын биелэлтийг үндэсний хэмжээнд болон бүс нутгуудаар гаргахаас гадна аймаг тус бүрээр хэрэгжилтийн явц байдлыг тодорхойлж тэр дундаа эрүүл мэнд, боловсролын түвшин, тэдгээрийн хүртээмж, улсаас өгч байгаа тусламж, дэмжлэг хөрөнгө оруулалтаар нь гаргаж үзлээ. Ингэхдээ хүний хөгжлийн индекс болон орон нутгийн хөгжлийн индекс, мөн НҮБ-ын хүүхдийн сангаас гаргадаг хүүхэд хөгжлийн индексэд үндэслэн эдгээр индексүүдийн хамгийн муу буюу тааруу үнэлгээтэй аймгуудад төр засгаас анхаарал тавьж тэр чиглэлд хөрөнгө оруулалт болон нийгмийн дэмжлэгүүдийг илүү үзүүлэх нь зүйтэй гэсэн зөвлөмж гаргажээ. МХЗ-уудын дөрөв дэх илтгэлээс эхлэн хөгжлийн гол гол үзүүлэлтүүдээр бусад аймгуудтай харьцуулахад дунджаар хамгийн доогуур түвшинд байгаа аймгийг тусгайлан авч үзэж тус аймгийн хөгжлийн сул талуудын бодит шалтгаан, цаашид анхаарах асуудлуудын талаар энэ илтгэлд оруулж байна. Хүний хөгжлийн индексийн эрүүл мэнд болон боловсролын түвшнээр Хөвсгөл аймаг бусад аймгаас доогуур байгаа бөгөөд мөн Орон нутгийн хөгжлийн индекс, хүүхдийн хөгжил индексээр ч тус аймаг нь харьцангуй доогуур түвшинд байгаа юм.

Хөвсгөл аймаг нь 125 мянган хүн амтай, төвөөс алслагдсан таруу байрлалтай олон сумдтай бөгөөд

тус аймаг нь Говьсүмбэр аймгаас ойролцоогоор 10 дахин, Булган аймгаас 3 дахин их хүн амтай манай улсын хамгийн олон хүн амтай том аймгуудын нэг юм. Тус аймгийн хувьд 1990 оноос өмнө фосфорын ордыг ашиглан түүнд түшиглэсэн хөгжлийн загварыг бий болгох төлөвлөгөөтэй байсан хэдий ч зах зээлийн нийгэмд шилжсэнээр тус аймаг, хөгжлийн бодлогоос гадуур үлдсэн гэж хэлж болох юм. Мянганы хөгжлийн зорилтуудын боловсрол, эрүүл мэнд, нялхасын эндэгдэл, ядуурлын түвшний үзүүлэлтүүдээр манай улсын баруун, хангайн бүсийн аймгууд ихээхэн тааруу дүнтэй байгаагийн дотор Хөвсгөл аймгийг онцлон авч үзэх шаардлагатай байгааг тухайн аймагт ажилласан ЗГ-ын болон НҮБ-ын төлөөллийн ажлын үр дүн харуулж байна.

Тус аймагт ажилласан бодит байдалтай танилцахад Мөрөн, Цагаан нуур, Алаг-Эрдэнэ сумдын эрүүл мэнд, боловсролын, хүртээмж үнэхээр тааруу байж, тэр хэрээр нялхсын эндэгдэл, хүн амын өвчлөл сүүлийн жилүүдэд тус сумдад нэмэгдсэн дүр зураг харгдаж байна. Ялангуяа алслагдмал Цагаан нуур сумын иргэдийн эрүүл мэндийн байдал нэлээн доогуур үзүүлэлттэй байв. Үүний гол шалтгааныг газар дээр нь судлан үзэхэд дараахь хүчин зүйлс их нөлөөлсөн байна.

- Цагаан нуур сум нь алслагдсан, өндөрлөг газарт оршдог учраас тус сумын иргэдийн дунд даралт огцом ихсэх, багасах үзэгдэл их байна.
- Тус суманд ахуйн хэрэглээний цэнгэг усны худаг байхгүй, дээрээс нь цагаан нуур нь сүүлийн жилүүдэд ихээхэн бохирдсоноос иргэдийн дунд гэдэсний халдварт өвчлөл, ходоодны шархлаа, шүдний өвчлөл их байна.
- Сумын зарим иргэд сумаас алслагдмал зайнд амьдарч байгаа нь эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ авахад бэрхшээлтэй тулгарч энэ нь иргэдийн дундаж наслалт бусад аймгуудаас доогуур байхад нөлөөлж байна.
- Сумын эмнэлэг нь байрны хувьд хүрэлцээгүй, стандарт бус жижиг өрөөнүүдтэй байгаа нь агаарыг хангалттай хуримтлуулж чадахгүйд хүрч улмаар амьсгалын замын өвчин эмгэгийг оношлох, эмчлэх багаж төхөөрөмж нь ажиллахгүйгээс шалтгаалан нялхас эндэж байна.
- Түүнчлэн тус эмнэлгийн шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмж хангалтгүйгээс өвчнийг эрт илрүүлэх, зөв оноглох боломжгүйн

дээр зарим нэг өвчнийг таамагаар эмчлэх тохиолдол гарч байна.

Цагаан нуур сумын боловсролын хүртээмж, хангалт мөн сайнгүй байна. Тухайлбал,

- Сургуулийн дотуур байранд хамрагдалт өндөр боловч нэг өрөөнд дөрвөн хүүхэд амьдрах ёстой байтал 10 хүүхэд амьдарч байгаа нь сурагчдын тав тух алдагдаж, боловсролын стандарт зөрчигдөн улмаар боловсролын чанарт сөргөөр нөлөөлж байна.
- Дотуур байранд амьдарч буй сурагчид цэвэр, халуун усны хангалт тааруугаас 14 хоногт нэг удаа усанд ордог, тэдгээр хүүхдүүдийн ариун цэвэр, эрүүл мэндийн орчин хангалтгүй байна.


Алслагдсан сумдаас гадна аймгийн төв Мөрөн суманд боловсролын хүртээмж тэр бүр сайнгүй байна. Мөрөн сумын 2 дугаар цэцэрлэгт хүчин чадлаас нь давсан тооны хүүхдүүд хүмүүжиж байгаагийн дээр 1931 онд баригдсан, аймгийн мэргэжлийн хяналтын газраас хаагаад байгаа зөвшөөрөлгүй байранд үйл ажиллагаа явуулж бага

насны хүүхдүүдийг хүмүүжүүлж байна. Энэ нь нэг хүүхдэд ногдох талбай болон бусад хангалтаар шаардлага хангахгүй байгаагийн дээр хүүхдүүдийн амь насанд ч аюултай юм.

Аймгийн хэмжээнд өсвөр насны хүүхдүүд эрүүгийн гэмт хэрэгт их холбогдож байна. Энэ нь аймгийн хэмжээнд үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байр дутмагаас шалтгаалж ажилгүйдэл, архи дан согтуурах шалтгаанаас хүүхдүүдэд тавих эцэг эхийн хяналт сул байгаатай холбоотой юм. Аймгийн цагдаагийн газарт хүүхдийн байцаагч цөөн байгаа нь гэмт хэрэгт орооцолдсон хүүхдүүдтэй тулж ажиллах, тэдгээрийг зөв замд нь оруулах, засан хүмүүжүүлэх, зөвлөгөө өгөх зэрэгт хүрэлцээ муу, үр дүн багатай байна.

Хөвсгөл аймгийн төв Мөрөн сумын нэгдсэн эмнэлэгийн байдалтай танилцахад нялхсын эндэгдэл тэр бүр буурахгүй байгаа нь эхийн суурь өвчлөл өндөр байгаатай холбоотой юм. Мөн ор, техник тоног төхөөрөмжийн хүрэлцээ муугаас өвчин хүндрэхээс урьдчилан сэргийлэх ажил хийгдэж чадахгүй байна.

Дүрслэл 42. Аймаг, нийслэлийн хөгжлийн индексийн ялгааг харуулсан газрын зураг




АЙМГИЙН НЭР	Ерөнхий индексийн утга
Өмнөговь	0.51601
Орхон	0.48252
Дархан-Уул	0.46537
Улаанбаатар	0.41875
Говьсүмбэр	0.41745
Төв	0.40823
Дундговь	0.40279
Булган	0.40216


АЙМГИЙН НЭР	Ерөнхий индексийн утга
Сэлэнгэ	0.40191
Сүхбаатар	0.39789
Архангай	0.38977
Хэнтий	0.38919
Завхан	0.38166
Дорноговь	0.37820
Хөвсгөл	0.37429

АЙМГИЙН НЭР	Ерөнхий индексийн утга
Дорнод	0.36623
Говь-Алтай	0.36413
Ховд	0.35413
Увс	0.33956
Өвөрхангай	0.31923
Баянхонгор	0.31282
Баян-Өлгий	0.31034


Дүрслэл 43. Аймаг, нийслэлийн боловсролын үйлчилгээний хүртээмж




Дүрслэл 44. Аймаг, нийслэлийн соёл, урлагийн байдал




Дүрслэл 45. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж




Дүрслэл 46. Аймаг, нийслэлийн хүрээлэн буй байгаль орчны байдал



Дүрслэл 47. Аймаг, нийслэлийн нийгэм, эдийн засгийн байдал



Дүрслэл 48. Аймаг, нийслэлийн санхүүгийн байдал



БҮЛЭГ 4

МХЗ-УУДЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо нь Ерөнхий сайдын 2009 оны 8 дугаар захирамжийн хүрээнд байгуулагдсан бөгөөд, үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтод тодорхойлсноор Мянганы хөгжлийн зорилт болон түүнд суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, судалгаа шинжилгээ хийх үүрэгтэй юм.

Өмнө гарсан III дахь илтгэлийн зөвлөмжид тулгамдаж байгаа асуудал хэмээн дурьдсан Мянганы хөгжлийн зорилт болон түүнд суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, судалгаа шинжилгээ хийх тогтолцоо нь тус хороонд бүрдэж байна.

Шигтгээ - 5. МӨЗ-д суурилсан цогц бодлогоос

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын 1 дүгээр тэргүүлэх чиглэлийн хүрээнд: “Монгол хүнд эрүүл, саруул аж төрөх, урт наслах, амар тайван байх, түүх, соёлоо хүндлэх, бүтээлчээр ажиллах, байнга суралцах, оюун ухаан, авьяас, чадвараа нээн хөгжүүлэх өргөн сонголттой байх таатай орчныг бүрдүүлэн “Монгол хүний амьдралын чанар”-ыг тасралтгүй дээшлүүлж, 2015 он гэхэд Мянганы хөгжлийн зорилтуудыг бүрэн биелүүлж, хүний хөгжлийн индексийг 0.83-д хүргэх бодлого баримтална. Монгол Улсын иргэдийн хөдөлмөр болон аж ахуй эрхлэлтийг дэмжих, ажлын байрны тоог нэмэгдүүлэх, гэр бүлийг бэхжүүлэх, амьжиргаагаа сайжруулах чадамжийг дээшлүүлэх, хүн амын нийгмийн хамгаалал, халамжийн тогтолцоог боловсронгуй болгох замаар Мянганы хөгжлийн зорилтыг хангах бодлого баримтална.” гэж заасан.

Мянганы хөгжлийн зорилтын хяналт шинжилгээ, үнэлгээний хүрээнд

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудыг НҮБ-аас зөвлөмж болгосон үзүүлэлтүүд болон стандарт, тооцох арга зүйд нийцүүлэн Монгол Улсын Их Хурлын 2008 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан Мянганы хөгжлийн зорилтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судлах үүрэг бүхий ажлын хэсэг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны даргын 2010 оны 53 дугаар тушаалаар яамд, агентлагууд, судлаачдын бүрэлдэхүүнтэй байгуулагдан дараахь асуудлуудыг судаллаа.

Мянганы Тунхаглал 2003 онд 8 зорилго, 18 зорилт, тэдгээрийг дүгнэх 48 шалгуур үзүүлэлтийг анх баталжээ. 2007 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 62 дугаар чуулганаар МХЗ-ыг шинэчлэн 8 зорилгын хүрээнд 21 зорилтыг 60 шалгуур үзүүлэлтээр дүгнэхээр баталсан. Үүнийг 2008 оны 1 дүгээр сараас мөрдөж эхэлсэн.

2008 оны 1 дүгээр сард УИХ-ын 13 дугаар тогтоолоор 2005 оны 25 дугаар тогтоолд өөрчлөлт оруулан шинэчилсэн. Манай орны хувьд Мянганы Хөгжлийн Зорилтууд нь 9 зорилго, 24 зорилт, 67 шалгуур үзүүлэлттэй.

Манай оронд Мянганы хөгжлийн зорилтуудыг дүгнэхээр тогтоосон 67 үзүүлэлтийн 32 нь олон улсын түвшинд зөвлөмж болгосон үзүүлэлт, харин 35 үзүүлэлт нь үндэсний хэмжээнд л хэрэглэх үзүүлэлт болсон байна.

НҮБ-аас зөвлөмж болгосон 60 үзүүлэлтийн 37 буюу 61.7 хувийг нь албан ёсны статистик мэдээгээр гаргадаг нь тогтоогдсон. НҮБ-аас зөвлөмж болгосон 60 үзүүлэлтээс манайд гардаггүй 23 үзүүлэлтийн 9 нь манай орны хувьд хамааралгүй, харин 14 үзүүлэлтийг мэдээлэл бүрддэггүй, арга зүйг нь мэдэхгүй шалтгаанаар тооцож чадаагүй байна.

2008 оноос НҮБ-аас МХЗ-ыг дүгнэхээр шинээр нэмсэн үзүүлэлтээс манай орны хувьд дараахь 7 үзүүлэлт гарах боломжтой байна:

- Нэг хүн амд ногдох ДНБ-ий өсөлтийн хувь,
- Нийт хүн амд ажиллагсдын эзлэх хувь,
- Нийт ажиллагсдад хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон өрхийн бизнест цалин хөлсгүй ажиллагчдын эзлэх хувь,
- Өсвөр насны охидын төрөлтийн хувь,
- Эхчүүдийн төрөхийн өмнөх хяналтанд хамрагдалтын хувь,
- Гэр бүл төлөвлөлтийн хүсээгүй хэрэгцээ,
- 1000 хүн ногдох гар утасны тоо зэрэг болно.

Матрицийн аргаар үнэлэхэд манай улс бүх зорилтын хэрэгжилт дараахь байдалтай байгаа болно.

Нийт зорилтын 11.1 хувь нь эрт хүрч, 38.9 хувь нь өнөөгийн хандлага цааш нь үргэлжлэвэл зорилтод түвшиндээ хүрэх боломжтой байна. Харин нийт зорилтын 50 хувийн хэрэгжилт удаан байна.

Засгийн газрын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг тооцдог аргаар тооцож үзэхэд МХЗ-уудын хэрэгжилт 77.9 хувьтай гарахаар байгаа юм.

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан Мянган хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод Монгол Улс 2015 он гэхэд “Мянган хөгжлийн зорилтууд”-ыг бүрэн хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Засгийн газрын 2010 оны 95 дугаар тогтоолоор Мянган хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын эхний шатны үнэлгээ хийх төлөвлөгөө батлагдаж баримт бичгийн стратегийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүрт шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тодорхойлж өгсөн.

Мянган хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын эхний шатны үнэлгээг 2010 онд төрийн захиргааны төв байгууллагууд⁵⁰,

судлаачид, ТББ-ууд, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр уламжлалт хяналт шинжилгээ, үнэлгээний аргаас⁵¹ гадна үр дүнд суурилсан үнэлгээний аргаар⁵² хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын бүх аймаг, нийслэл урт хугацааны хөгжлийн бодлого болох Мянган хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогоо батлан хэрэгжүүлж байгаа нь Монгол Улс Мянган хөгжлийн зорилтыг ханган биелүүлэхэд том алхам юм.

Хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ

Мянган хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг үнэлэх үр дүнд суурилсан үнэлгээний арга зүйг салбарын яамд, агентлагуудад чадавхийг бэхжүүлэх, нэгдсэн нэг арга зүйтэй байх үүднээс сургалтуудыг үе шаттай зохион байгуулж байна.

Мянган хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын эхний шатны үнэлгээний тайланг 2011 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж УИХ-д өргөн бариад байна.

Мянган хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн 3 дахь илтгэлд дурьдсан ойрын, дунд хугацаанд хэрэгжүүлэх ажлыг Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжилтийг хангахын төлөө ажиллаж байгаагийн зэрэгцээ мөн Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2012-2016 оны тэргүүлэх чиглэлийн төсөлд тусгаад байна.

Тулгамдаж буй асуудал

Монгол Улсын Мянган хөгжлийн зорилтуудыг НҮБ-аас зөвлөмж болгосон үзүүлэлтүүд болон стандарт, тооцох арга зүйд нийцүүлэн Монгол Улсын Их Хурлын 2008 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан Мянган хөгжлийн зорилтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг яаралтай шийдвэрлэх хэрэгтэй байна.

50 *Mitai e Yehui Ed"idee naeaii 2010.9.15-iu "adeei 72-d zadedaiie , Yia yniee o"avee oeyi oayeeei sidiiu aadaui 2010.10.05-iu "adeei 90-d o oadae*

51 *Zanhaeei aadui 2010 iuu 11 azaayud oiaadii e (oyoyaeeeo , azeiyuayee oyiadee oeiweeayy deeyai)*

52 *Toodei o"ne o"oe adaei o"ee"ee , oyoyaeeeo , azeiyuayeeei ziy eayai*

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын эхний шатны үнэлгээг УИХ-аар хэлэлцэж холбогдох шийдвэр гаргах шаардлагатай байна.

Цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ

- Мянганы хөгжлийн зорилтуудыг НҮБ-аас зөвлөмж болгосон үзүүлэлтүүд, стандарт, тооцох арга зүйд нийцүүлэн өөрчлөхийн тулд УИХ-ын 2008 оны 13 дугаар тогтоолд зохих өөрчлөлтүүдийг оруулах;
- ДевИнфо мэдээллийн санг тогтмол, байнгын ажиллагаатай болгох;
- МХЗ-уудын үзүүлэлтүүдийг сумдаар гаргах асуудлыг шийдвэрлэх.

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Монгол Улсын МХЗ-уудын хэрэгжилтийн хандлагын шинжилгээ, үнэлгээ

Зорилго/Зорилт/Шалгуур үзүүлэлт	Зорилт			
	2008	2009	2010	2015
Зорилго Нэг. Ядуурал, өлсгөлөнг бууруулах				
Зорилт 1. Амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой иргэдийн эзлэх хувь хэмжээг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 2 дахин бууруулах				
1. Ядуурлын түвшин /хувь/	35.2	38.7	39.2	18.0
2. Ядуурлын гүнзгийрэлт /хувь/	10.1	10.6	11.3	6.0
3. Үндэсний нийт хэрэглээнд хамгийн бага хэрэглээтэй хүн амын хэрэглээний эзлэх хувийн жин	7.2	8.5	7.8	11.0
4. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн /оны үнээр, мянган төгрөг/	2,305.2	2,432.2	3059.4	6800.0
Зорилт 2. Хоол, тэжээлийн дуталтай хүн амын тоог 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 6 дахин бууруулах				
5. 5 хүртэлх насны тураалтай хүүхдийн эзлэх хувь	6.3	2.0
6. 5 хүртэлх насны өсөлтийн хоцролттой хүүхдийн эзлэх хувь	21.0	13.0
7. 5 хүртэлх насны туранхай хүүхдийн эзлэх хувь	2.2	1.0
Зорилт 3. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг дээшлүүлж, хөдөлмөрийн зах зээлд шилжиж буй залуучуудын ажилгүйдлийн түвшинг бууруулах				
8. Ажиллах хүчний оролцооны түвшин /хувь/	63.5	66.8	61.6	70.0
9. 15-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин /хувь/	3.0	22.0	19.5	2.5
Зорилт 4. Хүн амын төвлөрөл, шилжих хөдөлгөөнтэй холбогдон гарч буй сөрөг үзэгдлийг багасгах, шилжин суурьшигчдыг нийгмийн суурь үйлчилгээнд хамруулах				
10. Хот, суурингийн нийт хүн амд хаягийн бүртгэлгүй оршин сууж буй хүн амын эзлэх хувь
Зорилго Хоёр. Бүх нийтээр анхан шатны боловсрол эзэмших				
Зорилт 5. 2015 он гэхэд бүх хүүхдэд бага боловсрол олгох				
11. Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин	91.5	94.3	94.7	100.0
12. Нэгдүгээр ангид элсэн ороод 5 дугаар анги хүртэл суралцагчдын хувь	92.8	89.9	92.9	100.0
13. 15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын хувь	97.7			100.0
Зорилго Гурав. Хүйсийн тэгш байдлыг дэмжин хөгжүүлж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх				
Зорилт 6. 2009 он гэхэд бага болон дунд боловсрол эзэмшигчдийн дунд, 2015 он гэхэд бүх шатны боловсролын байгууллагад суралцагчдын хүйсийн зохистой харьцааг хангах				
14. Бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа	0.97	0.96	0.96	1.0
15. Ерөнхий боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа	1.08	1.07	1.07	1.0
16. Дээд боловсрол эзэмшиж байгаа эмэгтэй, эрэгтэйчүүдийн тооны харьцаа	1.54	1.52	1.48	1.0
Зорилт 7. Цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын жендэрийн тэгш байдлыг хангах				
17. Хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь	53.0	48.8	48.4	50.0

Зорилт 8. Улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх				
18. Улсын Их Хуралд сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь	3.9	3.9	3.9	30.0
19. Улсын Их Хуралд нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь	18.5	-	-	30.0
Зорилго Дөрөв. Хүүхдийн эндэгдлийг бууруулах				
Зорилт 9. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 4 дахин бууруулах				
20. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлт тутамд/	23.2	23.5	25.6	21.0
21. Нялхсын эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлт тутамд/	19.4	20.0	20.2	15.0
22. Улаан бурхны эсрэг вакцинжуулалтад хамрагдсан хүүхдийн хувь	96.9	96.5	96.9	99.0
Зорилго Тав. Эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах				
Зорилт 10. НҮЭМ-ийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэж, эхийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 4 дахин бууруулах				
23. Эхийн эндэгдлийн түвшин /100,000 амьд төрөлт тутамд/	48.6	81.0	47.4	50.0
24. Эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь	99.8	99.8	99.8	99.8
Зорилго Зургаа. Бэлгийн замын халдварт өвчин, Хүний дархлал хомсдолын вирус /ХДХВ/, Дархлалын олдмол хомсдол /ДОХ/, сүрьеэтэй тэмцэх, бусад өвчнийг бууруулах				
Зорилт 11. 2015 он гэхэд ХДХВ, ДОХ өвчний халдварыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх				
25. Жирэмсэн эмэгтэйчүүдийн дундахь ХДХВ-ын халдварын тархалт /хувь/	0	-	0.003	<0.1
26. 15-24 насны залуучуудын дундахь ХДХВ-ын халдварын тархалт /хувь/	0.0005	0.0005	0.0012	<0.1
Зорилт 12. 2015 он гэхэд сүрьеэ өвчний тархалтыг бууруулах				
27. Сүрьеэ өвчний тархалт /100,000 хүн тутамд/	72.0	70.0	65.0	82.0
28. Сүрьеэгийн өвчлөлийн түвшин /100,000 хүн тутамд/	158.8	156.0	153.0	100.0
29. Сүрьеэгээс шалтгаалсан нас баралт /100,000 хүн тутамд/	2.7	2	3	2.0
30. Оношилгоо, эмчилгээний олон улсын стандартын хүрээнд сүрьеэг илрүүлж, эмчилсэн тохиолдлын хувь	85.0	82.4	84.5	100.0
Зорилт 13. Хүүхдийн шүд цоорох өвчний тархалтыг бууруулах				
31. 5-6 настай хүүхдийн шүд цоорох өвчний тархалт /хувь/	80.1	75.0
Зорилго Долоо. Байгаль орчны тогтвортой байдлыг хангах				
Зорилт 14. Тогтвортой хөгжлийн зарчмыг улсын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусган хэрэгжүүлж, хот суурин, ялангуяа Улаанбаатар хотын агаарыг цэвэршүүлэх				
32. Ойт нутгийн эзлэх хувь	7.7	7.7	7.7	9.0
33. Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн эзлэх хувь	13.4	13.4	13.4	30.0
34. Нэг хүнд ногдох нүүрсхүчлийн давхар ислийн ялгаралт /тонн/ хүн/	мб	6.05	...	4.0
35. Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн өвлийн хоногийн дундаж агууламж /мкг/м ³ /	34.0	39.0	52.0	30.0
36. Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн өвлийн дундаж агууламж /мкг/м ³ /	26.0	34.0	63.0	20.0

Зорилт 15. Гол, горхины усны эхийг хамгаалж, нөхөн сэргээх замаар ширгэлтийг багасгах				
37. Хамгаалалтад авсан гол, мөрний усны урсац бүрэлдэх ундаргын эхийн эзлэх хувь	44	77	90.6	80.0
38. Хамгаалалт барьж тохижуулсан усны эх үүсвэр, булаг шандын эхийн тоо	163	167	145	1000.0
Зорилт 16. 2015 он гэхэд баталгаат ундны усны хангамжгүй, сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амын эзлэх хувийг бууруулах				
39. Баталгаат ундны усны хангамжгүй хүн амын эзлэх хувь	мб			40
40. Сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амын эзлэх хувь	мб			60
Зорилт 17. 2015 он гэхэд хүн амын орон сууцны нөхцөлийг сайжруулах				
41. Инженерийн шугам сүлжээтэй орон сууцанд амьдарч байгаа хүн амын эзлэх хувь	мб			30
Зорилго Найм. Хөгжлийн төлөө дэлхий нийтийн түншлэлийг хөгжүүлэх				
Зорилт 18. Худалдааны болон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх замаар Мянганы хөгжлийн зорилтуудыг хангах таатай нөхцөл бүрдүүлэх				
42. Худалдааны хүчин чадлыг бий болгоход туслахаар үзүүлсэн хөгжлийн албан ёсны тусламжийн эзлэх хувь	0.006	0.053	0.029	10.0
43. Нийгмийн суурь үйлчилгээнд үзүүлсэн хөгжлийн албан ёсны тусламжийн эзлэх хувь	32.5	54.0	19.5	5.0
44. Дотоодын нийт бүтээгдэхүүнд экспортын эзлэх хувь	48.3	50.4	55.7	70.0
45. Санхүүгийн гүнзгийрэл: Дотоодын нийт бүтээгдэхүүн, нийт мөнгөний харьцаа	37.2	43.7	56.7	65.0
Зорилт 19. Далайд гарцгүй Монгол Улсын онцгой хэрэгцээ, шаардлагыг харгалзан илүү тааламжтай нөхцөлөөр далайд гарцтай болох, гадаадад дамжин өнгөрөх тээврийн үр ашгийг дээшлүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээврийг өргөжүүлэх				
46. Үндэсний нийт орлогод хөгжлийн албан ёсны тусламжийн эзлэх хувь	3.6	4.8	2.8	20.0
47. Төмөр замын ачаа тээвэрлэлтэд дамжин өнгөрөх ачааны эзлэх хувь	16.0	16.2	13.8	40.0
Зорилт 20. Урт хугацаанд гадаад, дотоод өрийн тогтвортой байдлыг хангах үүднээс өрийн стратегийг бий болгох, үндэсний болон олон улсад хэрэглэж байгаа арга хэрэгслийг судалж, Монгол Улсын төсөв, эдийн засагт хүндрэл учруулахгүйгээр өрийг зохицуулан шийдвэр				
48. Дотоодын нийт бүтээгдэхүүнд Засгийн газрын гадаад өрийн эзлэх хувь	33.3	39.6	28.0	30.0
49. Экспортод Засгийн газрын гадаад өрийн эзлэх хувь	80.3	78.7	49.3	40.0
50. Засгийн газрын орлогод гадаад өрийн эзлэх хувь	102.1	132.3	76.3	60.0
51. Экспортод Засгийн газрын гадаад өрийн үйлчилгээний эзлэх хувь	2.8	3.7	3.9	3.9
52. Засгийн газрын орлогод гадаад өрийн үйлчилгээний эзлэх хувь	3.3	6.3	6.1	7.5
Зорилт 21. Мэдээлэл холбооны шинэ технологийг хөгжүүлэх, "Мэдээлэлжсэн нийгэм" байгуулах				
53. Суурин утасны цэгийн тоо /1000 хүн тутамд/	57.0	53.0	52.0	100.0
54. Интернет байнгын хэрэглэгчдийн тоо /1000 хүн тутамд/	15.8	39.0	72.0	30.0
55. Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо /1000 хүн тутамд/	656.5	815.1	918.4	350.0

Зорилго Ес. Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх

Зорилт 22. Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүндэтгэн сахиж, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангаж, олон нийтэд мэдээллийг чөлөөтэй олж авах боломж олгох

56. Хүний хөгжлийн индекс	0.745	0.750	0.763*	0.8
57. Монгол Улсын хууль тогтоомж олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцэд нийцэж буй талаарх шинжээчдийн үнэлгээ (хувь)	мб	—
58. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт /хувь/	73.4	70.8	51.9	—
59. Төлбөрийн чадваргүй иргэдэд үйлчилгээ үзүүлж буй өмгөөлөгчдийн тоо	293	340	471	—
60. Улс төр, эдийн засаг, санхүүгээс хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хараат бус байдлын талаархи иргэдийн төсөөлөл	—	28.5	...	—
61. Төсөв, түүний зарцуулалтын тайланг вэб хуудсандаа тогтмол байрлуулдаг төрийн байгууллагын тоо	—	83.0	88.0	—

Зорилт 23. Ардчиллын үндсэн зарчим, хэв маягийг амьдралд хэвшүүлэх

62. Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаархи иргэдийн төсөөлөл	—			—
63. Улсын төсвийн төслийг боловсруулах, батлах үед саналаа албан ёсоор ирүүлсэн иргэний нийгмийн байгууллагын тоо	2	2	1	—
64. Баг, хорооны Засаг даргад нэр дэвшүүлэхэд оролцох иргэдийн ирцийн хувь	—			—

Зорилт 24. Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх

65. Авлигын индекс	...	0.64		—
66. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлигын талаархи төсөөлөл	4.09	3.95	4.07	—
67. Төрийн захиргаа болон үйлчилгээний байгууллагын хүрэн дэх авлигын талаархи иргэдийн төсөөлөл	—			—

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. “Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдлын талаарх мэдээлэл: 2010 он” Монгол Улсын Авлигатай тэмцэх газар, 2011 оны 3 сарын 16. УБ.,
2. Аймгуудын “Эхийн эндэгдлийг бууруулах 2005-2010 оны стратегийн хэрэгжилтийн тайлан, цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлд өгөх саналууд
3. Аймаг, дүүргүүдийн Эх барих эмэгтэйчүүдийн ерөнхий мэргэжилтэн, зөвлөх эмч нарын 2010 оны 5 дугаар сарын зөвлөгөөний тайлан, зөвлөмж,
4. Аймаг, дүүргүүдийн НҮЭМ-ын асуудал хариуцсан мэргэжилтэн зохицуулагчдын 2010 оны 10 дугаар сарын зөвлөгөөний тайлан, зөвлөмж
5. “Ардчилсан засаглал 2009 оны судалгааны үр дүн” Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, 2010 он. УБ.,
6. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны 2009 оны үйл ажиллагааны тайлан, УБ. 2009 он.
7. Боловсролын салбарын 2009-2010 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн эмхтгэл (I)
8. Боловсролын салбарын 2007-2008, 2008-2009, 2009-2010 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн эмхтгэл
9. Жирэмсний хяналтанд байгаа эмэгтэйчүүдийн бэлгийн замаар дамжих халдварын тархвар зүйн судалгааны тайлан, 2008,
10. “Монгол Улсын авлигын индексийн 2009 оны тооцооны үр дүн” Монгол Улсын Авлигатай тэмцэх газар, 2010 он. УБ.,
11. “Монгол Улсын Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл: 2010 он” Монгол Улсын Авлигатай тэмцэх газар, 2011 он. Улаанбаатар хот.
12. Монгол улсын Засгийн газар НҮБ-ын Хүүхдийн сангийн хамтын ажиллагааны хөтөлбөр 2007-2011
13. Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссын 2008 оны үйл ажиллагааны тайлан
14. Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссын 2009 оны үйл ажиллагааны тайлан
15. Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссын 2010 оны үйл ажиллагааны тайлан
16. Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
17. Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн явцын 2 дахь илтгэл, 2007 он
18. Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн явцын 3 дахь илтгэл, 2009 он
19. Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт. Үндэсний гуравдахь илтгэл. УБ. 2009 он.
20. Нийгмийн эрүүл мэндийн төлөв байдал (2000-2010). ЭМЯ, 2011 он
21. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа, 2008 он
22. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үзүүлэлт, 2009
23. Онцгой байдлын ерөнхий газрын харъяа төв, орон нутгийн анги байгууллагуудын захиргааны тайлан
24. Статистикийн эмхтгэл , 2008, 2009, 2010
25. Сүрьеэгийн дүн бүртгэлийн мэдээ. ХӨСҮТ, Сүрьеэгийн тандалт судалгааны алба. УБ., 2010 он
26. Сүрьеэтэй тэмцэх сэргийлэх үндэсний стратеги (2010-2015 он). ЭМЯ
27. Улс орны байдлын тойм үнэлгээ, 2010 он
28. “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн 2009 оны судалгааны үр дүн” Монгол Улсын Авлигатай тэмцэх газар, 2010 он. УБ.,
29. “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн 2010 оны судалгааны үр дүн” Монгол Улсын Авлигатай тэмцэх газар, 2011 он. УБ.,

30. ХДХВ/ДОХ, БЗДХ-аас сэргийлэх үндэсний стратеги төлөвлөгөө (2010-2015). УБ., 2010 он.
31. ХӨСҮТ, БЗДХ, ХДХВ/ДОХ-ын тандалт судлагааны албаны 2010 оны тайлан
32. Эх барихын яаралтай, нярайн нэн шаардлагатай тусламжийн өнөөгийн байдал, хэрэгцээний үнэлгээ, 2010 он
33. Эрүүл мэндийн салбар 2004-2008
34. Эрүүл мэндийн үзүүлэлтүүд, 2009 он
35. Эрүүл мэндийн үзүүлэлтүүд 2009, 2010 он. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Эрүүл мэндийн газар. 2009, 2010
36. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг 2010-2014 онд хөгжүүлэх бодлого
37. Эхийн эндэгдлийг бууруулах стратеги, 2000-2004
38. Эхийн эндэгдлийг бууруулах стратеги, 2005-2010
39. Эх яагаад эндэв, 2000-2004 он
40. Эх яагаад эндэв, 2005-2007 он
41. Accelerated and sustained action in reducing maternal Deaths in the Western Pacific region, WHO, 2009
42. Accelerating progress towards the attainment of international reproductive health goals, a framework for implementation the WHO global reproductive health strategy, 2006
43. Child survival profile: Mongolia, WHO
44. Inter-country review meeting on Prevention of unsafe abortion, WHO, 2008
45. Global strategy for the prevention and control sexually transmitted infections: 2006-2015; key messages, WHO
46. National- level monitoring of the Achievement of universal access to reproductive health, WHO, 2008
47. Promoting sexual and reproductive health for persons with disabilities, WHO, 2009
48. Strategies to reduce pregnancy related deaths, WHO, 2001
49. The global elimination of congenital syphilis rationale and strategy for action, WHO
50. The state of the world's children Maternal and Newborn Health, UNICEF, 2009
51. Trends in Maternal Mortality:1990 to 2008, WHO, UNIVREF, UNFPA and WB, 2010
52. WHO country, Cooperation strategies, guide, 2010
53. Workshop on Strengthening universal access to high quality reproductive health and family planning programmes in the western pacific region, WHO

Үндэсний илтгэлийг бэлтгэсэн баг

Хянан тохиолдуулсан:

Г.Батхүрэл	ҮХШХ-ны Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтийн газрын дарга
Ж.Жаргалсайхан	ҮХШХ-ны Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтийн газрын орлогч дарга

Илтгэлийг нэгтгэн боловсруулж, хэвлэлд бэлтгэсэн:

С.Санжжав	ҮХШХ-ны Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
З.Баярхүү	ҮХШХ-ны Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтийн газрын мэргэжилтэн

Удирдах зөвлөл:

Ч.Хашчулуун	Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга
Л.Зориг	Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дэд дарга
Б.Даринчулуун	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт, шалгалт, үнэлгээний хэлтсийн дарга
Ш.Бүүвэйбаатар	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах референт
Б.Мишигжав	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга
Ж.Бат-Эрдэнэ	Зам, тээвэр, барилга хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга
Д.Хүрэлбаатар	Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Төрийн нарын бичгийн дарга
У.Бямбасүрэн	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
Б.Батзориг	Авлигатай тэмцэх газрын Судалгаа, шинжилгээний албаны дарга, ахлах комиссар
А.Дэмбэрэл	Үндэсний статистикийн хорооны Шинжилгээ судалгааны газрын дарга
Б.Батбаяр	Сангийн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын газрын дарга
Г.Жаргалсайхан	Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын дарга
Т.Бат-Өлзий	Хууль, зүй дотоод хэргийн яамны Мэдээлэл, хяналт, шинжилгээ, үнэлгээний газрын дарга
Ц.Банзрагч	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тогтвортой хөгжил, стратегийн төлөвлөлтийн газрын дарга
Ш.Энхбат	Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
Б.Бурмаа	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга
Г.Батхүрэл	Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтийн газрын дарга
Э.Энхтайван	Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны Мэдээлэл, судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга
С.Нарантуяа	Хүүхдийн төлөө газрын дэд дарга
Р.Батмэнд	Онцгой байдлын ерөнхий газрын Тамгын газрын дарга
Ж.Гантөмөр	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Тамгын газрын дарга
Ө.Одгэрэл	Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын Статистик, мэдээлэл, хяналт шинжилгээний газрын дарга

Ажлын хэсэг:

Г.Батхүрэл	Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтийн газрын дарга
Ж.Жаргалсайхан	Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтийн газрын орлогч дарга
Ё.Манлайбаатар	Зам, тээвэр, барилга хот байгуулалтын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга
Д.Гэрэлмаа	Гадаад харилцааны яамны Олон улсын байгууллагын газрын 2 дугаар нарийн бичгийн дарга
Б.Нямдаваа	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Стратегийн төлөвлөлтийн газрын Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан орлогч дарга
Ш.Отгонхундага	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын орлогч дарга
Ч.Даваасүрэн	Авлигатай тэмцэх газрын Судалгаа, шинжилгээний албаны ахлах ажилтан, ахлах комиссар
Н.Түвшинжаргал	Сангийн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн
Д.Отгончимэг	Хууль зүй дотоод хэргийн яамны Мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээний газрын ахлах мэргэжилтэн
Р.Балжинням	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын газрын мэргэжилтэн
Ж.Мягмар	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын газрын мэргэжилтэн
Д.Алтанцэцэг	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Мэдээлэл-хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын мэргэжилтэн
Х.Хишигжаргал	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тогтвортой хөгжил, стратегийн төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
Р.Нарантуяа	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээний газрын мэргэжилтэн
М.Нямсүрэн	Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Хяналт-Шинжилгээ үнэлгээний газрын мэргэжилтэн
Л.Ариунзаяа	Үндэсний статистикийн хорооны Шинжилгээ судалгааны газрын шинжээч
Г.Соёлгэрэл	Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогыг хэрэгжүүлэх газрын мэргэжилтэн
Я.Буянжаргал	Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогыг хэрэгжүүлэх газрын мэргэжилтэн
П.Оюунцэцэг	Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн
Б.Болорчимэг	Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүлийн мэдийн бодлогыг хэрэгжүүлтийг зохицуулах газрын мэргэжилтэн
Л.Болдбаатар	Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас хамгаалах бодлого, төлөвлөлт, сургалт сурталчилгааны ахлах мэргэжилтэн
Р.Санжрагчаа	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Стратеги төлөвлөлт, бодлого зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
Х.Баавгай	Хүүхдийн төлөө газрын захиргааны хэлтсийн мэргэжилтэн
Б.Уранчимэг	Хүн, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын мэргэжилтэн
В.Батбаяр	Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын Статистик, мэдээлэл, хяналт шинжилгээний газрын мэргэжилтэн
Х.Оюунцэцэг	Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
Ш.Мөнхбат	Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
Т.Дэлгэрнаран	Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
Ж.Ганбаяр	Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
С.Түвшинжаргал	Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны Мэдээлэл, судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн
О.Хатанболд	Нэгдсэн Үндэсний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн Мянганы хөгжлийн зорилт, ядуурлын хяналт шинжилгээ үнэлгээний тогтолцоог дэмжих төслийн менежер

